

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо



ТӨСЛИЙН ТАЙЛАН

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛЫН СТРАТЕГИ
БОЛОВСРУУЛАХ, ОРОН НУТАГТ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ,
ТҮГЭЭХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХОД МЭРГЭЖЛИЙН ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨЛ

“Нээлттэй Мэдээллийн Төв” ТББ

**УЛААНБААТАР ХОТ
2015 ОН**

Төслийг хэрэгжүүлсэн:

“Нээлттэй Мэдээллийн Төв” ТББ-ын зөвлөх баг

Багийн гишүүд:

Ахлах зөвлөх – *Доктор, Профессор* Б.Эрдэнэсүрэн

Зөвлөх – *Доктор, Профессор* Б.Батмөнх

Зөвлөх – *Магистр* Б.Цэрэнханд

Зөвлөх – *Магистр* Г.Дагвасүрэн

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
1. ТӨСЛИЙН ОНЦЛОГ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	9
1.1. Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, нөхцөл, боломж	9
1.2. Орон нутгийн статистикийн үзүүлэлтийн хүрээ.....	11
2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	13
2.1. Мэдээллийн боловсролын стратеги боловсруулах, хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдтэй ажиллах	13
2.2. Мэдээлэл тархаалт, хэрэглэгчтэй харилцах харилцааг сайжруулах	13
2.3. Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх	14
2.4. Захиалагчаас өгсөн нэмэлт тодотгол.....	14
2.5. Төслийг хэрэгжүүлэх үе шатны ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө.....	15
3. ОРОН НУТАГТ ХИЙСЭН СУДАЛГАА, ТҮҮНИЙ ХАМРАЛТ, АРГА ЗҮЙ.....	17
3.1. Зохион байгуулж хийсэн гол ажлууд	17
3.2. Судалгааны арга зүй	19
4. ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД.....	21
4.1. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүд, тэдгээртэй ажиллах үндсэн чиглэл	21
4.2. Хэрэглэгчдийн статистик мэдээллийг олж авах, ашиглах чадвар.....	25
5. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, ХЭРЭГЛЭГЧИДТЭЙ ТОГТООСОН ХАРИЛЦАА	33
5.1. Статистикийн хэлтсээс мэдээллийн хэрэглэгчидтэй тогтоосон харилцааны өнөөгийн байдал.....	33
5.2. Орон нутгийн мэдээллийн хэрэгцээ	39
6. ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН	44
6.1. Орон нутгийн мэдээллийн сан, тэдгээрийн төрлүүд	45
6.2. Орон нутгийн мэдээллийн сангийн өнөөгийн байдал, түүнийг хөгжүүлэх арга зам	49
6.3. Бусад салбарын мэдээллийн санг ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сантай холбох боломж, арга зам	50
7. ХАӨМС-ИЙН БҮРДЭЛТ, АШИГЛАЛТЫН БАЙДАЛ.....	67
7.1. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн.....	67
7.2. ХАӨМС-ийн бүрдэлттэй холбоотой багийн ажилтнуудад тохиолддог бэрхшээл, гаргасан санал.....	75
7.3. ХАӨМС-г бүрдүүлэхтэй холбоотойгоор сумдын багийн засаг дарга, статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ҮСХ-ны Зөвлөх багаас хүргүүлсэн зөвлөгөө	79

8. ҮСХ-НЫ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН БҮРДЭЛТ, АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ	82
8.1. ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын хавсралтуудын алдааны тухай	83
8.2. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	85
8.3. Үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлтүүд.....	86
8.3.1. Мал, тэжээвэр амьтад, малчин өрх, малын хашаа, худаг, уст цэгийн тооны үзүүлэлтүүд	86
8.3.2. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	87
8.3.3. Тариалсан талбайн үзүүлэлтүүд	87
8.3.4. Аж үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, худалдааны салбарын үзүүлэлтүүд	88
8.4. Байгаль орчны статистик үзүүлэлтүүд.....	88
8.5. Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд.....	89
8.5.1. Өрх, хүн ам зүйн үзүүлэлтүүд.....	89
8.5.2. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд	90
8.5.3. Хүн амын амьжиргаа, хүний хөгжил, хүнсний хангамжийн үзүүлэлтүүд	91
8.5.4. Боловсролын салбарын үзүүлэлтүүд	91
8.5.5. Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүд	92
8.5.6. Хот, нийтийн аж ахуй, орон сууц.....	93
8.5.7. Нийгмийн даатгал	94
8.5.8. Соёл, урлаг,сүм хийдийн үзүүлэлтүүд.....	94
8.5.9. Гэмт хэргийн тоо, түүнээс учирсан хохирол, шүүхийн статистик үзүүлэлтүүд	94
8.6. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үзүүлэлтүүд.....	94
8.7. Бусад үзүүлэлтүүд.....	95
8.8. Эхний судалгааны дараагаарҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид боловсронгуй болгох талаар дэвшүүлсэн санал.....	95
8.9. ҮСХ-ноос 2015 оны 11 сард цахим хуудсандаа оруулсан нэмэлт өөрчлөлтүүд.	98
9. ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗОРИЛТОТ БҮЛГҮҮДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ 2016- 2020 ОНЫ СТРАТЕГИ БА БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	100
9.1. Нийтлэг үндэслэл	100
9.2. Орон нутгийн хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ	101

9.3.	Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүд	103
9.4.	Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд баримтлах бодлого	104
9.5.	Статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратегийн зорилго, зорилтууд	106
9.6.	Статистикийн мэдээллийн боловсрол олгох нөхцөл, хэлбэр, арга зам	109
9.7.	Стратегийн төсөөлж буй хүрэх үр дүн.....	112
10.	ХЭРЭГЛЭГЧДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ	114
10.1.	Жилийн сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөмж	114
10.2.	Орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх сургалтын модуль	115
11.	ОРОН НУТАГ ДАХЬ ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ	132
11.1.	Ядуу өрхийн талаарх хүмүүсийн төсөөлөл.....	132
11.2.	Сумын ядуурал түүнийг тооцох оролдлого.	134
12.	ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРСЭН ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	137
12.1.	Төслөөс гарсан гол үр дүн	137
12.2.	Дүгнэлтүүд	140
12.3.	Санал, зөвлөмжүүд.....	142
ХАВСРАЛТУУД:		146
<i>ХАВСРАЛТ -1. ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, газрын дарга нартай хийсэн уулзалтын протокол</i>		146
<i>ХАВСРАЛТ-2. ҮСХ-ны мэдээллийн системтэй танилцсан уулзалтын протокол ...</i>		150
<i>ХАВСРАЛТ-3. ҮСХ-ны Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн мэдээ хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын протокол</i>		154
<i>ХАВСРАЛТ-4. Төслийг хэрэгжүүлэх үе шатны ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө....</i>		158
<i>ХАВСРАЛТ - 5. Чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлага хэлбэрээр оролцооны аргаар явуулах удирдамж.....</i>		169
<i>ХАВСРАЛТ – 6. Хэрэглэгчийн дунд явуулсан судалгааны асуулгын хуудас</i>		172
<i>ХАВСРАЛТ - 7. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистик мэдээллийн идэвхтэй хэрэглэгчдийн бүртгэл</i>		174
<i>ХАВСРАЛТ – 8. Социологийн судалгааны үр дүнгийн хүснэгтүүд.....</i>		198
<i>ХАВСРАЛТ- 9. www.1212.mn сайтад мэдээлэл оруулах ажлыг хариуцах ажилтнуудын нэр</i>		206

ХАВСРАЛТ-10. ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-2а, 2б-д тусгагдсан орон нутгийн эдийн засгийн үзүүлэлтүүдээс ҮСХ-ны цахим хуудасны статистик мэдээллийн санд тавигдсан, тавигдаагүй үзүүлэлтийн тоо, 2015 оны 11 сарын 5-ны байдлаар.....	213
ХАВСРАЛТ-11. ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-2а, 2б-д тусгагдсан орон нутгийн эдийн засгийн үзүүлэлтүүдээс ҮСХ-ны цахим хуудасны статистик мэдээллийн санд тавигдсан, тавигдаагүй үзүүлэлтийн тоо, 2015 оны 12 сарын 5-ны байдлаар.....	216
ХАВСРАЛТ- 12. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх гарын авлага.....	218
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	262

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” MON/13/201 төслийг Сангийн яам хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн “Орон нутгийн статистикийн чадавхыг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийг Үндэсний статистикийн хороо хариуцан ажиллаж байна. Энэхүү төслийн эхний үе шатны ажлууд 2014 онд хийгдсэн билээ. Энэ ажлын хүрээнд орон нутгийн шийдвэр гаргагчдын мэдээллийн эрэлт хэрэгцээг судалж, шаардлагатай үзүүлэлтүүдийн хүрээг тогтоох, орон нутгийн доод, дунд түвшингээр тооцох бололцоотой нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг аймаг, сум, багаар нарийвчлан задалж, статистикийн товчоон лавлах гаргах, орон нутгийн түвшинд дотоодын нийт бүтээгдэхүүн(ДНБ), хэрэглээний үнийн индекс, ажил эрхлэлт, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох аргачлал боловсруулах туршилт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Төслийн хоёр дахь шатанд өмнөх судалгааны үр дүнд үндэслэн орон нутгийн статистикийн мэдээллийг хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаатай уялдуулах, нэмэлт шинэ мэдээллийн хэрэгцээг хангах боломжит арга замыг тодорхойлох, засаг захиргааны дунд, доод нэгжүүдэд ашиглагдах мэдээллийн хүртээмжийг аль болох өргөжүүлэх, мэдээллийн нэгдсэн эх үүсвэр бий болгох, орон нутагт мэдээллийг тархах, хэрэглэгчтэй харилцах харилцаа, хэрэглэгчийн мэдээлэл ашиглах чадавхыг сайжруулах зорилгоор зөвлөх үйлчилгээний баг шалгаруулах тендер зарласан билээ. Энэхүү тендерт нийт 4 баг оролцсоноос “Нээлттэй мэдээллийн төв” ТББ-ийн баг зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр шалгарсан болно.

Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхийн тулд “Нээлттэй мэдээллийн төв” ТББ-ийн Зөвлөх баг нь тендерт заасны дагуу 2 аймаг сонгон судалгаа явуулсан бөгөөд эдгээр аймгуудад Хэнтий болон Өвөрхангай аймаг сонгогдсон болно. Зөвлөх баг төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, орон нутагт ажиллах нэгдсэн удирдамж, хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролын байдалд үнэлгээ өгөх асуулга боловсруулж, тэдгээрийг удирдлага болгон ажилласан. Захиалагчтай байгуулсан гэрээний дагуу төслийн эхлэлтийн тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Энэхүү тайланд гол нь захиалагчийн эрэлт хэрэгцээг нарийвчлан судалж, цаашид хийх ажлаа уялдуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг гаргасан болно. Төслийн явцын анхны тайланг гэрээнд заасан хугацаанд нь гаргаж захиалагчид өгсөн. Энэхүү тайланд төслийн зорилтыг нарийвчилж, захиалагчаас өгсөн нэмэлт саналуудыг тусгаж, цаашдын үйл ажиллагаандаа удирдлага болгож ажиллалаа. Уг тайланд ХАӨБ-ийн санг судалгаанд хамрагдсан 2 аймагт бүрдүүлэх талаар зөвлөх үйлчилгээ үзүүлсэн үр дүн, цаашид анхаарах асуудлууд, ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн байдалд хийсэн үнэлгээ, ҮСХ-ны зүгээс анхаарах асуудлуудыг тодорхой тусгасан болно. Явцын анхдугаар тайланд тусгасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, төслийн зохицуулагчтай уулзаж танилцуулга хийлээ. Энэ үндсэн дээр ҮСХ-ны дарга, газар, хэлтсийн дарга, асуудал хариуцсан мэргэжилтэн нарыг оролцуулсан уулзалт ярилцлагыг 2015 оны 11 дүгээр сарын 2 –нд хийж, ҮСХ-ны 1212

мэдээллийн санг баяжуулах ажлыг шуурхайлах, үр дүнг 2 долоо хоног тутамд хорооны шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэж үр дүнг тооцож байхаар шийдвэр гаргаж, хорооны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг хариуцах мэргэжилтнүүдийг хуваарилж, биелэлтэд нь хяналт тавих ажлыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосон нь төслийг дуусгахыг хүлээхгүйгээр хэрэгжүүлэх явцад биелэлтийг нь хангахад чиглэгдсэн чухал ажил болсныг зориуд тэмдэглэж байна..

Явцын хоёр дахь тайланд “Орон нутгийн мэдээллийн сан”, “Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх 2015- 2020 оны стратеги ба бодлогын баримт бичиг” “Статистик мэдээллийн боловсролын сургалт”, “Орон нутаг дахь ядуурлын дүр төрх” гэсэн бүлгүүдийг шинээр нэмж тусгасан.

Төслийн энэхүү эцсийн тайланд өмнөх тайлангуудад тусгагдсан бүх ажлуудыг дахин нягтлан үзэж баяжуулж, зөвлөх багийн зөвлөмжүүдийг дахин нягталж, холбогдох бүлэг болон дүгнэлтийн хэсэгт нэгтгэн тусгалаа. Тайланд энэ төслийн өмнө хийгдсэн ажлууд ,тэдгээрийг үргэлжлүүлж, амьдралд нэвтрүүлэх шаардлагыг тусгасан нэг бүлэг шинээр нэмлээ. Энэ төслийн нэг онцлог бол төсөл дуусахыг хүлээхгүйгээр биелэлтийг хангахад анхаарч ажилласан явдал юм. Энэ зорилгоор төслийн явц, үр дүнг хорооны удирдлага, төслийн удирдах албанд тогтмол танилцуулж ажилласан. Ийм ч учраас эцсийн тайланд төслийг хэрэгжүүлэх явцад хүрсэн үр дүнг тусгайлсан дэд бүлэг болгож оруулах бололцоотой болсон.

Эцэст нь төслийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг нарийвчлан тодотгохоос эхлээд төслийн ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, төслийн явцтай байнга танилцаж, бидний ажилд үнэлгээ өгч, анхаарах асуудлыг тодруулж, төсөлд тусгагдсан зөвлөмжүүдийг цаг алдахгүй ажил хэрэг болгох талаар байнга хамтран ажиллаж, удирдамж, чиглэл өгч ажилласан ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, төслийн зохицуулагч ҮСХ-ны ерөнхий менежер Т.Гантөмөр, төслийн ажилтан Энхнаран нар болон ҮСХ-ны газар, хэлтсийн дарга нарт гүн талархлаа илэрхийлье.

1. ТӨСЛИЙН ОНЦЛОГ, ХАМРАХ ХҮРЭЭ

1.1.Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага,нөхцөл, боломж

“Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” MON/13/201 төслийн “Орон нутгийн статистикийн чадавхыг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн эхний үе шатны ажлууд 2014 онд хийгдсэн нь энэхүү төслийг хэрэгжүүлэх шаардлага, хийх ажлын чиглэлийг нарийвчлан тогтоох үндэслэл болсон. Төслийн баг өмнө хийгдсэн ажлуудыг давтан хийхээс зайлсхийж, өмнөх үр дүнд тулгуурлаж, түүнийг цааш нь үргэлжлүүлэх явдал төслийн үр өгөөжийг дээшлүүлэх чухал нөхцөл гэж үзсэн болно. Ийм учраас төслийн зорилго, зорилтууд, хүрэх үр дүнг нарийвчлан тодотгож, төслийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулахын тулд өмнө хийгдсэн ажлуудтай тодорхой танилцах ажил хийсэн. Энэхүү төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн 4 төрлийн ажлын тайлан, санал, зөвлөмж, ҮСХ-ноос гаргасан албан ёсны материалуудтай танилцсан. Ашигласан эдгээр мэдээллийн жагсаалтыг тайлангийн төгсгөлд тусгасан болно.

Өмнөх төслийн үр дүнг ҮСХ-ны даргын зөвлөлөөр 2 удаа хэлэлцэж, тушаал гаргасан, 3 төрлийн хавсралт баталж, албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийн хамрах хүрээг шинэчлэн тогтоосон 60 орчим хуудас томоохон хэмжээний материал нь энэхүү төслийн эхний үе шатны үр дүнг тусгасан, бидний хэрэгжүүлэхээр эхлүүлж байгаа төслийн өмнө ямар шаардлага тавигдаж байгааг тодорхойлох, судалгааны ажлын хамрах хүрээг нарийвчлан тогтоох, төслийн өмнө тавигдаж байгаа зорилго, зорилтууд болон хүрэх үр дүнг тогтооход чухал ач холбогдолтой байсныг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Энэ ажлын хүрээнд орон нутгийн шийдвэр гаргагчдын янз бүрийн түвшний мэдээллийн эрэлт хэрэгцээг судалж, шаардлагатай үзүүлэлтүүдийн хүрээг тогтоох, орон нутгийн доод, дунд түвшингээр тооцох бололцоотой нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг аймаг, сум, багаар нарийвчлан задалж, статистикийн товчоон лавлах гаргах, орон нутгийн түвшинд ДНБ хэрэглээний үнийн индекс, ажил эрхлэлт, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох аргачлал боловсруулах туршилт хийх зэрэг ажлуудыг хийжээ.

Төслийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулахад ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, газар хэлтсийн дарга нар, ажил хариуцсан мэргэжилтнүүдтэй хэд хэдэн удаа зохион байгуулсан албан ёсны уулзалт, ярилцлага чухал ач холбогдолтой болсныг тэмдэглэж хэлбэл зохино. Төсөл хэрэгжүүлэхээр манай баг шалгарсныхаа дараахан

С.Мэндсайхан даргатай уулзаж цаашид ажиллах чиглэлийн талаар санал солилцсоны дагуу хоёр дахь уулзалт, ярилцлагад ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, ҮСХ-ны ерөнхий менежер Т. Гантөмөр, Бүртгэл, тооллого, мэдээллийн газрын дарга Б.Ганбат, Мэдээллийн боловсруулалт, технологийн газрын дарга Л.Мягмарсүрэн, төслийн зохицуулагч Энхнаран нар оролцов. Протоколыг хавсаргав /Хавсралт-1/. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээг тогтооход ҮСХ-ны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга Л.Мягмарсүрэн, мэргэжилтэн Тамир, Жаргал нарыг оролцуулж, мэдээллийн сангийн асуудлаар хийсэн семинар чухал ач холбогдолтой байлаа. Протоколыг хавсаргав /Хавсралт-2/.

ҮСХ-ны мэргэжилтэн Алтантүлхүүр, Ариунжаргал, Амартүвшин, Амаржаргал нартай нийгмийн статистик, бизнес регистрийн сангийн асуудлаар хийсэн уулзалтаар боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн үзүүлэлтүүдийг тооцоход учирч байгаа бэрхшээл, шийдвэрлэх асуудлуудын талаар ярилцав. Протоколыг хавсаргав /Хавсралт-3/.

Эдгээр уулзалт, ярилцлагаар гарсан саналыг бүлэглэж үзвэл дараах байдалтай байв. Үүнд:

1. Бүх шатны мэдээлэл хэрэглэгчдийн мэдээллийн боловсролын өнөөгийн байдал, мэдээлэл ашиглах чадавхад үнэлгээ өгч, мэдээллийн боловсрол олгох арга, хэлбэрийг тогтоож, хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг сайжруулах стратеги, бодлогыг боловсруулах,
2. Орон нутгийн статистикийн мэдээллийн хүрээ, давтамж, тархаалт, хэрэглэгчтэй тогтоосон харилцааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, орон нутагт статистикийн мэдээллийг тархаах, хэрэглэгчтэй харилцах оновчтой тогтолцоог бий болгох зөвлөмжийг боловсруулах,
3. Орон нутгийн мэдээллийн хүрээ, давтамж, урсгал, мэдээллийн сангийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, боловсронгуй болгох зөвлөмж боловсруулах.

Эдгээр 3 бүлэг зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай болох нь ҮСХ-ны удирдлага болон мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагаас харагдлаа. Төслийг хэрэгжүүлэхдээ мэдээлэл тархаалт, хэрэглэгчидтэй харилцах харилцааг сайжруулах, орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлагатай болох нь харагдлаа.

Хорооны зүгээс төслийн зорилго, зорилтуудыг тодотгох чиглэлээр гаргасан саналуудыг нэгтгэн бүлэглэж энэ тайлангийн 2-р бүлгийн Захиалагчаас өгсөн нэмэлт тодотгол гэсэн хэсэгт тусгасан болно. Ийнхүү өмнө хэрэгжүүлсэн төслийн үр дүнг амьдралд

хэрэгжүүлэх зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч ирсэн нь тодорхой болсон юм.

Орон нутгийн статистикийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой улсын хэмжээний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сан зэрэг төвлөрсөн сангуудтай танилцаж, цаашид ажиллах чиглэлээ тогтоолоо.

1.2. Орон нутгийн статистикийн үзүүлэлтийн хүрээ

Өмнөх судалгааны үр дүнг ҮСХ-ны даргын зөвлөлийн хурлаар 2014 оны 6-р сарын 13, 8-р сарын 29-ний өдрийн хурлаар авч хэлэлцээд хорооны даргын А-101 тоот тушаалаар статистикийн үзүүлэлтүүдийн хүрээг шинэчлэн баталсан талаар өмнө дурдсан. Энэхүү үзүүлэлтүүдийн хүрээ нь Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заагдсан нийгэм, эдийн засгийн 48 бүлэг үзүүлэлтүүдийг нэгтгэн илэрхийлсэн, тэдгээрийг дотор нь задалсан үзүүлэлтүүдээс бүрдэж байна. Үзүүлэлтүүдийг 15 хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар улс, бүс, аймаг, нийслэл, баг, хороо гэсэн ангиллаар боловсруулжээ. Үзүүлэлтүүдийг ямар салбараар оны болон зэрэгцүүлэх үнээр хэрхэн тооцохыг мөн тусгасан нь сонгосон аймгуудын статистикийн үзүүлэлтийн хүрээг харах, энэ үндсэн дээр судалгаа явуулах бололцоог бүрдүүлж өгсөн болно. Аймаг, сум, багийн түвшинд тооцох үзүүлэлтүүдийн хүрээг Хүснэгт-1-д тусган харуулав

ХҮСНЭГТ 1. ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалаар аймаг, сум, багийн түвшинд тооцож, мэдээлэх үзүүлэлтүүд

Орон нутгийн түвшинд гаргах үзүүлэлтүүд	Аймгийн түвшин	Сумын түвшин	Багийн түвшин
1.Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	20	6	
2.Мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худаг, уст цэгийн тооны үзүүлэлтүүд	11	11	11
3.Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	6	6	
4.Тариалсан талбайн үзүүлэлтүүд	11	11	9
5.Аж үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, худалдааны салбарын үзүүлэлтүүд	19	4	
6.Байгаль орчны статистик үзүүлэлтүүд	9	1	
7.Өрх, хүн ам зүйн үзүүлэлтүүд	28	26	12
8.Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд	12	11	1

9.Хүн амын амьжиргаа, хүнсний хангамжийн үзүүлэлтүүд	11	8	1
10.Боловсролын салбарын үзүүлэлтүүд	29	18	2
11.Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүд	25	21	
12.Хот, нийтийн аж ахуй, орон сууц	5	5	
13.Нийгмийн даатгал	4		
14.Соёл, урлаг,сүм хийдийн үзүүлэлтүүд	12	10	
15.Гэмт хэргийн тоо, түүнээс учирсан хохирол, шүүхийн статистик үзүүлэлтүүд	7	6	
16.Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үзүүлэлтүүд	4	4	
Бусад үзүүлэлтүүд	4	3	
ДҮН	217	151	36

Эндээс үзвэл улсын хэмжээнд тооцож нийтэд мэдээлж байгаа 48 чиглэлийн 404 үзүүлэлтээс 217 үзүүлэлтийг аймгийн хэмжээнд, 151 үзүүлэлтийг сумын хэмжээнд, 36 үзүүлэлтийг багийн хэмжээнд тооцохоор тогтоосон байна. Эдгээр үзүүлэлтүүдийг дотор нь нарийвчлан задалж, хамгийн олон тоотойг нь дурдвал: макро эдийн засгийн 20, хүн ам, нийгмийн статистикийн 51, аж үйлдвэр, барилга зэрэг эдийн засгийн салбарын 47, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын 75 үзүүлэлтийг аймгийн түвшинд тооцох шаардлагатай. Сумын түвшинд макро эдийн засгийн 6, хүн ам, нийгмийн статистикийн 51, эдийн засгийн салбарын 32, нийгмийн салбарын 54 үзүүлэлтийг тооцох юм. Харин багт хүн ам, нийгмийн статистикийн 14, эдийн засаг, нийгмийн салбарын 22 үзүүлэлтийг тооцох шаардлагатай. Эдгээр үзүүлэлтүүдийг хэрхэн тооцож байгаа, ҮСХ-ны даргын баталсан тушаал газар дээрээ хэрхэн биелэгдэж байгааг үнэлэх, түүнийг хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгөх нь цаашдын судалгааны зорилго, зорилтыг нарийвчлан тогтооход чухал ач холбогдолтой байсныг тэмдэглэж байна..

2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зөвлөх үйлчилгээ нь дараах үндсэн зорилготой. Үүнд:

2.1. Мэдээллийн боловсролын стратеги боловсруулах, хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдтэй ажиллах

- I. Сонгосон аймгийн хэмжээнд мэдээлэл хэрэглэгчдийн зорилтот бүлгийг тогтоож, хамрагдах хүмүүсийн статистик мэдээллийн талаарх мэдлэг, боловсролын байдалд үнэлгээ өгөх;
- II. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн талаарх боловсролыг дээшлүүлэх стратеги, арга замыг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж, түүнийг ҮСХ-ны даргын Зөвлөлөөр хэлэлцүүлэх;
- III. Хэрэглэгчдийн бүлэг тус бүрт зориулагдсан сургалтын модуль боловсруулж, турших;
- IV. Орон нутгийн хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулах.

2.2. Мэдээлэл тархаалт, хэрэглэгчтэй харилцах харилцааг сайжруулах

- I. Орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, хэрэглэгчтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийх, эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийн энгийн, хүртээмжтэй тархаалтын тогтолцоог бий болгох зөвлөмж боловсруулах;
- II. Аймаг, сум, багийн хэмжээнд тооцох статистикийн үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлгээ өгч, санал боловсруулах, сонгосон аймаг, сум, багийн үзүүлэлтийн хүрээг нарийвчлан тогтоох;
- III. Сумын хөгжлийн индекс тооцох аргачлалыг хэрэгжүүлэх бололцоонд үнэлгээ өгч, шинээр тооцох шаардлагатай үзүүлэлтүүдийн талаар санал боловсруулах. Өмнөх төслөөр сумын хэмжээнд тооцох эдийн засаг, нийгмийн зарим үзүүлэлтийн талаар боловсруулсан аргачлалтай танилцах, боловсруулсан хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх.

2.3. Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх

- I. Орон нутгийн статистикийн мэдээллийн давтамж, хүрээ, урсгал, мэдээллийн сангийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, статистик мэдээллийн оновчтой шинэ урсгалыг бий болгох, ҮСХ-ны мэдээллийн урсгалтай уялдуулах талаар санал, зөвлөмж боловсруулах;
- II. Сонгосон аймгуудын орон нутгийн мэдээллийн санг ХАӨМС-тай холбох арга зүйг боловсруулах;
- III. Орон нутгийн мэдээллийн санг ХАӨМС-тай холбох, түүнийг онлайн горимоор ашиглах зөвлөмж боловсруулах;
- IV. Аймаг, сум, багийн мэдээллийн бааз бүрдүүлж ашиглах асуудлаар сонгогдсон 2 аймгийн түвшинд сургалт зохион байгуулах;
- V. Эрүүл мэнд, боловсрол, бизнес регистр, мал тооллого, төрийн сангийн мэдээллийн сангуудын үзүүлэлтүүдийн бүтэц, зориулалттай танилцаж, тэдгээрийг хооронд нь уялдуулах, ашиглах санал зөвлөмжийг гаргах.

2.4. Захиалагчаас өгсөн нэмэлт тодотгол

Төслийн захиалагч ҮСХ нь уг төслийн зорилго, зорилтуудыг жил гаруйн өмнө тодорхойлсон бөгөөд өнгөрсөн хугацаанд ажлын хэрэгцээ шаардлага, нөхцөлд өөрчлөлтүүд орсон тул төслийн зорилго, зорилтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, захиалгат шинэ үйлчилгээг зайлшгүй оруулах хэрэгцээ, шаардлага гарсан тул энэхүү нэмэлт тодотголуудыг төслийн зорилго, зорилтуудыг нарийвчлан тодорхойлохдоо харгалзан үзэхийг захиалагч тал хүссэнийг төслийн баг бүх талаар харгалзан үзсэн болно. Эдгээр гол ажлуудыг дурдвал:

- I. Хүн ам орон сууцны завсрын тооллогыг 2015 оны эцсээр бүртгэлд суурилсан аргаар явуулах болсонтой холбоотойгоор ХАӨМС-ийн мэдээллийг сонгосон аймгуудад багийн засаг дарга нар хэрхэн үнэн зөв, бүрэн нөхөж, хөтөлж байгааг газар дээр нь хянан, шалгах, ҮСХ-ноос тухайн аймгийн ХАӨМС-д гарсан алдаа, тодруулах, лавлах зүйлийн жагсаалтын дагуу засвар өөрчлөлт оруулах, заавар, зөвлөгөөг өгөх;
- II. Орон нутагт статистик мэдээллийн хэрэглээ ямар байгааг тодруулж, түүнийг ашиглах чадавх ямар байгааг үнэлж, тодорхой санал, зөвлөмж боловсруулах;

- III. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 10 –ны өдрийн 1/101 тоот тушаалаар аймаг, сум, багийн түвшинд тооцож, мэдээлж байх үзүүлэлтийн жагсаалтыг тогтоосон. Эдгээр үзүүлэлтүүдийг бүрэн тооцох ажил орон нутагт ямар байдалтай байгааг газар дээр нь тодруулах.
- IV. ҮСХ-ны статистик мэдээллийг олон нийтэд тархаадаг цахим хуудас www.1212.mn орон нутгийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг нь хангаж байгаа эсэх болон эдгээр мэдээллийн сангийн үзүүлэлтүүдийг орон нутгийн хэрэглэгчид ашиглаж чадаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх;
- V. Орон нутгийн амьдрал дээр ядуу хүн гэж яг ямар хүнийг хэлээд байгааг газар дээр нь судалж, тодруулах.
- VI. Бусад мэдээллийн сантай 1212- г холбож онлайн горимоор ашиглах, аймаг, сум, багийн хэрэгцээт мэдээллийг ХАӨБ- ийн сантай холбох ажил бол ҮСХ хийх асар том ажил. Энэ ажлыг ҮСХ шат дараалалтайгаар шийдэхээр төлөвлөж байгаа учир төслийн баг энэ ажил руу орох шаардлагагүй бөгөөд бололцоогүй. Харин боловсролын мэдээллийн санг ҮСХ-ны 1212 мэдээллийн сантай холбох асуудалтай холбогдуулан энэ санд байгаа үзүүлэлтүүдийг тооцсон аргачлал нь ҮСХ-ны аргачлалтай нийцэж байгаа эсэх, цуглуулж байгаа мэдээллийн чанарын талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй гэж үзсэн.

2.5. Төслийг хэрэгжүүлэх үе шатны ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө

Төслийн ерөнхий зорилго болон түүнийг хэрэгжүүлэх тодорхой зорилтуудыг судалгааны төлөвлөгөөнд тусгаж, энэхүү төлөвлөгөөний дагуу зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэв.

Энэхүү төлөвлөгөө нь “Нийтлэг хийгдэх ажлууд”, “Зорилтот бүлэгтэй ажиллах” “Мэдээллийн тархаалт, хэрэглэгчидтэй харилцах харилцааг сайжруулах”, “Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх” гэсэн үндсэн 4 хэсэгтэй. Төлөвлөгөөт ажлуудыг хэн хариуцах, аль сарын хэд дахь арав хоногт хийж дуусгах, ямар ажлуудыг багаараа хариуцах зэргийг тодорхой тусгасан болно.

Энэхүү төлөвлөгөөний эхний бүлэгт 21 ажил тусгалаа. Энд төслийг хэрэгжүүлэх урьдчилсан бэлтгэл хангах чиглэлээр хийх уулзалт, сургалт, семинарууд, төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн ажлын үр дүнтэй танилцах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг сум, багийн түвшинд хэрхэн тооцож байгаа зэргийг тодруулах олон ажлыг төлөвлөсөн. Түүнчлэн ҮСХ-ны 1212 сайтад үзүүлэлтүүдийг сум, багаар задалж тусгаж байгаа

байдалд мониторинг хийх, орон нутагт чанарын судалгаа явуулах бэлтгэл хангахтай холбогдсон ажлуудыг тусгасан.. Төлөвлөгөөний хоёрдугаар бүлэгт статистикийн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг орон нутгийн зорилтот бүлгүүдийг тодорхойлох, бүлэг тус бүрийн мэдээллийн боловсролын байдалд үнэлгээ өгөх, мэдээллийг тархаах аргыг боловсронгуй болгох, мэдээлэл олж авах, ашиглах чадавх бүрдүүлэх талаар 7 асуудлуудыг тусгалаа. Төлөвлөгөөний гурав дахь бүлэгт мэдээллийн тархаалтыг боловсронгуй болгох, хэрэглэгчидтэй тогтоосон харилцааг сайжруулах чиглэлээр 7 асуудал тусгалаа. Энд аймаг, сум, багийн түвшинд цуглуулдаг статистикийн үзүүлэлтийн жагсаалтыг албан ёсны болон захиргааны төрлөөр байгууллага нэг бүрээр, түүний давтамж, хариуцан гаргадаг албан тушаалтан, хүлээн авч ашигладаг байгууллага, хүн, хамрах хүрээгээр нь гаргаж, мэдээллийн урсгалыг судлах, ҮСХ-ны www.1212.mn болон ХАӨМС-г хэрхэн ашиглаж байгаа, тэнд байгаа үзүүлэлтүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлгээ хийх, энэ чиглэлээр хэрэглэгчдийн санал хүсэлтийг судлах тодорхой асуудлуудыг тусгалаа. Чанарын судалгааны үр дүнд үндэслэн орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийх, эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийн энгийн, хүртээмжтэй тархаалтын тогтолцоог бий болгох зөвлөмж боловсруулах заалтуудыг орууллаа.

Төлөвлөгөөний сүүлчийн бүлэгт 21 бүлэг асуудал орууллаа. ҮСХ-ны өнөөгийн эрэлт хэрэгцээтэй уялдсан зорилтуудыг тусгах чиглэл барьж боловсрууллаа. Чанарын судалгааны үр дүнг үндэслэн орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, хэрэглэгчтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийх, эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийн энгийн, хүртээмжтэй тархаалтын тогтолцоог бий болгох хэд хэдэн заалт орууллаа. ҮСХ-ны сайт болон ХАӨМС, яам, албан байгууллагуудын сангуудын мэдээллийг орон нутгийн мэдээллийн сантай холбох чиглэлээр заалт тусгагдсан болно.Орон нутгийн мэдээллийн чанарт үнэлгээ өгөх асуудлыг мөн тусгасан /Хавсралт-4/

3. ОРОН НУТАГТ ХИЙСЭН СУДАЛГАА, ТҮҮНИЙ ХАМРАЛТ, АРГА ЗҮЙ

3.1. Зохион байгуулж хийсэн гол ажлууд

Зөвлөх үйлчилгээний баг Хэнтий аймгийн Хэрлэн, Баянмөнх, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Төгрөг, Баянгол, Хайрхандулаан, Хужирт сумдад ажиллав.

Төслийг хэрэгжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөнд тусгагдсан зорилтууд болон орон нутагт ажиллах ажлын удирдамжийн дагуу зөвлөх үйлчилгээний баг Хэнтий, Өвөрхангай аймагт 9 гол чиглэлээр судалгаа хийж, зөвлөх үйл ажиллагааг явууллаа. Үүнд:

1. Төслийн үндсэн зорилго, ажлын хүрээнд хамаарах асуудлаар орон нутгийн холбогдох байгууллага, нэгжүүдтэй уулзалт, ярилцлагууд хийж, тэндээс холбогдох мэдээллийг олж авсан. Шийдвэр гаргах түвшний дарга нартай ганцаарчилсан ярилцлага явуулав. Үүнд Хэнтий аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар, ЗДТГ-ын газар хэлтсийн дарга, мэргэжилтэн, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартай уулзаж, зөвлөх багийн ажлын зорилгыг танилцуулан удирдамжийн дагуу холбогдох мэдээллийг тодруулах ярилцлага хийлээ.
2. Өвөрхангай аймгийн Засаг дарга Д.Тогтохсүрэн, ЗДТГ-ын газар, хэлтсийн дарга, аймгийн төвийн бүх албан байгууллагын дарга нар болон баг, сумын удирдлагуудтай уулзалт, ярилцлага хийж, эрэлт хэрэгцээг нь судаллаа.
3. Орон нутаг дахь статистикийн мэдээллийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдтэй фокус бүлгийн ярилцлагыг тусгайлсан чиглүүлэх асуудлын хүрээнд явуулж, мэдээлэл цуглуулав.
4. Тусгайлсан асуулгаар гол хэрэглэгчдээс статистик мэдээллийн хэрэглээ, ашиглалт, шинэ эрэлт хэрэгцээний талаар судалгаа явуулав. Судалгаанд нийт 348 хүн хамрагдсаны 41 нь аймаг, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, ажлын алба, Тамгын газрын дарга зэрэг өндөр түвшний удирдах албан тушаалтнууд, 34 нь аймгийн санхүү, төрийн сан, хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлого, статистикийн хэлтэс болон бодлого, төлөвлөлтийн бусад ажилтнууд, 22 нь сумдын тамгын газрын ажилтнууд, 48 нь багийн Засаг дарга нар, зохион байгуулагчид, 42 нь эрүүл мэнд, боловсрол, халамж, даатгал, иргэний

бүртгэлийн ажилтнууд, 9 нь хэвлэл, мэдээллийн ажилтнууд, 73 нь ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, 18 нь бизнесийн болон ТББ-ын төлөөлөл, 51 нь иргэдийн төлөөлөл байв. Судалгаанд тухайн сумын төв дэх статистик мэдээллийг хэрэглэж болох нийгмийн өргөн төлөөллийг хамруулж чадсан гэж үзлээ. Судалгааны үр дүнг тайлангийн холбогдох хэсгүүдэд оруулсан болно.

5. ХАӨМС-ийн мэдээллийг багийн Засаг дарга нар хэрхэн бүрдүүлж байгааг газар дээр нь танилцаж, уг санд байхгүй Нийгмийн даатгалын мэдээллийн санд байгаа иргэдийг олж тодруулах, шилжсэн иргэдийн баталгаажуулалтыг хийгээгүй учир шалтгааныг тодруулах, боломжтой хүмүүсийн хувьд баталгаажуулалтыг газар дээр нь хийлгүүлэх, уг санд гарсан алдаануудыг газар дээр нь тодруулж, засуулах 4 чиглэлийн ажлыг багийн Засаг дарга нараар хийлгэв. Энэ ажилд маш их цаг хугацаа зарцуулсан бөгөөд энэ талаар тайлангийн 6-р бүлэгт тодорхой дурдсан болно.
6. Аймгийн орон нутгийн мэдээллийн санг бүрдүүлэх, зөвлөгөө өгөх, туслан дэмжих үйл ажиллагааг явуулав.
7. ҮСХ-ны цахим хуудсыг хэрэглэгчдэд сурталчлах, хэрхэн ашиглах, тухайн аймгийн улс орны хэмжээнд эзлэх байр суурийн талаар товч сургалт явуулав. Мөн ХАӨМС-ийн зориулалт, ач холбогдлын талаар сурталчиллав. Аймгийн телевиз, радиод ярилцлага өгч, төслийн зорилгыг танилцуулж, статистикийн мэдээлэл хаанаас хэрхэн олж, ашиглах талаар зөвлөгөө өглөө.
8. Сонгогдсон 2 аймгийн нийт 196 багийн Засаг дарга нартай холбоо тогтоож, ХАӨМС-г бүрдүүлэх асуудлаар байнгын зөвлөгөөг интернетээр өгч байна.
9. Хоёр аймгийн нийт сумдаас 669 хэрэглэгчийг сонгон авч, ҮСХ-ны 1212 мэдээллийн санг байнга ашигладаг болгох ажлыг онлайнаар хийж статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчдийн хүрээг бий болгож түүгээр дамжуулан нийт хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх ажлыг эхлүүлээд байна.
10. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх сургалтын модуль, сургалтад ашиглах гарын авлагыг боловсрууллаа.

3.2. Судалгааны арга зүй

Зөвлөх үйлчилгээг ажлын даалгаврын дагуу чанартай сайн гүйцэтгэхийн тулд чанарын судалгааг явуулж, судалгааны үр дүнгээр үнэлгээ, дүгнэлт гаргаж, цаашдын үйл ажиллагааны стратегийг тодорхойлсон.

Чанарын судалгаагаар бүх шатны мэдээлэл хэрэглэгчдийн доторх зорилтот бүлгийг тогтоож, тэдгээрийн статистик мэдээллийн талаарх мэдлэг, боловсролын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, албан ёсны болон захиргааны статистикийг эрхлэн бэлтгэдэг орон нутгийн байгууллагаас статистик мэдээллийн хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа шаардлагыг хэрхэн хангаж байгаа болон мэдээллийг тархаадаг хэлбэр, мэдээллийн хүртээмж, орон нутгийн удирдлагын бүх түвшний статистик мэдээллийн эрэлт хэрэгцээ, мэдээллийг ямар хэлбэрээр авч ашиглах шаардлагатай байгаа, онлайн хэрэглээг нэвтрүүлэх дэд бүтэц, технологийн боломж, хэрэглэгчдэд дутагдаж байгаа мэдээлэл, үзүүлэлт зэргийг тодорхойлсон.

Чанарын судалгааны оролцооны арга зүйг хэрэглэсэн. Оролцооны аргын ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын хэлбэрийг ашигласан. Ярилцлагыг явуулахын тулд ярилцлагын чиглүүлэх асуудлын жагсаалтыг урьдчилан бэлтгэж, хөтлөгч ярилцлагыг удирдан чиглүүлж, багийн нэг гишүүн тэмдэглэл хөтөлсөн. Ганцаарчилсан ярилцлагыг орон нутгийн түвшинд статистикийн мэдээллийг ашигладаг болон энэ талаар сайн мэддэг хүнтэй хийв. Фокус бүлгийн ярилцлагыг явуулах удирдамж, чиглүүлэх асуултуудыг хавсаргав (Хавсралт-5).

Чанарын судалгааны зэрэгцээ хэрэглэгчдээс тусгайлсан асуулгаар судалгаа явуулж, хэрэглэгчид албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн талаар ямар төсөөлөл, мэдлэг, мэдээлэлтэй байгаа, тэдгээрийг ашиглах чадвар, түвшин ямар байгааг шалгах асуулга явуулсан. Ялангуяа, ҮСХ-ны цахим хуудсыг (www.1212.mn) мэддэг, ашигладаг эсэх, ер нь орон нутгийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн эрэлт, хэрэгцээ ямар байгааг тандан судална. Асуулгын хуудсыг хавсаргав (Хавсралт-6).

Сонгосон аймгуудын статистикийн хэлтэс болон аймгийн төвийн захиргааны мэдээлэл бэлтгэн гаргадаг орон нутгийн байгууллагууд дээр ажиллаж, мэдээллийн бүтэц, гаргадаг гол үзүүлэлтүүд, мэдээллийн урсгал, давтамж, тархаадаг хугацаа зэргийг судална.

“Статистикийн тухай” хуульд тусгасан 48 бүлэг үзүүлэлтээс ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалд зааснаар аймаг, сум, багийн түвшинд тооцож, мэдээлэх ёстой үзүүлэлтүүд ҮСХ-ны цахим хуудсанд (www.1212.mn) хэрхэн тусгагдсан, ямар үзүүлэлт тавигдаагүй, ямар түвшинд задаргаа нь хангалтгүй байгаа талаар нарийвчилсан тулгалтыг хийж, тогтооно. Мөн ХАӨМС болон боловсрол, эрүүл мэндийн мэдээллийн санд байгаа үзүүлэлтүүд орон нутгийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгаа талаар судалсан.

Орон нутагт ХАӨМС-гийн үзүүлэлтүүдийг багийн Засаг дарга нар хэр үнэн зөв бүрдүүлж байгаа байдалд мониторинг хийж, тодорхой тооны өрхүүдийг түүвэрлэн тэдгээрийн мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг газар дээр нь хянаж, шалгаж, заавар зөвлөгөө өгсөн.

Судалгааны хүрээнд хэрэглэгчдийн статистик мэдээллийн талаарх мэдлэг, ур чадварт хийсэн үнэлгээг үндэслэн зорилтот бүлгүүдэд зориулсан сургалтын модулийг олон улсын нийтлэг загвараар боловсруулна. Энэхүү модулийг хэрэгжүүлэхэд ашиглах сургалтын гарын авлага бэлтгэв.

4. ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД

4.1.Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүд, тэдгээртэй ажиллах үндсэн чиглэл

Хэнтий, Өвөрхангай аймагт ажиллахдаа хэрэглэгчдийн ямар зорилтот бүлгүүд байж болох тэдгээр бүлэг тус бүртэй уулзалт, ярилцлага хийх сценарыг урьдчилан боловсруулж ажиллалаа. Бид дараах 5 зорилтот бүлгүүдийг тогтоож, судалгаа явуулав. Үүнд:

1. Бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажил хариуцсан орон нутгийн хэрэглэгчид

Энд аймаг, сумдын захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөлөл, төлөвлөлт хийдэг ажилтнууд болон мэдээлэл цуглуулж, боловсруулж, тархаах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг статистик, улсын бүртгэлийн ажилтнууд, статистикч эмч нар, халамж, даатгалын зэрэг байгууллагуудын мэргэжилтнүүдийг хамруулав. Нийтдээ газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн, аймгийн статистикийн болон хөгжлийн бодлогын хэлтсийн 117 хүн хамрагдав.

2. Хэвлэл, мэдээллийн байгууллагын орон нутаг дахь төлөөлөл

Хэнтий аймагт 2 телевиз, 1 сонин, 1 FM радио, Өвөрхангай аймагт орон нутгийн 4 телевиз, 2 сонин, 1 сэтгүүл, 1 FM радио тус тус ажилладаг. Эдгээр байгууллагын эрхлэгч, сурвалжлагч, оператор 19 хүн ярилцлагад хамрагдав.

3. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын төлөөлөл.

Аймгийн ерөнхий боловсролын нийт сургууль, цэцэрлэг, МСҮ-ийн төвийн захирал, багш, нийгмийн ажилтныг төлөөлсөн 73 хүн ярилцлагад хамрагдав.

4. Бизнесийн байгууллага, ТББ, иргэдийн төлөөлөл.

Аймгийн төвийн аж ахуйн нэгжийн захирал, менежер, ТББ, иргэдийг төлөөлсөн 69 хүн уулзалт, ярилцлагад оролцов.

5. Сумдын ЗДТГ, эмнэлэг, сургууль, бизнесийн болон ТТБ-ын ажилтнууд болон иргэдийн төлөөлөл

Энэ бүлэгт сумдын засаг дарга, ИТХ-ын дарга, ажилтнууд, ЗДТГ-н хэлтэс, тасгийн ажилтнууд, багийн Засаг дарга, сургууль, цэцэрлэгийн багш, эмч 70 хүнийг хамрууллаа.

Зорилтот бүлгүүдийн судалгаа явуулахын тулд төр, захиргааны байгууллагын удирдах ажилтан, багш, эмч, иргэд, бизнесийн болон төрийн бус байгууллага зэрэг бүлэг тус бүрийн онцлогт зориулсан сценари боловсруулж ажиллав. (Зорилтот бүлэгтэй ажиллах удирдамжийг хавсаргав) Судалгаанд хамрагдагчдад уулзалт, ярилцлагын зорилгыг танилцуулах, статистикийн бүтээгдэхүүн тухайн бүлэгт хамрагдах хүмүүсийн эрхлэх ажилд ямар ач холбогдолтойг тайлбарлах, мэдээллийн боловсролын байдалд үнэлгээ өгөхөд чиглэгдсэн асуулга бөглүүлж авах, статистикийн тоо мэдээлэл хэрхэн ашигладаг, ямар эрэлт хэрэгцээ байгааг нь тодруулахад чиглэгдсэн ярилцлага хийх аргуудыг хэрэглэв.

Уулзалт ярилцлагад хамрагдсан хүмүүсийн хариулт, оролцооноос үзэхэд шууд нүүр тулж ярилцахад санал, бодлоо бүрэн илэрхийлж чадахгүй байгаа, статистикийн мэдээллийн талаарх мэдлэг дутагдалтай болох нь харагдсан учир цаашид зорилтот бүлгүүдтэй байнгын холбоо тогтоож, судалгааг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв. Энэ зорилгоор уулзалт ярилцлагад хамрагдсан болон уулзалтад хүрэлцэн ирж чадаагүй боловч зайлшгүй санал, бодлыг нь сонсох, мэдээлэл өгөх шаардлагатай хүмүүсийг хамруулсан бүртгэл гаргах нь зүйтэй гэж үзлээ. Үүний тулд аймгийн статистикийн хэлтэстэй ярилцаж судалгаанд хамрагдвал зохих үндсэн гол хэрэглэгчдийн электрон шуудангийн хаяг, эрхэлдэг ажил, ажилладаг байгууллагыг тусгасан дэлгэрэнгүй жагсаалт гаргав. Эдгээр хүмүүсийг бид орон нутаг дахь статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчид гэж үзсэн болно. Цаашид эдгээр хүмүүсийг орон нутгийн харьяалал, ажил, мэргэжлээр нь бүлэг болгон хувааж, онлайнаар холбоо тогтоож ажиллах юм. Ийм хэлбэрээр хамтарч ажиллахын ач холбогдлыг хэрэглэгчдэд ойлгуулах ажил хийж байна.

ҮСХ-ны цахим хуудасны идэвхтэй хэрэглэгчидтэй онлайнаар харилцах замаар юуны өмнө, тэдний эрэлт хэрэгцээг тодорхой судлах бололцоо бүрдэнэ. Ингэж байнгын харилцаатай ажилласнаар хэрэглэгчдийн янз бүрийн бүлгийн хэрэгцээт мэдээллийн төрлүүдийг тодорхой судалж, ашиглагдах мэдээллийн хүрээг өргөжүүлэх бололцоотой

болсон. Түүнчлэн **1212** цахим хуудасны мэдээллийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж занших, цахим хуудсыг ашиглахад тохиолдож байгаа бэрхшээлийг тодруулж, холбогдох зөвлөгөө өгөх таатай нөхцөл бүрдэж байгаа юм.


Уулзалт ярилцлагын явцад дүгнэлт хийж хэрэглэгчдэд статистикийн бүтээгдэхүүнийг хэрхэн олж авах ҮСХ-ны нэгдсэн мэдээллийн сан, ХАӨМС-ийн сангийн талаар уулзалтын төгсгөлд мэдээлэл хийж, зөвлөгөө өгөв. Хэнтий, Өвөрхангай аймгийн хувьд уулзалт, ярилцлагад нийт 348 хүн оролцож, асуулгад хамрагдлаа. Харин статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчдээр 669 хүнийг бүртгэж авлаа (Статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчдийн бүртгэлийг Хавсралт-7-д харуулав). Эдгээр бүртгэгдсэн хүмүүс хэрэглэгчдийн ямар зорилтот бүлэгт хамрагдаж байгааг Хүснэгт-2-г харуулав.

ХҮСНЭГТ - 2.Бүртгэгдсэн идэвхтэй хэрэглэгчдийн тоо

Д/д	Бүлгүүд	Хамрагдсан хүний тоо		
		Хэнтий аймаг	Өвөрхангай аймаг	Нийт
1	Аймгийн удирдлага, төр захиргааны байгууллагын албан хаагчид	76	99	175
2	Сумын удирдлага, төр захиргааны байгууллагын албан хаагчид	71	128	199
3	Боловсролын байгууллагын төлөөлөл	73	54	127
4	Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл	6	7	13
5	Оюутан, сурагчдын төлөөлөл	49	35	84
6	Бизнесийн болон ТББ, Иргэдийн төлөөлөл	39	32	71
Нийт		314	355	669

Нийт идэвхтэй хэрэглэгчдийн дотор зорилтот бүлгүүд хэдэн хувь эзэлж байгааг зураг- 1-ээр харуулав.

ЗУРАГ - 1. Идэвхтэй хэрэглэгчдийн цахим шуудангийн хаягийн бүртгэл, бүлгүүдийн дүнд эзлэх хувиар



Нийт идэвхтэй хэрэглэгчээр бүртгэгдсэн хүмүүсийн хамгийн олон нь сумын удирдлага, төр захиргааны байгууллагын албан хаагчид байгаа бөгөөд нийт хүмүүсийн 30% болж байна. Аймгийн удирдлага, төр, захиргааны байгууллагын албан хаагчид 26%-ийг, боловсролын байгууллагын багш нарын төлөөлөл 19%-ийг оюутан, сурагчид 13%-ийг, бизнесийн болон ТББ, иргэдийн төлөөлөл 11%-ийг тус тус эзэлж байгаа юм.

Нийт 600 гаруй хаягаар материалыг 2-3 удаагийн давтамжтайгаар мэдээлэл илгээх ажлыг эхэлж хийсэн болно. Гэвч тодорхой хугацаа өнгөрөхөд бидэнд хариу ирэхгүй байлаа. Энэхүү нөхцөл байдал нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалж байв. Үүнд:

- ❖ Интернетийн сүлжээнд холбогдоход хүндрэлтэй
- ❖ Цахим шуудангийн хаягаа шалгадаггүй
- ❖ Цахим шуудангийн хаяг бүртгэхэд алдаа гарсан

Энэ байдлыг засварлах үүднээс утас нь бүртгэгдсэн 210 хэрэглэгч рүү “Бид танд статистикийн мэдээллийн санг ашиглах аргачилсан заавар илгээсэн, та ашиглаж үзээд бидэнд хариу өгч тус болно уу” гэсэн утга бүхий мессеж давхар илгээсэн. Тэгэхэд хэрэглэгчид:

- ❖ Цахим шуудангаар мэдээлэл хүлээн авсан
- ❖ Интернет ашиглах боломжгүй байгаа
- ❖ Цахим шуудангаа хараахан шалгаагүй байгаа

- ❖ Цахим шуудангийн хаягаа сольсон
- ❖ Цахим шуудангийн хаяг нь буруу бүртгэгдсэн гэх мэт хариуг өгч байв.

Цаашлаад бидэндтэй хамтран ажиллахдаа таатай байгаа болон мэдээлэл хүргэж, заавар зөвлөгөө өгч байгаад талархлаа гэсэн мессеж, цахим шуудангаар хариу болгон илгээж байна.

Зөвлөмж:

1. Цаашид зөвхөн очиж ажилласнаар хязгаарлахгүй бүх сумдын идэвхтэй хэрэглэгчдийн жагсаалт боловсруулж, холбоо тогтоож, хамтран ажиллах.
2. Хэрэглэгчдийн бүлэг тус бүрийн онцлогт тохирсон мэдээллийг энэ сүлжээг ашиглан тодорхой давтамжтайгаар ҮСХ-ны мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвөөс аймгуудын статистикийн хэлтэс хүргэдэг болох.
3. Ямар асуудлыг төв, ямрыг нь орон нутаг хариуцах чиглэл, хугацааны давтамжийг ҮСХ-ноос нэгдсэн журмаар тогтоож өгөх.
4. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хялбарчлан тайлбарлах, цаг үеийн шинжтэй шуурхай мэдээлэл дамжуулах, шинээр гарсан аргачлал, аргагүйг хүргэх, тайлбарлах асуудлыг төвөөс боловсруулж хүргэдэг байх. Харин орон нутгийн чанартай асуудлуудаа аймгуудын статистикийн хэлтэс хариуцаж байвал тохиромжтой гэж үзэж байна

4.2. Хэрэглэгчдийн статистик мэдээллийг олж авах, ашиглах чадвар

Хэрэглэгчдийн мэдээллийн боловсролд үнэлгээ өгөхдөө ҮСХ-ны нэгдсэн мэдээллийн сан болох 1212 цахим сан, энэхүү төслийн эхний шатны үр дүнд үндэслэж боловсруулсан Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн товчоон номыг хэрхэн ашигладаг байдлыг тодруулах, хэрэглэгчид өөрийн аймаг, сумын талаар хэр мэдээлэлтэй байдаг, түүнийгээ хэр зэрэг ашигладаг эсэхийг тодруулах, ҮСХ-ноос санаачлан хийж байгаа ХАӨМС-ийн талаар мэдээлэл хүрсэн эсэхэд үнэлгээ өгөх чиглэл барьж ажилласан болно.

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодруулах, статистикийн мэдээллийн эх үүсвэрийг хэрхэн ашиглаж байгааг тогтоох зорилгоор зорилтот бүлгийн нийт төлөөллийг хамарсан асуулгын судалгаа явууллаа. Судалгаанд 2 аймгийн 348 хүн хамрагдсаны 47,9%-нь Хэнтий аймгийн, 52,1% нь Өвөрхангай аймгийн харьяат хүмүүс байна. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн бүлгийг Хүснэгт- 3”т харууллаа.

ХҮСНЭГТ - 3. Судалгаанд хамрагдагчид, бүлгээр, дүнд эзлэх хувиар

Хэрэглэгчийн бүлэг	Хамрагдагсад	Дүнд эзлэх хувь
Аймаг, сумын Засаг дарга нар, Хурлын дарга, Хурлын ажлын алба, Тамгын газрын дарга, холбогдох удирдах ажилтан	41	11.8%
Аймгийн Санхүү, төрийн сан, Хөгжлийн бодлого, Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс болон бусад бодлого, төлөвлөлтийн ажилтан	22	6.3%
Сумдын холбогдох ажилтан	22	6.3%
Багийн Засаг дарга, зохион байгуулагч	48	13.7%
Статистикийн хэлтэс, сумын төрийн сангийн ажилтнууд	12	3.4%
Эрүүл мэнд, боловсрол, халамж, даатгал, иргэний бүртгэлийн ажилтан	42	12.1%
Хэвлэл мэдээллийн ажилтан	19	5.5%
Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагч	73	21.0%
Иргэн	51	14.7%
Бизнесийн байгууллагын төлөөлөл	8	2.3%
ТББ-ийн төлөөлөл	10	2.9%
НИЙТ ДҮН	348	100%

Судалгаанд хамрагдагчдын 53,6% нь орон нутгийн төр, захиргааны байгууллага, агентлагийн удирдах ажилтан, мэргэжилтнүүд, 21,0% нь ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, 19,9% нь бизнесийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл, 5,5% нь хэвлэл мэдээллийн ажилтнууд байгаа юм.

Эдгээрийн 43,4% статистикийн тоо мэдээллийг байнга, 35,1% хааяа, 14,9% бага зэрэг хэрэглэдэг хүмүүс байв. Мэдээллийг олж авдаг суваг нь хэвлэмэл бүтээгдэхүүн /39,4%/ , интернет /34,8%/ , тогтмол хэвлэл болон зурагт радио /25,9%/ юм. /Хавсралт-8/ Статистикийн ихэнх бүтээгдэхүүн интернетээр дамжуулан ашиглахаар тархагдаж байхад бодлого шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүдийн интернет ашиглалт туйлын хангалтгүй байна.

Хөдөө сумдын хувьд интернет ашиглах боломж хязгаарлагдмал гэж бодоход аймгийн төвийн албан хаагчид маш бага ашиглаж байгаад дүгнэлт хийх шаардлагатай. Аймаг, сумын засаг дарга, ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын ажилтнуудын дөнгөж 36,6% интернет ашиглан статистикийн мэдээлэл авч байна. Харин багийн Засаг дарга нар мэдээллээ өөрсдөө шивж оруулдаг болсон, ХАӨМС-г бүрдүүлэх ажлыг зөвхөн компьютер дээрээ хийж байгаатай холбоотойгоор тэд нарын компьютер дээр ажиллах, интернет ашиглах чадвар эрс дээшилсэн байна. Бид аймгийн статистикийн хэлтэстэй хамтарч багийн Засаг дарга, зохион байгуулагчдын интернет ашиглах чадварт үнэлгээ өгөх оролдлого хийсэн болно. Хэнтий аймгийн 87 багийн Засаг дарга нарын 54,0% компьютер дээр сайн

ажилладаг 43,7% бусдын дэмжлэгтэйгээр ашигладаг, хоёр хүн л ашиглах чадваргүй гэсэн дүгнэлтийг аймгийн статистикийн хэлтэс хийжээ /Хүснэгт- 4/.

ХҮСНЭГТ - 4. Хэнтий аймгийн багийн засаг дарга нарын интернет ашиглалтын байдал

№	Сумын нэр	Багийн тоо	Шилэн кабель ашигладаг баг	Сумын төвд очиж интернет ашигладаг	Багийн даргын компьютер, интернет ашиглах чадвар		
					СА ¹	БДАА ²	АЧГ ³
1.	Хэрлэн	8	6	2	4	4	-
2.	Батноров	7	2	5	6	1	-
3.	Батширээт	4	1	3	1	3	-
4.	Баян-Адрага	4	1	3	1	3	-
5.	Баянмөнх	4	1	3	-	2	2
6.	Баян-Овоо	4	-	4	2	2	-
7.	Баянхутаг	3	1	2	1	2	-
8.	Биндэр	5	1	4	5	-	-
9.	Дадал	4	-	4	4	-	-
10.	Өмөндэлгэр	6	1	5	3	3	-
11.	Дэлгэрхаан	4	1	3	2	2	-
12.	Галшир	6	1	5	-	6	-
13.	Мөрөн	5	1	4	5	-	-
14.	Бор-Өндөр	6	4	2	4	2	-
15.	Цэнхэр мандал	4	1	3	2	2	-
16.	Жаргалтхаан	5	1	4	-	5	-
17.	Дархан	4	1	3	4	-	-
18.	Норовлин	4	1	3	3	1	-
Бүгд		87	25	62	47	38	2

1. СА- сайн ашиглана
2. БДАА- бусдын дэмжлэг авч ашиглана
3. АЧГ- ашиглаж чадахгүй

Өвөрхангай аймгийн 109 багийн дарга, зохион байгуулагчдын 22,9 % сайн ашигладаг, 68,8% бусдын дэмжлэгтэйгээр ашигладаг, 8% нь ашиглаж чадахгүй /Хүснэгт-5/ гэсэн дүгнэлт хийжээ.

ХҮСНЭГТ - 5. Өвөрхангай аймгийн багийн засаг дарга нарын интернет ашиглалтын

байдал

№	Сумын нэр	Багийн тоо	Шилэн кабель ашигладаг баг	Сумын төвд очиж интернет ашигладаг	Багийн даргын компьютер, интернет ашиглах чадвар			
					СА	БДАА	АЧГ	
1.	Баян-Өндөр	5	1	4	3	2	-	
2.	Бүрд	5	1	4	-	4	1	
3.	Бат-Өлзий	5	2	3	1	3	1	
4.	Баруунбаян-Улаан	4	1	3	4	-	-	
5.	Баянгол	6	1	5	-	6	-	
6.	Гучин-Ус	4	1	3	-	4	-	
7.	Есөн зүйл	4	1	3	-	4	-	
8.	Өлзийт	4	1	3	-	4	-	
9.	Зүүнбаян-Улаан	6	1	5	1	5	-	
10.	Богд	7	-	7	-	1	6	
11.	Нарийн тээл	4	1	3	-	4	-	
12.	Сант	5	1	4	-	5	-	
13.	Тарагт	6	1	5	-	6	-	
14.	Төгрөг	5	1	4	-	1	3	1
15.	Уянга	8	2	6	-	1	7	-
16.	Хайрхан дулаан	6	1	5	-	2	4	-
17.	Хужирт	6	2	4	-	2	4	-
18.	Хархорин	8	1	7	-	1	7	-
19.	Арвайхээр	11	1	10	-	9	2	-
Бүгд		109	21	88	-	-	22	87

Төслийн баг бүх багийн Засаг дарга нартай уулзаж, мэдээллийн технологийн мэдлэг, чадварын байдалд үнэлгээ өгөх бололцоогүй байсан учраас аймгийн хэлтсээр үнэлгээ хийлгэсэн болно. Судалгаанд хамрагдсан 2 аймгийн нийт багийн засаг дарга нарын 62,2% бусдын дэмжлэг авч байж интернет ашиглаж компьютер дээр ажиллаж байгаа болон 5,6% нь огт ашиглаж чадахгүй гэж үнэлэгдсэн нь интернет, компьютер ашиглах чадваргүй хүмүүс нэлээд байгааг харуулж байна. Бусдын дэмжлэг авна гэдэг ажлын шаардлага бүрэн хангахгүй байна гэсэн үг. Энэ нь цаашид орон нутгийн анхан шатны нэгжийн дарга нарын мэдээллийн боловсролыг дээшлүүлэх ажлыг тогтмол

давтамжтайгаар хийж байх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. ҮСХ-ноос статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа бүх ажлууд интернет ашиглахгүйгээр хэрэгжих бололцоогүй. Иймд цаашид багийн Засаг дарга нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэд нарыг сонгон шалгаруулахдаа мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг харгалзан үзэж байх талаар сонгон шалгаруулалтын холбогдох баримт бичигт тусгуулах ажлыг хөөцөлдөж хийх шаардлагатай байна.

Хэрэглэгчдийн статистикийн боловсролын байдалд үнэлгээ өгөх зорилгоор ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн санг мэддэг эсэх, тэнд тавигдсан тоо мэдээллийг ашигладаг эсэхийг тодруулах 2 асуултанд хариулт авсан болно. Энэ зорилгоор эхлээд Та www.1212.mn гэсэн цахим хуудсыг мэдэх үү. Хаанахын цахим хуудас вэ? гэсэн асуулт тавьсан юм. Энэ асуултанд судалгаанд хамрагдагчдын 60% мэдэхгүй гэж хариулсан эсвэл хариулаагүй байна. Хариултыг судалгаанд хамрагдагчдын эрхэлдэг ажлын чиглэл, аймгаар нь нэгтгэн хүснэгт- 6-д харуулав.

ХҮСНЭГТ - 6. ҮСХ-ны www.1212.mn гэсэн цахим хуудасны талаарх мэдлэг


	Та www.1212.mn гэсэн цахим хуудасыг мэдэх үү. Хаанахын цахим хуудас вэ?					
	Хэнтий аймаг		Өвөрхангай аймаг		Нийт дүнгээр	
	ҮСХ	Мэдэхгүй	ҮСХ	Мэдэхгүй	ҮСХ	Мэдэхгүй
	Мөрийн дүнд эзлэх хувь		Мөрийн дүнд эзлэх хувь		Мөрийн дүнд эзлэх хувь	
Аймаг, сумын Засаг дарга нар, Хурлын дарга, Хурлын ажлын алба, Тамгын газрын дарга, холбогдох удирдах ажилтан	0.0%	100.0%	70.6%	29.4%	59.0%	41.0%
Аймгийн Санхүү, төрийн сан, Хөгжлийн бодлого, Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс болон бусад бодлого, төлөвлөлтийн ажилтан	18.2%	81.8%	18.2%	81.8%	18.0%	82.0%
Сумдын холбогдох ажилтан	40.0%	60.0%	66.7%	33.3%	55.0%	45.0%
Багийн Засаг дарга, зохион байгуулагч	7.1%	92.9%	88.2%	11.8%	65.0%	35.0%
Статистикийн хэлтэс, сумын төрийн сан	100.0%	0.0%	88.9%	11.1%	92.0%	8.0%
Эрүүл мэнд, боловсрол, халамж, даатгал, иргэний бүртгэлийн ажилтан	29.2%	70.8%	38.9%	61.1%	33.0%	67.0%
Хэвлэл мэдээллийн ажилтан	30.0%	70.0%	66.7%	33.3%	47.0%	53.0%

Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагч	20.5%	79.5%	41.2%	58.8%	30.0%	70.0%
Иргэн	8.6%	91.4%	25.0%	75.0%	14.0%	86.0%
Бизнесийн байгууллага	0.0%	100.0%	0.0%	100.0%	0.0%	100.0%
ТББ	14.3%	85.7%	66.7%	33.3%	30.0%	70.0%

Эндээс үзвэл мэдээлэл ашиглалт аймаг бүрт ялгаатай байна. Хэнтий аймгийн сулалгаанд хамрагдагсдын 85,7% 1212 сайтыг мэдэхгүй байхад Өвөрхангай аймагт 33,3%- тай байх жишээтэй. Хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдийн мэдээлэл ашиглалт эрс ялгаатай байна.Багийн засаг дарга, зохион байгуулагчдын 35,0% 1212 сайтыг мэдэхгүй байхад бизнесийн байгууллагын төлөөлөл 100%, иргэд 86,0% мэдэхгүй гэдгээ илэрхийлжээ. Хамгийн их анхаарал татаж байгаа нь аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын 82,0%, хэвлэл мэдээллийн ажилтнуудын 53,0%, багш, сурагчдын 70,0% мэдээллийн энэхүү том эх үүсвэрийг мэдэхгүй байсан явдал юм. Иргэдийн 86,0% мөн ийм хариулт өгснөөс үзвэл орон нутгийн хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн санг нийтэд сурталчлах, ашиглах аргыг нь дахин давтан зааж, сургаж байх, ашиглахын ач холбогдлыг ойлгуулах ажил нэн чухлаар шаардагдаж байна.

ҮСХ-ны 1212 сайтын талаарх мэдлэгийг дахин нотлох зорилгоор 2 дахь асуулт тавьсан юм. Энэ нь Та www.1212.mn сайтаас мэдээлэл авч ашигладаг уу? гэсэн асуулт байсан юм. Хариултыг зураг 2- р харуулав.

ЗУРАГ - 2. ҮСХ- ны www.1212.mn сайтаас мэдээлэл авч ашигладаг байдал



Энэхүү зураг дүрслэлээс харвал хэрэглэгчдийн 71,0% ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн санг ашигладаггүй юм байна гэсэн дүгнэлт гарч байна. Ашиглахгүй байгаа гэдэг мэдэхгүй гэсэнтэй адил утгатай гэж үзвэл өмнө дурдсан 60,0% мэдэхгүй гэсэн хариулт нотлогдож байгаа төдийгүй бүр илүү олон хүн мэддэггүй, ашигладаггүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Статистикийн мэдээлэл хүргэх олон төрлийн эх үүсвэр бий. Тэдгээрийн дотор ҮСХ-ны мэдээллийн төрөлжсөн сангууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энд юуны өмнө ХАӨМС-ийн болон мал тооллогын сангийн талаарх мэдлэгийг тодруулах зорилгоор хэд хэдэн асуулт тавьсан юм.

Сүүлийн үед ҮСХ ихээхэн ач холбогдол өгч ажиллаж байгаа ХАӨМС-г хэрэглэгчид хэрхэн хүлээн авч байгаа нь сонирхол татаж байгаа юм. Энэ зорилгоор Хүн ам, өрхийн мэдээллийн ХАӨМС онлайн сан байдгийг Та мэдэх үү? гэсэн асуултанд хариулт авсан юм. Судалгаанд хамрагдагсдын 56,0% энэ сангийн талаар мэдэхгүй байв. Хамгийн

сонирхол татаж байгаа нь мөн л ЗДТГ-ын албан хаагчдын 68,2% мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Улс орон даяар бүтэн жилийн турш хийгдэж байгаа энэ чухал ажлыг дэмжиж, хамтарч ажиллах нь бүү хэл мэдэхгүй байна. Энэ сан байгуулагдсанаар орон нутгийн анхан шатны нэгжид ажиллагчдын хөдөлмөр асар их хөнгөвчлөгдөж, мэдээллийн хангамж, чанар сайжирна. Энэ чиглэлээр орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, уг сангийн талаарх сурталчилгааг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байна. Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулах явцад манай зөвлөх баг 1212 сайт болон ХАӨМС-ийн талаар орон нутгийн хэрэглэгчдэд хичээл зааж, зөвлөгөө өгөх ажлыг эхлүүлээ. Манай улсын хамгийн сайн боловсрогдсон сангуудын нэг нь мал тооллогын мэдээллийн сан юм. Энэ сангийн мэдээлэл 1212 сайтад бүрэн тавигдаагүй бөгөөд орон нутагт нэн чухал тоо мэдээг эндээс гаргаж авах бололцоотой. Гэтэл судалгаанд хамрагдагчдын 54,0%, боловсролын төлөөллийн 80,8% хэвлэл мэдээллийн ажилтнуудын 73,7%, бизнесийн салбарынхны 87,5% ийм сан байдгийг мэдэхгүй байна.

ҮСХ-ны нэгдсэн сангуудыг орон нутагт ашиглах талаар юу хийх вэ? гэсэн асуулт төслийн багийн өмнө тавигдлаа. Энэ чиглэлээр Танд статистикийн мэдээллийг олж авах, хэрэглэх талаарх сургалт хэрэгцээтэй юу? гэсэн асуулга тавьсан юм. Судалгаанд хамрагдагчдын 88,2% сургалт зайлшгүй чухлыг тэмдэглэсэн байна. Ялангуяа орон нутгийн төр, захиргааны удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн 90,5- 97,6% сургалтын ач холбогдлыг онцгойлсон байна./ Хавсралт- 8/ Энэ байдлыг төслөөс гарах зөвлөмжид тусгах болно.

Дээр дурдсанаас үзвэл хэрэглэгчдийн бүх бүлгийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх асуудал нэн чухал болох нь харагдаж байна. Түүнчлэн хэрэглэгчдийн бүлэг тус бүрт зориулагдсан сургалтын модуль, гарын авлага боловсруулж өгөх шаардлагатай гэж үзлээ. Зорилтот бүлгүүдийн эрэлт хэрэгцээний талаар энэхүү тайлангийн 5-р бүлэгт тодорхой дурдсан болно.

5. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, ХЭРЭГЛЭГЧИДТЭЙ ТОГТООСОН ХАРИЛЦАА

5.1. Статистикийн хэлтсээс мэдээллийн хэрэглэгчидтэй тогтоосон харилцааны өнөөгийн байдал

Орон нутагт статистикийн мэдээллийг цуглуулж, бэлтгэж, тархаадаг гол нэгж нь аль ч аймагт ЗДТГ-ын статистикийн хэлтэс билээ. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс нь статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх талаар дараах үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар явуулж байна. Үүнд:

Хэнтий аймагт:

1. Сар бүр хэвлэлийн бага хурал тогтмол хийж байна. Гол оролцогчид нь хэвлэл мэдээллийн ажилтнууд, ЗДТГ-ын газар хэлтсүүд, ИТХ-ын ажлын албаныхан ажээ. Харин Хэнтий аймгийн хэлтсийн дарга Д.Болдбаатар хэвлэлийн бага хурлыг сар бүр хийх нь орон нутгийн хувьд төдийлөн тохиромжгүй байгаа бөгөөд түүнийг улирлаар буюу цаг үеийн нөхцөлдөө тааруулан цөөн давтамжтай хийх санал гаргав.
2. Статистик мэдээллийг тархаадаг дараагийн хэлбэр нь орон нутгийн сонин хэвлэлүүдээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэх хэлбэр юм. “Хэнтийн мэдээ” сонинд 7 хоног бүр статистикийн товч мэдээлэл нийтлүүлдэг байна.
3. Хэнтий аймгийн статистикийн хэлтэс сар бүрийн мэдээллээ нэгтгэн бюллетень хэлбэрээр 6 хувь хэвлэн аймгийнхаа гол удирдах албан тушаалтнууддаа өгдөг байна. Үүнд аймгийн Засаг дарга, ИХТ-ын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Хөгжлийн бодлогын хэлтэс гэх мэт.
4. Статистикийн сарын мэдээллээ тархаадаг гол хэлбэр нь сарын бюллетены файлаа цахимаар ЗДТГ-ын хэлтэс, албад, аймгийн төрийн гол байгууллагуудад өгдөг ажээ.
5. Засаг дарга 7 хоног тутамд ЗДТГ болон байгууллагуудын удирдлагуудтай уулзаж, орон нутгийн ажил хэлэлцэх үед статистикийн мэдээллээ товч танилцуулдаг ажээ.
6. Аймгийн төвийн иргэд, байгууллагуудаас статистикийн хэлтэст хандаж, мэдээлэл ирж авдаг байна.

7. Эдгээр хэлбэрээр статистик мэдээллийг хэрэглэгчдэд гол төлөв тархааж иржээ. Харин орон нутгийн телевизээр мэдээлэл тархаахад мөнгө нэхдэг тул нэлээд хязгаарлагдмал хэмжээнд ТВ ашиглаж байна. Мөн орон нутгийн радиог ашиглах талаар төдийлөн ажиллаагүй тал харагдлаа.

Сар бүрийн бюллетенийг хэвлэх цаасны зардлаасаа болоод цөөн тоотой хэвлэж байгаа ажээ. Харин сумууд сар бүр өөрсдөө мэдээллээ тархаадаг байх ёстой талаар Д.Болдбаатар дарга саналаа хэллээ. Харамсалтай нь хариуцсан хүнээсээ хамаараад сумууд сарын мэдээгээ зарим нь хэвлэж тараадаг, зарим нь тарааж чаддаггүй ажээ.

Сүүлийн 2 жилд статистикийн албаны ойгоор 11 сард дунд сургуульд хичээл заадаг болсны зэрэгцээ ахлах ангийн сурагчдын дунд Эссэ бичих уралдаан зарлаж, шалгарсан хүүхдүүдийг урамшуулж байгаа ажээ. Энэ нь орон нутагт статистикийг сурталчлах гол ажил болж байна.

Статистикийн хэлтсийн хувьд мэдээллийг хэрэглэгчдэд тархаах ажлыг цаашид өргөн хүрээнд явуулахад санхүүгийн дэмжлэг, тухайлбал, ТВ, радиогоор мэдээлэл цацах нэмэлт зардлыг төсөвт тусган өгөх хүсэлтийг тавьсан.

Өвөрхангай аймагт:

Тус аймагт ҮСХ 2015 оны 7 сард “Орон нутагт статистикийн мэдээлэл тархаалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх боломж, нөхцөлийг судлах, энэ чиглэлээр төслийн хүрээнд хийх ажлын хөтөлбөр боловсруулах “ ажлын багийг ажиллуулж, төсөл хэрэгжүүлсэн байна.

1. Тамгын газрын шуурхай хурал дээр статистикийн хэлтсээс гаргадаг мэдээллийг ажилтнуудад байнга сонсгодог ажээ.
2. Аймгийн статистикийн хэлтэс сар бүрийн мэдээллээ нэгтгэн бюллетень хэлбэрээр хэвлэн аймгийнхаа гол удирдах албан тушаалтнуудад өгдөг байна. Үүнд аймгийн Засаг дарга, ИХТ-ын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Хөгжлийн бодлогын хэлтэс гэх мэт.
3. Статистикийн сарын мэдээллээ тархаадаг гол хэлбэр нь сарын бюллетены файлаа цахимаар ЗДТГ-ын хэлтэс, албад, аймгийн төрийн гол байгууллагуудад өгдөг ажээ.
4. “Өвөрхангайн өнгө” сэтгүүл нь нийт 1000 хувь хэвлэгддэг 7 хоног тутмын сэтгүүл бөгөөд статистикийн мэдээллийг инфографик хэлбэрээр нийтэлж, тогтмол буланг ажиллуулдаг байна.

3. Өвөрхангай аймаг нь орон нутгийн 4 телевиз, 2 сонин, 1 сэтгүүл, 1 FM радио нийт хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай бөгөөд статистикийн мэдээ, мэдээллийг олон нийтэд тархаах чиглэлээр “Арвайхээр” телевиз, “Таны элч” сонин, “Өвөрхангайн өнгө” сэтгүүл, аймгийн FM радиотой 2016 он хүртэл хамтран ажиллах гэрээ байгуулахаар удирдах ажилтнуудтай уулзаж, тохиролцсон ажээ.
4. Аймгийн төвд цацагддаг FM радиогоор албан ёсны статистикийн мэдээллээс гадна сонирхолтой статистикийн тоог бэлтгэж, мэдээлж байна. Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс нь аймгийн FM радиогоор мэдээлэл түгээх ажлыг тогтмолжуулсан байна.
5. Сурталчилгааны төсөл хэрэгжээд гудамжинд баннер байршуулах, таксин дээр наалт наасан нь чухал сурталчилгаа болж байна гэж статистикийн хэлтсийнхэн танилцуул-сан. Орон нутгийн телевизэд сар бүр 100 мян. төг байршуулаад бүх мэдээллээ суртал-чилж байгаа ажээ.
6. Аймгийн нийгэм, эдийн засгийн статистикийн мэдээллээс салбаруудын гол үзүүлэлтээр хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар байдлаар мэдээллийг хүргэх зорилгоор аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн 78,8 сарын статистик мэдээллээр инфографик хийж хэвлэн гаргаж хэрэглэгчдэд хүргэсэн байна. Цаашид инфографик мэдээг өргөжүүлж, боловсронгуй болгох талаар ажиллаж байна.
7. Хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээний мах, гурил, будааны үнийн мэдээг “Арвайхээр”, “ХАС” телевизийн мэдээллийн цагаар дэлгэцийн доогуур урсдаг зар мэдээллээр 7 хоног бүрээр шинэчилж тавьж иргэдэд мэдээллийг хүргэж байна
8. Аймгийн худалдааны чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн мэдээлэгч нарт “ХУ-1, ХУ-1а мэдээг гаргах аргачлал”, “жижиглэн худалдаалах үнийн улирлын мэдээ гаргах арга зүй”, Статистикийн мэдээллийг хаанаас хэрхэн авах тухай мэдээллийн сан /www.1212mn/-г сурталчилсан сургалтыг 9 сарын 7-нд зохион байгуулж худалдааны мэдээнд хамрагддаг 17 аж ахуйн нэгжийн мэдээлэгч нар хамрагджээ. Өвөрхангай аймгийн статистикийн хэлтсийнхэн дараах саналыг гаргалаа. Үүнд:

Төсөв санхүүгийн асуудал шийдэж өгөөд байвал янз бүрийн ажил зохион байгуулах бололцоотой. Тодорхой зорилтот бүлгүүдтэй үе үе өнөөдрийн хэлбэрийн уулзалт, ярилцлага хийж, мэдээлэл өгвөл их үр дүнтэй

Сонин, радио, телевиз ашиглаж мэдээллээ тогтмол цацаад байвал чухал. Олон хүнд мэдээлэл хүрч очих болно.

Орон нутагт мэдээлэл сурталчилгаа явуулахад хүн хүч хүрэлцдэггүй. Ачаалал маш их байдаг. Энэ асуудал хариуцсан орон тоо байдаг бол их ажил хийх бололцоо байна.

Статистикийн бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг төвөөс нэгдсэн журмаар явуулахад анхаарахыг хүсэв. Энэ ажил хариуцсан бүхэл бүтэн төв ажиллаж байгаа тул энэ нэгжийн бололцоог сайн ашиглах шаардлагатай гэж үзэж байна.

Нийгэм, эдийн засгийн тодорхой ойлголтуудыг хялбарчилсан байдлаар нэгдсэн журмаар бэлтгэж, сурталчилгаанд ашиглахыг санал болголоо.

Манай мэдээллийн санг оюутнууд л овоо ашигладаг. Бусад хүмүүст хүрч чадахгүй байна. Энэ байдалд анхаарах шаардлагатай.

Мэдээллийн чанарт анхаарах шаардлагатай. Сум, аймгаар шахаж гаргасан мэдээллийг айл өрх, багаар задлахад ихээхэн зөрүү гарна. Тариалсан талбай, нэг га-н ургац, хадсан хадлан зэргийг төлөвлөсөн зорилттойгоо уялдуулаад зохиомлоор гаргах хандлага байна. Ялангуяа салбарын яаман дээр ийм зүйл ажиглагддаг. Статистик энэ бүхнийг нягтлахад хүч хүрэлцдэггүй байна.

Мэдээллийг доош нь баг, айл өрх хүртэл задалж байгаатай холбогдоод мэдээллийн чанар сайжирч, анхан шатны мэдээ гаргадаг хүмүүсийн хариуцлага эрс дээшилнэ.

Дээр дурдсанаас үзвэл аймгийн статистикийн хэлтэс ойролцоо чиглэлээр хэрэглэгчидтэйгээ холбоо тогтоон ажиллаж байна. Тухайн аймгийн статистикийн хэлтсийн үйл ажиллагаа, санаачлагатай холбоотой өөрийн гэсэн онцлогтой ажлууд зохион байгуулдаг нь харагдлаа. Орон нутгийн статистикийн хэлтэс 45 төрлийн мэдээлэл хариуцан гаргаж байна. Эдгээр мэдээллийг 2 чиглэлийн урсгалаар гаргаж байна. Үүнд:

1. Багийн Засаг дарга хариуцан гаргаж, сумдын статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн нэгтгэж, аймгийн статистикийн хэлтэст дамжуулдаг 17 төрлийн мэдээлэл байгаа бөгөөд тэдгээр нь нийт мэдээллийн 37,8% болж байна.
2. Аймгийн статистикийн хэлтэс аж ахуйн нэгж байгууллага, мэдээлэгчидтэй шууд холбогдож цуглуулдаг мэдээлэл нийт мэдээллийн 62,2%-ийг эзэлж байна. ААНБ-ын мэдээллийг татвар, нийгмийн даатгал, статистик зэрэг олон байгууллага өөр өөрсдийн чиглэлээр шаарддаг учраас ААНБ-д дургүйцэх, нэг эх үүсвэрээр бүх мэдээллээ нэгмөсөн авч байх санал тавьдгийг аймгууд онцлон хэлж байна.

Цаашид төр, захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, ААНБ- аас авдаг мэдээллийн нэгдсэн урсгал бий болгох шаардлагатай байна.

Хэдийгээр аймгийн статистикийн хэлтсүүдээс хэрэглэгчидтэй тодорхой харилцаа холбоотой ажиллаж, статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд янз бүрийн хэлбэрээр тогтмол тарааж байгаа боловч гол хэрэглэгчид нь энэ талаар ямар санаа бодолтой байдгийг фокус бүлгийн ярилцлагаар тандан судалсан. Энэхүү ярилцлагын явцад хэрэглэгчдэд статистикийн мэдээлэл хэр зэрэг хүртээмжтэй очдог талаар хөндөн асуусан болно.

Хэнтий аймагт хийсэн фокус бүлгийн ярилцлагын дүнгээс

Хэнтий аймагт хийсэн аймгийн захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөллийн бүлгийн ярилцлагад Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир, спортын газрын дарга, мэргэжилтэн 12 хүн оролцлоо.

Бодлого, төлөвлөлтийн ажилтнууд аймгийн статистикийн хэлтсээс хэрэгтэй мэдээллээ авдаг, нэмэлт мэдээллийг салбар салбарынхаа мэдээллээс авч ашигладаг ажээ. Статистикийн танилцуулга, эмхтгэлийн тоог статистикийн хэлтсээс авчихдаг. Гэхдээ нарийн дэлгэрэнгүй мэдээллийн хэрэгцээ гардаг тэр нь олддоггүй ажээ.

Хэнтий аймгийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаатар ажлын хэрэгцээнд шаардлагатай гол судалгаа, мэдээллээ статистикийн хэлтсээсээ авчихдаг гэсэн. Сүүлийн жилүүдэд манай аймагт барилгын салбар эрчимтэй хөгжиж, барилгын компаниуд статистикийн тоо мэдээлэл их сонирхдог болсон. Иргэдэд мэдээлэл хомс байгааг дурдаад тэдэнд тоо мэдээллийг хаанаас яаж олж авах талаар зар сурталчилгааг сайн хийж өгмөөр байна гэсэн санал бодлоо илэрхийлсэн.

Шигтгээ-1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын бизнесийн байгууллага, ТББ, иргэдтэй хийсэн ярилцлагаас:

Төсөл боловсруулах, зээл авах үндэслэл гаргахад статистикийн тоо мэдээлэл их хэрэг болдог. Зах зээлийнхээ багтаамж хэрэгцээг тооцоход нийгмийн үзүүлэлтүүдийг статистикийн хэлтсээсээ өөрөө очоод авдаг. Мэдээлэл авьяа гэвэл боломжтой. Мөн эрүүл мэндийн албанаас мэдээлэл авдаг.

Ярилцлагад оролцсон “Жимсний баяжмал” нөхөрлөлий гишүүн Г.Оюун

Хэнтий аймагт хийсэн аймгийн захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөллийн бүлгийн ярилцлагад оролцогчид статистикийн хэлтсээс мэдээлэл авах шуурхай, амархан байдаг гэж байв. Статистикийн мэдээллийн хэрэглэгчдэд мэдээллийг хаанаас яаж олж авах, яаж ашиглах анхан шатны сургалт, дадлага дутагдаж байна. Сум, багийн түвшний мэдээлэл дутагддаг гэдгийг хэд хэдэн хүн хэллээ.

Шигтгээ-2. Хэнтий аймгийн Хэрлэн сумын бизнесийн байгууллага, ТББ, иргэдтэй хийсэн ярилцлагаас:

Тендерт орох, төсөл бичихэд статистикийн тоо мэдээлэл хэрэгтэй байдаг. Аймгийнхаа худалдаа, үйлдвэрийн танхим болон статистикийн хэлтсээс хэрэгтэй тоо мэдээллээ олж авахад хялбар байдаг. Зарим тохиолдолд компаниуд төсөл бичихэд маш нарийн мэдээлэл хэрэг болдог. Ихэвчлэн өөрсдөө судалгаа явуулж мэдээлэл цуглуулдаг.

Ярилцлагад оролцсон “Биг оргил” ХХК, Ц.Энхзаяа

Өвөрхангай аймагт хийсэн фокус бүлгийн ярилцлагын дүнгээс

Аймгийн Засаг дарга Д. Тогтохсүрэнгтэй хийсэн ярилцлагаас Статистикийн хэлтсийнхэн ачаалал ихтэй ажилладаг, ажил нь тогтмолжсон хамт олон. Тамгын газрын шуурхай хурал дээр статистикийн хэлтсээс гаргадаг мэдээллийг ажилтнуудад байнга сонсгодог. Статистикийн хэлтсийн дарга Ц.Должин шаардлагатай мэдээллийг цаг, тухайд гаргаж өгдөг гэж үнэлж байсан. Харин цаашид доорх зүйлүүдэд анхаарал тавьж ажиллахыг статистикийн байгууллагаас хүсэж байв. Үүнд:

- Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд илүү хүргэж ажиллах,
- Орон нутагт хүний нөөцөө нэмэгдүүлэх /ачаалал ихтэй байдаг/,
- Анхан шатны мэдээллийн тогтолцоог сайжруулах,
- Сумдад статистикийн анхан шатны мэдээлэл гаргадаг мэргэжилтэнтэй болбол мэдээллийн чанар сайжирна гэдгийг хэлж байв.
- Статистикийн хэлтэст мэдээлэл, сурталчилгааны зардал нэмж өгөх хэрэгтэй, хэдий чинээ илүү мэдээлж сурталчилна, төдийчинээ өргөн хэрэглэнэ.
- Суманд статистикийн ажлыг хавсаргаас гаргах хэрэгтэй байна
- Ядаж эхний ээлжид хүн ам олонтой сумдыг статистикчтэй болгох хэрэгтэй гэж үзэж байна.

Багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үед ҮСХ-ны мэдээллийн сангийн талаар ямар ч мэдээлэл байхгүй учир ашиглахгүй байгаа ажээ. Иймд мэдээлэл өгсөн явдал чухал ач холбогдолтой боллоо гэж тэд үзсэн. Багш статистик мэдээллийг ашиглаж эхэлбэл цаашдаа маш олон хүнд зааж, ашиглуулах боломжтой тул анхаарч ажиллах

хэрэгтэй байгааг дурдлаа. Мөн багш нар аймгийн статистикийн товчоон хэмээх ном гарсан талаар ямар ч мэдээлэлгүй байв. Энд гарсан мэдээллүүдийг ихэд сонирхож байв. Эндээс харахад аймгийн статистикийн хэлтсээс явуулдаг сурталчилгаа зорилтот бүлэгтээ тэр бүр хүрэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Дунд сургуулийн сурагчидтай хийсэн уулзалтаар хүүхдүүд ҮСХ-ны www.1212.mn сайтын талаар ерөөсөө дуулаагүй байв. Харин бүх хүүхэд facebook ашиглаж хоорондоо бүлэг үүсгэж харилцдаг тухайгаа ярьж байв. Аймаг, орон нутгийн талаар сонирхолтой тоонуудыг танилцуулахад цаашид ҮСХ-ны www.1212.mn сайтын мэдээллийн санг ашиглаж, сонирхолтой тоог бие биедээ харилцан мэдээлж байхаар тохиролцов.

5.2. Орон нутгийн мэдээллийн хэрэгцээ

Хэнтий аймагт хийсэн ярилцлагын дүнгээс

Хэнтий аймгийн Засаг дарга Б. Оюунбаатартай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар шинээр бий болгох мэдээлэлд анхаарал хандуулахыг санал болгосон. Тухайлбал, Хэнтий аймагийн ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын орлого ямар хэмжээтэй байдаг талаар статистикийн хэлтсээс тоо мэдээлэл гаргаж чаддаггүй, ажлын байрны талаар нарийн мэдээлэл гардаггүй хомс байдаг талаар тэрээр дурдсан. Ядуу хүмүүсийн тоо нарийн гардаггүй. ДНБ-ний тоо цаг алдаж удаж гардгийн зэрэгцээ хэр үнэн бодитой вэ гэдэг асуудал гардаг. Ер нь орон нутгийн эдийн засгийн чадавхыг харуулсан үзүүлэлтүүд хомс байгаад анхаармаар байна гэж хэлсэн. Эдийн засгийн мэдээлэл нэн чухал. Хэд хэдэн гол асуудал байна. ХАА-с ордог орлогын хэмжээг бодитой тогтоох, ажлын байртай холбоотой мэдээлэл, гэмт хэрэг, гэр бүл салалт, ядуу гэр бүл г.м. Хүнсний карт олгосон судалгаа оновчтой бус болсон. Аймаг, сумын хөгжлийн индекс хир зөв тооцогдож байгааг анхаарах. ДНБ бидний хувьд их чухал. Нэг хүнд ногдох ДНБ-г их сонирхож байна. Тоо материал дээр хийсэн анализ дүгнэлт маш чухал байгааг тэрээр анхааруулав.

Хэнтий аймагт хийсэн аймгийн захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөллийн бүлгийн ярилцлагад оролцогчид үндсэн чиглэлийн тооцоо, томоохон төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, арга хэмжээний тайлан бэлтгэх үед дэлгэрэнгүй мэдээллийн эрэлд гардаг. Хэнтий аймгийн товчоон эмхтгэлийг үзсэн, адилхан л дэлгэрэнгүй мэдээлэл байгаагүй. Ер нь хүүхэд, залуучуудын асуудлаар танилцуулга бэлтгэх гэсэн боловсролын мэдээлэл нас бүрээр олдоогүй, бүлэглэчихсэн насыг задалж ашиглах

боломжгүй байсан, их дээд сургууль төгсөгчдийн тоог боловсролын түвшингээр авч болоогүй, тойргийн сумдын СӨБ, ЕБС-ийн сурагчдын тоо олддоггүй. Сургалтын төрийн сангийн зээлээр, буцалтгүй тусламжаар суралцагчид хаачсан юу болсон тухай мэдээлэл олддоггүй гэж ярилцлагад оролцогчид санал бодлоо илэрхийллээ.

Шигтгээ-3. Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЕБС-ийн багш, сурагчидтай хийсэн ярилцлагаас:

Сурах бичиг хуваарилахад өрхийн мэдээлэл их хэрэг болдог. Нэг өрхийн хэдэн хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байгааг мэдэх шаардлага байнга гардаг. Олон хүүхэд сурдаг гээд иргэд тусламж хүсдэг. Ашиглах мэдээлэл байдаггүй. Мөн үнийн мэдээлэл их чухал. Бид төвийн үнийн мэдээлэл авдаг. Харин аймаг, сумын мэдээлэл их хэрэг болох юм.

Хэнтий аймгийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаатар аймгийн хэмжээнд ирсэн жуулчдын тоо дотоод, гадаад гэсэн ялгаатайгаар гарахгүй байгаа. Манай аймгийнхан жуулчны баазад буусан жуулчдын тоог л гаргадаг. Дотоодын аялал жуулчлал их болж байна. Хувиараа майхан савтай аялсан хүний тоо бүрэн гарахгүй байна гэсэн. Тэрээр мөн ДНБ-ийг сумын түвшингээр тооцож, аймгийн эдийн засагт сумдын оруулсан хувь нэмэрийг тооцдог болох шаардлагатай байгааг онцлов.

Тэрээр МАА-н болон хүнсний гол нэрийн барааны үйлдвэрлэлийн мэдээлэл их чухал байдаг. Малын ашиг шимийн үзүүлэлтүүдийг бүрэн тооцож чадахгүй байна гэж дарга нар байнга ярьдаг гэсэн.

Хэнтий аймагт хийсэн аймгийн захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөллийн бүлгийн ярилцлагад оролцогчидын ярилцлагын үед “Хэнтий аймгийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт 2015 оны 4 сард болсон юм. Уулзалтад зориулсан илтгэлд ашиглах хүйсээр задалсан мэдээлэл дутмаг байсан, уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүний тоо, түүнээс эмэгтэйчүүдийн тоо олдоогүй. Мөн ажилгүйчүүдийн тоо, тэр тусмаа хувиараа лангуун дээр ажиллаж гэр бүлийнхээ гол амьжиргааг залгуулж байгаа хүний тоо байхгүй байсан. Гэхдээ энэ тайланг бэлтгэх явцдаа маш их мэдээлэл байдгийг олж мэдсэн. Статистикийн хэлтсийнхэн хэрэгтэй мэдээллийг байгаа хэмжээнд нь шуурхай гаргаж өгсөн. Ажилгүйчүүдийн тодорхойлолт сум орон нутгийн ажилгүйчүүдийн тоо гаргахад тохиромжгүй байна. Ажил хайж байна гэж бүртгүүлээгүй өчнөөн ажилгүй хүмүүсийн тухай мэдээллээр дутагдаж байна” гэж санал бодлоо илэрхийлэв.

Ядуу өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо үнэмшил муутай болсон. Хүнсний талон олгож байгаа өрхийг ядуу гэж үзэхэд учир дутагдалтай байдаг, ядуу гэж хэлэх аргагүй айлууд хүнсний талон авч байгаа. Аливаа мэдээлэл сум, багийн түвшнээр их дутмаг байна гэж олон хүн үзэж байна.

Судалгаанд хамрагдсан аймгуудад хийсэн аймгийн захиргааны болон төсвийн байгууллагууд, ИТХ-ын төлөөллийн бүлгийн ярилцлагад оролцогчид дараах үзүүлэлтүүдийг орон нутагт хэрэгтэй байгаа, олдоц хүртээмж дутмаг гэсэг санал хэллээ. Үүнд:

- Байгаа мэдээлэл нь сум, багаар гарахгүй байна;
- Нас бүрээр, хүйсээр задалсан тоо хэрэгтэй байна;
- Ажилгүйчүүдийн тоо бодит байдлыг илэрхийлэхгүй байна. Ажил хайж байна гэж бүртгүүлээгүй өчнөөн ажилгүй хүмүүс мэдээнд хамрагдахгүй байна;
- Нийтийн биеийн тамираар хичээллэдэг хүний тоо, спортын заал, талбайн хэмжээ, тоног төхөөрөмж г.м мэдээлэл огт байдаггүй тул ЭМСЯ-ны зааварчилгаар бүх сумдаараа явж энэ тоо, хэмжээг гаргах гэж байна;
- Худалдааны лангуун дээр зогсож байгаа компани, хоршоонд харьяалагддаггүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт бүртгэгдэхгүй байна;
- Ядуу өрхийг хүнсний талон авдаг өрхөөр тооцоолох нь учир дутагдалтай байна;
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо үнэмшилгүй байгаа. Газар, орон байр, үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийн гэрчилгээг байнга оршин суугч хүнд олгож байгаагаас маш их асуудал үүсэж байна. Өрхийн гишүүн бүр өөр хаягтай болчих гээд байна. Гэрээ хийх, зээл авах бүрд эзэмшигчдийг байлцуулахыг шаарддаг учраас ганц хүний эзэмшил их болсон. Цаг үеийн анхаарал татаж байгаа мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бодлого боловсруулагчдад нууцлалын зэрэгтэйгээр өгдөг баймаар байна;
- Бодлого, төлөвлөлтөд ашиглах шаардлагатай арга зүй, тооцооны аргачлалыг видео хичээл болгоод сайтад тавивал цаг хэмнэхээс гадна хэрэглэх хүн нь хэзээ ч ашиглах боломжтой болно. Хэнтий аймгийн хувьд сумдын дотоод сүлжээний www.ofshare.khentii.com сайтад байрлуулах боломжтой.

Хэнтий аймагт 2 телевиз, нэг сонин, хоёр радио ажилладаг. Ярилцлагад оролцсон хэвлэл, мэдээллийн ажилтнууд дараах санал гаргав:

1. “Хэнтийн мэдээ” сонин эрэлт хэрэгцээг нь бодолцож үзээд сар бүр статистикийн асуудлаар булан гаргадаг. Бид бас зах зээлийн зарчмаар ажилладаг учир үнэгүй мэдээлэл тавихад их хүндрэлтэй байдаг. Иймд хэвлэлийн болон сурталчилгааны зардлыг төсөвт нь тусгаж өгмөөр байна.
2. Олон тооны мэдээлэл гарч байна. Ашиглалтад нь эргэлзэж байна.Хэтэрхий олон тоо мэдээлэхээс зайлсхийж, гол гол тоонд анхаарч байх.
3. Суманд мэдээлэл хүргэх ажил тогтмолжоогүй байгаад анхаарах.
4. ҮСХ-ны 1212 гэдэг цахим хуудас байдгийг та бүхнээс мэдлээ. Маш чухал зүйл мэдэхгүй байжээ. Цаашид та нартай холбоотой ажиллаж, байнга ашиглах болно.
5. ҮСХ-ны цахим хуудас ашиглах талаар манай телевизээр сурталчилвал сайн байна.
6. Нийгэм, эдийн засгийн ойлголтуудыг үнэнийг хэлэхэд сайн ойлгохгүй юм. Ийм энэ чиглэлээр сургалт,зөвлөгөө хэрэгтэй байна.
7. Зарим үзүүлэлтийг хэрхэн тооцох талаар хялбарчилсан ойлголт өгвөл сайн байна.

Өвөрхангай аймагт хийсэн ярилцлагын дүнгээс

Өвөрхангай аймгийн Засаг дарга Б. Толгтохсүрэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үед албан бус секторын мэдээлэл, үйлдвэр, хувийн АА-н мэдээлэл хэрэгтэй байгааг цохон тэмдэглэсэн.

Статистикийн хэлтсийнхэн Хөдөлмөрийн нөөцийн баланс (ХН1) гэдгийг өмнө нь гаргаж нийгмийн олон үзүүлэлтүүдийг, тухайлбал, ажилгүй хүн,эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөрийн насны хүн ам зэргийг сум, багаар гаргаж байсан. Ажиллах хүчний судалгаа явуулдаг болсноор хөдөлмөрийн нөөцийн балансыг ашиглах бололцоогүй болсон. Хүчингүй болгосон ч хэрэгцээтэй байсан тул нэг хэсэг гаргаж ашиглаж байгаад больсон. Яам хүчингүй болсон үзүүлэлт гаргахгүй гээд нэг талаас,мэдээ өгөхгүй болсон нөгөө талаас, бид ч хөдөлмөрийн хэлтэстэй хамтарч гаргадаг байснаа зогсоосон. Бүх үзүүлэлт ажиллах хүчний судалгаагаар гардаг ч орон нутгийн бодит байдлаас зөрүүтэй үр дүн гарах явдал ажиглагддаг.Ажиллах хүчний судалгаа орон нутагт нэг их хэрэг болдоггүй. Үзүүлэлтүүд нь сумаар задрахгүй байна.

Төрийн бус байгууллага,бизнес эрхлэгчид болон иргэдтэй хийсэн ярилцлагаар орон нутгийн чанартай жижиг бизнесийн төсөл хийх гэхээр тухайн чиглэлээр хэдэн хүн юу хийдэг, хаана ямар боломж байгааг олж үзэх мэдээлэл олддоггүй талаар ярьсан. Тэд мөн хүн, малын тоог үнэн гэдэгт эргэлздэг, учир нь мал тооллогыг урьдных шиг хийхээ

байсан, зээлийн шаардлага хангах гээд малынхаа тоог нэмдэг айлууд байгааг хүмүүс мэддэг гэж ярьсан.

Сумдаас ирүүлсэн санал дотор сумын түвшний дэлгэрэнгүй мэдээлэл гарахгүй байна.

Үүнд:

- ЕБС анги ангиараа,
- Оюутнууд сургууль мэргэжлээр,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэлбэрээр,
- Хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны чиглэл, ажилладаг байгууллагаар
- Ажиллагчид, ажилгүйчүүд, хөдөлмөрийн насны хүн ам гээд орон нутгийн төлөвлөлтөд хэрэгтэй, аймаг, сумдтай зэрэгцүүлмээр үзүүлэлтүүд гардаг баймаар байна.
- Ажиллах хүчний судалгаа нь түүвэр учраас сум, багт ямар ч үр дүн гардаггүй.

Өвөрхангай аймгийн хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудтай хийсэн ярилцлагаар дараах саналууд гарсан. Үүнд:

1. Нийгэм,эдийн засгийн ойлголтуудын агуулгыг үнэндээ сайн мэдэхгүй байна. Иймд тодорхой сэдвээр,энгийн үгээр,ойлгомжтой тайлбарласан сургалт, зөвлөгөө их чухал байна.
2. Уг мэдээлэл хувь хүний ахуй, амьдралд ямар хэрэгтэйг ойлгуулж тайлбарлах явдал нэн чухал. Ийм нөхцөлд л хэрэглэгчид сонирхож, уг мэдээллийг ашиглана.
3. Эдийн засгийн асуудлаар төрөлжсөн сэтгүүлч их чухал байна. Аймагт тийм мэргэжилтэн алга. Иймд эдийн засгийн ойлголтуудаар сэтгүүлчдэд зориулагдсан сургалт чухал байна.
4. Орон нутгийн статистикийн алба бид нарт зориулагдсан сургалт хийж баймаар байна.
5. Орон нутагт үзүүлэлтүүдийн өсөлт, бууралт, малын тоо толгойн өөрчлөлт, үнийн мэдээлэл, цалин хөлсний холбогдолтой мэдээллийг илүү их сонирхдог.
6. Дундаж цалин их өндөр, буруу гарч байна. Цалингийн зөрүү өндөр учир дундаж үзүүлэлт өсч гардаг гэж тайлбарласан ч энэ дундаж их утгагүй зүйл гэж хариулж байв.

6. ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Төслийн үндсэн нэг зорилго нь “Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх” асуудалд чиглэж байгаа бөгөөд түүний өнөөгийн байдалд үнэлгээ хийж, хэрхэн хөгжүүлэх боломж, сайжруулах арга замыг хайж, холбогдох санал зөвлөмж боловсруулах явдал юм. Энэ зорилгоор орон нутгийн мэдээллийн сангуудын бүтэц, зориулалт, ашиглалттай танилцаж салбар хоорондын мэдээллийн урсгал, мэдээлэл цуглуулж буй арга, давхцал, харилцан мэдээлэл солилцох боломжийг илрүүлэх оролдлого хийсэн. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг бүрдүүлж буй эрүүл мэнд, боловсрол, нийгмийн даатгал, халамж, бизнес регистр, мал тооллого зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудын бүтэц, зориулалттай танилцаж, эдгээр мэдээллийн системүүдийн хооронд шууд мэдээлэл солилцох боломж, технологийн дэд бүтэц хангагдсан эсэх нь анхаарах асуудлын нэг байсан бөгөөд тухайн салбарууд мэдээллээ бусад салбартай солилцох хэрэгцээ шаардлага байгаа эсэх нь нэн ач холбогдолтой байлаа.

Эдгээр салбаруудын мэдээллийн сангийн анхдагч мэдээллийг орон нутагт цуглуулж, газар дээр нь мэдээллийн баяжилтыг хийж байна. Иймээс орон нутгийн бодлого, төлөвлөлтөд эдгээр сангуудын мэдээллийг ашиглах боломжийг өргөжүүлэх зорилгоор орон нутгийн мэдээллийн сан гэж нэрлээд байгаа билээ.

Энэ зорилгоор ҮСХ-ны МБТГ-ын дарга Л.Мягмарсүрэн, ахлах шинжээч Ц.Эрдэнэмөнх, шинжээч Б.Тамир, М.Жаргал, БТМГ-ын Бизнес регистр хариуцсан шинжээч Ц.Амаржаргал, ХАНСГ-ын Боловсрол, шинжлэх ухааны салбар хариуцсан шинжээч Э.Ариунчимэг, Эрүүл мэнд нийгмийн үзүүлэлт хариуцсан шинжээч Н.Алтантүлхүүр, Нийгмийн даатгал, халамжийн үзүүлэлт хариуцсан шинжээч Амарбаясгалан, Хүн ам хариуцсан статистикч Т.Уянга, Тооллогын товчооны дарга Ж.Мөнхбадар, БШУЯ-ны Боловсролын салбарын мэдээллийн системийн төслийн удирдагч Г.Лхагвасүрэн, НДЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Батжаргал, ЭМСЯ-ны ЭМХТ-ийн Судалгаа, төлөвлөлт, статистикийн мэдээллийн албаны дарга Зулцэцэг, ажилтан Х.Нарантуяа, С.Даваажаргал, Мэдээллийн технологийн программист Ж.Эрдэнэ-Очир нартай уулзаж ярилцан холбогдох мэдээллийн сангуудтай танилцлаа. Мөн Хэнтий, Өвөрхангай аймгуудын холбогдох ажилтнуудтай уулзаж ярилцлаа.

6.1. Орон нутгийн мэдээллийн сан, тэдгээрийн төрлүүд

Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх суурь систем болох ҮСХ-ны ХАӨМС, Бизнес регистрийн сан болон мал тооллогын мэдээллийн сангууд онлайн горимд ажиллаж байгаа бөгөөд ААНБ-ын болон иргэний регистрийн дугаараар УБЕГ-ын холбогдох бүртгэлийн сангуудтай уялдуулан шалгасан мэдээлэлтэй байна. Мал тооллогын мэдээллийн сангийн мэдээллийг малчдын зээлийн барьцаа хөрөнгийг тодорхойлоход арилжааны банкууд ашиглах боломжтойгоор Монгол банктай үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр арга хэмжээ нь үнэн бодитой, харилцан итгэл хүлээсэн мэдээллийг салбар хооронд харилцан солилцох боломжийг хэрэгжүүлсэн бодит туршлага болсон байна.

Гол салбаруудын мэдээллийн системтэй танилцсан байдлыг авч үзье. Үүнд:

Нэг. Боловсролын мэдээллийн сан

Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)-ийн үндсэн зорилго нь боловсролын салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн бөгөөд салбарын бүхий л үйл ажиллагааны удирдлагын цогц систем болж байгаа юм байна.

Энэхүү мэдээллийн систем нь өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургуулийн талаарх өргөн хүрээтэй мэдээллийг хамарсан байна. Харин мэргэжил, үйлдвэрлэлийн сургалтын төвүүд нь Хөдөлмөрийн яаманд харьяалагддаг тул хамрагдаагүй үлджээ. Одоо сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын (ясли, цэцэрлэгүүд) мэдээллийг дараагийн ээлжид системд оруулахаар бэлтгэж байгаа ажээ. Мэдээлэл нь хамрах хугацааны хувьд зөвхөн 2014 оны байдлаар байна.

Мэдээллийн эх үүсвэр нь тусгайлан бэлтгэсэн 10 гаруй багц асуулгаар, тухайлбал, байгууллагын, багшийн, удирдлага, нийгмийн ажилтны, ажилтны асуулга, дотуур байрны орчны, суралцагчийн гэх мэт асуулгаар боловсролын холбогдох байгууллагуудаас мэдээллийг нөхүүлж, мэдээллийн санг үүсгэсэн байна.

Аймаг орон нутгийн түвшинд БСМС-ийг 2015-2016 оны хичээлийн шинэ жилийн эхэнд 10 хоног нээж, мэдээллийн бүрдэлт хийгээд хаасан байна. Одоогоор ЕБС-иуд энэ системийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлгүй байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийг статистикийн мэдээллийн нэгдсэн системтэй уялдуулах бүрэн боломж байгаа нь нэн ач холбогдолтой байна. Үүнд:

1. Сурагч, оюутан, багш ажиллагчдыг регистрийн дугаараар нь бүртгэн, УБЕГ-ын холбогдох мэдээллийн санд тулгалт хийж, ургийн овог, овог, нэр, хаягийг бүртгэлийн сангаас татаж авч байгаа нь ХАӨМС-тай уяж болох бүрэн боломжтой байна.
2. Мөн сургууль байгууллагуудыг регистрийн дугаараар бүртгэж, УБЕГ-ын хуулийн этгээдийн мэдээллийн санд тулгалт хийж, байршлын мэдээллийг авдаг юм байна. Иймээс шаардлагатай гэж үзвэл ҮСХ-ны БР-ийн сантай мэдээлэл солилцох боломжтой.
3. Боловсролын салбарын мэдээллийн системд сурагч бүрийн мэдээллийн бүртгэлийг эцэг, эх, өрхийн нэгдсэн бүртгэлтэй холбох бодит хэрэгцээ бий болсныг төслийн удирдагч танилцууллаа. Энэ бол ҮСХ-ны ХАӨМС-тай уяж гол гарц гэдгийг Төслийн баг санал болголоо. Яриа хэлцэл хийх боломжтой гэдгээ илэрхийлсэн болно.
4. Ялангуяа ҮСХ-ны ХАӨМС-д ашиглаж байгаа өрхийн бүртгэлийн дугаараар хоёр системийг холбон мэдээлэл солилцох боломжтой байна.

Хоёр. Нийгмийн даатгалын сан

НДЕГ-т тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, ЭМД, хөдөлмөр эрхлэлт, шимтгэлийн гэсэн 6 төрлийн мэдээллийн сан байдаг байна.

Даатгуулагчийн иргэний мэдээлэл нь регистрийн дугаарт суурилсан бүртгэл тул УБЕГ-ын мэдээллийн санд хайгаад холбогдох мэдээллээ авдаг. Бүртгэлийн санд олдоогүй иргэнд даатгалын үйлчилгээ үзүүлдэггүй юм байна.

Ажил олгогчийн регистрийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн санд тулгалт хийгээд Шимтгэлийн мэдээллийн сангийн бүрдэлтээ хийдэг. ҮСХ-ны зөвлөмж болгосон ангилал, нэршил ашигладаг, хамтын ажиллагаа сайтай салбарын нэг ажээ.

НДЕГ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил олгогч байгууллагууд, хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг мэдээллийн системүүд хооронд солилцох хэрэгцээ албан ёсны статистикт байгаа юм.

НДЕГ-ын мэдээллийн системийг ҮСХ-ны ХАӨМС-тай уялдуулах боломж:

1. НДЕГ-ын мэдээллийн системийг ХАӨМС-тай холбох бодит хэрэгцээ, технологийн боломж байна.
2. Даатгалын салбарын шинэчлэлттэй холбоотойгоор нэг өрхийн даатгуулагчдын тухай мэдээлэл НДЕГ-т нэн хэрэгтэй байгааг илэрхийлж байна.
3. УБЕГ-ын бүртгэлийн сангуудаас түлхүүр үзүүлэлтээ авч байгаа нь уг сангууд хооронд мэдээлэл солилцох боломжтой байна.

Гурав. Эрүүл мэндийн сан

Эрүүл мэндийн Н-Info системийн давуу талууд:

Эрүүл мэндийн Н-Info систем нь чамгүй удаан ашиглаж байгаа эрүүл мэндийн салбарын онлайн систем юм. Интернетгүй сумд офлайн программаар мэдээллээ шивээд захиргаа, холбоо зэрэг интернеттэй газраас аймагт дамжуулдаг, офлайн бэлтгэгдсэн мэдээллийг системд оруулахдаа зөвхөн өөрчлөлт орсон мэдээллийг шалгаж татаж авдаг байна.

Төрөлтийн мэдээллийг нэлээд дэлгэрэнгүй агуулдаг. Эрт нярайн эндэгдэл бүрэн бүртгэгддэг. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тухай мэдээлэлтэй. Халдварт болон халдварт бус өвчлөлийн мэдээлэл бүхий сан юм.

Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлангаа системээсээ цахимаар гаргаж өгдөг. Төрөлт, өвчлөл байнга оршин суудаг харьяаллаар биш яг төрсөн, өвдсөн тохиолдол гарсан газраараа бүртгэгддэг ажээ.

Үүний зэрэгцээ гадаадын иргэдийн төрөлтийг бүртгэлд оруулах дугаар байдаггүй хүндрэл байгаа гэж ЭМХТ-ийн ажилтнууд танилцууллаа.

Энэ мэдээллийн системийг ҮСХ-ны ХАӨМС-тай эхийн регистрийн дугаараар уялдуулж, УБЕГ-н бүртгэлийн сангаас шинэ төрсөн хүүхдэд регистрийн дугаар олгоод буцааж Н-Info системд шилжүүлж байх шийдэл хийхээр ЭМ-ийн болон ҮСХ-ны мэргэжилтнүүд хамтран ажиллаж байгаа юм.

Н-Info системийн дутагдалтай талууд:

1. Регистрийн бүртгэлд суурилсан мэдээллийн систем хараахан биш учир хүүхэд төрүүлсэн эхчүүдийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн сантай тулгаж шалгадаггүй. Энэ нь регистрийн дугаарыг алдаатай шивсэн байж болох эрсдэлийг дагуулж байна.

2. Мөн төрөх гэж буй эхийг хэзээ ч, хаана ч хүлээж авах ёстой. Бичиг баримтгүй эхчүүд төрөх эмнэлэгт цөөнгүй ирдэг тул регистрийн дугааргүй эхчүүд мэдээллийн санд байгаа юм байна.
3. Мэдээллийн технологийн дэд бүтцийн тухайд Үндэсний дата төвтэй холбогдоогүй, мэдээллийн санг удирдах системийн өөрчлөлт хийх гэж байгаа.
4. Дээрх төлөв байдлууд нь эрүүл мэндийн мэдээллийн сангийн үзүүлэлтүүдийг эхлээд зөв болгох ажил хийгдэх ёстой гэдгийг анхааруулж байна.

Эрүүл мэндийн салбарын H-Info мэдээллийн системийг ҮСХ-ны ХАӨМС-тай уялдуулах боломж, хэрэгцээ

Эрүүл мэндийн салбарын мэдээллийн системийг статистикийн мэдээллийн нэгдсэн системтэй уялдуулах хоёр тал санаачилга гаргасан, ийм боломж, бодит хэрэгцээ байна.

Үүнд:

1. Албан ёсны статистикийн мэдээ тайланг хоёр системийн хооронд автоматаар солилцож байх нь Эрүүл мэндийн болон Статистикийн салбарын аль алиных нь ашиг сонирхолд нийцэж байна.
2. Тоо, мэдээний зөрүү их гардаг төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг эрүүл мэндийн мэдээллийн системээс шууд татаж авдаг болох нь чухал ач холбогдолтой.
3. Хүүхэд төрүүлсэн эхийн улсын бүртгэлийн систем дэх мэдээлэлд үндэслэн шинээр төрсөн хүүхдэд регистрийн дугаар олгоод Эрүүл мэндийн болон ХАӨМС-д уг мэдээллийг солилцож байх нь олон байгууллага, хувь хүмүүсийн ажлыг хөнгөвчлөх найдвартай арга мөн.
4. Эрүүл мэндийн даатгалыг гэр бүлийн гишүүдийн дунд ашиглаж болох эрх зүйн өөрчлөлттэй уялдуулан эрүүл мэндийн даатгал төлөгч нэг өрхийн гишүүдийн мэдээлэл гарцаагүй бодит хэрэгцээ болсон байна.

Дөрөв. Нийгмийн халамжийн сан

Нийгмийн халамжийн салбар “Өрхийн амьжиргааны нэгдсэн сан”-тай. Өрхийн мэдээллийн салбар дундын сан болгохоор УБЕГ, НДЕГ-ын сангуудтай уялдуулах хүсэлт тавиад байгаа гэж Хэнтий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Захиргаа хяналтын албаны дарга Ч.Гажидмаа танилцууллаа. Амьжиргааг дэмжих зөвлөл ажилладаг, амьжиргааны 1-2-р түвшинтэй гэж тогтоогдсон айлуудад хүнсний талон

олгодог. Засгийн газар хүнсний талон болон ипотекийн зээл олгоход өрхийн амьжиргааны дундаж түвшинг харгалзан үзэх чиглэл барьж байгаа тул “Өрхийн амьжиргааны нэгдсэн сан”-д дахин үнэлгээ хийх, амьжиргааг 1-20 түвшингээр задлах зэрэг зорилгоор АХБ, НҮБ-аас санхүүжилт хайж байгаа юм байна. Энэ сангийн түлхүүр үзүүлэлт нь өрхийн тэргүүлэгчийн регистрийн дугаар, гэрийн хаяг байна.

Өвөрхангай аймагт томилолтоор ажиллаж байх хугацаанд Өрхийн амьжиргааны сангийн мэдээллийг баталгаажуулах ажил өрнөж, Багийн Засаг дарга нарт сургалт хийж байлаа. Энэ санг 2013 оны үеийн мэдээллээр баталгаажуулах чиглэл өгөгдсөн байв.

6.2. Орон нутгийн мэдээллийн сангийн өнөөгийн байдал, түүнийг хөгжүүлэх арга зам

Эдгээр мэдээллийн сангуудын орон нутаг дахь хэрэглээний түвшинг Хэнтий, Өвөрхангай аймгуудад үзэж танилцлаа. Үүнд:

1. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг бүртгэлд суурилан явуулж байгаатай холбоотойгоор ҮСХ-ны ХАӨМС-ийн бүрдэлт хийх ажил эрчимтэй явагдаж байна. ХАӨМС-ийн мэдээллийг УБЕГ-ын бүртгэлийн мэдээллийн сан, НДЕГ-ын даатгалын мэдээллийн сантай иргэний регистрийн дугаараар тулган шалгаж, давхардлыг арилгаж, нэг системээс нөгөөд нөхөлт хийж байгаа тул дээрх 3 системд байгаа иргэдийн талаар адил мэдээлэлтэй болох бүрэн боломжтой болжээ.
2. ҮСХ-ны МАЛ ТООЛЛОГО-ын мэдээллийн санд сүүлийн 3 жил онлайн горимд мэдээллийг оруулж, хэрэглээ тогтворжиж байна. Арилжааны банкууд малчдын зээлийн барьцааны мэдээллийг уг мэдээллийн сангаас авч хэвшиж байгаа бөгөөд энэ нь малчид, Багийн Засаг дарга нар, банкны ажилтнуудад тохиолддог бичиг цаасны чирэгдлийг арилгах нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй цахим мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх сайн туршлага болж байна.
3. Аймаг орон нутгийн түвшинд БСМС-ийг 2015-2016 оны хичээлийн шинэ жилийн эхэнд 10 хоног нээж, мэдээллийн бүрдэлт хийгээд хаасан байна. 2015 оны 11 сарын эхний байдлаар БСМС-ийн төсөл улсын хэмжээний бүх түвшний сургуулиудад компьютер техник хэрэгсэл суурилуулж, мэдээллийн систем бүрэн утгаараа онлайн горимд ажиллаж эхлэх нөхцөлийг бүрдүүлээд байна.

4. Эрүүл мэндийн H-Info-3 мэдээллийн санд суманд гарсан төрөлт, нас баралтын тохиолдол бүрийг шивж байна.
5. Нийгмийн даатгал сумаас онлайн шивэлт хийхгүй байгаа юм байна. Одоогоор цаасаар мэдээгээ хүргүүлээд аймагт шивэлтийг хийж байна.
6. Нийгмийн халамжийн мэдээллийг аймагт офлайн програмаар шивдэг юм байна. Ерөнхий газар нь онлайн хувилбарын туршилт хийж байгаа ажээ. Удахгүй 2016 оноос онлайн горимд шилжинэ гэсэн төлөвлөгөөтэй байна.
7. Дээрх салбаруудын мэдээллийн сангаас өөр орон нутгийн чанартай нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.
8. Статистикийн хэлтсийн ажилтнууд сарын танилцуулга, эмхтгэлийн мэдээллээ excel-ийн файл хэлбэрээр хадгалж байна. Дотоод сүлжээний public хавтсанд сарын танилцуулгын загвараа байрлуулаад мэргэжилтэн бүр хариуцсан мэдээллээ оруулж байна.
9. Аймгийн захиргаа, сумдын ЗДТГ-ын ажилтнуудын хариуцсан мэдээллүүд нь excel-ийн файл хэлбэрээр ажилтан бүрийн компьютерт хадгалагдаж байна. Хэнтий аймгийн сумд www.ofshare.khentii.com дотоод сүлжээгээр мэдээлэл солилцдог юм байна.

Дүгнэлт Албан ёсны статистикийн мэдээллийг бүрдүүлдэг гол салбаруудын мэдээллийн систем бүр УБЕГ-ын бүртгэлийн мэдээллийн системтэй тулгаж баталгаажуулсан “**хувь хүний регистрийн дугаар**”-ыг агуулж байгаа нь түүнийг салбар хооронд мэдээлэл солилцох “**түлхүүр үзүүлэлт**” болгон ашиглах боломжийг олгож байна.

Түүнчлэн ХАӨМС-ийн **өрхийн хувийн дугаарыг** салбар дундын хэрэглээ болгох бодит хэрэгцээ бий болсныг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн салбаруудын өрхөд суурилсан мэдээллийн хэрэгцээ харуулж байна.

6.3.Бусад салбарын мэдээллийн санг ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сантай холбох боломж, арга зам

Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх гэдэг нь статистикийн мэдээллийг албан ёсны нэг эх үүсвэрээс хаанаас ч, хэн ч, хэзээ ч олж авах, ижил мэдээллээр эрх тэгш хангагдах боломжийг өргөжүүлэх явдал гэж ойлгож байна.

Чанарын судалгааны дүнгээс үзвэл, хөдөө орон нутгийн иргэд 1212 сайтаас мэдээлэл хайж олох аргыг илүү хялбарчлах саналыг гаргаж байна. Мэдээллийн технологийн дэд бүтцийн хөгжил, ард иргэдийн шинэ технологи ашиглах боловсрол, техник хэрэгслийн боломжоос хамаарч интернетийн хурд муу, сүлжээ байнга тасардаг нөхцөлд мэдээллийн хайлтын систем олон шат дамжлагатай байгаа нь тодорхой хүндрэлийг бий болгож байгаа юм байна. Өөрийн сум, багийн түвшний мэдээллийг шууд харж чадахгүй учраас мэдээллийн нэгдсэн системийг ашиглахад төвөгтэй гэж үзэхийн зэрэгцээ илүү хялбар тухайлбал, хэвлэмэл бэлэн мэдээлэл хайхыг илүүд үзэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд найдах хандлага гардаг ажээ.

Иймээс www.1212.mn цахим хуудасны статистикийн мэдээллийн MONSIS нэгдсэн санг дээрх шаардлагыг хангах хэмжээнд сайжруулахад анхаарах хэрэгтэй гэж Зөвлөх баг үзэж, дараах зорилтуудыг нэн тэргүүнд хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

Нэгдүгээрт: ҮСХ-ны Даргын 2014 оны 1/101 тоот тушаалын 2А, 2Б хавсралтаар заасан сум, багийн түвшинд тооцож, мэдээлэх ёстой үзүүлэлтүүдээр статистикийн мэдээллийн MONSIS нэгдсэн санг баяжуулж, графикт хугацаанд нь шинэчилж байх ажлыг хэрэгжүүлэх,

Хоёрдугаарт: Статистикийн мэдээллийн нэгдсэн санд тухайн аймаг, сумаар хайлт хийх боломжийг нэмэх, аймгуудын статистикийн хэлтсийн мэдээллийн дэд сан бүрдүүлэх боломж, арга замыг санал болгох,

Гуравдугаарт: ХАӨМС болон бусад салбарын мэдээллийн сангууд хооронд мэдээлэл солилцох, статистикийн мэдээллийн нэгдсэн www.1212.mn цахим хуудасанд сервис хийх боломжийг БСМС-тэй мэдээлэл солилцох загвар дээр авч үзэх шаардлагатай.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх арга зам, авсан арга хэмжээ

Зөвлөх баг төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг 2015 оны 10 сарын 30-ны өдөр захиалагчид танилцуулахдаа эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх саналаа илэрхийлсэн билээ.

ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, орон нутагт статистик мэдээллийн хэрэглээ, түүнийг ашиглах чадавх ямар байгааг үнэлж, тодорхой санал, зөвлөмж боловсруулахыг Зөвлөх багаас хүсэж байгаа гэдгээ дахин нотлоод, нэгдүгээр зорилт болон хоёрдугаар зорилтын эхний ажлыг хамтарч хэрэгжүүлэх бүрэн боломжтой байгааг илэрхийлэв.

Ажлыг шуурхай эрчимжүүлэх үүднээс 2015 оны 11 сарын 2-ны өдөр ҮСХ дээр ажлын уулзалт зохион байгуулж уг уулзалтад ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, Даргын зөвлөлийн гишүүд, ҮСХ-ны удирдах ажилтнууд, салбар хариуцсан 40 орчим мэргэжилтэн, Зөвлөх баг оролцож өргөн хүрээтэй хэлэлцүүлэг хийлээ.

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

Зөвлөх баг төслийн үйл ажиллагааны явцын дүгнэлтээс харахад статистикийн мэдээллийг нийтэд хүргэж байгаа www.1212.mn цахим хуудсыг сонгогдсон 2 аймгийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 39.4% л мэдэж байгаагаас гадна ашиглалтын түвшин нэн бага байгааг танилцуулав.

Түүнчлэн ҮСХ-ны Даргын 2014 оны 1/101 тоот тушаалын 2А, 2Б хавсралтаар заасан сум, багийн түвшинд тооцож, мэдээлэх ёстой үзүүлэлтүүдийг www.1212.mn цахим хуудсанд байрлуулах мэдээллийн баяжилт нэн хангалтгүй байгаа тул статистикийн мэдээллийн MONSIS нэгдсэн санг тушаалд заасан мэдээллээр баяжуулж, графикт хугацаанд нь шинэчилж байх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг мэдээлэв. Зөвлөх багийн дүгнэлтэд үндэслэн www.1212.mn цахим хуудсанд сум, багийн түвшний мэдээллээр баяжилт хийх ажил үүргийн хуваарийн жагсаалт гарган хариуцах эздийг томилсон бөгөөд уг жагсаалтыг тайланд хавсаргав /Хавсралт-9/.

Уг уулзалтын үр дүнд:


1. Тушаалд заасан үзүүлэлтүүдийг 1212 санд ачаалах ажлыг МССТ(А.Дэмбэрэл) хариуцах,
2. Арга зүй боловсруулах үзүүлэлтүүдийг НБХАГ(Б.Бадамцэцэг) хариуцах,
3. БШУЯ, ЭМСЯ, БОНХЯ, НДЕГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг ҮСХ-ны түвшинд багцаар байгууллага хооронд харилцах замаар шийдвэрлэх,
4. Тооллогын дүнгээс тооцох үзүүлэлтүүдийг МБТГ-тай хамтран шууд сум, багийн түвшнээр мэдээллийг www.1212.mn цахим хуудсанд оруулах ажлыг ҮСХ-ны дарга холбогдох хүмүүст тус тус үүрэг болгов.

Ингээд Статистикийн мэдээллийн нэгдсэн санг ачаалах ажлыг эрчимжүүлэх 2 сарын аян зохион байгуулж, www.1212.mn цахим хуудасны баяжилтын явцын үр дүнг 2 долоо хоног тутам Удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулж байхыг МССТ (А.Дэмбэрэл) хариуцах шийдвэр гаргалаа.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

1. Статистикийн мэдээллийн MONSIS нэгдсэн сангийн хайлтын системд нэмэлт хийх хэрэгтэй гэж үзлээ.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хайлтын хэсэгт “АЙМГААР” гэсэн бүлэг нэмж, MONSIS санд байгаа мэдээллийг аймаг аймгаар нь ялгаж харуулдаг шийдэл хийвэл хэрэглэгчдэд зөвхөн өөрийн эсвэл сонирхсон аймгийнхаа мэдээллийг аймгийн дүнгээр болон сум, багийнхаа түвшинд харах боломжийг бүрдүүлнэ.



Энэ нь хэрэглэгчийн тухайд мэдээллийн хайлтыг ихээхэн хялбарчилна. Тухайн аймгийг сонгоход эхний хуудсанд сонгосон аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн товчоо гарч ирдэг байж болох юм. Хайлтын системд шинэ ангилал нэмэх асуудлыг судалж үзэхийг зөвлөж байна.

2. Орон нутгийн статистикийн хэлтсийн дотоод үйл ажиллагааны DevInfo мэдээллийн сангуудыг шинэчлэн зохион байгуулж, ҮСХ-ны нэгдсэн серверт

байрлуулж, аймгууд www.1212.mn цахим хуудаснаас онлайнаар ханддаг шийдэл хийж болох **санал оруулж** байна.

DevInfo мэдээллийн сангууд нь аймгуудын статистикийн хэлтсийн ажилтнуудын ажлын компьютерт байдаг мэдээллийг агуулсан, гарын дор бэлэн байдаг, танилцуулга эмхтгэлд нь ордог, сум, багийн түвшний мэдээллийн нэгдсэн сан байх юм. Энэхүү орон нутгийн мэдээллийн сан нь:

- сарын танилцуулга, жилийн эмхтгэл, аймгийн товчоон эмхтгэлийн үзүүлэлтүүдийг агуулна,
- ҮСХ-нд сум, багаар мэдээлдэг ч нэгдсэн эмхтгэлд ордоггүй задгай мэдээллийг аймгийн түвшинд нь ашиглах боломжийг нээлттэй болгоно
- Статистикийн ажилтнуудын мэдээлэл эрж, хайх ажлыг хөнгөвчилнө
- Статистикийн www.1212.mn цахим хуудсанд онлайн хандаж шинэ мэдээллийн баяжилтаа хийдэг, орон нутгийн онцлог бүхий мэдээллийг агуулах юм.
- Офлайн хувилбартай байж болно

ДэвИнфо дэд сан үүсгэх зөвлөх багийн саналыг төслийг хэрэгжүүлэх явцад ҮСХ-нд хараахан танилцуулаагүй бөгөөд www.1212.mn цахим хуудсанд байгаа нэгдсэн сангийн мэдээлэл аймаг, орон нутгийн задгай мэдээллийг бүрэн агуулаагүй нөхцөлд ашиглаж болох гарц гэж харж байгаа юм. Учир нь аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд ДэвИнфо програм хангамжийг ашиглаж чаддаг бөгөөд уг мэдээллийн санд өөрсдийн мэдээллийн баяжилтыг тогтмол хийсээр байна.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

Төслийн баримт бичигт тусгайлан сонгосон боловсролын салбарын мэдээллийн хүртээмжийг аваад үзье.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-2б-д тусгаснаар боловсролын салбарын 29 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 18 үзүүлэлтийг сумын түвшинд, 2 үзүүлэлтийг багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн нэгдсэн санд 2015 оны 10 сарын эцсийн байдлаар аймгийн түвшний 6 үзүүлэлт тавигдсан, харин сум, багийн түвшний үзүүлэлтүүд огт тавигдаагүй байсан.

Аймгийн түвшинд 2014 оноос тооцож, мэдээлэх ёстой бөгөөд www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байгаа 23 үзүүлэлтүүдийг жагсаавал:

1. 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин
2. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин
3. ЕБСургуульд 1-р ангид шинээр элсэгчдийн тоо, хичээлийн жилийн эхний байдлаар
4. 1-р ангид элсэн ороод 5-р анги хүртэл дэвшин суралцагчдын хувь
5. Дотуур байранд амьдардаг суралцагчдын тоо
6. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо
7. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, хичээлийн жилийн эцсийн байдлаар
8. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, хичээлийн жилийн эхний байдлаар
9. Сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоо
10. Сурагч-багшийн тооны харьцаа
11. Суралцагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр
12. Төгсөгчийн тоо, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр
13. Хамран сургалтын цэвэр, бохир жин
14. Анги улиран суралцагчдын тоо
15. Анги дэвшилтийн хувь
16. Анги улиралтын хувь
17. Сургууль завсардалтын хувь
18. Мэргэжлийн багшийн эзлэх хувь
19. Бага, дунд, дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа
20. Суралцагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр
21. Төгсөгчдийн тоо, мэргэжлийн чиглэлээр
22. ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь
23. Улсын нэгдсэн төсвийн зардалд боловсролын салбарын зардлын эзлэх хувь гэсэн 23 үзүүлэлт орж байна.

Энэхүү жагсаалтын 1,2-р-т байгаа бичиг үсэг тайлагдалтын түвшинг тооллогын онуудаар сум, багийн түвшинд тооцон тархаах бүрэн боломжтой.

Жагсаалтын 22,23-г байгаа үзүүлэлтүүдийг ҮСХ тооцдог, нэгдсэн санд тавих боломжтой.

Бусад 19 үзүүлэлтийг БШУЯ-ны мэдээгээр аймаг, нийслэлийн түвшингээр www.1212.mn цахим хуудсанд байрлуулах ажлыг боловсролын салбар хариуцсан шинжээч гүйцэтгэх үүрэгтэй.

Боловсролын салбарын 29 үзүүлэлтийг цаашид БСМС-ээс шууд www.1212.mn цахим хуудсанд сервис хийлгэх боломжтой байгааг боловсролын салбарын мэдээллийн системийн асуулгаас харж болохоор байна. БСМС-ийн ЕБС-ийн холбогдолтой систем бэлэн болсон гэдгийг систем хөгжүүлэгчид танилцуулж байсан билээ. Иймээс уг системийн “сурагчийн” болон “багшийн” асуулгаас дээрх жагсаалтад байгаа холбогдох мэдээллийг аймаг, сум, багийн түвшингээр татаж авах сервис хийх талаар БШУЯ-ны болон ҮСХ-ны мэргэжилтнүүдтэй зөвлөж, туршилтын загвар гаргалаа.

Харин танилцуулж буй 3-р зорилтын хүрээнд 2 ажлыг л Зөвлөх баг гүйцэтгэ гэсэн чиглэл захиалагч ҮСХ өгсөн. Үүнд:

1. БШУ-ны салбарын хэмжээнд мөрдөж буй боловсролын салбарын үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолтыг ҮСХ-ны баталсан ойлголт, тодорхойлолттой тулгаж тэдгээр үзүүлэлтүүдийг www.1212.mn цахим хуудасны мэдээллийн сантай холбоход аргачлал, арга зүйн хувьд боломжтой эсэхийг тогтоох.

БСМС-ийн үзүүлэлтүүдийг хэрхэн цуглуулж, шинэчлэлт баяжилтыг хийж байгаа эрх зүйн акт, урсгал, мэдээллийн чанарт дүгнэлт өгөх гол 2 ажлыг хэрэгжүүлэхийг Зөвлөх багаас хүссэн болно. Учир нь БСМС-ийн үзүүлэлтүүд “Албан ёсны статистик”-ийн мэдээллийн стандартыг хангаж байна гэж Зөвлөх баг үзвэл ҮСХ, БШУЯ-тай хамтран хэлэлцээд хоёр байгууллагын мэдээллийн систем хооронд мэдээлэл солилцох ажлыг албан ёсоор хэрэгжүүлэх нь цаг хугацааны бөгөөд технологийн шийдэл байх болно. Үүнийг ҮСХ хэрэгжүүлнэ гэлээ.

Дээрх 2 асуудлаар БШУЯ-ны Инноваци, өндөр технологийн газрын мэргэжилтэн Ю.Алтантуяа болон БСМС-ийн төслийн удирдагч Г.Лхагвасүрэн нартай уулзаж ярилцлаа. Албан ёсны статистикийн холбогдох үзүүлэлтүүд үйл ажиллагаа явуулж буй аймаг, сум, өмчийн бүх хэлбэрийн сургуулиар БСМС-ээс гарах бүрэн боломжтой байна.

Үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт: Боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн маягт, зааврыг батлах, зөвшөөрөх тухай ҮСХ-ны даргын 2008 оны 1/548 тоот, Захиргааны статистикийн мэдээллийн маягт, зааврыг

батлах тухай БСШУ-ны сайдын 2008 оны 431 тоот тушаалуудыг холбогдох мэдээллийг цуглуулах үйл ажиллагаанд баримталж байгаа юм байна. ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 16-ны өдрийн 1/145 тоот тушаалаар баталсан “Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”, Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын аргачлалыг баримтлан үзүүлэлтийн тооцоог хийдэг. Аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтсийн ажилтнуудад “Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг ашиглах сургалтыг зохион байгуулсан байна.

Энэ мэдээллээс үзвэл ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын 2Б хавсралтаар заасан аймаг, сум, дүүргийн түвшинд тооцож, 1212 нэгдсэн сангаар тархаах ёстой боловсролын салбарын бүх үзүүлэлтийг ҮСХ баталсан албан ёсны болон зөвшөөрсөн захиргааны статистикийн мэдээллийн маягтаар цуглуулж, батлагдсан аргачлалаар тооцож байгаа нь албан ёсны статистикийн мэдээллийн стандартыг хангаж байна.

Мэдээлэл цуглуулж буй урсгал: ҮСХ-ны зөвшөөрсөн захиргааны мэдээний маягтаар сум, дүүрэг, өмчийн бүх хэлбэрийн сургуулиудаас анхдагч мэдээллийг цуглуулаад, түүнээс аймаг, нийслэлийн түвшинд нэгтгэл хийсэн мэдээллийг ҮСХ-ны баталсан улсын тайлангийн маягтаар ҮСХ-нд мэдээлж байна.

Тэгэхээр улс, бүс, аймаг, нийслэлийн түвшний мэдээллийг албан ёсны статистикийн улсын тайлангаас, сум, дүүрэг, баг, хорооны түвшний мэдээлэл БШУЯ-ны захиргааны статистикийн дотоод мэдээллээр цуглуулж тархаагдаж байна.

БСМС-ийг бүрдүүлэхдээ захиргааны мэдээллийн маягтуудаар цуглуулдаг бүх үзүүлэлтийг тус системийн мэдээлэл цуглуулах нэгдсэн асуулгад оруулаад, үр дүнгийн тайланг батлагдсан маягтуудын загвараар нэгтгэл хийн гаргаж байна. Энэ системээс нэгтгэсэн мэдээллийг л БШУЯ албан ёсны статистикийн мэдээллийн маягтаар ҮСХ-нд мэдээлж байна. БСМС-ийн зарим үр дүнг www.esis.edu.mn сайтаар орж үзэх боломжтой. Иймээс нэгэнт ҮСХ-нд тайлагнадаг мэдээллийн урсгалаар цуглуулсан мэдээлэл бөгөөд энэ мэдээллийг л маягтын хэлбэрт оруулаад ирүүлж байгаа тул БСМС-ээс улсын тайлан мэдээг татаж авах боломжтой гэж үзлээ.

Мэдээллийн чанар ба Боловсролын салбарын мэдээлэл цуглуулж буй маягтуудыг дахин хянан үзэх хэрэгцээ байгаа тухай санал:

Мэдээллийн чанарын үнэлгээ нь тусгай арга зүйгээр, цаг хугацаа зарцуулж хийх ёстой өргөн хүрээний ажил билээ.

Боловсролын салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан мэдээллийн чанарт үнэлгээ хийх бодит хэрэгцээ байна. Учир нь:

- Боловсролын салбарын мэдээллийг БСМС-д оруулахдаа системийн хэмжээндбагш, сурагчдын гэх мэт нэгдсэн асуулгууд боловсруулж түүнд хариулт авах замаар олон тооны мэдээлэл цуглуулж байна. Эдгээр асуулгаар бүрдүүлсэн мэдээллүүдийг ҮСХ-ны баталсан болон зөвшөөрсөн албан маягтаар цуглуулж байгаа эсэхийг газар дээр нь үзэх шаардлагыг бий болгож байна,
- Боловсролын салбарын хэмжээний бүх үзүүлэлтийг БСМС-ийн нэгдсэн асуулгад уясан байгаа тул мэдээлэл цуглуулах маягт, зааварт өөрчлөлт орох эсэхийг хянан үзэх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Мөн хоёр тал анхаарч, хамтран хэлэлцвэл зохих хэд хэдэн асуудал байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт зөрүүтэй байна

	ҮСХ-ны Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1): ҮСХ-ны Даргын 2013 оны 11 сарын 20-ны өдрийн 1/131 тоот тушаалаар баталсан	Боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистикийн мэдээний маягт, заавар: ҮСХ-ны Даргын 2008 оны 1/548 тоот, БСШУ-ны Сайдын 2008 оны 431 тоот тушаал
Хуулийн заалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.	Боловсролын тухай хуулийн 3.1.9-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасаниргэнийг ойлгоно. Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" иргэн гэнэ.
Тодотгосон заавар	Хөдөлмөр магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулна.	
Хөгжлийн бэрхшээлийн төрлийн тодорхойлолт	Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд: Төрөлхийн: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон	“Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь

<p>төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Олдмол: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:</p> <p>Харааны: Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Ярианы: Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Сонсголын: Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Хөдөлгөөний: Биений тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хамруулна.</p> <p>Сэтгэцийн: Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх</p>	<p>алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ. (“Боловсролын тухай” Монгол улсын хууль)</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Харах эрхтний” гэсэн үзүүлэлтэд хараагүй, сул хараатай хүүхдийг хамруулна. Хараагүй гэдэгт хоёр нүд нь хоёул юу ч хардаггүй буюу гэрлийн мэдрэмжгүй хүүхэд, эсвэл нүдний шил зүүсэн ч 40 см-с дотогш зайд хуруугаа тоолж чаддаггүй сул хараатай хүүхдийг бичнэ. 2. “Сонсох эрхтний” гэсэн үзүүлэлтэд сонсголгүй, сул сонсголтой хүүхдийг хамруулна. Сонсголгүй гэдэгт 20 см-ийн зайд ярьж байгаа энгийн яриа юм уу дууг сонсголын туслах хэрэгслэлгүйгээр сонсдоггүй, 20 см-ийн зайд ярьж байгаа энгийн яриа юм уу дууг сонсголын туслах хэрэгсэлгүйгээр сонсдог хүүхдийг бичнэ. 3. “Хэл, ярианы эрхтний” гэсэн үзүүлэлтэд хэлгүй, хэл ярианы өөрчлөлттэй хүүхдийг хамруулна. Хэлгүй гэж ярьж чадахгүй, хүний хэлснийг ойлгодоггүй, хүмүүстэй зөвхөн ганц үгээр ярьдаг, ойлгомжгүй ярьдаг, ээрүү, гаж сонин дуугаар ярьдаг болон бусад ярих эрхтний согогтой хүүхдийг бичнэ. 4. “Оюун ухааны” гэсэн үзүүлэлтэд ойлгох, суух, зогсох, алхах, ярих, хувцас өмсөх, хоол идэх зэрэг чадварын бэрхшээлтэй хүүхдийг бичнэ. 5. “Бие эрхтний” гэсэн үзүүлэлтэд биений аль нэг хэсэгт хөдөлгөөний бэрхшээл үүссэн, тухайлбал, яс, булчин, гар, хөл гэх мэт хөдөлгөөний холбогдолтой эрхтэнд гарсан согог, гажигтай хүүхдийг бичнэ.
--	---

	<p>бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.</p> <p>Хавсарсан: Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна /Тухайлбал: сэтгэцийн, хөдөлгөөний, ярианы бэрхшээлтэй байж болно гэх мэт/.</p> <p>Бусад: Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг үүнд хамруулна /Тухайлбал: дотор эрхтний эмгэгүүд хавдар гэх мэт/.</p>	<p>6. “Хавсарсан хэлбэрийн согогтой” гэсэн үзүүлэлтэд 2 ба түүнээс дээш хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог бичнэ. “Хавсарсан хэлбэрийн согогтой” хүүхэд нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоонд орохгүй болно.</p>
--	---	---

2. Сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоо

Энэ мэдээллийг “ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн ... хичээлийн жилийн тайлан”-ийн БДБ-15 маягтаар цуглуулдаг байна. БСМС-д сургуульд сурч байгаад завсардсан хүүхдийг амьдралын гачигдал, сурах дургүй, ажил эрхлэх, өвчний улмаас, бусад гэсэн шалтгаануудаар “Хасагдсан сурагчийн асуулга”-р бүртгэсэн байна.

Тэгэхээр сургуульд огт ороогүй, сургуулийн гадна байгаа хүүхдийн талаарх мэдээлэл БСМС-ээс гарах боломжгүй болж байна. Огт сурч байгаагүй хүүхэд илрүүлэлтээр Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад орж ирж болох ч бүрэн хамрагдах боломжгүй.

Иймээс “Сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоо” нь сургуульд сурч байгаад завсардсан хүүхдийн тоо болох магадлалтай байна.

3. Харин сургуульд огт хамрагдаж байгаагүй, ЕБС-ийн гадна байгаа суурь боловсрол заавал эзэмших 6-14 насны хүүхдийн тоог ХАӨМС-аас гаргаж байх нь илүү бодитой байх үндэслэлтэй. Гэхдээ ХАӨМС-д “сургуульд хамрагдаагүй” гэсэн ганцхан ангиллаар энэ мэдээллийг гаргаж болохоор байна.

4. БШУЯ-ны тооцоогоор жишээ нь, 7 настнуудын хамран сургалтын цэвэр жин 100 давчихаад байгаа гэнэ. Энэ нь БСМС-н суралцагчдын бүртгэлд гадаадын ажиллагчдын хүүхдүүд орж байгаа, харин суурин хүн амын тоонд бүрэн ордог эсэхээс хамаарч болох юм гэсэн асуудал бас байгаа ажээ.

Боловсролын салбарын мэдээллийн систем БСМС нь суралцагчдыг регистрийн дугаараар нь ХАӨМС-ийн өрхийн мэдээлэлтэй холбож, суурин хүн амын тоо, суурьшил, сургуульд хамрагдалтын байдал зэрэг үзүүлэлтүүдийг сум, багийн түвшнээр тооцоо хийхэд ашиглах боломжтой байна. Мөн нэг өрхийн суралцагчдын мэдээллийг судлах, түүнийг өрхийн бусад нөхцөл байдалтай холбон шинжилгээ хийх өргөн боломж нээлттэй байна.

Иймээс БШУЯ-ны болон ҮСХ-ны бодит хэрэгцээг хамтран хэлэлцэж, мэдээллийн системүүдийг хамтран ашиглах боломжийг авч үзэхийг зөвлөж байна.


Орон нутгийн мэдээллийн сангийн нэг төрөл болох “Боловсрол”-ын салбарын мэдээллийн системээс статистикийн графикт мэдээг онлайн горимоор статистикийн мэдээллийн нэгдсэн санд татан авах програмын вэб сервис хийх загварыг боловсрууллаа. Энэ вэб сервисийг 2016 оны 1 улиралд багтаан ашиглахаар хоёр байгууллагын холбогдох ажилтнууд харилцан ойлголцлоо. Учир нь албан ёсны статистикийн мэдээллийн эх үүсвэрийг хууль, эрх зүйн хүрээнд хамгаалах, статистикийн үндсэн зарчмыг хангах зорилгоор ҮСХ болон БШУЯ хооронд техникийн уулзалтууд хийх, удирдлагын түвшинд харилцан ойлголцлын эрх зүйн баримт бичиг байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх тодорхой хугацаа шаардсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Албан ёсны статистикийн мэдээний дараах маягтуудаар цуглуулсан боловсролын салбарын мэдээллийг вэб сервис ашиглан БСМС-ээс статистикийн мэдээллийн нэгдсэн санд татаж, мэдээлэл тархаалтын www.1212.mn цахим санг баяжуулан нийтэд тархаахаар тохирлоо. Үүнд:

- А-БДБ-1. Аймаг, нийслэлийн ЕБС-ийн бүлгийн 20... / 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-2. Аймаг, нийслэлийн ЕБС-д өдрөөр суралцагчдын 20... / 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-3. ЕБС-д өдрөөр суралцагчдын 20... / 20... оны хичээлийн жилийн тайлан /байршил/

- А-БДБ-4. ЕБС-ийн 1 дүгээр ангид шинээр элсэгчдийн 20... / 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-5. ЕБС-ийн дотуур байр, амьдарч буй суралцагчид, ажиллагчдын 20.../ 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-6. ЕБС-ийн ажиллагчдын 20.../ 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-7. ЕБС-ийн орой, эчнээгээр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын 20.../ 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-8. ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдүүдийн 20.../ 20... оны хичээлийн жилийн тайлан
- А-БДБ-9. ЕБС-ийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн 20... оны тайлан
- А-БДБ-9А. Хувийн өмчийн сургуулиудын төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийн 20... оны тайлан
- А-БДБ-10. ЕБС-ийг төгсөгчдийн 20.../ 20... оны хичээлийн жилийн тайлан

ЗУРАГ - 3. Вэб сервисийн зураглал



Салбар хооронд мэдээлэл солилцох боломжийн тухай санал, зөвлөмж

ҮСХ-ны ХАӨМС нь өрхийн гишүүн бүрийг УБЕГ-ын бүртгэлийн санд регистрийн дугаараар ньтулгаж баталгаажуулсан сан юм. ХАӨМС-ийн давуу талууд:

- Үндэсний дата төвд байрласан учир мэдээллийн аюулгүй байдал хангагдсан,
- Өрх, хүний давхардалгүй,
- УБЕГ-ын иргэний мэдээллийн сантай уялдуулан баталгаажуулсан,

- ГХГЗЗГ-ын Хаягийн сантай өрхүүдийн хаягийн мэдээллийг тулгасан,
- Шилжилт хөдөлгөөнийг хянах боломжтой,
- Нэгдсэн удирдлагаар хангагдсан,
- Мэдээллийн шинэчлэлт тогтмол, шууд хийгдэнэ-Real time,
- Мэдээллийн чанар сайн,
- Цаг хугацаа хэмнэсэн,
- Стандарт, ухаалаг тайлангийн системтэй.

ХАӨМС нь өөрөө цэгцэрсэн, зохион байгуулалттай, давхцалгүй, бодит цагийн (REAL TIME) мэдээлэл учраас “их хэмжээний өгөгдөл” буюу BIG DATA болж байна. BIG DATA болж чадсан нь чанартай мэдээлэл агуулсан, бодлого, төлөвлөлт хийх, мэдлэг мэдээлэл олгох стандартыг хангаж байгаа гэсэн үг юм.

Орон нутгийн бодлого, төлөвлөлт хийхэд Засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшний мэдээлэл нэн хэрэгтэй байгаа тухай дээрх Орон нутгийн мэдээллийн хэрэгцээ бүлгээс үзэх боломжтой. Салбаруудын мэдээллийг цуглуулж байгаа анхан шатны нэгжид яагаад мэдээллийн хүртээмж хангалтгүй байна вэ гэдэг асуулт зүй ёсоор урган гарна. Мэдээлэл хүртээмжгүй, мэдээллийг ашиглах мэдлэг дутмаг байдлаас үүдэн гарах бодлогын алдааны үр уршиг өндөр үнэтэй байх болно.

Иймээс төрийн байгууллагуудын буюу салбар хооронд мэдээлэл солилцох боломжийг онлайн мэдээллийн сангууд олгож байгааг үр дүнтэй ашиглах ёстой гэж Зөвлөх баг үзэж байна.

Иргэний тухай хамгийн баталгаатай дэлгэрэнгүй био мэдээлэл УБЕГ-ын бүртгэлийн санд байгаа билээ. УБЕГ-ын мэдээллийн сан бол хувь хүний мэдээлэл агуулдаг.

Харин ҮСХ-ны ХАӨМС бол өрхөд суурилсан мэдээлэл агуулдгаараа бүртгэлийн сангаас ялгаатай. Хувь хүний адилаар өрх бүр давтагдашгүй хувийн дугаартай байгаа нь салбаруудын хооронд мэдээлэл солилцох өргөн боломжийг олгож байна. ХАӨМС нь өрхийн ам бүлийн гишүүдийн мэдээллийг хувь хүний регистрийн дугаараар УБЕГ-ын иргэний мэдээлэл цаашлаад бусад салбарын мэдээлэлтэй холбож, уяж өгч байгаад ач холбогдол нь оршиж байгаа юм.


Статистикийн олон төрлийн мэдээллийн сангаас нэгдсэн санд төвлөрүүлсэн мэдээллийг www.1212.mn цахим хуудсаар олон нийтэд тархааж байна.



ХАӨМС нь хувь хүний регистрийн дугаараар Улсын бүртгэлийн сангийн мэдээлэлтэй нийцэрч, өрхийн бүртгэлийн давтагдашгүй дугаараар өрхийн гишүүдийн мэдээллийг real time уяж өгснөөрөө “их хэмжээний өгөгдлийн” санг бүрдүүлж чадсан байна. Иймээс мал тооллогын мэдээллийг малчин өрх, малчны түвшинд ХАӨМС-тай болон бусад сангийн мэдээлэлтэй холбон ашиглах боломжийг нээж байгаа. Бизнес регистрийн сан аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаараар Улсын бүртгэлийн сангийн мэдээлэлтэй шалгагдсан тул статистикийн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан үнэн бодитой, чанартай мэдээлэл хэрэглэгчдэд хүрч байна.

Ерөнхий арга зүй бол, салбаруудын мэдээллийн санг хувь хүний регистрийн дугаараар холбож, холбогдох мэдээллийг харилцан солилцох боломж юм. Дараах зурагт Үндэсний дата төвөөр дамжуулан хувь хүний регистрийн дугаараар уясан салбаруудын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг харууллаа.

ЗУРАГ - 5. Төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох бүдүүвч зураглал



Одоогийн байдлаар ҮСХ-ны ХАӨМС болон УБЕГ-ын бүртгэлийн сангийн мэдээллийг Үндэсний дата төвд дундын сан хэлбэрээр байршуулан мэдээллийг харилцан уялдуулж байна. Мөн Боловсролын салбарын мэдээллийн сан БСМС болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн сангууд регистрт суурилсан тул мэдээлэл солилцох баталгаа хангагдсан байгаа юм. Хэрвээ Эрүүл мэндийн болон Халамж үйлчилгээний мэдээллийн сангууд Үндэсний дата төвийн дундын санд байршвал эдгээр салбаруудын мэдээллийн сангаас маш их хэмжээний real time мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх боломж бүрдэхээр байна.

Хувь хүний регистрийн дугаараар ХАӨМС-д буй өрхийг нь тогтоогоод нэг өрхөд суралцагчдын тоо, хамтын тэтгэвэр, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгал г.м олон асуудлыг судлах мэдээллийн шинжилгээ хийх боломж нээгдэж байна.

Зөвлөх багийн санал

1. ХАӨМС-г нийтэд ашиглуулахад мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

- 1.1. Сонгосон аймгуудад хийсэн судалгааны дүнгээс үзвэл ХАӨМС-д хандах эрхтэй хүний тоо багийн Засаг дарга, зохион байгуулагчдын тооноос бараг хоёр дахин олон байна. Санг бүрдүүлэхтэй холбоотойгоор интернет ашиглах чадвар, ажлыг эрчимжүүлэх хэрэгцээтэй уялдан сумын ЗДТГ-ын ажилтан, статистик хариуцсан санхүүгийн ажилтан, багийн Засаг дарг, багийн зохион байгуулагч, тооллогын ажилтан зэрэг ХАӨМС-д хандах эрхийг ашиглах хүний тоо нэмэгдэж байна. ХАӨМС нь хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа билээ.
- 1.2. ХАӨМС-ийн тайлангийн системээр гарч байгаа аймаг, сум, багийн түвшний нэгтгэлийн дүнгийн мэдээллийг нийтэд шууд тархаах боломжтой.
- 1.3. Харин өрх, хувь хүний түвшний мэдээллийг зөвхөн бодлого, төлөвлөлт хийх, судалгаа шинжилгээний ажлын зорилгоор ашиглах албан тушаалтан, судлаачид ҮСХ-ны “Тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийн нууцлалыг хангах, нууцлал хангагдсан анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулахад баримтлах журам”-ын дагуу ашиглуулах, мэдээлэл ашигласан хүний бүртгэл хийлгэх зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзэж байна.
2. Салбар хооронд мэдээлэл солилцоход анхаарах асуудлууд
 - 2.1. БСМС-тэй мэдээлэл солилцох загвар боловсруулах явцад ажиглагдсан асуудал бол төрийн байгууллагуудын мэдээллийн онлайн сангуудыг ачаалж байгаа анхдагч мэдээлэл албан ёсны болон захиргааны статистикийн мэдээлэл цуглуулах ҮСХ-ны баталсан болон зөвшөөрсөн маягт, заавар, аргачлалыг мөрдөж байгаа эсэхийг хянан үзэх шаардлагатай байна.
 - 2.2. Мөн мэдээллийн онлайн систем хооронд шууд мэдээлэл солилцох нөхцөлд мэдээллийн урсгалд өөрчлөлт орж болохоор байгаа тул ялангуяа орон нутгийн статистикийн байгууллагуудаар дамжихгүй тохиолдолд мэдээллийн урсгалын эргэх холбоог тогтоож өгөх хэрэгтэй болно.
3. Засгийн газрын 2013 оны 212 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах” журмыг **хуульчлах нь** мэдээлэл солилцох эрх зүйн хүрээнд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нэн чухал арга хэмжээ болно гэсэн саналтай байна. Энэ чиглэлээр байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй юм.
4. ҮСХ-ны “Тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийн нууцлалыг хангах, нууцлал хангагдсан анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулахад баримтлах журам”-ын дагуу ХАӨМС-д мэдээллийн нууцлалын техникүүдийг хандалтын эрхийн түвшнээр ялгаатай програмчлах хүсэлтийг аутсоорсинг компанидаа илгээхийг зөвлөж байна.

7. ХАӨМС-ИЙН БҮРДЭЛТ, АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

7.1. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн

Манай зөвлөх багийн ажлын нэг чухал хэсэг нь ХАӨМС-г орон нутагт бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд хийж байгаа ажлаа захиалагчийн цаг үеийн эрэлт, хэрэгцээтэй нягт уялдуулах төслийн зорилтыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой юм. Энэ зорилгоор Хэнтий аймагт томилолтоор явахын өмнө ҮСХ-ны дарга С.Мэндсайхан болон холбогдох мэргэжлийн албадтай уулзаж, орон нутагт ажиллах чиглэлээ тохиролцсон болно. Мөн Өвөрхангай аймагт ажиллахаар явахын өмнө Хэнтий аймагт ажилласан ажлын явцыг ҮСХ-ны МБТГ, ХАОСТТ-ны дарга, мэргэжилтнүүдэд танилцуулж, орон нутагт ажиллахдаа өгч байсан заавар зөвлөмжөө зөв эсэхийг тодотгон, нэмэлт зөвлөгөө авсан.

Зөвлөх баг Хэнтий аймгийн Хэрлэн, Жаргалтхаан, Баянмөнх, Дэлгэрхаан сумд, Бэрх тосгон, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянгол, Төгрөг, Хайрхандулаан, Хужирт сумдад ажиллав. Бусад сумдтай холбоо тогтоож, онлайнаар зөвлөгөө өгч байна.

ХАӨМС-н бүрдэлтийг идэвхжүүлэх, хүн ам, орон сууцны 2015 оны бүртгэлд суурилсан завсрын тооллогын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажилтай холбоотой дараах 4 төрлийн захиалгыг Зөвлөх багт ҮСХ-оос гаргаж өгсөн болно. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сан (НДС)-аас олж авсан ХАӨМС-д ороогүй иргэдийг олж тогтоох,
2. Тухайн Засаг захиргаанаас шилжин явах өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх,
3. Тухайн Засаг захиргаанд шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх,
4. ХАӨМС-г бүрдүүлэх явцад гарч байгаа алдааг засуулах.

Эдгээр 4 төрлийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор сумдын багийн Засаг дарга нар болон зохион байгуулагч нар, тооллогын гэрээт ажилтнууд, статистикийн хэлтсийн асуудал хариуцсан ажилтан, сумдын Санхүү, төрийн сангийн албаны дарга, статистикийн асуудал хариуцсан ажилтантай хамт сууж, засвар өөрчлөлтийг газар дээр нь хийлгэж, зөвлөж, зааварлаж, шаардлагатай үед ҮСХ-ны МБТГ-ын ажилтан Б.Тамиртай холбоо

барьж, заавар авах, мэдээллийн санд хайлт хийлгэх, учир шалтгааныг тодруулах зэргээр хамтран ажиллав. Энэ арга нь олон асуудлыг тодорхой болгож, орон нутгийн ажилтнуудад маш үнэтэй сургалт болсныг тэмдэглэж байна. Судалгаанд хамрагдсан аймгийн бүх багтай байнгын холбоо тогтоож, зөвлөгөөг одоо ч өгч байна.

ХАӨМС-г бүрдүүлэх ажил дараах байдалтай байна:

1. Нийгмийн даатгалын сан (НДС)-аас олж авсан ХАӨМС-д ороогүй иргэдийг олж тогтоох.

ХАӨМС-д бүртгэлгүй НДС-д бүртгэлтэй хүмүүсийг хайхад багийн Засаг дарга, зохион байгуулагч нартай хамт сууж, таниж магадгүй хүнээс сураг гаргах, овоглосон хүнээр нь хайж гэр бүлийнхэн нь тухайн сум багт бүртгэлтэй эсэхийг тогтоон холбоо барих замаар хайлтыг хийлээ.

Томилолтоор ажиллах явцдаа Хэнтий аймгийн 3 сумын 247 хүнээс 106 хүний, Өвөрхангай аймгийн 46 хүнээс 30-ийг нь олж системд оруулсан болно. НДС-д байгаа хэрнээ ХАӨМС-д бүртгэлгүй байгаа хүмүүсийн шалтгааныг ажиглахад:

- Сүүлийн жилүүдэд төрсөн бага насны хүүхдүүд улсын бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч багийн бүртгэлд байхгүй,
- Тухайн сум, багаас өөр хаа нэг тийшээ шилжин очоод, тэндээ ямар нэг бүртгэл хийлгээгүй,
- Гэр бүл хоёр өөр газар амьдарч байгаагаас хүүхдүүд бүртгэлээс завсардсан,
- Багийн ажилтнууд өрхөөр болон иргэнээр шилжүүлэх үйлдлийг буруу хийснээс системд алдаа гаргаж хүнээ олохгүй болсон,
- Цөөн тооны овог нэр өөрчилсөн хүүхдүүд 2 регистрийн дугаартай байгаа нь өрхдөө орохгүй алдаа өгөөд ХАӨМС-д ороогүй,
- Цөөнгүй тохиолдолд нас барсан хүмүүс байна.

Жишээ нь: Өвөрхангай аймгийн хэмжээнд 46 хүнийг олж тогтоохоос 9 нь нас барсан хүн байв. Арвайхээр сумын харьяат ЙЮ12301213, ЙЮ27082001, Бат-Өлзий сумын харьяат ЙБ12310331, ЙБ89082927, ЙБ12270618, ЙБ14210917, Богд сумын харьяат ЙД13233121, Бүрд сумын харьяат ЙЕ13311505, Архангайн АИ69081601 регистрийн дугаартай эдгээр хүмүүсийн бүртгэлийг Иргэний бүртгэлийн нас барсан тухай мэдээлэлд дахин шалгуулахыг зөвлөсөн болно.

Давхар регистртэй:

AM02280202 дугаараар НДС-аас гарч ирсэн Жигмэддоржийн Сэрээтэр нь НФ01280901 регистрийн дугаараар Хархорин сумын ХАӨМС-д бүртгэлтэй байна.

Өвөрхангайн Уянгаас хайж байгаа ЙМ00291423 регистрийн дугаартай Оюунтогтохын Долгорсүрэн ЙП00291424 регистрийн дугаартайгаар Арвайхээр сумын 9-р багт ээжийн хамт бүртгүүлсэн байна.

Дүгнэлт, санал:

Хайж байгаа хүний овгоор хэдэн зуун ижил нэртэй хүн гарч ирж байгаа нь эдгээр хүмүүсийг олох ажлыг хэт нүсэр болгож байна. Иймээс:

1. Нийгмийн даатгалын сангаас олж авсан, ХАӨМС-д байхгүй хүмүүсийг олж тодруулах үүрэг өгөхдөө хайж байгаа хүний эцэг, эхийн овог, нэр, хаягийг УБЕГ-ын Бүртгэлийн сангаас гаргуулж өгвөл хайлтыг илүү хурдан болгоно.
2. Бид томилолтоор ажилласан аймгуудынхаа Иргэний бүртгэлийн байцаагчтай уулзаж дээрх хүсэлтийг тавьсан болно.

2. Тухайн Засаг захиргаанаас шилжин явах өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх

ҮСХ-ны ХАОСТТ-оос өгсөн чиглэлийн дагуу ХАӨМС дахь шилжих хөдөлгөөн бол хүн ам, орон сууцны тооллогын зарчмыг баримтлан хийж буй хүн амын хөдөлгөөн тул УБЕГ-ын шилжих хөдөлгөөний нарийн бичгийг заавал шаардахгүйгээр баталгаажилтыг хийх ёстой гэсэн зааврыг орон нутагт өгсөн болно. Мөн нэг айл 2 өрх болон амьдарч байгаа хөдөлгөөний баталгаажилтыг аймаг хооронд бол бүртгэлийн нарийн бичгээр бүрмөсөн шилжүүлэх, оюутнуудыг сурч байгаа газар нь “байнга оршин суугч”-аар бүртгэнэ гэж зөвлөсөн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 109 хүнээс 77 хүний шилжилт, Өвөрхангай аймгийн бүх сумдын хэмжээнд шилжих хөдөлгөөний баталгаажилт хүлээж байсан 405 хүний 366-н шилжилт томилолтын хугацаанд хийгдлээ.

Шилжих хөдөлгөөнийг хүлээж авах, өгөх 2 тал аль аль нь тэмдэглээний алдаа хийснээс, дахин давтан шилжүүлэх, шивж оруулах оролдлого хийх зэргээр программд блоклогдох алдаа бас гарч байна. ҮСХ-ны МБТГ-ай холбогдож алдааг залруулсан болно.

Шилжих хөдөлгөөний баталгаажилт хийхэд нөлөөлж буй хүчин зүйлс:

1. Өрхөөрөө шилжиж байгаа тохиолдолд хаанаас авах гээд байгааг нь харж чаддаггүй, шилжих хүмүүс нь өөрсдөө Баг дээрээ ирж явах гэж байгаагаа хэлдэггүй учир баталгаажилт хийхийг түдгэлздэг байна. Улайгаад байхаар нь зарим айлаас асуухаар манайх шилжих гээгүй гэдэг тул түүнийг нягтлах хэрэгтэй болдог. Зарим айл үнэнээ хэлэхгүй ч явдал байна. Жишээ нь, Хэнтий аймгийн 2301650105421, 2301650109731, 2301650100029, 2301650100029 дугаартай өрхүүд улайчихсан, шилжиж байгаа юмуу гэж өөрөөс нь асуухаар шилжээгүй, мэдэхгүй гэсэн байна.
2. Оюутнуудыг заавал байнга оршин суугчаар шилжүүлж авна гээд байна. Түр оршин суугчаар бүртгэвэл зүгээр байна. Төгсөөд буцаж ирээд бүртгүүлдэг хүн байхгүй шүү дээ гэж орон нутаг нь тайлбарлаж байгаа бөгөөд оюутнуудаа “байнга оршин суугч”-аар шилжүүлэхгүй гэсэн орон нутгийнхаа ам шийдвэрээр шилжих хөдөлгөөний баталгаажилт хийгддэггүй юм байна.
3. Улсын бүртгэлээс нарийн бичгээ авч ирээгүй хүмүүсийн баталгаажилтыг хийхгүй байгаа. Яагаад гэвэл Багийн Засаг дарга нар хүн амын тоогоо сумынхаа бүртгэлийн ажилтантай тулгах ёстой байдаг юм. Тоо зөрөхөөр бүртгэлээс нарийн бичиг аваагүй хүнийг шилжүүлээ гэсэн асуудал үүсэж, бид буруутан болдог гэж Багийн ажилтнууд тайлбарлаж байна.
4. Суурин газар, нийслэл, дүүрэгт үл хөдлөх хөрөнгө, газар, хашаа байшин, орон сууц эзэмшиж байхын тулд (ж/нь: ийм шалтгаантай хүргэн, бэр Дэлгэрхаан суманд 20 орчим байгаа) амьдарч байгаа газраа шилжин ирдэггүй олон жил болдог,
5. Хөгжлийн бэрхшээлийн группийн сунгалт хийхэд танихгүй газар хүндрэл чирэгдэл их гардгаас бэрхшээгээд шилжилтээ хийлгэдэггүй,
6. Тэтгэвэрт гарах үед бичиг баримт бүрдүүлэх ажилд маш их чирэгдэл гардаг тул харьяаллаа өөрчлөхийг хүсдэггүй,
7. Шилжүүлэг хийлгэсэн хэрнээ очих газраа солиод бүртгэлгүй яваад байдаг (орон нутагтаа өртэй гэж зарим хүний тухай сонссон),
8. Цэргийн алба хаагаагүй залуучууд төлбөрөөс зугтаад бүртгүүлдэггүй,
9. Сургууль, цэцэрлэгийн эмээ өвөө, ах дүүс дээрээ байгаа хүүхдийг тухайн засаг захиргаанд албан ёсны бүртгэлгүй бол авахгүй гэдэг. Аймгийн боловсролын

газар авч болохгүй гэдэг, эцэг, эх нь ажилтай, хотод сургууль, цэцэрлэг олдохгүй байгаа эмээ, өвөөгийн хүүхдүүд олон байна. Хүүхэд шилжүүлэх асуудал нь заавал эхийгээ дагана гэсэн хуулийн заалтыг хөнддөг ажээ.

Эндээс салбар хоорондын зохицуулалт хиймээр асуудал нэлээд байгааг харж болохоор байна.

3. Тухайн Засаг захиргаанд шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх.

Шилжиж ирэх хүмүүсийнхээ хувьд хүсэлтээ явуулаад л хүлээж байна. Цаад Засаг захиргааных нь ажилтнуудтай холбоо бариад байгаа боловч зөвшөөрөл нь ирэхгүй байгааг тайлбарлаж байна. Ялангуяа нийслэлийн хороодын ажилтнууд харилцаа муутай, уур уцаар ихтэй байдаг гэнэ. Хэнтий аймгийн 194 өрх, 94 иргэний асуудал байсан. Үүнээс 42 өрх, 59 хүний асуудал шийдвэрлэгдэв. Өвөрхангай аймгийн 124 хүнээс 22 хүний хүлээгдэж байсан шилжилт хийгдсэн.

4. ХАӨМС-г бүрдүүлэх явцад гарч байгаа алдааг засуулах.

Томилолтын хугацаанд Хэнтий аймгийн 3 сумын нийт 3817 мөр алдааны протокол авч явсан бөгөөд ажилласан хугацаанд 1449 алдаа засварлагдсан. Өвөрхангай аймагт ХАӨМС-ийн алдаа ерөнхийдөө бага, аймгийн бүх сумдын хэмжээнд нийт 8817 мөр алдааны протокол авч явсан бөгөөд ажилласан хугацаанд 3217 алдаа засагдсаны зэрэгцээ Арвайхээр сумын ХАӨМС-ийн алдааны 34 хувийг засварласан байна.

Засагдаагүй байгаа алдааны ихэнх нь ургийн овог болон хүүхэдтэй холбоотой алдаа байна. Өрхийн сууцны нөхцөл, аж ахуйн хэсэг нөхөгдөөгүй айл олон байгаа бөгөөд тооллогын гэрээт ажилтны хамт айлуудаараа явж байгаа тэгээд оруулна аа гэсэн хариулт өгч байна. Бидний томилолтоор ажилласан сумдад ажил нэлээд идэвхжсэн бөгөөд орон нутгийн ажилтнууд үргэлжлүүлэн ажиллаж байгаа болно.

ХАӨМС-ийн алдааны тухайд юуны өмнө заавраа үзэх, ямар төрлийн алдааг үлдээж болох тухай чиглэл өгөгдсөн эсэхийг лавлав. Шууд огт алдаагүй болгох нь олон дам алдаа үүсгэж болохоор байгааг анхаарах шаардлагатай байна. Хэдийгээр ХАӨМС-ийн бүрдэлтийг хангах сургалт хийгдэж, заавар өгсөн хэдий ч мэдээллийн сангийн программаа бүрэн эзэмшээгүй, асуудал гармагц асууж лавлах, тодруулахаар холбогдох хүнтэй утсаар ярих нь байнга хялбар биш байгаагаас “зүгээр л алдаагүй болгох гэсэн

хандлага” ажиглагдав. Жишээ нь, Эцэг, эхтэйгээ хүүхдийн насны зөрүү15-аас бага байгаа тухай алдаа өгөхөөр дагавар хүүхдийг нь “дүү” гээд засчихдаг юм байна. Өрхийн тэргүүлэгчийн хамаарлын алдаа 2 өрх болон амьдарч байгаа айлуудад түгээмэл гарч байгаа бөгөөд шууд 2 өрх болгоод, эхнэрийг нь өрхийн тэргүүлэгч гээд засаж байна.

ХАӨМС-г бүрдүүлэхэд үзүүлсэн зөвлөх үйлчилгээний үр дүн дараах байдалтай байна/Хүснэгт- 7, Хүснэгт-8/.

ХҮСНЭГТ - 7. Хэнтий аймаг /3 сум/

Шийдвэрлэх асуудал	Томилолтын өмнө	Томилолтын хугацаанд шийдвэрлэгдсэн	12 сарын 5-ны байдлаар шийдвэрлээгүй байгаа
1.Олж тодруулах хүний тоо	247	106	-
2.Шилжих хөдөлгөөнийг нь баталгаажуулах өрхийн тоо	114	42	31
3. Шилжих хөдөлгөөнийг нь баталгаажуулах хүний тоо	109	77	208
4. Шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа өрхийн тоо	194	42	66
5. Шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа хүний тоо	94	59	141
6. Нийт алдаа	3817	1449	1456

ХҮСНЭГТ - 8. Өвөрхангай аймаг /бүх сумд/

Шийдвэрлэх асуудал	Томилолтын өмнө	Томилолтын хугацаанд шийдвэрлэгдсэн	12 сарын 5-ны байдлаар шийдвэрлээгүй байгаа
1.Олж тодруулах хүний тоо	46	30	-
2.Шилжих хөдөлгөөнийг нь баталгаажуулах өрхийн тоо	133	23	109
3. Шилжих хөдөлгөөнийг нь баталгаажуулах хүний тоо	405	366	793
4. Шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа өрхийн тоо	105	18	92
5. Шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа хүний тоо	124	22	488
6. Нийт алдаа	8117	3217	6904

Зөвлөх баг төслийн хугацаанд дээрх 2 аймгийн статистикийн хэлтэс, сум, багийн ажилтнуудтай байнга холбоотой ажиллав. Хүн бол байнгын хөдөлгөөнд байдаг тул шилжих хөдөлгөөн тогтмол хийгдэж, түүнтэй холбоотой програмын алдаатай мэдээлэл байнга гарсаар байх юм байна.

Түүнчлэн төслийн үйл ажиллагааны сүүлийн үе шатанд ХАӨМС-ийн программын шинэ хувилбарыг гаргасан тул,

5. Нийгмийн даатгалын сан (НДС)-аас олж авсан ХАӨМС-д ороогүй иргэдийг олж тогтоох,
6. Тухайн Засаг захиргаанаас шилжин явах өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх,
7. Тухайн Засаг захиргаанд шилжиж ирэхээр хүлээгдэж байгаа өрх, иргэний хөдөлгөөний баталгаажуулалт хийх,
8. ХАӨМС-г бүрдүүлэх явцад гарч байгаа алдааг засуулах

чиглэлээр хийсэн ажлын бодит үр дүнг гаргахад нөлөөлсөн болно. Өөрөөр хэлбэл, ХАӨМС-ийн программын 2 өөр хувилбар гарснаар үзүүлэлт хоорондын уялдааны балансын болон логик шалгалтууд, байж болох нөхцөлүүдийг олж тогтоох хэрхэн тооцох арга зүйн зөрүү гарсан болов уу гэж үзэж байна.

Сонгосон 2 аймагт дээрх 4 чиглэлээр хийсэн ажлын үр дүнг 2015 оны 12 сарын 5-ны өдрийн байдлаар Хүснэгт-7, 8-д харууллаа. Хүснэгтүүдийн үр дүнг товч тайлбарлавал:

Нийгмийн даатгалын сангаас олж авсан ХАӨМС-д ороогүй иргэдийг олж тогтоох ажлын сүүлийн дүн программын шинэчлэлттэй холбоотойгоор хараахан гарсангүй. Программын өөрчлөлттэй холбоотойгоор эх өгөгдөл нь дундын санд байршаагүй байж болох юм гэж таамаглав. Аймгууд бол хүнээ олж тодотгосон гэсэн тайлбар өгч байгаа бөгөөд нас баралтын бүртгэлтэй холбоотой тодруулга хийж байгаа хүмүүс байгаа болно.

Шилжих хөдөлгөөний баталгаажилт хийх болон хүлээгдэж байгаа өрхийн тоо төдийлөн буураагүй, шилжилт хийх хүний тоо өссөн байгааг ихэвчлэн оюутнууд эзэлж байна. Оюутнуудыг түр оршин суугаа, түр эзгүй төлөвөөр харилцан бүртгэнэ гэж ойлголцсон боловч нийслэлийн хороод байнга оршин суугчаар бүртгээд шилжих хөдөлгөөн удааширч байна гэж орон нутаг тайлбарлаж байгаа юм.

ХАӨМС-г мэдээллээр ачаалах, баяжилт хийх явцад гардаг алдааны тоо засвар хийсээр байгаа хэдий ч алдаагүй болоогүй хэвээр байна. Засвар хийх боломжгүй “Ургийн овог буруу” гэсэн алдаа Хэнтий аймагт 189, Өвөрхангай аймагт 203 байна.

Хэдийгээр хүн амын хөдөлгөөн байнга гардаг, завсрын тооллогын бүртгэлийг үргэлжлүүлэн хийсээр байгаа ч программын шинэ хувилбар дээр дараах алдаанууд гарч ХАӨМС-г бүрдүүлэх явцын алдаа нэмэгдсэнийг орон нутгаас мэдээлж байна. Үүнд:

1. Анхан шатны нэгжийн түвшинд засварласан алдаа засагдахгүй буцаж алдаатай гэж гарч ирээд байна. Тухайлбал,
 - 1.1. Газар тариалан эрхэлдэг эсэх нөхөгдөөгүй гэсэн алдаа Хэнтий аймгийн алдааны 10.4%, Өвөрхангай аймгийн алдааны 14.7%-ийг эзэлж байна.
 - 1.2. Хэнтий аймгийн Бор-өндөр сумын 4-р багийн 2352571400015, 2352571400016 дугаартай өрхүүдийн алдаа засагдахгүй байна
 - 1.3. Холбоо барих утасны дугаар буруу байна гэсэн алдаа маш их, мянга гараад байна. Утасны дугаар өөрчлөгдсөн, ашиглагдахаа больсон, зарим нь утасгүй гэх олон шалтгаан байгаа ажээ. Гол нь утасны дугаарын оронг гүйцээж заавал “тэг” үзүүлэлт шивж өгөх ёстой байгаа нь хүндрэлтэй бүрэн хийгдэхгүй байна гэж орон нутгаас ярихолаа.
 - 1.4. Сууцны төрөл нөхөөд байхад хадгалахгүй байна.
2. Дотоод шилжих хөдөлгөөний баталгаажилт, хүлээлтийг “ЗАХИА” бичиж харилцан мэдээлэх өөрчлөлт ХАӨМС-д шинээр нэмэгдэж хийгдсэн боловч захианд хариу өгдөг, захиагаа үздэг хүн байхгүй утсаараа ярьсан хэвээр байна.
3. Өвөрхангай аймгийн газрын зургийг ҮСХ өгөөгүй байгаа тул хаягийн өөрчлөлт хийгдэхгүй байна.
4. Давхар регистрийн дугаартай, айлд өргөгдөөд овог нэр, регистрээ өөрчлөөд өмнөх дугаараа хүчингүй болгоогүй хүмүүс бас байна. Хэнтий аймгийн Хэрлэн сумын СЙ94081541 регистртэй Батхуягийн Нарантуяа нь өмнө нь эрэгтэй регистртэй байгаад эмэгтэй болгож солиулсан боловч ХАӨМС-д “эрэгтэй” гэж бичигдсэн хэвээр байгааг сольж өгнө үү. Энэ шалтгаанаар “Цэргийн алба хаасан нөхөгдөөгүй” гэсэн алдаа гараад байна. Дадал сумын СЙ81070406 регистртэй Лхагвасүрэнгийн Оюун-Од СЙ82070406 гэсэн регистрээр давхар бүртгэгдсэн.

Их хэмжээний өгөгдөлтэй ажиллаж байгаа real time мэдээллийн системийн туршин боловсруулалтыг бүрэн хийсний дараа улсын хэмжээнд ашиглалтад өгөх нь технологийн үе шатанд мөрдвөл зохих зүй ёсны үйл ажиллагаа байх ёстой. Энэ ажил бүрэн хийгдээгүй байсны зэрэгцээ ХАӨМС-гийн туршин боловсруулалтыг төслийн үйл ажиллагааны явцад хэрэгжүүллээ гэдгийг хэлэх хэрэгтэй. Учир нь зөвлөх баг ажиллах хугацаандаа газар дээр нь олж харсан болон программын алдаа байх олон асуудлыг илрүүлэн санал болгосныг программын сүүлийн хувилбарт авч үзсэн байх гэж найдаж байна.

Ер нь ХАӨМС-г бүрэн зөв болгоход байнгын маш их ажил хийх ёстой бөгөөд ҮСХ-ны холбогдох ажилтнууд орон нутагтай тогтмол харилцаатай байж, хэрэгтэй заавар зөвлөгөөг өгч байх хэрэгтэй гэдгийг зөвлөж байна.

Зөвлөх баг ажилласан хугацааны амжилт, үр дүн бол сонгосон аймгуудын сум, багийн ажилтнууд ХАӨМС-гийн програм ыг бүрэн ашиглах, мэдээллийн баяжилт хийхтэй холбоотой дадлага сургалт хийж, сайн туршлагатай болсон явдал юм.

7.2. ХАӨМС-ийн бүрдэлттэй холбоотой багийн ажилтнуудад тохиолддог бэрхшээл, гаргасан санал

ХАӨБ-ийн сан бүрдүүлэх гол ачаалал сумдын багийн Засаг дарга нар, зохион байгуулагчид, санхүүгийн албаны дарга, статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэнд ногдож байна. Иймд эдгээр албан тушаалтнуудад тохиолдож байгаа бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлуудыг тодруулж, шийдвэрлэх арга замын талаар зөвлөх, ҮСХ-ны удирдлага болон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах чиглэл барьж ажиллав.. Хэнтий аймагт ажиллаж ирсний дараа ҮСХ-ны МБТГ-ын дарга Л.Мягмарсүрэн, Тооллогын товчооны дарга Ж.Мөнхбадар болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан уулзалт хийж, анхаарах асуудлуудыг тусгасан мэдээлэл өгсөн.

ХАӨМС-ийн асуудал хариуцсан хүмүүст дараах бэрхшээлүүд тохиолдож байгаа бөгөөд түүнийг шийдвэрлэх талаар тодорхой санал дэвшүүлснийг тайланд тусгав.

1. Гэрийн хаягаар, ургийн овгоор хайлт хийхгүй байна
2. Хэдэн өрх шивсэнээ тоог нь харж болдоггүй, өрхийн дугаар ижил байхад нэг өрхийн гишүүд хамт гарч ирдэггүй
3. Өрхөөрөө шилжиж байгаа айлыг хаашаа шилжиж байгааг харж болохгүй байна.
4. Шилжиж ирсэн өрхүүд дэвтрээ авч ирдэггүй.
5. Шараар тэмдэглэсэн хүмүүсийн ард ямар ч тэмдэглээ, үзүүлэлт гарч ирэхгүй юу ч хийж болохгүй байна
6. Оюутнуудыг заавал байнга оршин суугчаар шилжүүлж авна гээд байна. Түр оршин суугчаар бүртгэвэл зүгээр байна. Төгсөөд буцаж ирээд бүртгүүлдэг хүн байхгүй шүү дээ.
7. Цэргээс ирсэн хүн бүртгүүлэх гэсэн нас барсан гэж гараад байна. (УБЕГ-ын санд шалгуулахыг зөвлөв).

8. Ургийн овог, эцгийн нэр нь ижил шинэ хүн нэмэгдэж орж ирсэн. Айлаас нь лавлахаар ийм хүн манайд ерөөсөө байхгүй гэж байгаа. Хаанаас гарч ирсэн бэ? Хүргэн, бэр гээд танихгүй хүмүүс орж ирээд байна.
9. Ургийн овоггүй, ургийн овог нь буруу бичигдсэн (үг үсгийн алдаатай) хүн их байна
10. Улсын бүртгэлээс нарийн бичгээ авч ирээгүй хүмүүсийн баталгаажилтыг хийхгүй байгаа. Яагаад гэвэл Багийн Засаг дарга нар хүн амын тоогоо бүртгэлийн ажилтантай тулгах ёстой байдаг юм. Тоо зөрөхөөр бүртгэлээс нарийн бичиг аваагүй хүнийг шилжүүлээ гэсэн асуудал үүсэж, бид буруутан болдог.
11. Нэрээр, насаар судалгаа гаргаж болохгүй байна
12. Сургуулийн хүүхдүүд 2,3-аараа нэг гэрт амьдрах тохиолдол цөөнгүй байдаг юмаа. Гэтэл өрхийн тэргүүлэгчийн нас 15-аас бага гэсэн алдаа өгөөд байдаг.
13. Өрхийн тэргүүлэгч нь нас барсан айл хүүхдээ өрхийн тэргүүлэгч болгодог, нас 15-с бага гэсэн алдаа өгөөд байхаар ээжийг нь тэргүүлэгч болгохоор эмээ нь бас байгаа тохиолдолд нас 30-аас бага гээд байх юмаа.
14. Өндөр настны судалгаанд РД-ыг нь гаргадаггүй РД нь хэрэгтэй байна.
15. Оюутнууд сонгуулийн жилд яах вэ? Хичээл тарах үед нь шилжих хөдөлгөөн хийхээ больчихно. Сонгуульд оролцох боломжгүй болно шүү.
16. Нэг өрх 2 салж амьдрах ердийн үзэгдэл боллоо.
17. Цэргийн алба хаагаагүй залуучууд төлбөрөөс зугтаад бүртгүүлдэггүй
18. Алдаа: Хэрлэн сумын 8-р багт 2301650002621, 2301650005921-тай өрхүүд байхгүй байна
19. 6-р багт: 2301610002121 өрхийн тэргүүлэгчийн насыг 18 гэж бодоод алдаа өгөөд байгаа. Энэ мэтээр РД-н насыг буруу бодоод байна аа. Ийм тохиолдол олон гарсан байлаа.
20. Залуу хойд эцгийг яах вэ? Дагавар хүүхдүүдийг хүү, охин л гэж бүртгэх ёстой гэсэн зөвлөгөө өгсөн. Эцэг, эхтэйгээ хүүхдийн насны зөрүү бага байгаа тухай алдаа өгөхөөр дагавар хүүхдийг нь “дүү” гээд засчихдаг юм байна.

Программтай холбоотой байж болох дараах алдаануудад анхаарч ажиллахыг зөвлөв.

21. Хүүхэдтэй холбоотой бөглөх ёсгүй асуултуудыг бөглөхгүй болохоор гардаг алдаанууд:
 - а. Зургаан настай хүүхдийг сургуульд орсныг бүртгэхэд л ажил эрхлэлт, орлогыг заавал бөглүүлэх гээд алдаа өгөөд байдаг. Ажилгүй, орлогогүй

гээд бөглөхөөр “...бөглөгдөхгүй.. “ гэсэн алдаа өгч байгаа нь түгээмэл байна.

- b. Цэцэрлэгийн насны хүүхдийг СӨБ-д бүртгэхээр “СӨБ-д хамрагдалт нөхөгдөхгүй” гэсэн алдаа өгч байна
- c. Хүүхдийг цэрэгт бөглөхгүй гэсэн алдаа гараад байгаа

22. Яаж ч шалгаад мэдээлэл нь зөв байхад алдаа өгөөд байдаг. Зүгээр л ороод хадгалаад гарахаар алдаагүй болчихдог тохиолдол олон байна. Заримыг нь яаж засах учрыг нь олохгүй байна. Жишээ нь:

- a. 6201510901522 дугаартай өрхийн тэргүүлэгч Адилбишийн Найдансүрэнгийн эцэг, эхийн хүйс зөв байгаа боловч “эцэг, эхийн хүйс эсрэг” гэж гараад байна.
- b. 6201550404021 дугаартай Гаваагийн Долгорын ач/зээ хүү Золбоогийн эхнэр Уранчимэгийг өрхийн тэргүүлэгчийн “бэр” гэж кодлохоор алдаа өгөөд байна.

23. Өмнөх сангаас хөрвүүлсэн үе шатны алдаа байж болох асуудлууд гарч байна. Тухайлбал, ургийн болон эцгийн овог ижилхэн боловч тухайн өрхөд огт байхгүй хүүхэд, хүргэн, бэр орж ирээд байгаа.

24. Регистрийн дугаараас хүйсийг эсрэгээр нь бичээд байна.

25. Хэрлэн сумын 5-р багийн нэг өрхийн хаяган дээр 38 хүнтэй болчихоод, нэрээр нь шүүж өгөх хүсэлтийг УБЕГ-т хүргүүлсэн байна. Дамжлага олонтой, бичиг цаас их шаарддаг, цаг хугацаа их авсан ажил болсон. Иймээс завсрын тооллоготой уялдуулан Иргэний бүртгэлийн газар хамтарч ажиллаад шүүгээд өгчихдөг баймаар байна. Хамтарч ажиллахад хүндрэлтэй, багийн ЗД мөн ч юмуу г.м –ээр асуудалд ханддаг. УБЕГ-аас чиглэл өгсөн гэж статистик хэлж байгаа боловч газар дээрээ Бүртгэлийн хэлтэс тийм чиглэл аваагүй гэсэн.

26. Хайлт хийх:

Багийн ажилтнуудад ХАӨМС-аас хүн хайхдаа нэрээ янз бүрээр бичиж хайх хэрэгтэй байгааг хэлж өглөө. Тухайлбал, Лхагвасүрэн гэж хайгаад олдоогүй хүн нь Лхавгасүрэн гэж бүртгэгдсэн байв.

ХАӨМС-гийн бүрдэлттэй холбоотойгоор Багийн ажилтнуудаас гаргасан санал хүсэлт:

1. Хөдөө сумдад бодит амьдралаас урган гарч байгаа сургуулийн хүүхдүүд нэг гэрт амьдарч байгаа тохиолдолд нас, ЕБС-д суралцаж байгаа байдлыг нь шалгаж үзээд алдааг нь тооцолгүйгээр үлдээж болохгүй юу?
2. Оюутнуудыг бүрмөсөн шилжүүлэх асуудлыг зогсоож өгнө үү? Түр оршин суугаа, түр эзгүй хэлбэрээрээ бүртгээд байхад болмоор байна.
3. Хүн ам, орон сууцны завсрын тооллоготой холбоотойгоор УБЕГ-тай хамтран ажиллаж байгаа гэсэн боловч Улсын Бүртгэлийн хэлтсийн дарга нь, статистикийн тоо мэдээлэл үнэн худлаа байх ямар хамаатай юм бэ, хүний эрх зөрчиж байна, хуулийн дагуу амьдрах газар руу нь бүрмөсөн шилжүүлэх хэрэгтэй гэсэн. Тиймээс бид бүртгэлийн нарийн хуудсаар л баталгаажилтыг хийж байгаа.
4. Багийн Засаг дарга нарт модем зэрэг хэрэгцээтэй техник хэрэгслээр хангах боломж байгаа юу?

Мал тооллогын сантай холбоотой багийн ажилтнуудаас гаргасан санал:

1. “А” дансгүй болчихсон айл сангаас хасагдахгүй байна
2. ХАӨМС-с шилжин явсан айл мал тооллогын сандаа байгаад байна, хооронд нь уялдуулаад хасаж болдоггүй юм болов уу?
3. Төрийн банк зээлийн барьцаанд малын тооны тодорхойлолтыг авсан хэвээр байгаа.

ХАӨМС-г бүрдүүлэхтэй холбоотой салбар дундын асуудлуудыг шийдвэрлэх – Зөвлөх багийн санал

1. Бүс нутгуудын хөгжлийн ялгаатай байдал, эд хөрөнгө, орон байр, мал, газар эзэмшилтэй холбоотойгоор нэг айл хоёр өрх болон амьдарч байгаа нөхцөлийг хэлэлцэж, нэгдсэн шийдэлд хүрэх хэрэгтэй байна. Энэ нь өрхийн тоог хиймлээр өсгөх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Зөвлөх багийн санал

- Өрх хуваагдан амьдарч буй нөхцөлд, түр шилжиж байгаа гишүүдийг дэд өрх болгох. Тухайлбал, дэд өрхийг очиж буй газар нь заавал байнга

оршин суугч байхыг шаардахгүй байх, түр оршин суугаа, түр эзгүй төлөвөөр бүртгэх боломжийг ашиглаж болно.

- Магадгүй дэд өрхийн мэдээлэлд үндсэн өрхийн дугаарыг холбох, хадгалах шийдэл хийвэл өрх, өрхийн тэргүүлэгчийн тоог өсгөж буй асуудлыг шийдвэрлэх гарц болж болох юм.
- Шилжих хөдөлгөөний хугацааг НҮБ-ын зарчимд нийцүүлэн өөрчлөх нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор хүн амын хөдөлгөөн харьцангуй их байгаа үед их чухал байна.
- Нийгмийн даатгалын сангаас олж авсан, ХАӨМС-д байхгүй хүмүүсийг олж тодруулах үүрэг өгөхдөө хайж байгаа хүний эцэг, эхийн овог, нэр, хаягийг УБЕГ-ын Бүртгэлийн сангаас гаргуулж өгвөл хайлтыг илүү хурдан болгоход дэмжлэг болохоор байна.

7.3.ХАӨМС-г бүрдүүлэхтэй холбоотойгоор сумдын багийн засаг дарга,статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ҮСХ-ны Зөвлөх багаас хүргүүлсэн зөвлөгөө

“Хэрэглэгчдийн статистикийн боловсрол, орон нутгийн мэдээллийн сан” төсөл ҮСХ дээр хэрэгжиж байна.Энэхүү төслийг хэрэгжүүлэх зөвлөх баг Хэнтий аймагт ажиллалаа. ХАӨМС-ийн бүрдэлттэй аймгийн төв болон зарим сумдад очиж газар дээр нь танилцаж зөвлөгөө өглөө.

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого бүртгэлд суурилан явагдаж байгаатай холбоотойгоор ХАӨМС-г бүрдүүлэх ажлыг ойрын хугацаанд дуусгах шаардлагатай байна. Энэ ажилд дэмжлэг болгох зорилгоор дараах зөвлөгөөг явуулав. Тодруулах асуудал гарвал аймгийн статистикийн хэлтэс болон Зөвлөх багийн bideriya_tserenkhand@yahoo.com хаягаар харилцана уу.

Та бүхний анхааралд:

- Ургийн овгийг багийн түвшинд засварлахгүй. Ургийн овог огт бичигдээгүй, үг үсгийн алдаатай, гэр бүлийн бусад гишүү дээсээ өөр ургийн овогтой болсон байдал түгээмэл байгаа бөгөөд, системд нэгдсэн журмаар УБЕГ-ын мэдээллийн сантай тулгаж засвар хийгдэх юм. Харин ургийн овгийг яаралтай засуулах, өөрчлүүлэх шаардлагатай бол хүсэлтээ аймгийн статистикийн хэлтэст өгөөрэй.

- Шилжих хөдөлгөөний баталгаажилт хийхдээ заавал УБЕГ-ын бүртгэлийн шилжилт хийлгэхийг биш зөвхөн ХАӨМС-д шилжих өөрчлөлтийг тусгах чиглэл баримтлах нь зүйтэй. Энэ нь хүн ам, орон сууцны тооллогын зарчимд нийцэж байгаа юм. Харин тооллогын дараа УБЕГ-т шилжих хөдөлгөөн хэрхэн хийлгэх асуудлыг шийдвэрлэх юм.
- Дагавар хүүхдийг хүү, охин гэж л бүртгэх ёстой, өрхийн тэргүүлэгчийн болон дагавар хүүхдийн насны зөрүү бага байгаа тухай алдаа гарвал засварлалгүй үлдээх нь зүйтэй.
- Хоёр өөр газар амьдарч байгаа гэр бүлүүдийг алдаагүй болгохын тулд шууд 2 өрх болгоод, эхнэрийг нь өрхийн тэргүүлэгчээр засаж болохгүй. Энэ нь өрхийн тоо хиймлээр өсөх, өрх толгойлсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо өсөх нөхцөлийг бий болгож байна. Иймээс орон нутагтаа заавал байнга оршин суугч байхыг шаардаагүй нөхцөлд түр оршин суугаа, түр эзгүй төлөвөөр бүртгэхийг илүүд үзэхийг хүсэж байна. Тооллогын зааврын дагуу аймаг хооронд албан шилжүүлэг хийлгэж болох юм байна.
- Хаягийн засвараа яаралтай хийх хэрэгтэй байна. Учир нь улсын хэмжээнд хаягийн нэгдсэн стандартад шилжүүлэх ажил хүлээгдээд байгаа болно.

ХАӨМС-д сүүлийн үед нэмэгдэж орсон өөрчлөлтүүд:

1. Системд нас дэвшилт хийдэг болсон
2. Хүн амын суурьшлын төлөв
 - 2.1. Байнга оршин суудаг
 - 2.2. Түр оршин суугч
 - 2.3. Түр эзгүй
3. Сургуульд хамрагдалтын тухайд
 - 3.1. Төгссөн
 - 3.2. Завсардсан
 - 3.3. Гэртээ
 - 3.4. Хамрагдаагүй гэсэн 4 бүлгийг нэгтгээд “хамрагдаагүй” гэж кодолно.
4. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт
 - 4.1. “хавсарсан” гэсэн хэлбэр нэмэгдсэн
5. Ухаалаг тайлангийн бүлэг шинээр нэмэгдэнэ. Ингэснээр Та бүхний хүсэж байгаа цэрэг, сургуулийн насны, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт үзүүлэлтүүдийг

овог нэрээр нь ХАӨМС-аас гаргаж харах нөхцөл бүрдэх болно. Одоохондоо уг санг бүрдүүлж дуусаагүй байгаа гэдгийг ойлгоорой.

6. ҮСХ-ны вэб хуудсан дээр

1. Иргэн өөрийнхөө мэдээллийг баталгаажуулах
2. Гадаадад 183-аас дээш хоногоор оршин суугаа МУ-ын иргэд интернет тооллогод хамрагдах

тухай хоёр баннер шинээр нэмэгдсэн байгаа.

ХАӨМС-д байгаа иргэд өөрийнхөө мэдээллийг хэрхэн шалгах тухай зааврын дагуу сайт руу орж холбогдох мэдээллээ шалгаад шаардлагатай бол засвар хийгээд “хадгалах” товчийг дарах юм. Үүний дараа өөрийнх нь тухай сонирхолтой статистик мэдээлэл бүхий гэрчилгээ гарч ирнэ ээ. Ийм аргаар айлд интернет хаягтай нэг л хүн байхад бусад хүмүүсийнхээ мэдээллийг шалгаж болно.

Иргэд өөрсдийн мэдээллээ интернетээр шалгаж үзсэний дараа болон интернет тооллогын дүнг боловсруулсны дараа тухайн багийн харьяат хүн амтай холбоотой засвар өөрчлөлт орохоор бол Багийн Засаг дарга, зохион байгуулагчдад мэдээлэл өгөх юм. Байнгын холбоотой ажиллаж өгсөн зөвлөгөөг тусгахыг хүсье.

8. ҮСХ-НЫ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН БҮРДЭЛТ, АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 10 –ны өдрийн 1/101 тоот тушаалаар "Статистикийн тухай" хуульд заагдсан 48 бүлэг үзүүлэлтээс аймаг, сум, багийн түвшинд ямар үзүүлэлтүүдийг тооцож, мэдээлж байхыг тогтоосон билээ. Эдгээр үзүүлэлтүүдийг олон нийт, хэрэглэгчдэд хүргэх хамгийн тохиромжтой, түгээмэл хэлбэр нь ҮСХ-ны олон нийтэд зориулсан www.1212.mn нэртэй цахим хуудас юм. Энэхүү цахим хуудасны статистик мэдээллийн сан нь хэрэглэгчдийн зүгээс статистик тоо мэдээллийг сэдвээр нь хайж олох гол хэсэг болдог. Үүний зэрэгцээ уг цахим хуудсанд жил бүрийн статистикийн эмхтгэлийг тавьдаг боловч сүүлийн оны эмхтгэлийг нийтэд зориулан тавьдаггүй. 2015 оны 10 сарын байдлаар тус цахим хуудсанд 2012 оны статистикийн эмхтгэл нийтэд тавигдсан, харин 2013 болон 2014 оны эмхтгэлүүд тавигдаагүй, зөвхөн тусгай хандах эрхтэй хэрэглэгчдэд зориулсан тавьсан бололтой байна. Энэ тохиолдолд хэрэглэгчид 48 бүлэг үзүүлэлтэд тусгасан үзүүлэлтүүдийг статистикийн эмхтгэлээс авах боломжгүй байгаа юм. Үүний зэрэгцээ сар бүр гардаг статистикийн бюллетенийг дээрх цахим хуудсанд байрлуулдаг тул хэрэглэгчид дээр дурдсан 48 бүлэг үзүүлэлтээс бюллетенд орсон үзүүлэлтүүдийг олж авах боломжтой байна. Энэ тохиолдолд дурдсан 48 бүлэг үзүүлэлтүүдийг цахим хуудасны статистикийн мэдээллийн санд байршуулах нь хэрэглэгчдэд хайж олоход хамгийн хялбар байдгийг энд цохон тэмдэглэмээр байна.

“Статистик мэдээллийн боловсролын стратеги боловсруулах, орон нутагт мэдээллийг цуглуулах, түгээх чадавхыг бий болгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний төсөл”-ын хүрээнд ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын дагуу аймаг, сум, багийн түвшинд гарсан байх ёстой үзүүлэлтүүд дээрх цахим хуудасны статистикийн мэдээллийн санд тавигдсан эсэхийг нэг бүрчлэн тулган шалгаж, 10-р сарын байдлаар доорхи дүгнэлтүүдийг хийсэн болно. Төслийг хэрэгжүүлэх явцад ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд ямар ахиц дэвшил гарсныг харуулах зорилгоор анхны бодит байдлыг эхэлж харуулаад энэ бүлгийн эцэст гарсан ахиц өөрчлөлтийг тусгалаа.

8.1. ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын хавсралтуудын алдааны тухай

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-1, Хавсралт-2а ,Хавсралт 2б-д тусгагдсан үзүүлэлтүүд нэг хавсралтад нь байхад нөгөөд нь тусгагдаагүй, хоорондоо зөрүүтэй, уялдаагүй байгаа нь тушаалыг гаргахаас өмнө сайтар тулган шалгаагүйг харуулав. Тухайлбал, ДНБ-нийг үйлдвэрлэлийн аргаар орон нутагт 3 үзүүлэлтээр тооцохоор Хавсралт-1-д тусгасан бол Хавсралт-2а-д зөвхөн үйлдвэрийн аргын 2 хэлбэрээр тооцохоор оруулжээ. Үндэсний нийт орлогыг аймаг, нийслэлээр тооцно гэж Хавсралт-1-д оруулсан хирнээ Хавсралт-2а-д зааж оруулаагүй орхигдуулжээ. Хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн эх үүсвэрээр зөвхөн аймгаар тооцохоор Хавсралт-1-д тусгасан бол Хавсралт-2а энэ үзүүлэлтийг 2014 оноос сумаар тооцохоор тусгажээ. 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-1-д мал, тэжээвэр амьтдын тооны талаар 8 үзүүлэлтийг аймаг, сум, багаар гаргаж байхаар тусгасан бол Хавсралт-2а-д зөвхөн 5 үзүүлэлтийг аймаг, сум, багаар гаргаж байхаар тусгасан байна. Энд мал төллөлт, төл бойжилт, төллөх малын тоо, толгойн өөрчлөлт, цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн болон нутгийн сайжруулсан үүлдрийн малын тоо, төрлөөрөө зэрэг үзүүлэлт Хавсралт-2а-д тусгагдаагүй үлдсэн байна. Мөн хэрэглэсэн үр, төрлөөр Хавсралт-1-д аймаг, сум,багаар гаргахаар тусгасан бол Хавсралт-2а –д энэ үзүүлэлтийг огт оруулаагүй орхижээ. Аялал жуучлалын орлого, жуулчдын тооны үзүүлэлтийг Хавсралт-1-д аймаг, нийслэлээр гаргахаар оруулсан бол Хавсралт-2а –д энэ үзүүлэлтийг огт оруулаагүй орхижээ.

Тушаалын Хавсралт-1-д оруулсан тээсэн ачаа, ачаа эргэлтийн үзүүлэлтийг Хавсралт-2а-д зөвхөн авто тээврийн тээсэн ачаа, ачаа эргэлтээр тусгажээ. Мөн Хавсралт-1-д шилжүүлсэн тонн. км болон агаарын тээврийн үндсэн үзүүлэлтийг аймгаар гаргахаар оруулсан бол Хавсралт-2а-д огт тусгаагүй орхисон байна. Мөн Хавсралт-1-д оруулсан аймаг, нийслэлээр гаргах цаг уурын талаар 3 үзүүлэлтийг Хавсралт-2а болон Хавсралт-2б-гийн алинд ч оруулаагүй үлдээжээ.

Үзүүлэлтүүдийн нэр хавсралтуудад өөр өөрөөр орсон байна. Хавсралт-1-д орсон “Банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үзүүлэлт, оны эцэст “ гэсэн үзүүлэлт Хавсралт-2а-д ББСБ-уудын олгосон зээлийн хэмжээ болж өөрчлөгджээ.Хавсралт-1-д орсон хадгаламж, зээлийн хоршоодын үндсэн үзүүлэлт, оны эцэст гэсэн үзүүлэлт Хавсралт-2а-д хадгаламж зээлийн хоршоодын хүүгийн орлого болон хоршоодын тоо гэж 2 үзүүлэлт

болон задарчээ.Хавсралт-1-д орсон мал төллөлт, төл бойжилт, төрлөөр гэсэн үзүүлэлт Хавсралт-2а-д бойжуулсан төлийн тоо, төрлөөр болж өөрчлөгдсөний зэрэгцээ мал төллөлт, төл бойжилтын хувийг харуулсан маш чухал үзүүлэлтийг аймаг, сумаар гаргахгүйгээр орхигдуулжээ.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын үзүүлэлтүүдэд эргэж харахаар үзүүлэлтүүд цөөнгүй байна. Тухайлбал, аймаг ,нийслэлийн эдийн засгийн өсөлтийг хэмжихэд зайлшгүй ашиглагдах ёстой ДНБ-ний зэрэгцүүлэх үнээр үнэлсэн хэмжээ аймаг, нийслэлээр тооцохоор дээрх тушаалд тусгагдаагүй үлджээ. Иймээс аймгаар тооцсон ДНБ зөвхөн оны үнээрээ л байгаа бөгөөд түүнийг аймгийн удирдлага эдийн засгийн өсөлтөө хэмжихэд ашиглаж байна. Тэгсэн хирнээ малын тоо толгойн өөрчлөлт, төрлөөр, төлийн тоо толгойн өөрчлөлт, төрлөөр зэрэг нь үндсэн үзүүлэлт биш, зөвхөн тооцооны үзүүлэлт билээ. Мал, төлийн тоо нь байхад хэрэглэгч өөрсдөө шаардлагатай бол тооцоод гаргах үзүүлэлтийг үндсэн 48 үзүүлэлтийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагагүй байсан. Мөн “Экспорт, импортын гол нэр төрөл, хэмжээ” гэсэн Хавсралт -1 –ийн 35 дахь бүлэг үзүүлэлтийн дотор дотоод худалдааны борлуулалт, жижиглэн худалдааны борлуулалт гэсэн 2 үзүүлэлтүүдийг оруулсан нь утга агуулгын хувьд нийцэхгүй, гадаад худалдаанд огт хамаарахгүй дотоод худалдааны үзүүлэлтүүдийг энд оруулсан байх жишээтэй байна..

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын хавсралтад статистик үзүүлэлтүүдийг нэгдсэн нэг шалгуураар тусгаагүй, тодорхой нэг үзүүлэлт дотроо төрөл, ангиар задарсаныг тус бүр бие даасан үзүүлэлт мэтээр оруулжээ. Тухайлбал, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл, ангиар гэсэн нэг тодорхой үзүүлэлт Хавсралт -1-ын 39 дэх бүлэг үзүүлэлтийн 11 –д байгаа бол түүний дээр энэ үзүүлэлт нь дотроо гэмт хэргийн төрлөөрөө 10 бие даасан үзүүлэлт болон задарч давхардан тусгагдсан байна.

Үзүүлэлтүүдийн бүлэглэлт, нэр хүртэл мэргэжлийн түвшинд зохимжгүй байна. Тухайлбал, Хавсралт-2б-д хүн ам зүйн үзүүлэлтүүдийг хүн ам зүй, төрөлт, нас баралт, дундаж наслалт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт гэх мэтээр ангилсан байх юм. Зүй нь бүгдээрээ л хүн ам зүй гэсэн ганц нэрд хамаарах үзүүлэлтүүд юм. Энэ мэтчилэн 2014 оны 1/101 тоот тушаалын хавсралтад орсон үзүүлэлтүүдэд шүүмжлэлтэй хандах зүйл цөөнгүй гарч байна.

Дээрх тушаалын Хавсралт-2а ,Хавсралт 2б-д тусгагдсан сумаар тооцох зарим үзүүлэлтүүдийг гаргах тодорхой хугацаа заасан байхад аймгаар тооцох үзүүлэлтүүдийн хувьд ихэнхдээ хугацаа заагаагүй байгаа нь дүгнэхэд хүндрэл учруулж байна.

Орон нутгийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцон хэрэгжүүлж байгаа байдлыг тулган шалгах явцад тус тушаалын Хавсралт-2Б-д үзүүлэлтийн тоо зөрснийг тайлбарлах нь зүйтэй гэж үзлээ. Учир нь Хавсралт-2Б-д аймаг, нийслэлээр 138, сум, дүүргээр 107, баг, хороогоор 15 үзүүлэлтийг гаргахаар төлөвлөсөн нь харгалзан 137, 109, 16 болж өөрчлөгдсөн болно.

Уг хавсралтад 50 гэсэн дугаарыг алгассан байгаа тул нийт үзүүлэлт 137 болж байна. Мөн 2Б хавсралтын 45-47-р мөрөнд Ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлт, Ядуурлын мэдрэмжийг аймгаар гарах үзүүлэлтийн тоонд гурван үзүүлэлт гэж тоолсон байгаатай адилаар авсан тул сум, дүүргийн үзүүлэлт 109 болж 2-оор нэмэгдэв. Баг, хороогоор гарах үзүүлэлтийн тоо 16 байгаа болно.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын дагуу аймаг, сум, багийн түвшинд гарсан байх ёстой Хавсралт-2а, Хавсралт 2б-д тусгагдсан үзүүлэлтүүд дээрх цахим хуудасны статистикийн мэдээллийн санд тавигдсан эсэхийг 2015 оны 10 сарын эцсээр нэг бүрчлэн тулган шалгаж үзэхэд дараах байдалтай байв.

8.2. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалаар "Статистикийн тухай" хуульд заагдсан 48 бүлэг үзүүлэлтээс Хавсралт-2а-д макро эдийн засгийн 20 гол үзүүлэлтийг аймгийн түвшинд гаргаж, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны статистикийн мэдээллийн санд 11 үзүүлэлт аймгаар тавигдаж, харин доорх 9 үзүүлэлт аймгаар алга байв. Үүнд:

1. ДНБ, үйлдвэрийн аргаар, харьяатын зарчмаар
2. ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь, 2014 оноос
3. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр, 2014 оноос
4. Хуримтлал, хөрөнгийн ангиллаар, 2015 оноос
5. Банк бус санхүүгийн байгууллагын олгосон зээлийн хэмжээ
6. Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан хадгаламж, зээлийн хоршоодын тоо

7. Хадгаламж, зээлийн хоршоодын хүүгийн орлого
8. Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого
9. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг

Эдгээр 9 үзүүлэлтээс хуримтлал хөрөнгийн ангиллаар гэсэн ганц үзүүлэлтийг тооцох хугацаа хараахан болоогүй, бусад үзүүлэлтүүдийн хувьд гаргах цаг хугацаа нь болсон байв.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалаар макро эдийн засгийн 6 үзүүлэлтийг сумаар тооцох, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны статистикийн мэдээллийн санд бүгд алга байв. Эдгээрийг харуулбал:

1. ДНБ, үйлдвэрийн аргаар, 2015-2016 онуудад
2. ДНБ, үйлдвэрийн аргаар, харьяатын зарчмаар, 2015 оноос
3. Нэг хүнд ногдох ДНБ, 2015-2016 онуудад
4. Гол нэрийн зарим барааны жилийн дундаж үнэ, 2015 оноос
5. Нийт хадгаламж, төгрөг, валют
6. Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого.

Сумын түвшний эдгээр 6 үзүүлэлтээс 4 үзүүлэлтийн хувьд гаргахаар заасан хугацаа нь хараахан болоогүй байгаа юм. Харин макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс дээрх тушаалд багийн түвшинд гаргах үзүүлэлт байхгүй болно.

8.3. Үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлтүүд

8.3.1. Мал, тэжээвэр амьтад, малчин өрх, малын хашаа, худаг, уст цэгийн тооны үзүүлэлтүүд

Энд 11 үзүүлэлтийг аймаг, сум, бүр багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар дээрх тогтоолд тусгасан. ҮСХ-ны цахим хуудасны статистикийн мэдээллийн санд 6 үзүүлэлтийг аймгаар, 3 үзүүлэлтийг сумаар, 3 үзүүлэлтийг багаар тавьсан байв. Цахим хуудасны статистикийн мэдээллийн санд аймгаар тавигдаагүй 5 үзүүлэлтийг харуулбал:

1. Малын тоо толгойн өөрчлөлт, төрлөөр
2. Малчин өрхийн тоо
3. Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоо
4. Худаг, усан сан, уст цэгийн тоо, төрлөөр
5. Малыг хашааны тоо, төрлөөр

Эдгээрээс гадна аймгаар байгаа боловч сум, багаар тавигдаагүй дараах 8 үзүүлэлт байв.

1. Малын тоо толгойн өөрчлөлт, төрлөөр
2. Том малын зүй бус хорогдол, төрлөөр
3. Тэжээвэр амьтдын тоо, төрлөөр
4. Бойжуулсан төлийн тоо
5. Малчин өрхийн тоо
6. Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоо
7. Худаг, усан сан, уст цэгийн тоо, төрлөөр
8. Малын хашааны тоо, төрлөөр

Энд мал төллөлтийн хувь аймаг, сум, багаар огт тавигдаагүйг анхаармаар байна. д Бүх 11 үзүүлэлтийг аймаг, сум, бүр багийн түвшинд тооцож, мэдээлж байх цаг хугацаа нь болсон байна.

8.3.2. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Энэ бүлэгт 6 үзүүлэлтийг аймаг болон сумын (багийн түвшинд ямар нэг үзүүлэлт гаргахгүй) түвшинд тооцож, мэдээлж байх ёстой боловч дээрх цахим хуудасны статистикийн мэдээллийн санд эдгээр үзүүлэлтүүд бүгд алга байв. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, төрлөөр
2. Тэжээвэр амьтдын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, төрлөөр
3. Сүү, цагаан идээний үйлдвэрлэл
4. Ноос, ноолуурын үйлдвэрлэл
5. Арьс, ширний бэлтгэл
6. Бэлтгэсэн тэжээл, төрлөөр

Эдгээр бүх үзүүлэлтүүдийг тооцох цаг хугацаа нь болж өнгөрсөн байна.

8.3.3. Тариалсан талбайн үзүүлэлтүүд

Тариалсан талбайн 11 үзүүлэлтийг аймгаар, 11 үзүүлэлтийг сумаар, 9 үзүүлэлтийг багаар тооцож, мэдээлж байх ёстойгоос цахим хуудасны статистикийн мэдээллийн санд зөвхөн 5 үзүүлэлтийг л аймгаар тавьсан байна. Дараах 6 үзүүлэлт аймгаар тавигдаагүй байв.

1. Бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ
2. ААНБ-ын тариалсан талбай, төрлөөр
3. Хураасан талбай, төрлөөр
4. ААНБ-ын хураасан ургац, өвс хадлан, төрлөөр

5. Өрхийн хураасан ургац, өвс хадлан, төрлөөр
6. Жимс, жимсгэний нийт бут, модны тоо, төрлөөр.

Сумаар тооцож, мэдээлэх ёстой тариалсан талбайн 11 үзүүлэлт, багаар гаргах ёстой 9 үзүүлэлт бүгдээрээ статистикийн цахим мэдээллийн санд алга байв. Газар тариалангийн талаарх үзүүлэлтүүд сум, багаар огт тавигдаагүй байгаа нь орон нутгийн хэрэглэгчдийн энэ чиглэлийн мэдээллийн хэрэгцээг хангахгүй, цахим хуудасны хамгийн учир дутагдалтай хэсэг нь болж байна.

Дээрх 11 үзүүлэлтүүдийг бүгдийг нь 2014 оноос эхлэн тооцож, мэдээлж байхаар Хавсралт-2а-д тусгажээ.

8.3.4. Аж үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, худалдааны салбарын үзүүлэлтүүд

Энд нийт 19 үзүүлэлтийг аймгаар тооцож, мэдээлэх, 4 үзүүлэлтийг сумын түвшинд гаргаж байхаар дээрх тушаалд тусгаснаас ҮСХ-ны цахим хуудасны статистикийн мэдээллийн санд 15 үзүүлэлт аймгаар, сумаар дөнгөж 1 үзүүлэлт тавигджээ.

Дараах 4 үзүүлэлт аймгаар тавигдаагүй, түүний нэг нь гаргах хугацаа нь арай болоогүй байна.

1. Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэр төрлөөр, 2015 оноос
2. Ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажил
3. Холбооны үйлчилгээний нийт орлого, радио, төрлөөр
4. Хүн амаас орсон орлого

Сумын түвшинд гаргаж байх дараах 3 үзүүлэлт байгаа боловч хугацаа нь 2015 оноос гаргах юм.

1. Үүрэн утас хэрэглэгчдийн тоо, 2015 оноос
2. Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо, 2015 оноос
3. Техникийн үзлэгт хамрагдсан авто машины тоо, төрлөөр, насжилтаар, 2015 оноос

8.4. Байгаль орчны статистик үзүүлэлтүүд

Байгаль орчны статистикийн 9 үзүүлэлтийг аймгаар, 1 үзүүлэлтийг сумаар гаргаж, мэдээлж байх ёстойгоос ҮСХ-ны цахим хуудасны статистикийн мэдээллийн санд зөвхөн 4 үзүүлэлт л аймгаар тавигдсан, харин дараах 5 үзүүлэлт алга байв. Үүнд:

1. Ойн зохицуулалт
2. Ойн нөөц, хамгаалалт, ой зохион байгуулалт
3. Ой ашиглалт, зориулалтаар

4. Ойн санд учруулсан хохирол, зарцуулсан хөрөнгө, эх үүсвэрээр

5. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ

Эдгээр үзүүлэлтийг гаргах хугацаа аль хэдийнээ өнгөрсөн байна.

8.5. Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд

8.5.1. Өрх, хүн ам зүйн үзүүлэлтүүд

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-26- тусгаснаар өрх, хүн ам зүйн 28 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 26 үзүүлэлтийг сумын түвшинд, 12 үзүүлэлтийг багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд аймгийн түвшний 20, сумын түвшний 11, багийн түвшний 3 үзүүлэлт тавигдсан байна.

Аймгийн түвшинд гаргаж байх ёстой дараах 8 үзүүлэлт www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байв. Үүнд:

1. Төрсөн хүүхдийн тоо, эхийн насны бүлгээр
2. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо, боловсролын түвшнээр
3. Нас барсан хүний тоо, хүйс, насны бүлгээр
4. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо, насны бүлгээр, хүйсээр
5. Хүн амын шилжих хөдөлгөөн, ирсэн явсан аймаг/хотоор
6. Ганц бие эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн гишүүдийн тоогоор
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, төрлөөр
8. Тэтгэвэр, тэтгэмж авдаггүй өндөр настай хүний тоо, хүйсээр

Сумын түвшинд гаргаж байх ёстой өрх, хүн ам зүйн дараах 15 үзүүлэлт www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байна. Тушаалын Хавсралт-26 эдгээр үзүүлэлтүүдийг 2014 оноос тооцож, мэдээлж байхаар тусгажээ. Үүнд:

1. Хүн амын тоо, байршлаар
2. Хүн амын жилийн дундаж тоо
3. Хүн ам зүйн ачаалал
4. Төрөлт, нас баралтын тоо, хүйсээр
5. Төрсөн хүүхдийн тоо, эхийн насны бүлгээр
6. Төрөх үеийн хүйсийн харьцаа
7. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо, боловсролын түвшнээр
8. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо, гэрлэлтийн байдлаар

9. Нас барсан хүний тоо, хүйс, насны бүлгээр
10. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо, насны бүлгээр, хүйсээр, 2015 оноос
11. Гэрлэлт, цуцлалт, 1000 хүнд ногдохоор, 2015 оноос
12. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн гишүүдийн тоогоор
13. Ганц бие эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн гишүүдийн тоогоор
14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, төрлөөр
15. Тэтгэвэр, тэтгэмж авдаггүй өндөр настай хүний тоо, хүйсээр

Багийн түвшинд гаргах ёстой дараах 8 үзүүлэлтийг www.1212.mn цахим хуудсанд тавиагүй байна. Үүнд:

1. Хүн амын жилийн дундаж тоо
2. Нас барсан хүний тоо, хүйс, насны бүлгээр
3. Нас баралтын ерөнхий коэффициент
4. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн гишүүдийн тоогоор
5. Ганц бие эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн гишүүдийн тоогоор
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, төрлөөр
7. Тэтгэвэр, тэтгэмж авдаггүй өндөр настай хүний тоо, хүйсээр
8. Өрхийн тоо, хот, хөдөөгөөр

Эдгээр үзүүлэлтүүдийг Хавсралт-2б-д 2014 оноос тооцож, мэдээлж байхаар тусгажээ.

8.5.2. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-2б-д тусгаснаар хөдөлмөр эрхлэлтийн 12 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 11 үзүүлэлтийг сумын түвшинд, нэг үзүүлэлтийг багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд аймгийн түвшний 7 үзүүлэлт тавигдсан, харин сум, багийн түвшний үзүүлэлтүүд огт тавигдаагүй байв.

Хөдөлмөр эрхлэлтийн дараах 5 үзүүлэлт аймгийн түвшинд www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байв. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
2. Ажиллагчид, салбараар
3. Ажиллагчдын тоо, насны бүлгээр, салбараар
4. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй хүн ам, насаар
5. Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Сумын түвшинд тооцож, мэдээлэх ёстой хөдөлмөр эрхлэлтийн 11 үзүүлэлт www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байгаа бөгөөд эдгээрээс 10 үзүүлэлтийг 2016 оноос эхлэн тооцож, мэдээлэхээр Хавсралт-2б- тусгасан байна.

8.5.3. Хүн амын амьжиргаа, хүний хөгжил, хүнсний хангамжийн үзүүлэлтүүд

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт-2б-д тусгаснаар энэ бүлэгт 11 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 8 үзүүлэлтийг сумын түвшинд, 1 үзүүлэлт багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд Хүний хөгжлийн индекс аймгаар тавигдсанаас өөр ямар ч үзүүлэлт аймаг, сум, багаар тавигдаагүй байна.

Аймгийн түвшинд 2014 оноос тооцох ёстой 10 үзүүлэлтүүдэд:

1. Өрхийн орлого, зарлага
2. Өрхийн мөнгөн орлого, зарлага
3. Орон сууц болон гэрт амьдардаг өрх, аймаг, сум, багаар
4. Ядуу өрх, хүн ам /ХААДТ-ээс доогуур орлоготой хүн ам/
5. Ядуурлын хамралтын хүрээ,
6. Ядуурлын гүнзгийрэлт,
7. Ядуурлын мэдрэмж
8. Нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний дундаж хэрэглээ
9. Нэг хүнд сард ногдох хүнсний шимт тэжээлийн хэрэглээ
10. Нэг хүнд сард ногдох хүнсний шимт тэжээлийн хэрэглээний зохистой байдлын түвшин

Сумын түвшний 4 үзүүлэлтийг 2016 оноос тооцохоор тусгагджээ.

8.5.4. Боловсролын салбарын үзүүлэлтүүд

Тушаалын Хавсралт-2б-д тусгаснаар боловсролын салбарын 29 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 18 үзүүлэлтийг сумын түвшинд, 2 үзүүлэлтийг багийн түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд аймгийн түвшний 10 үзүүлэлт тавигдсан, харин сум, багийн түвшний үзүүлэлтүүд огт тавигдаагүй байна.

Аймгийн түвшинд 2014 оноос тооцож, мэдээлэх ёстой бөгөөд www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байгаа 19 үзүүлэлтүүдэд:

24. 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин
25. ЕБСургуульд 1-р ангид шинээр элсэгчдийн тоо, хичээлийн жилийн эхний байдлаар
26. Дотуур байранд амьдардаг суралцагчдын тоо
27. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо
28. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, хичээлийн жилийн эцсийн байдлаар
29. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, хичээлийн жилийн эхний байдлаар
30. Сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоо
31. Сурагч-багшийн тооны харьцаа
32. Суралцагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр
33. Төгсөгчийн тоо, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр
34. Анги улиран суралцагчдын тоо
35. Анги дэвшилтийн хувь
36. Анги улиралтын хувь
37. Сургууль завсардалтын хувь
38. Мэргэжлийн багшийн эзлэх хувь
39. Суралцагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр
40. Төгсөгчдийн тоо, мэргэжлийн чиглэлээр
41. ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь
42. Улсын нэгдсэн төсвийн зардалд боловсролын салбарын зардлын эзлэх хувь орж байна.

Орон нутгийн хэрэглэгчдийн хувьд сум, багийн түвшний боловсролын үзүүлэлтүүд www.1212.mn цахим хуудсанд огт тавигдаагүй байгаа нь харамсалтай байна.

8.5.5. Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүд

Хавсралт-2б-д тусгаснаар эрүүл мэндийн салбарын 25 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 21 үзүүлэлтийг сумын түвшинд тооцож, мэдээлж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд аймгийн түвшний 9 үзүүлэлт, сумын түвшинд 2 үзүүлэлтл одоогоор тавигдсан, аймгийн түвшний 17 үзүүлэлт, сумын түвшний 19 үзүүлэлт тавигдаагүй байна. Аймгийн түвшний 2, сумын түвшний тавигдаагүй 10 үзүүлэлт нь 2015 оноос тооцохоор төлөвлөгдсөн тул хугацаа нь хараахан болоогүй ажээ.

Аймгийн түвшинд 2014 оноос тооцож, мэдээлэх ёстой бөгөөд www.1212.mn цахим хуудсанд тавигдаагүй байгаа 15 үзүүлэлтүүдэд:

1. Амаржсан эхийн тоо
2. Нас барсан хүний тоо, зонхилох өвчний ангиллаар, хүйсээр
3. Хорт хавдраар өвчлөгчид, нас барагчид, 10 000 хүн амд ногдохоор
4. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, өвчний ангиллаар
5. 10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид
6. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, 10 000 хүн амд ногдохоор, зонхилох өвчлөлийн шалтгаанаар
7. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эхний 3 сартайд эмнэлгийн хяналтад хамрагдсан хувь
8. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эхний бба түүнээс дээш удаа эмнэлгийн хяналтад хамрагдсан хувь
9. Оношилгоо, эмчилгээний ОУ-ын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн
10. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр
11. Эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо, мэргэжлээр
12. Эрүүл мэндийн байгууллагын тоо
13. Эмнэлгийн орны тоо
14. 10,000 хүнд ногдох эмнэлгийн үр ашгийн үзүүлэлтүүд
15. ҮОМШ өвчнөөр өвчлөгчдийн тоо орж байна.

Сумын түвшинд тооцож, мэдээлэх хугацаа нь болсон 9 үзүүлэлтэд:

1. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, мэргэжлийн чиглэлээр
2. Их эмчийн тоо
3. Эм зүйчдийн тоо
4. Эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо, мэргэжлээр
5. Нэг их эмч, сувилагчид ногдох хүний тоо
6. Эрүүл мэндийн байгууллагын тоо
7. Эмнэлгийн орны тоо
8. 10,000 хүнд ногдох эмнэлгийн үр ашгийн үзүүлэлтүүд
9. ҮОМШ өвчнөөр өвчлөгчдийн тоо орж байна.

8.5.6. Хот, нийтийн аж ахуй, орон сууц

Хавсралт-2б-д энэ салбарын 5 үзүүлэлтийг аймаг, сумын түвшинд гаргахаар оруулсанаас ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд 3 үзүүлэлт аймгаар тавигдсан, харин сумын түвшинд тооцох 5 үзүүлэлтийн хугацаа 2015

оноос төлөвлөгдсөн байна. Аймгийн түвшинд гаргах боловч тавигдаагүй 2 үзүүлэлтүүдийг харуулбал:

1. Ашиглалтад оруулсан орон сууц, өмчийн төрлөөр
2. Ашиглалтад оруулсан орон сууцны талбай /нийтийн зориулалттай орон сууц, сууцны тусдаа байшин/

8.5.7. Нийгмийн даатгал

Хавсралт-2б-д нийгмийн даатгалын 4 үзүүлэлтийг аймгийн түвшинд 2015 оноос гаргахаар тусгасан хугацаа нь хараахан болоогүй, ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд тавигдаагүй байна.

8.5.8. Соёл, урлаг,сүм хийдийн үзүүлэлтүүд

Хавсралт-2б-д энэ чиглэлээр 10 үзүүлэлтийг аймаг,нийслэлийн түвшинд, 8 үзүүлэлтийг сум, дүүргийн түвшинд гаргаж байхаар тогтоосноос ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд 9 үзүүлэлтийг аймгаар тавьжээ. Харин сумаар гаргахаар тогтоосон 8 үзүүлэлтийг 2015 оноос эхлэн гаргахаар тусгажээ. Аймгаар харуулаагүй үзүүлэлт нь:

1. Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо

8.5.9. Гэмт хэргийн тоо, түүнээс учирсан хохирол, шүүхийн статистик үзүүлэлтүүд

Хавсралт-2б-д энэ чиглэлээр 7 үзүүлэлтийг аймгийн түвшинд гаргахаар, 6 үзүүлэлтийг сум, дүүргээр гаргахаар тусгаснаас ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд 7 үзүүлэлт бүгд аймгаар тавигдсан байна. Сумын түвшинд тооцсон 3 үзүүлэлт ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд тавигдсан, үлдсэн 3 үзүүлэлтийг 2016 оноос гаргахаар тогтоосон байна.

8.6. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үзүүлэлтүүд

Энэ чиглэлээр Хавсралт-2б-д 4 үзүүлэлтийг 2014 оноос аймгийн болон сумын түвшинд гаргахаар тусгаснаас ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд нэг ч үзүүлэлт тавигдаагүй байна. Эдгээр үзүүлэлтүүдийг харуулбал:

1. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо

2. Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон өрхийн тоо
3. Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон нийт өрхийн тоо
4. Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрх зэрг орж байна.

8.7. Бусад үзүүлэлтүүд

ААНБ-ын нийт тоо,салбараар, дэд салбараар, ажиллагчдын тооны бүлгээр, үйл ажиллагаа явуулж буй эсэхээр гэдэг үзүүлэлтийг аймаг, сумаар гаргахаар Хавсралт-2а-д тусгасныг ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд аймаг, сумдаар харуулжээ.

Харин нийт байгууллагын тоог 2014 оноос аймаг, сумдаар гаргахаар Хавсралт-2а-д тусгасан нь ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд алга байна.Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэлийг Хавсралт-2а-д аймгаар гаргахаар тусгасан нь ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд алга байна. Хүний хөгжлийн индексг Хавсралт-2б-д аймгаар тоцоохоор тусгасныг ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд харуулжээ. Харин 2016 оноос сумдаар тоцоохоор тогтоосон байна.

8.8. Эхний судалгааны дараагаар ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид боловсронгуй болгох талаар дэвшүүлсэн санал

Дүгнэлт

1. ҮСХ-ны цахим хуудас, түүний статистикийн мэдээллийн санд тавигдсан үзүүлэлтүүд нь "Статистикийн тухай" хуульд заагдсан 48 бүлэг үзүүлэлтүүдийг аймаг, сум, багийн задаргаатайгаар хэрэглэгчдэд хүргэх талаасаа хангалтгүй түвшинд байна. Энд ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11 –ны өдрийн 1/101 тоот тушаалаар баталсан аймаг, сум, багийн түвшинд тоцоохоор тогтоосон үзүүлэлтүүдийн жагсаалтаас 2015 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар аймгийн түвшинд 51.2 хувь нь, сумын түвшинд дөнгөж 13.2 хувь нь, багийн түвшинд 20 хувь л тавигдсан байв. Үүнийг доорх нэгтгэл хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ – 9. ҮСХ-ны даргын 1/101 тоот тушаалаар аймаг, сум, багийн түвшинд тооцох үзүүлэлтийн тоо, тэдгээрээс ҮСХ-ны цахим хуудасны статистик мэдээллийн санд тавигдсан, тавигдаагүй үзүүлэлтийн тоо, 2015 оны 11 сарын 5-ны байдлаар

	Нийт	Аймгийн түвшин	Сумын түвшин	Багийн түвшин
ҮСХ-ны даргын 1/101 тоот тушаалын Хавсралт 2а, 2б	404	217	151	36
ҮСХ-ны цахим хуудасны мэдээллийн санд тавигдсан	137	111	21	6
Тавигдсан үзүүлэлтүүдийн эзлэх хувь	33.9	51.2	13.2	20.0
ҮСХ-ны цахим хуудасны мэдээллийн санд тавигдаагүй нийт үзүүлэлт	267	106	130	30
Үүнээс тавигдах хугацаа нь болсон, тавигдаагүй үзүүлэлтүүд	207	100	77	30

2. Хүснэгтээс харахад ҮСХ-ны цахим хуудас нь албан ёсны статистикийн хүрээнд гаргах ёстой үзүүлэлтээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг зохих ёсоор хангахааргүй бүрдэлттэй байна. ҮСХ-ны даргын 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон Хавсралт-2б-д тусгагдсан орон нутгийн хэмжээнд гаргах нийт 404 үзүүлэлтийн зөвхөн 33.9 хувь нь ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн санд нийтэд ил тодоор тавигджээ. Дээрх хүснэгтийн дэлгэрэнгүй задаргааг Хавсралт-10 –д харуулав.

3. ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн сангаас орон нутгийн хэрэглэгчид газар тариалангийн болон хүн амын амьжиргааны түвшин, хүнс тэжээлийн хангамжийн талаар аймгаар тооцсон ямар ч үзүүлэлт, мөн сумын түвшинд боловсролын ямар ч үзүүлэлт олж ашиглах боломжгүй байна.

4. ҮСХ-ны цахим хуудас нь хэрэглэгчдийн зүгээс албан ёсны статистикийн тоо мэдээллийг хайж олоход тийм хялбар бус, хэрэглэгчдэд хайж олоход зохих бэрхшээл учруулж байна. Эхний ээлжид хэрэглэгч цахим хуудасны статистикийн мэдээллийн санд холбогдох сэдвээр нь хэрэгцээтэй үзүүлэлтээ хайж, тэнд байхгүй бол цахим хуудасны бусад хэсгээс, тухайлбал, статистикийн жил бүрийн эмхтгэл, статистикийн бюллетень, орон нутгийн задаргаатай мэдээллийг “Аймгийн статистикийн товчоон” товхимлоос хайхад хүрнэ. Гэхдээ зөвхөн 2012 оны статистикийн эмхтгэл нийтэд тавигдсан, харин 2013 болон 2014 оны эмхтгэлүүд тавигдаагүй байна. “Аймгийн статистикийн товчоон” товхимлын сүүлчийн он нь 2013 он байгаа болно. Харин

статистикийн сар бүрийн бюллетень нийтийн хэрэгцээнд зориулан тавигддаг нь сайшаалтай.

5. ҮСХ-ны цахим хуудас, түүний статистикийн мэдээллийн санд тавигдсан үзүүлэлтүүд нь хэрэглэгчдийн хувьд цөөхөн оноор тавигдсан, 2012 оноос өмнөх оны тоо мэдээлэл ховор тавигдсан, зарим нь зөвхөн 2013 оноор тавигдсан хуучирсан, түүнийг шинэчлэх ажил хангалтгүй байна.

6. Явцын анхны тайлангийн дараа ҮСХ-ны дарга С.Мэндсайхан болон газар, хэлтэсийн дарга, мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтаар хорооны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийг сайжруулах талаар газар, хэлтэсүүд онцгой анхаарч ажиллахыг үүрэг болгосон.

Санал

1. Орон нутгийн болон нийт хэрэглэгчдийн статистик тоо мэдээллийн хэрэгцээг "Статистикийн тухай" хуульд заагдсан 48 бүлэг үзүүлэлтүүдийн хүрээнд хангахын тулд ҮСХ нь өөрийн цахим хуудасны (www.1212.mn) тоо мэдээллийг аль болох яаралтай бүрэн бүрдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.
2. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б –д тусгагдсан үзүүлэлтүүдийг www.1212.mn цахим хуудсанд оруулах ажлын хуваарийг газар, хэлтэс, хариуцах мэргэжилтэн нэг бүрээр гаргаж, гүйцэтгэлийг нь 15 хоног тутамд хянаж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцэж байхыг зөвлөмж болгож байна.
3. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б –д тусгагдсан үзүүлэлтүүд өөр хоорондоо зөрүүтэй, газар хэлтсийн дарга нарын ойлголт зөрүүтэй байгааг ҮСХ-ны удирдлага анхааралдаа авч, тодорхой болгох шаардлагатай байна. Үнэхээр сум, багаар гаргах боломжгүй үзүүлэлтүүдээ хэрхэх талаар шийдвэр гаргах шаардлагатай гэж үзлээ.
4. Хэнтий болон Өвөрхангай аймгийн удирдлага, хөгжлийн бодлогын хэлтсийн гаргасан санал болон өмнөх “Үндэсний бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх MON/13/201 төсөл”-ийн хүрээнд хийсэн “Орон нутгийн түвшин дэх статистикийн мэдээллээр хангах одоогийн боломж, дутагдалтай байдлыг үнэлж, хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан”- гаас харахад ДНБ-ийг сумдаар тооцож, аймгийнхаа эдийн засагт сум бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэх практик хэрэгцээ, шаардлага орон нутагт байна. Иймээс ҮСХ ДНБ-ийг сумдаар тооцох

аргачлалаа боловсруулж, мөрдүүлэх, тооцоог тогтмол хийж, мэдээлж байх шаардлагатай болжээ.

5. Макро түвшинд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг аль нэг оныг суурь болгосон зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ний өсөлтөөр хэмждэг. Угаасаа олон улсын түвшинд стандарт аргачлал ийм байдаг. Гэтэл аймаг орон нутгийн түвшинд ДНБ-ийг зөвхөн оны үнээр л тооцож, мэдээлж ирсэн. Эндээс аймгуудын эдийн засгийн өсөлтийг үнэндээ бодитой хэмжих боломжгүй байна. Аймгийн удирдлагууд эдийн засгийн өсөлтөө оны үнээр үнэлсэн ДНБ-ний хэмжээгээр ярьж, бичиж байна. Иймээс ҮСХ аймгийн ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлж тооцох шаардлагатай байна.

8.9. ҮСХ-ноос 2015 оны 11 сард цахим хуудсандаа оруулсан нэмэлт өөрчлөлтүүд.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын дагуу аймаг, сум, багийн түвшинд гарсан байх ёстой үзүүлэлтүүд ҮСХ-ны www.1212.mn цахим хуудасны статистикийн мэдээллийн санд тавигдсан эсэхийг нэг бүрчлэн тулган шалгаж, гаргасан дүгнэлтүүдийг ҮСХ-ны даргын зөвлөлийн хурлаар 2015 оны 11 сарын 2-ны өдөр танилцуулж, дээрх цахим хуудсанд тавигдаагүй үзүүлэлтүүдийг шинээр шивж орууулах талаар холбогдох газар, хэлтэс, хариуцсан албан тушаалтнуудад хугацаатай үүрэг, даалгаврыг өгүүлсэн.

Ингээд ҮСХ-ны холбогдох газар, хэлтсүүдээс өгсөн үүрэг даалгаврын дагуу www.1212.mn цахим хуудасны статистикийн мэдээллийн санд шинээр оруулсан үзүүлэлтүүдийг 2015 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар дахин нэг бүрчлэн шалгаж үзэхэд дараах байдалтай байв.

Өнгөрсөн нэг сарын хугацаанд ҮСХ-ны www.1212.mn цахим хуудасны статистикийн мэдээллийн санд аймгийн түвшний 31 үзүүлэлт, сумын түвшний мөн 31 үзүүлэлт, багийн түвшний 14 үзүүлэлтийг шинээр нэмж оруулсан байна. Ингэснээр 2015 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар энэхүү мэдээллийн санд ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын дагуу аймгийн түвшинд гаргах ёстой 217 үзүүлэлтийн 142 нь буюу 65.4 хувь нь, сумын түвшинд гаргах ёстой 151 үзүүлэлтийн 52 нь буюу 34.4 хувь нь, багийн түвшинд гарсан байх ёстой 36 үзүүлэлтийн 20 буюу 55.6 хувь нь тавигдаад байна.

ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б-д тусгагдсан үзүүлэлтүүдээс www.1212.mn цахим хуудасны статистикийн мэдээллийн санд

тавигдсан болон тавигдаагүй үзүүлэлтийн тоог 2015 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар шинэчлэн Хавсралт-11-д харуулав.

ХҮСНЭГТ – 11. *ҮСХ-ны даргын 1/101 тоот тушаалаар аймаг, сум, багийн түвшинд тооцох үзүүлэлтийн тоо, тэдгээрээс ҮСХ-ны цахим хуудасны статистик мэдээллийн санд тавигдсан, тавигдаагүй үзүүлэлтийн тоо, 2015 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар*

	Нийт	Аймгийн түвшин	Сумын түвшин	Багийн түвшин
ҮСХ-ны даргын 1/101 тоот тушаалын Хавсралт 2а, 2б	404	217	151	36
ҮСХ-ны цахим хуудасны мэдээллийн санд тавигдсан	214	142	52	20
Тавигдсан үзүүлэлтүүдийн эзлэх хувь	52,9	65,4	34,4	55,5
ҮСХ-ны цахим хуудасны мэдээллийн санд тавигдаагүй нийт үзүүлэлт	190	75	99	16
Үүнээс тавигдах хугацаа нь болсон, тавигдаагүй үзүүлэлтүүд	207	100	77	30

Хэдийгээр өнгөрсөн нэг сарын хугацаанд цөөнгүй үзүүлэлтүүдээр цахим хуудсыг баяжуулсан боловч ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б-д тусгагдсан үзүүлэлтүүдээс цаана нь нийтдээ 190 үзүүлэлтийг, үүний дотор 75 үзүүлэлтийг аймгийн түвшинд, 99 үзүүлэлтийг сумын түвшинд, 16 үзүүлэлтийг **багийн түвшинд гаргаж, тэдгээрийг** уг мэдээллийн санд нэмж оруулж, орон нутгийн хэрэглэгчдийг мэдээллээр хангах шаардлага байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийг 2015 оны 11-р сарын эхний байдлаар болон 12-р сарын эхний байдлаар тус тус гаргаж хавсралт 10, 11-д тусгав. Энэ 2 хавсралтаас одоо мэдээллийн нэгдсэн санд тусгагдаагүй байгаа 190 үзүүлэлт тодорхой харагдаж байгаа болно. Мөн энэ 2 хавсралтад байгаа тооны өөрчлөлтөөс төслийг хэрэгжүүлэх явцад www.1212.mn сайтын санг нөхөн бүрдүүлэх талаар хийсэн ажлын үр дүнг тодорхой харж болно.

Харин ҮСХ-ны даргын 2014 оны 1/101 тоот тушаалын хавсралтуудын алдааг залруулах талаар төсөл хэрэгжүүлэх явцад ямар нэгэн алхам хийгдээгүй болно. Цаашид эдгээр алдааг хэрхэн залруулах, мэдээллийн нэгдсэн санг бүрэн баяжуулах асуудалд үргэлжлүүлэн анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна.

9. ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗОРИЛТОТ БҮЛГҮҮДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ 2016- 2020 ОНЫ СТРАТЕГИ БА БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Орон нутгийн хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ.
3. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүд
4. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд баримтлах бодлого
5. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратегийн зорилго, зорилтууд
6. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх нөхцөл, хэлбэр, арга зам, хугацаа
7. Төсөөлж буй хүрэх үр дүн буй

9.1. Нийтлэг үндэслэл

Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратеги нь стратегийн төлөвлөлтийн маркетингийн стратеги (“marketing strategies”) хэсэгт хамаарахаар байна. Учир нь бид төрийн тодорхой төрлийн үйлчилгээг иргэдэд илүү хүртээмжтэй, нээлттэй хүргэх дунд болон урт хугацааны стратеги ба бодлогын хүрээнд хэрэглэгчдийнхээ боловсролыг дээшлүүлэх асуудлыг авч үзэж байгаа билээ.

Маркетингийн стратеги нь өргөн утгаараа бизнесийн байгууллагаас бараа, үйлчилгээгээ хэрэглэгчдэд борлуулахад чиглэсэн үйл ажиллагааны урт хугацааны стратеги юм. Иймээс энэхүү баримт бичиг бол статистик мэдээллийн талаар өргөн мэдлэгтэй, түүнийг ашиглах ур чадвартай ирээдүйн хэрэглэгчдийг бэлтгэхэд чиглэсэн стратеги болно.

Аливаа стратеги болон бодлого нь тухайн байгууллага болон үйл ажиллагааны өнөөгийн түвшинг алс хэтэд нь улам сайжруулах тодорхой зорилго, зорилтуудыг

оновчтой тодорхойлсон, түүний хэрэгжилтийг хэмжих, дүгнэх боломжтой үзүүлэлтүүдээр илэрхийлсэн, хэрэгжих үндэслэлтэй баримт бичиг байх ёстой.

9.2. Орон нутгийн хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ

XIX зуунд амьдарч байсан Английн статистикч, эрдэмтэн Н. G.Wells “Статистик сэтгэлгээн нь нэг л өдөр боловсролтой хүний хувьд уншиж, бичихийн нэгэн адил чухал хэрэгцээ нь болно” (“Statistical thinking will one day necessary for efficient citizenship as the ability to read and write”) * гэж хэлсэн байдаг.

*Mark L. Berenson and David M. Levine. Basic business statistics: Concepts and Applications, 1996

Сүүлийн жилүүдэд орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд онцгой анхаардаг боллоо. Аймаг, сумдад хөгжлийн сан бий болж, тэдгээрийг зүй зохистой төлөвлөж зарцуулах шаардлага орон нутгийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын өмнө тавигдах боллоо. Түүнчлэн орон нутаг нь өөрийн гэсэн төсөвтэй түүнийгээ бие даан боловсруулж ИТХ-аараа баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, зохион байгуулдаг. Улсын төвлөрсөн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын үндэслэлийг орон нутаг тооцоолон гаргаж санхүү, эдийн засгийн төв байгууллагуудад уламжилдаг. Орон нутгийн бие даасан байдал нэмэгдэж, хөрөнгө санхүүгийн боломж нэмэгдэхийн хэрээр шийдвэр гаргах түвшинд ашиглах статистик мэдээллийн эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх хандлагатай болж байна.

Орон нутгийн түвшинд дээр дурдсан хариуцлагатай зорилтуудыг шийдвэрлэхэд үндэслэл муутай хандах, ИТХ-ын төлөөлөгчдийн санаанд хөтлөгдөх явдал түгээмэл байна. Энэ нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдлыг тусган илэрхийлсэн үзүүлэлтүүд дутмаг, аймаг, сумынхаа бодит байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах арга барил хэвшиж тогтоогүйтэй холбоотой. Түүнчлэн энэ бүхэн нь нийт шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдын статистик мэдээллийн боловсрол шаардлагын хэмжээнд хүрч чадаагүй байгаатай холбоотой юм. Ийм нөхцөлд нэг талаас, орон нутгийн доод шатны нэгж болох баг, сумын бодит байдлыг илэрхийлсэн статистикийн үзүүлэлтийн хүрээг өргөжүүлж, боловсронгуй болгох нөгөө талаас, эдгээр үзүүлэлтүүдээ ашиглаж дүн шинжилгээ хийдэг, тэр үр дүндээ тулгуурлаж төлөвлөгөө боловсруулдаг, шийдвэрээ гаргадаг байх шаардлага тавигдаж байна. Зөвхөн сумын

Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчдийн зүтгэл чармайлтаас хамаарсан төлөвлөлт амьдрал хэрэгжиж байгаа учраас шинээр хөрөнгө оруулалт хийх сум, багаа буруу тооцоолдог явдал байна. Орон нутагт ажиллах явцад статистикийн тоо мэдээллээ ашиглахгүйгээр төсөвт барилга объект тусгадаг баримт олон таарч байна.

Сургууль, цэцэрлэгийн өргөтгөл, жишиг сум сонгох зэрэг олон шийдвэрүүд шийдвэр гаргагчдын үзэмжээр гарснаас болоод нэг газар байр илүүдэж нөгөөд нь дутагдах, онцын шаардлагагүй газар хөрөнгө оруулалт хийгдэж байна. Статистикийн байгууллагаас гаргасан мэдээллийг ашиглах арга барилд суралцаагүй шийдвэр гаргагчид орон нутагт түгээмэл байна. Судалгаанд хамрагдсан Хэнтий, Өвөрхангай аймгийн санхүү, төрийн сан, хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс болон бусад бодлого, төлөвлөлтийн ажилтны 82 хувь ҮСХ-ны 1212 сайтыг мэддэггүй 86 хувь бараг ашигладаггүй болох нь тогтоогдлоо. Дээрх 2 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 70 хувь нь, эмч нарын 67, хэвлэл мэдээллийн ажилтнуудын 53, иргэдийн 86 хувь нь ҮСХ-ны мэдээллийн цахим санг огт мэдэхгүй байна. Ийм нөхцөлд хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд ялангуяа, орон нутагт онцгой анхаарч, тодорхой зорилт, түүнд хүрэх ойрын болон урт хугацааны зорилтуудыг дэвшүүлж ажиллах шаардлагатай байна.

“Үндэсний бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх MON/13/201 төсөл”-ийн хүрээнд хийсэн “Орон нутгийн түвшин дэх статистикийн мэдээллээр хангах одоогийн боломж, дутагдалтай байдлыг үнэлж, хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан”-д орон нутгийн түвшинд статистик мэдээллийн хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх шаардлагатай байгааг оролцооны аргаар явуулсан бүлгийн ярилцлагуудын явцад тодорхой дүгнэсэн байдаг.

Үүнд:

1. Статистикийн тухай ойлголтыг хүүхэд наснаас нь эхлэн өгөх, боловсролын хөтөлбөрт статистикийн анхан шатны мэдлэг олгох хичээл оруулах,
2. Төлөвлөгчдийг (дарга нар төдийгүй салбар хариуцсан мэргэжилтнүүд) статистикийн мэдээлэл ашиглах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх сургалтад хамруулах,
3. Төсөл, хөтөлбөрийн үнэлгээ хийх, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд ашигладаг компьютерийн програмын сургалт зохион байгуулах,

4. Сургалтад дарга нар суугаад л сонгуулиар гараад явчихдаг, орон нутгийн ажилтнуудын чадавх бэхэжсэн юмгүй, ажиллах ч хүнгүй хэвээрээ хоцорч байгааг анхаарах,
5. Төлөвлөгчдийн компьютер, англи хэлний мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах,
6. Цаг алдалгүй мэдээлэл авахын тулд интернетийн хурдыг нэмэгдүүлэх,
7. Судалгааны тайланг ойлгомжтой, тайлбартай болгох,
8. Статистик тооцооны аргачлал, ойлголтын талаар мэргэжлийн сургалт зохион байгуулах,
9. Гарын авлага, материалаар хангах, тоог хэрхэн ашиглах талаас нь сургах,
10. Одоо ажиллаж байгаа мэргэжлийн статистикч цөөхөн хүнд тусгайлсан мэргэжлийн сургалт хийх арга хэмжээ авах;
11. Эксэл програмын ашиглалтын сургалт хийх, функцүүдийг ашиглаж сурах хэрэгтэй
12. Статистик хариуцсан ажилтанд байвал зохих програм хангамжийн жагсаалт, вирусын программын эрх лицензтэй байх,
13. Орон нутгийн төлөвлөгчдийн гарын авлагад төлөвлөгчдөд хэрэгтэй хууль эрх зүйн баримт бичгүүд байх,
14. Шинээр томилогдсон, өөрчлөгдсөн удирдах ажилтнууд болон статистик хариуцсан ажилтнуудыг анхан шатны ойлголт, мэдлэг олгох гарын авлага, лавлах материалаар хангадаг байх;
15. Орон нутгийн статистикийн албад статистикийн анхан шатны сургалт хийх сургалтын материал, холбогдох мэдээллийн гарын авлага, лавлахын нөөцтэй байх шаардлагтай гэж үзсэн.

9.3. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүд

Статистикийн мэдээллийг хэрэглэгчдийн зорилтот бүлгийг тодорхойлохдоо ашиглах гол шалгуур нь албан ёсны статистик мэдээллийг өөрсдийн албан ажил, үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг байдал байх явдал гэж үзсэн.

Зорилтот бүлгээ дотор нь анхан шатны, дунд шатны, ахисан түвшний болон дээд түвшний гэж гэж ерөнхийд нь 4 ангилж авч үзлээ. Энэхүү ангиллын гол шалгуур нь албан ёсны статистик мэдээллийн ашиглалтын түвшин юм. Тухайлбал, статистик мэдээллийг өндөр түвшинд ашиглан академик болон бодлогын судалгаа, шинжилгээний ажил хийдэг хүмүүсийг дээд түвшний хэрэглэгчид гэж үзсэн. Дээд түвшний хэрэглэгчид судалгаа хийгдсэн Хэнтий болон Өвөрхангай аймагт маш ховор

байна гэж үзсэн. Харин судалгааны чанартай материал, танилцуулга, санал, дүгнэлт бэлтгэдэг, төлөвлөлт, хөгжлийн бодлогын асуудалд шаардлагатай тооцоо, судалгаанд статистикийн мэдээллийг өргөн ашигладаг хүмүүсийг ахисан түвшний зорилтот бүлэгт хамруулав. Энд аймгийн статистикийн хэлтэс, эдийн засаг, төлөвлөлтийн албад, хөдөө аж ахуйн салбар хариуцсан мэргэжилтнүүд, шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг ТББ-уудын холбогдох хүмүүс орно.

Харин орон нутгийн сэтгүүлчид, телевиз, хэвлэл мэдээллийн ажилтнууд, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнууд, төрийн байгууллагын зарим удирдах болон статистикийн мэдээллийг ажилдаа ашигладаг ажилтнуудыг дунд түвшний зорилтот бүлэгт хамруулав. Анхан шатны түвшний зорилтот бүлэгт жирийн иргэд, хөдөөгийн малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулан авч үзлээ.

Статистик мэдээллийн боловсролыг эзэмшүүлэх, дээшлүүлэхдээ хэрэглэгчдийн зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээтэй нягт уялдаатайгаар авч үзэх шаардлагатай юм. Орон нутгийн төр, захиргааны байгууллага, агентлагийн удирдах ажилтан, мэргэжилтэн, аж ахуйн нэгж, ТББ, багш, сурагчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэдийн төлөөлөл гээд мэдээллийн өөр өөр хэрэгцээтэй хэрэглэгчид байна. Цаашид эдгээр хэрэглэгчидтэй байнгын харилцаа, холбоотой ажиллахын тулд тэдгээрийг:

1. Төр, захиргааны байгууллага, албан газрын бодлого төлөвлөгөө боловсруулагч, шийдвэр гаргагчид.
2. Хэвлэл мэдээллийн ажилтнууд.
3. Боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсад.
4. Бизнес эрхлэгчид, төрийн бус байгууллагын ажиллагсад
5. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон иргэд, хөдөөгийн малчид гэсэн таван чиглэлд ангилж, хоорондоо зохих хэмжээний ялгаа, онцлогтой мэдээллээр үйлчилдэг болох шаардлагатай. Эдгээр зорилтот бүлгүүдийн эхнийхийг нь ахисан түвшин, хоёр, гурав, дөрөв дэх бүлгийн хэрэглэгчдийг дунд түвшин, тав дахь бүлгийг анхан шатны түвшний хэрэглэгчид гэж үзэх бололцоотой.

9.4. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд баримтлах бодлого

Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд ҮСХ-ноос дараах бодлогыг баримтлахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Нийт хүн амд статистикийн болон мэдээллийн боловсрол олгох иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх бодлогыг урт хугацаанд баримтлах, энэхүү тогтолцоо нь хүүхдэд бага боловсролын түвшингээс нь дээд боловсрол эзэмших хүртэлх бүх түвшинд нь статистикийн мэдээллийг ойлгох, үр ашигтай ашиглах шат дараалсан боловсрол олгоход чиглэгдсэн байх ёстой.
2. Статистикийн болон мэдээллийн боловсрол олгох тогтолцоонд хамтран оролцогч талуудыг өргөн хамруулах, үүнд БСШУЯ болон бүх шатны боловсролын байгууллага, албан ёсны болон захиргааны мэдээлэл бэлтгэн гаргадаг төрийн байгууллагууд, төв, орон нутгийн удирдлагууд, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд гэх мэт.
3. Хэрэглэгчдэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагааг явуулж, сурталчилгаа, сургалтын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, статистик мэдээллийг хэрэглэгчдэд шинэ бүтээгдэхүүн санал болгох бодлого явуулах,
4. Статистик мэдээллийн хэрэглээг өргөжүүлэх нь түүний чанар, үнэн бодит байдалд эерэгээр нөлөөлнө гэж үзнэ.
5. Төв, орон нутгийн хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг байнга үе шаттайгаар дээшлүүлж байдаг сургалтын төв байгуулах, сургалтын шаталсан хөтөлбөрөөр тогтмол сургалт явуулдаг тогтолцоог бий болгох бодлогыг урт хугацаанд баримталж, хэрэгжүүлэх шаардлагатай.
6. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсрол дээшилснээр статистикийн мэдээлэл, тоо баримтын эрэлт хэрэгцээ эрс өснө гэж тооцоолж, өсөн нэмэгдэх эрэлтэд нийцсэн нийлүүлэлтийг бүх талаар нэмэгдүүлэх урт хугацааны бодлого баримтлах шаардлагатай гэж үзэж байна.
7. Статистик мэдээллийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхдээ хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг байнга судлах, түүнийг харгалзан үзэх, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх арга хэлбэрийг олшруулах, ҮСХ-ны цахим хуудсанд тавих мэдээллийн төрөл, хэмжээг эрс нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
8. ҮСХ нь хэрэглэгчдийн мэдээллийн эрэлт хэрэгцээг үнэн бодит мэдээллээр хангахын тулд төрийн байгууллагуудын мэдэлд байгаа төрөл бүрийн мэдээллийн сангуудын үзүүлэлт, тоо мэдээллийн уялдааг хангах, харилцан мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох хууль эрх зүйн болон зохион байгуулалтын бүх талын арга хэмжээг дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

9.5. Статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратегийн зорилго, зорилтууд

Статистик тоо мэдээллийг ойлгож, ашиглах мэдлэг, чадварыг бүх түвшний хэрэглэгчдэд бий болгоход статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратегийн гол зорилго оршино.

Стратегийн зорилт -1. Нийт хүн амын дунд статистикийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны тусгайлсан хөтөлбөрийг 2016 - 2020 онд үе шаттай хэрэгжүүлэх,

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Бага, дунд, ерөнхий боловсрол болон дээд боловсролын түвшинд статистикийн боловсрол, ур чадварын ямар түвшинг олгосон байх стандартыг боловсруулж, мөрдүүлэх,
2. Дээрх стандартын дагуу БСШУЯ-тай хамтран боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрт статистикийн боловсрол олгох шаталсан тогтолцоог хөгжингүй орнуудын жишгээр бий болгох, одоогийн хөтөлбөрүүдийг эргэн харах,
3. ҮСХ нь Монгол Улсын Боловсролын Их Сургуультай хамтран залуу багш нарыг бэлтгэхдээ статистикийн тоо мэдээллийг сургалтан өргөн ашиглах чадвар олгох, ерөнхий боловсролын сурагчдыг улс орон, аймаг, сумынхаа талаар зохих мэдлэгтэй, түүнийгээ суралцах үйл ажиллагаатайгаа холбон ойлгох сэтгэлгээ, арга барилтай болгоход чиглүүлэх,
4. ҮСХ- нь өөрийн бүтцэд нийт хүн амд статистикийн мэдээллийн боловсролын түвшинг сайжруулах сургалтыг явуулж, сурталчилгаа хийдэг байнгын ажиллагаатай нэгжийг ажиллуулж, сургалт, сурталчилгааны тусгайлсан хөтөлбөрийг 2016 - 2020 онд үе шаттай хэрэгжүүлэх,
5. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх орчин үеийн зайны сургалтын тогтолцоог бий болгох,
6. Иргэд өөрийн улс орныхоо талаар, аймаг, сумынхаа талаар мэдээлэлтэй байж, төр захиргааны байгууллагын ажилд бодитой үнэлэлт дүгнэлт өгч чаддаг болгох сургалтыг ҮСХ болон орон нутгийн статистикийн байгууллагаас тогтмол явуулах нь иргэдийн төрийн үйл хэрэгт ухамсартай оролцох оролцоог нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Стратегийн зорилт-2. Орон нутгийн хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг 2016-2021 онд үе шаттай дээшлүүлэх,

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. ҮСХ-ноос орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдэд зориулсан сургалт, сурталчилгааны тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх,
2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтсүүд орон нутгийн хэрэглэгчдийн статистик мэдээллийн эрэлт хэрэгцээг тогтмол судалж, тэрхүү хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааг ҮСХ-той хамтран хэрэгжүүлэх,
3. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтсүүдийг орон нутгийн хэрэглэгчдэд статистик мэдээллийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг тогтмол явуулдаг дэд хөтөлбөртэй болгож, түүнийг хэрэгжүүлдэг болгох,

Стратегийн зорилт-3. Статистик мэдээллийн ойрын ирээдүйн өсөн нэмэгдэх хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн арга зүйгээр бэлтгэсэн үнэн бодит тоо мэдээллээр хангах цар хэмжээ болон арга, хэлбэрийг шинэ түвшинд гаргах,

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Статистикийн мэдээллийг www.1212.mn хаягаар хэрэглэгчдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа одоогийн үзүүлэлтийн цар хүрээ, тэдгээрийг аймаг, сум, багаар илүү задаргаатай хүргэх хэмжээг эрс нэмэгдүүлэх,
2. Статистикийн мэдээллийн www.1212.mn цахим хуудсанд өндөр түвшний хэрэглэгчдэд зориулсан олон жилийн динамик эгнээ бүхий үзүүлэлтүүдийг байршуулж, төлбөртэйгөөр ашиглуулах,
3. Статистикийн төв, орон нутгийн байгууллагууд аль болох хэрэглэгчдийн зорилтот бүлэг тус бүрийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг шинэ үйлчилгээг ажилдаа нэвтрүүлэх,
4. Статистикийн жил бүрийн эмхтгэлд оруулах үзүүлэлтүүдийг олшруулах, хэрэглэгчдэд хямд үнэтэйгээр хүргэх арга хэлбэрийг улам боловсронгуй болгох,
5. Төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудын үзүүлэлт, тоо мэдээллийн уялдааг хангах, харилцан мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох хууль эрх зүйн болон зохион байгуулалтын бүх талын арга хэмжээг авч, алсдаа төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах.

6. Төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг хэрэглэгчдэд ашиглуулах дүрэм, журмыг боловсруулан хэрэгжүүлэх.

Стратегийн зорилт-4. Статистик мэдээллийг хэрэглэгчдэд зориулсан орчин үеийн шинэ бүтээгдэхүүн бий болгож, шинэ эрэлтийг үүсгэх

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Үүрэн телефоны оператор компаниудтай хамтран гар утасны тусгай апликайшн бий болгож,, түүнийг ашиглан хэрэглэгчдэд гар утас уруу нь статистикийн мэдээлэл дамжуулах, сургалт, сурталчилгаа явуулах,
2. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг, сурагчдын дэвтрийн хавтас зэрэгт статистикийн мэдээлэл, сурталчилгааг байнга хэвлэн хүргэх,
3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон их, дээд сургуулийн оюутнуудын дунд статистикийн шинжлэх ухааны мэдлэг, практик ур чадварыг түвшинг шалгасан тусгай олимпиадыг жил бүр зохион байгууулах.

Стратегийн зорилт-5. Ахисан түвшний хэрэглэгчдэд зориулсан тусгай сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх,

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагын бодлого төлөвлөгөө боловсруулагч, шийдвэр гаргагчсудад статистикийн тоо, мэдээллийн үндсэн дээр бодлого шийдвэрийг гаргадаг арга барил, чадавхыг төлөвшүүлэх, тэдэнд тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүйг эзэмшүүлэх, сургалт тогтмол явуулах,
2. Аймгийн статистикийн хэлтсийн ажилтнуудад сүүлийн үеийн программ хангамжид гарсан өөрчлөлтийг цаг алдахгүй эзэмшүүлэх, мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх арга зам, хэрэглэгчдийн янз бүрийн бүлэгтэй ажиллах арга барил эзэмшүүлэх, мэдээллийн чанарт үнэлгээ өгөх чадварыг дээшлүүлэх чиглэлд түлхүү анхаарах.

Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо “Үндэсний бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх MON/13/201 төсөл”-ийн хүрээнд хийсэн “Орон нутгийн түвшин дэх статистикийн мэдээллээр хангах одоогийн боломж, дутагдалтай байдлыг үнэлж,

хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан” болон Хэнтий, Өвөрхангай аймгуудад явуулсан чанарын судалгааны үр дүнг ашигласан болно.

9.6. Статистикийн мэдээллийн боловсрол олгох нөхцөл, хэлбэр, арга зам

Орон нутгийн хэрэглэгчдэд мэдээллийн боловсрол олгоход энэхүү бодлогын баримт бичиг чиглэгдсэн болно. Нийслэлийн хэрэглэгчдээс орон нутгийн хэрэглэгчид хэд хэдэн ялгаатай асуудал байгааг боловсрол олгох хэлбэрүүдийг сонгон авахдаа харгалзан үзлээ. Орон нутагт шилэн кабель татагдаж, интернет ашиглах бололцоо харьцангуй сайжирсан байна. Судалгаанд хамрагдсан 2 аймгийн 37 сумдын 33 нь шилэн кабелиар холбогдсон байна. Нийт 45 баг шилэн кабель шууд ашиглах бололцоотой, харин 141 баг сумын төвд ирж интернет ашиглаж байгаа бол 9 баг модемаар интернет ашиглаж байна. Хэдийгээр ихэнх сумд шилэн кабелиар холбогдсон ч интернет байнга тасардаг, хурд маш муу байдал ажиглагдлаа. Энэ нь сумдад интернет ашиглалтын зардлаа төлж чадахгүй болдгоос хурдыг бууруулах зохицуулалт хийдэг бололтой. Нэгэнт суурилагдсан шилэн кабелиг оператор компаниар дамжуулан ашиглаж байгаатай холбоотойгоор ашиглалтын зардал өндөр болдог гэж орон нутгийнхан тайлбарлаж байна. Энэ байдалд дүн шинжилгээ хийж, хамгийн бага зардлаар орон нутагт интернет ашиглах нөхцөл бололцоог бүрдүүлэх асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны явцад 669 хэрэглэгчдийн цахим шуудангийн хаягийг бүртгэн авч урьдчилан боловсруулсан хуваарийн дагуу төрөл бүрийн мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх ажил хийх явцад орон нутгийн хэрэглэгчдийн интернет ашиглалт туйлын хангалтгүй байдаг нь харагдлаа. Иймд манай баг хэрэглэгчдээр ҮСХ-ны www.1212.mn сайтыг ашигладаг болгох олон төрлийн ажил зохиолоо. Зарим хэрэглэгчидтэй пэйс (FB) ашиглаж харилцах, зарим хэсэг хэрэглэгчдэд интернет ашиглахыг биечлэн зөвлөх, ажил амьдралд нь хэрэгцээтэй, сонирхолтой материал илгээх зэрэг аргуудыг ашигласан болно. Гэвч хэрэглэгчдийг интернет ашиглаж, статистикийн мэдээлэлтэй танилцдаг болгох талаар маш их ажил хийх шаардлагатай нь ажиглагдлаа. Энэ байдлаас үндэслэн хэрэглэгчдэд мэдээллийн боловсрол олгох ажлыг интернетийн хэрэглээнд сургахаас эхлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Орон нутгийн интернет ашиглах бололцоог сайжруулах, ашиглалтын зардлыг бууруулах нь мэдээллийн боловсрол олгох чухал нөхцөл гэдгийг харгалзан үзэхгүй бол энэ ажилд үр дүн гарахгүй гэдэг нь харагдлаа. Хэрэглэгчдийг статистикийн мэдээлэл байнга ашигладаг болгоход зорилтот бүлэг тус бүрийн онцлогт тохирсон, ойлгоход хялбар мэдээллийг цаг хугацаа алдахгүй дамжуулах явдал нэн чухал юм. Мэргэжлийн хүмүүст зориулагдсан, маш олон үзүүлэлттэй, нүсэр мэдээлэлд хэрэглэгчид анхаарлаа хандуулахгүй, танилцахгүй орхидог, дахин ашиглах гэж сонирхдоггүй байдал ажиглагдлаа. Иймд хэрэглэгчдийн зорилтот бүлэг тус бүрийн онцлогт нийцсэн мэдээлэл тусгайлан бэлтгэж хүргэх шаардлагатай байна.

Хэрэглэгчдийг мэдээллийн боловсролтой болгоход статистикийн тоо, мэдээг төлөвлөлт болон сургалт, сурталчилгааны ажилдаа хэрхэн ашиглаж байгаа талаар хэрэглэгчдийн туршлагыг судалж, сурталчлах явдал чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Түүнчлэн иргэд, сургуулийн сурагчдын статистикийн мэдлэгийг сорьсон төрөл бүрийн тэмцээн, эссе бичлэгийн уралдаан, “АХА” нэвтрүүлэг явуулж, нийтэд сурталчлах хэлбэр ихээхэн өгөөжтэй болох нь ажиглагдлаа.

Орон нутгийн хэрэглэгчдэд мэдээллийн боловсрол олгоход дараах хэлбэрүүдийг ашиглахаар энэхүү баримт бичигт тусгалаа. Үүнд:

1. Эхний ээлжид сум бүрт статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчдийн багийг бүрдүүлж, тэд нараар дамжуулан нийт хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх чиглэл барьж ажиллах нь зүйтэй гэж үзлээ. Өнөөгийн нөхцөлд орон нутгийн хэрэглэгчид интернет байнга ашиглах, статистик мэдээллийг тогтмол хүлээн авах арга барилд хараахан суралцаагүй, ач холбогдлыг нь бүрэн ойлгоогүй байна. Энэ ажлыг эхлүүлэхэд ихээхэн цаг, уйгагүй оролдлого шаардагдана. Зөвхөн хэрэглэгчдээ тогтоож, хаягтай болсноор асуудал шийдэгдэхгүй. Эхний ээлжид явуулсан мэдээлэлд хариу ирүүлэхгүй, цахим шуудангаа шалгахгүй хүндрэл гарч байна. Гар утсанд давхар мэдээлэл явуулах, пэйс ашиглах зэрэг боломжтой бүх аргыг ашиглаж хэрэглээг төлөвшүүлэх хэрэгтэй. Энэ ажлыг аймгийн статистикийн хэлтэс хариуцаж хийнэ.
2. Эхэлж явуулах мэдээллийн чанараас цаашдын хэрэглээ хамаарахыг анхаарч ажиллах шаардлагатай байна. Юуны өмнө хийж байгаа ажил тухайн хүний ажил, амьдралд дэмжлэг үзүүлэх зорилготой гэдгийг мэдэгдэх шаардлагатай. Дараа нь цаашид хэрхэн хамтарч ажиллах чиглэлээ танилцуулна. Тухайн сум, баг, аймгийн

тухай, улсын хэмжээнд танай байгууллага ямар байр суурь эзэлдэг, аймгийн сумдын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хооронд нь зэрэгцүүлж харуулах, тухайн сум, багийн байгаль, газар зүйн онцлог, хүн малын тоо, боловсрол, эрүүл мэндийн байгууллага зэрэг хамгийн ойрхон мэдээллүүдийг хүргэх замаар аймгийн статистикийн хэлтэстэй хамтарч ажиллахын ач холбогдлыг ойлгуулахад анхаарах нь чухал байна. Өнөө үед статистикийн хэлтэс ямар ажил эрхэлдэг, тэр нь хэрэглэгчдэд ямар ач холбогдолтой талаар нийт хэрэглэгчдийн ойлголт хангалтгүй байдаг гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ байдлыг өөрчлөхийн тулд өмнөх ажлын арга барилаа шинэчлэх зайлшгүй шаардлагатай болж байна.

3. Зорилтот бүлэг тус бүрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдээллээр үйлчлэх нь хэрэглээг төлөвшүүлэх чухал нөхцөл гэдгийг анхаарч ажиллах нь чухал байна. Бүх хүмүүст нэг адил мэдээлэл дамжуулаад байвал хүссэн үр дүнд хүрэхгүй. Боловсрол, эрүүл мэнд, банк, даатгал гээд салбарын чанартай байгууллагад ажилладаг хүмүүст тухайн салбарын хөгжлийн байдал, ажиллагсдын тоо, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтэц, нэг ажилтанд ногдох харьцуулсан үзүүлэлтүүд зэрэг мэдээлэл илэрхий сонирхол татаж байгаа нь судалгаанаас харагдлаа. Энэ чиглэлийн мэдээллийг ҮСХ төвлөрсөн журмаар бэлтгэж, аймгийн статистикийн хэлтсээр дамжуулан зорилтот бүлгүүдэд хүргэх шаардлагатай.
4. Хэрэглэгчидтэйгээ эргэх холбоо тогтоож, эрэлт хэрэгцээг нь судлах, санал хүсэлтийнх нь дагуу мэдээлэл илгээж ажиллах нь хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал нөхцөл мөн.
5. Нийт хэрэглэгчдийн эдийн засгийн мэдлэгт дэм болох тайлбар зөвлөгөө өгөх, тодорхой нэг статистик үзүүлэлтийн өөрчлөлтийн урт хугацааны хандлага, түүний учир шалтгааныг хэрэглэгчдэд ойлгомжтой энгийн үгээр тайлбарлаж хүргэх нь тэдний мэдээллийн боловсролыг төлөвшүүлэх чухал хүчин зүйл мөн. Энэ чиглэлээр тухайн жилд ямар давтамжтай, ямар үзүүлэлтүүдээр мэдээлэл өгөх төлөвлөгөөг ҮСХ-ны хэмжээнд боловсруулж, хэрэгжилтийг аймгийн статистикийн хэлтсээр дамжуулан зохион байгуулах нь зүйтэй.
6. Мэдээллийн боловсрол олгоход хэрэглэгчдийг идэвхжүүлэх аргуудыг өргөн ашиглах шаардлагатай. Зорилтот бүлэг тус бүрийн онцлогт тохирсон олон төрлийн идэвхжүүлэлт байх бололцоотой. Багш нарын дунд сургалтдаа статистик мэдээлэл өргөн ашиглаж байгаа багшийг шалгаруулж, урамшуулах, туршлагыг

нь нийтийн хүртээл болгох, сургуулийн захиргаа, аймгийн боловсролын хэлтэст уламжлах г.м.

Сурагчдын дунд статистикийг хэн сайн мэдэх вэ? сэдэвт зохион бичлэгийн болон мэдлэг сорих уралдаан зохиох, радио, телевизээр сурталчлах, статистикийн чиглэлээр их, дээд сургуульд суралцахыг санал болгох г.м. Төр, захиргааны байгууллагын ажилтнуудын дунд эрхэлсэн ажилдаа статистик аргуудыг ашиглаж, дүн шинжилгээ хийх, илтгэл бэлтгэх уралдаан зарлаж урамшуулах, ажилладаг байгууллагад нь уламжлах, статистикийн боловсролын тодорхой түвшинг эзэмшсэнийг гэрчлэх батламж гардуулах г.м. Нийт хэрэглэгчдийн дунд ч иймэрхүү ажил өрнүүлэх бололцоотой байна.

7. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдэд тухайн үед боловсрогдсон статистик мэдээллийг хэрхэн ашиглах асуудлаар хичээл заах нь чухал байна. Заах хичээлийг ҮСХ нэгдсэн журмаар боловсруулж, сургалт хэрхэн зохион байгуулах зөвлөгөөг аймгийн статистикийн хэлтэст хүргэж ажиллах бололцоотой. Дэлхийн статистикийн өдөр, Монголын статистикийн албаны өдөр зэрэг тэмдэглэлт үеэр болон хэрэглэгчдийн нэгдсэн уулзалт, семинарыг ашиглан ийм ажлыг зохион байгуулж болно.
8. ҮСХ-ны www.1212.mn сайтад байгаа мэдээлэлд анализ хийж, дүгнэлт гаргасан бэлэн материалыг дээд, дунд түвшний хэрэглэгчдэд хүргэх нь тоо мэдээлэл ашиглах сонирхол төрүүлэх, арга барил төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

9.7. Стратегийн төсөөлж буй хүрэх үр дүн

1. Хүн амын дунд статистикийн тоо мэдээлэл ашиглах чадвартай хүмүүсийн тоо эрс нэмэгдэнэ.
2. Хэрэглэгчдийн зүгээс статистикийн мэдээллийн эрэлт хэрэгцээ өсөж, ялангуяа ҮСХ –ны цахим хуудас www.1212.mn -ээс мэдээлэл авдаг хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдэнэ.
3. ҮСХ-ноос хэвлэмэл байдлаар тараадаг статистикийн эмхтгэл, сар бүрийн бюллетенийг хэрэглэгчдийн тоо өснө.
4. Хэрэглэгчдийн зүгээс ҮСХ болон орон нутгийн статистикийн хэлтсүүдээс хүсдэг тоо мэдээллийн хэмжээ, цар хүрээ өргөжинө.

5. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнуудын статистикийн тоо мэдээлэл ашиглах түвшин, түүнд дүн шинжилгээ хийх чадвар дээшилнэ.
6. ХАӨМС болон боловсролын мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан зэрэг төрийн байгууллагуудын хөтөлдөг мэдээллийн сангуудыг ажилдаа өргөн ашигладаг болно.
7. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсрол дээшилснээр тоо мэдээллийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, тэр хэмжээгээр ҮСХ болон орон нутгийн статистикийн хэлтсүүдэд статистик мэдээллийн чанар, үнэн бодит байдалд эерэгээр нөлөөлнө.

10. ХЭРЭГЛЭГЧДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ

Мэдээллийн боловсрол олгоход сайтар боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх гарын авлага нэн чухал. Сургалтын төлөвлөгөө нь жил бүр өөрчлөгдөж байхгүй бол статистикийн байгууллагын өмнө тавигдаж байгаа зорилтыг тусган илэрхийлж чадахгүй. Иймд бид хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх жилийн сургалтын төлөвлөгөө боловсруулж ажиллах зөвлөмж, сургалтын модуль, түүнийг хэрэгжүүлэхэд эн тэргүүнд ашиглах гарын авлага боловсруулах зорилт тавьсан болно.

10.1. Жилийн сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөмж

1. Жил бүр орон нутгийн хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, ҮСХ-ны дарга баталж, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллана
2. Төслийн баг 2016 оны загвар төлөвлөгөө боловсруулна.
3. Энэхүү төлөвлөгөө нь жил бүр өөрчлөгдөж байх шаардлагатай. Жилийн төлөвлөгөөнд тухайн жилд статистикийн байгууллагын өмнө тавигдаж байгаа зорилт, зорилгуудтай уялдсан байх шаардлагатай.
4. Жил бүр орон нутгийн хэрэглэгчдээс сургалтын эрэлт хэрэгцээ, сонирхсон сэдвийг нь судалсны үндсэн дээр тухайн жилийн сургалтын хөтөлбөрийг өөрчлөн боловсруулна.
5. Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэхдээ сар, жилийн эмхтгэл, танилцуулгад тавигддаг мэдээлэл, хүснэгтүүдийг шууд хуулбарлаж дамжуулахаас аль болох зайлсхийх шаардлагатай. Эдгээр мэдээлэл үндсэн хэрэглэгчдэд өмнө нь хүргэгдсэн учраас тэдгээрийг давтан мэдээлэх нь орон нутгийн хэрэглэгчдэд нэмэлт ачаалал үүсгэх, мэдээлэл нь сонирхол төрүүлэхүйц болж чадахгүйд хүргэнэ. Иймд тодорхой нэг үзүүлэлтийн өөрчлөлт, уг ойлголтын агуулгыг янз бүрийн хэрэглэгчдийн өргөн давхаргын онцлогт тохирсон, энгийн, ойлгоход хялбархан хэлбэрээр тайлбарласан, урт хугацааны өөрчлөлт, хандлагыг тусгасан, үзүүлэлтийн өөрчлөлтийг зураг, график, инфографикаар илэрхийлдэг байх нь чухал байна.
6. Мэдээллийг илүү сонирхолтой, хэрэглэхүйц болгохын тулд хэрэглэгчдийн зорилтот бүлэг тус бүрт ялгаатай мэдээлэл дамжуулахад онцгой анхаарах

шаардлагатай. Тухайлбал, багш, бизнес эрхлэгч, төр, захиргааны байгууллагын албан хаагчид, иргэд гэх мэт хэрэглэгчдийн бүлгүүдийн эрэлт, хэрэгцээ ихээхэн ялгаатай байгаа учраас тэр онцлогийг нь тусгасан мэдээлэл өгч чадвал мэдээллийг байнга хэрэглэдэг болно. Товчоор хэлбэл, бүх хэрэглэгчдэд дандаа бодлого, шийдвэр гаргагчдад ашиглагдах мэдээлэл дамжуулаад байвал сүүлдээ тэдгээр мэдээлэлтэй танилцах сонирхолгүй болдгийг судалгаа харууллаа.

7. Дамжуулах мэдээллийг хэрэглэгчид илүү ойлгомжтой болгохын тулд инфографик дүрслэлийг түлхүү ашиглах чиглэл баримталбал зохино.
8. Зайны сургалтын хэлбэрийг ашиглахад түлхүү анхаарах шаардлагатай.
9. Видео хичээлүүд бэлтгэж нэгдсэн мэдээллийн сан болон ҮСХ-ны www.1212.mn вэб хуудсанд байрлуулах, хэрэглэгчдэд онлайн зөвлөгөө өгөх булан ажиллуулах шаардлагатай.

10.2. Орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх сургалтын модуль

А. Сургалтын модуль-1. Анхан шатны түвшний зорилтот бүлэгт зориулсан сургалт (Нийт хугацаа: 6 цаг, Зорилтот бүлэг: иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид)

Сэдэв №1. Статистикийн мэдээлэл, тоо баримтыг хүмүүс амьдрал ахуй, ажил төрөлдөө хэрхэн хэрэглэх боломжтой вэ?

Сургалтын зорилго: Хүмүүс өөрсдийн хэрэгцээтэй статистик мэдээллийнхээ талаар ярилцаж, ҮСХ-ноос гаргадаг хэвлэмэл бүтээгдэхүүн, түүнд орсон гол гол мэдээллийн талаар ойлголттой болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага

Сэдвийн задаргаа: Жирийн иргэдэд хэрэгцээтэй зарим мэдээлэл, бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй байж болох мэдээллийн тухай, мэдээллийг хаанаас хэрхэн олж авах арга зам, ҮСХ-ноос хэвлүүлдэг статистикийн эмхтгэл, бюллетень, түүний гол үзүүлэлтүүд

Сэдэв № 2. Монгол Улсын Статистикийн албаны зохион байгуулалт, мэдээллийн урсгал, ҮСХ –ноос явуулдаг томоохон тооллого, судалгаанууд

Сэдвийн зорилго: Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгал, мэдээлэл цуглуулах эрх зүйн орчин, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Статистикийн албаны үүсэл хөгжил, түүхийн талаар товч дурдаад статистикийн болон хүн ам, орон сууцны тооллогын талаарх хуулийн гол заалтуудыг танилцуулна. Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгалын талаар танилцуулж, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Сэдэв № 3. ҮСХ-ны цахим хуудаснаас (www.1212.mn-наас) мэдээлэл хайж олох тухай

Сургалтын зорилго: ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) бүтцийн тухай мэдээлэл олж авч, уг цахим хуудаснаас статистикийн мэдээллийг хайж олж авах, түүнээ ашиглан хүснэгт, график байгуулах чадвар эзэмшинэ.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) бүтцийн тухай танилцуулах, гол үзүүлэлтүүдийг аймаг, сум, багаар хэрхэн хайж олох аргыг харуулна. Эдгээр үзүүлэлтүүдээ үндэслэн хүснэгт, график байгуулах боломжийг харуулна.

Сэдэв № 4. Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС), түүний зориулалт, ач холбогдол, бүтэц

Сургалтын зорилго: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүд, мэдээллийг бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар ойлголт, мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт өгнө.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүдийн талаар авч үзнэ. ХАӨМС-г мэдээллийн бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар танилцуулна. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан орон нутгийн түвшинд шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв № 5. Улс орны эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийн агуулга, тооцдог арга зүй, эх үүсвэр

Сургалтын зорилго: Улс орны эдийн засгийн хөгжлийн талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас цуглуулдаг, ямар эх үүсвэртэй байдаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт өгнө.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), Үндэсний нийт орлого, нэг хүн амд ногдох ДНБ, инфляци, хэрэглээний үнийн индекс, төсвийн орлого, зарлага, төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд, гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулахад хэрхэн ашиглах, харьцуулан санал, дүгнэлт гаргах талаар тодорхой жишээгээр харуулна.

Сэдэв № 6. Хөдөө аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Хөдөө аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүдийн талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Мал аж ахуйн болон газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох арга зүй, эдгээр үзүүлэлтүүдийг орон нутгаар цуглуулдаг сувгуудын талаар авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар тодорхой жишээтэйгээр харуулна.

Сэдэв № 7. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Хүн ам зүйн ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Хүн амын дундаж тоо, хүн амын нас, хүйсийн бүтэц, төрөлт нас баралт, шилжих хөдөлгөөн, хүн ам зүйн ачаалал, төрөлтийн ерөнхий болон тусгай коэффициент, хүн амын дундаж наслалт, гэрлэлт, цуцлалт гэх мэт. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар тодорхой жишээтэй харуулна.

Сэдэв № 8. Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Хүн амын ажил эрхлэлтийн ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн ам, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин зэрэг үзүүлэлтүүд, ажиллагчид, ажилгүйчүүд, хөдөлмөрийн насны хүн амын талаарх

ойлголтыг хамруулна. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Б. Сургалтын модуль-2. Дунд шатны түвшний зорилтот бүлэгт зориулсан сургалт

(Нийт хугацаа: 9 цаг, Зорилтот бүлэг: Хэвлэл мэдээллийн ажилтнууд, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсад, төрийн бус байгууллагууд зарим төрлийн бизнес эрхлэгчид)

Сэдэв № 1. Монгол Улсын Статистикийн албаны зохион байгуулалт, мэдээллийн урсгал, ҮСХ –ноос явуулдаг томоохон тооллого, судалгаанууд

Сэдвийн зорилго: Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгал, мэдээлэл цуглуулах эрх зүйн орчин, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Статистикийн албаны үүсэл хөгжил, түүхийн талаар товч дурдаад статистикийн болон хүн ам, орон сууцны тооллогын талаарх хуулийн гол заалтуудыг танилцуулна. Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгалын талаар танилцуулж, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Сэдэв №2. ҮСХ-ны цахим хуудаснаас (www.1212.mn-наас) мэдээлэл хайж олох тухай

Сургалтын зорилго: ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) бүтцийн тухай мэдээлэл олж авч, уг цахим хуудаснаас статистикийн мэдээллийг хайж олж авах, түүнээ ашиглан хүснэгт, график байгуулах чадвар эзэмшинэ.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) бүтцийн тухай танилцуулах, гол үзүүлэлтүүдийг аймаг, сум , багаар хэрхэн хайж олох аргыг харуулна. Эдгээр үзүүлэлтүүдээ үндэслэн хүснэгт, график байгуулах боломжийг харуулна.

Сэдэв №3. Улс орны эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийн агуулга, тооцдог арга зүй, эх үүсвэр

Сургалтын зорилго: Улс орны эдийн засгийн хөгжлийн талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас цуглуулдаг, ямар эх үүсвэртэй байдаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), Үндэсний нийт орлого, нэг хүн амд ногдох ДНБ, инфляци, хэрэглээний үнийн индекс, төсвийн орлого, зарлага, төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд, гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулахад хэрхэн ашиглах, харьцуулан санал, дүгнэлт гаргах талаар тодорхой жишээгээр харуулна.

Сэдэв №4. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Хүн ам зүйн ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Хүн амын дундаж тоо, хүн амын нас, хүйсийн бүтэц, төрөлт нас баралт, шилжих хөдөлгөөн, хүн ам зүйн ачаалал, төрөлтийн ерөнхий болон тусгай коэффициент, хүн амын дундаж наслалт, гэрлэлт, цуцлалт гэх мэт. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар тодорхой жишээтэйгээр харуулна.

Сэдэв № 5. Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Хүн амын ажил эрхлэлтийн ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн ам, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин зэрэг үзүүлэлтүүд, ажиллагчид, ажилгүйчүүд, хөдөлмөрийн насны хүн амын талаарх ойлголтыг хамруулна. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв №6. Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС), түүний зориулалт, ач холбогдол, бүтэц

Сургалтын зорилго: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүд, мэдээллийн бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар ойлголт, мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүдийн талаар авч үзнэ. ХАӨМС-г мэдээллийн бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар танилцуулна. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан орон нутгийн түвшинд шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв № 7. Ядуурал, амьжиргааны түвшний үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Ядуурал, амьжиргааны түвшний талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Ядуурлын хамралтын түвшин, ядуурлын гүнзгийрэлт, мэдрэмж зэрэг үзүүлэлтийг тооцох арга, гол агуулгыг танилцуулах, өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны талаар товч ойлголт өгөх, ядуурлын бусад судалгааны талаар танилцуулах. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв № 8. Боловсролын статистик үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Боловсролын салбарын үйл ажиллагааны талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Бичиг үсгийн мэдлэгийн түвшин, сургууль завсардалтын хувь, хамран сургалтын цэвэр болон бохир жин, анги дэвшилт, улиралтын хувь, нэг багшид ногдох сурагчдын тоо, сургууль, багш нарын тоо, элсэгчид болон төгсөгчдийн тоо, 1-р ангид элсээд 5 –р анги хүртэл дэвшин суралцагчдын хувь, суралцагчдын хүйсийн харьцаа, ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь, улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын салбарын зардлын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв № 9. Боловсролын мэдээллийн сангийн тухай

Сургалтын зорилго: БСШУЯ –ны боловсролын мэдээллийн нэгдсэн сангийн зориулалт, ач холбогдол, бүтэц, гол үзүүлэлтийн талаар ойлголт мэдлэгтэй болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Боловсролын боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сангийн зориулалт, ач холбогдол, уг санг байгуулах талаар БСШУЯ-наас хийж байгаа ажил, үр дүнг танилцуулна. Энэхүү мэдээллийн сангийн бүтэц, үндсэн үзүүлэлтүүд, мэдээллийг түүнд хэн хэрхэн оруулдаг, ашиглах боломж, ажиллах зарчмын талаар авч үзнэ.

Сэдэв 10. Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүд, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Сургалтын зорилго: Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас ямар эх үүсвэрээс гаргадаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Нялхсын эндэгдэл, эхийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, дундаж наслалт, халдварт өвчнөөр өвчлөгсөд, 10000 хүнд ногдох зонхилох өвчнөөр эмчлүүлэгчдийн тоо болон хорт хавдраар өвчсөгсөд зэрэг үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна.

Сэдэв № 11. Үзүүлэлтүүдийн энгийн харьцуулалтын арга: олон улсын түвшин дэх зэрэгцүүлэлт, аймаг, сумдын үзүүлэлтийн зэрэгцүүлэлт

Сургалтын зорилго: Статистикийн тоо үзүүлэлтүүдийг харьцуулан шинжлэх, түүнийгээ үндэслэн дүгнэлт гаргах энгийн ур чадвар олгоно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага

Сэдвийн задаргаа: Тодорхой үзүүлэлтүүдээр олон улсын түвшинд зэрэгцүүлэлт хийсэн жишээ болон аймгуудын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийг дундаж, дээд түвшин, хамгийн доод түвшинтэй зэрэгцүүлсэн жишээ баримт ашиглан заана.

Сэдэв 12. EXCEL программ ашиглан хүснэгт, график байгуулах

Сургалтын зорилго: EXCEL программ ашиглан хүснэгт, график байгуулах чадвар эзэмшүүлнэ.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: Статистикийн хүснэгт гэж юу болох, түүнд тавигдах үндсэн шаардлагуудыг авч үзэж, EXCEL программ ашиглан хүснэгт байгуулах дадал олгоно. Статистикийн графикуудын төрөл, түүнд тавигдах үндсэн шаардлагуудын талаар авч үзэж, EXCEL программ ашиглан төрөл бүрийн графикуудыг хэрхэн байгуулах талаар заана.

В. Сургалтын модуль-3. Ахисан түвшний зорилтот бүлэгт зориулсан сургалт

(Нийт хугацаа: 12 цаг 45 минут, **Зорилтот бүлэг:** Төр, захиргааны байгууллага, албан газрын бодлого төлөвлөгөө боловсруулагч, шийдвэр гаргагчид)

Сэдэв № 1. ҮСХ-ны цахим хуудаснаас (www.1212.mn-нээс) мэдээлэл хайж олох тухай

Сургалтын зорилго: ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) бүтцийн тухай мэдээлэл олж авч, уг цахим хуудаснаас статистикийн мэдээллийг хайж олж авах, түүнээ ашиглан хүснэгт, график байгуулах чадвар эзэмшинэ.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдэв № 2. Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС), түүний зориулалт, ач холбогдол, бүтэц

Сургалтын зорилго: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүд, мэдээллийн бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар ойлголт, мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Интернетийн сүлжээтэй олон компьютер бүхий орчинд шууд дадлага олгох сургалт

Сэдвийн задаргаа: ХАӨМС ямар зориулалттай, хэрхэн ажилладаг, тэнд мэдээллийг хэрхэн оруулдаг, түүний ач холбогдол, энэхүү санд оруулсан үзүүлэлтүүдийн талаар авч үзнэ. ХАӨМС-г мэдээллийн бусад сангуудтай хэрхэн уялдуулдаг, хүн амын завсрын тооллогод хэрхэн ашиглах талаар танилцуулна. Эдгээр үзүүлэлтүүдээ ашиглан орон нутгийн түвшинд шийдвэр гаргах, харьцуулан дүгнэлт хийх талаар жишээтэй харуулна

Сэдэв № 3. Монгол Улсын Статистикийн албаны зохион байгуулалт, мэдээллийн урсгал, ҮСХ –ноос явуулдаг томоохон тооллого, судалгаанууд

Сэдвийн зорилго: Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгал, мэдээлэл цуглуулах эрх зүйн орчин, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Статистикийн албаны үүсэл хөгжил, түүхийн талаар товч дурдаад статистикийн болон хүн ам, орон сууцны тооллогын талаарх хуулийн гол заалтуудыг танилцуулна. Манай орны статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, албан ёсны болон захиргааны мэдээллийн урсгалын талаар танилцуулж, ҮСХ-ноос зохион байгуулдаг томоохон тооллого, түүвэр судалгааны талаар ойлголт, мэдлэг олгоно.

Сэдэв № 4. Улс орны макро эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийн агуулга, тооцдог арга зүй, эх үүсвэр

Сургалтын зорилго: Улс орны макро эдийн засгийн ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас цуглуулдаг, ямар эх үүсвэртэй байдаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал, дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), Үндэсний нийт орлого, нэг хүн амд ногдох ДНБ, инфляци, хэрэглээний үнийн индекс, төсвийн орлого, зарлага, төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд, гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүдийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Мөн Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь, татварын ачаалал, гадаад өрийн дарамт зэрэг үзүүлэлтүүдийг авч үзнэ. Эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулахад хэрхэн ашиглах, харьцуулан санал, дүгнэлт гаргах талаар тодорхой жишээгээр харуулна.

Сэдэв № 5. Улс орны нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийн агуулга, тооцдог арга зүй, эх үүсвэр

Сургалтын зорилго: Улс орны нийгмийн хөгжлийн талаар ямар гол үзүүлэлтүүд байдаг, тэдгээрийн гол агуулга, хэрхэн тооцдог, хаанаас цуглуулдаг, ямар эх үүсвэртэй байдаг талаар мэдлэгтэй болж, эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, санал дүгнэлт бэлтгэхэд ашиглах талаар тодорхой ойлголт авна.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Хүн ам зүйн болон өрхийн үндсэн үзүүлэлтүүд, ажил эрхлэлт, ажилгүйдлийн үндсэн үзүүлэлтүүд, ядуурал, амьжиргааны түвшний үзүүлэлтүүд, боловсрол, эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийн агуулга, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийн талаар мэдлэг олгоно. Эдгээр үзүүлэлтүүдийг шийдвэр гаргах,

бодлого боловсруулахад хэрхэн ашиглах, харьцуулан санал, дүгнэлт гаргах талаар тодорхой жишээгээр харуулна.

Сэдэв № 6.1. Монгол Улсын хөгжлийн түвшинг олон улсын хэмжээнд зэрэгцүүлсэн байдал

Сургалтын зорилго: Монгол Улсын хөгжлийн ерөнхий түвшинг дэлхийн бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн олон улсын түвшний судалгааны үр дүнг үндэслэн мэдээлэл мэдлэг олгож, улс орныхоо цаашдын хөгжлөө төлөвлөхөд юунд анхаарах шаардлагатайг эндээс олж мэдэх болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Хөгжлийн ерөнхий түвшин, эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгмийн хөгжлийн түвшин, өрсөлдөх чадварын түвшингээр Монгол Улс хаана явааг харуулж, ямар үзүүлэлт дээр хоцрогдож, цаашид юуг анхаарах шаардлагатайг авч үзнэ.

Сэдэв № 7. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал, сорилт, хүндрэл, бэрхшээл

Сургалтын зорилго: Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан эдийн засгийн өнөөгийн байдалд судлаачийн байр сууринаас хэрхэн бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлбар, шалтгааныг хэрхэн гаргахыг практик жишээгээр харуулах зорилготой.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Эдийн засгийн өсөлт, бууралт, түүний үндсэн шалтгаан, хүртээмжтэй өсөлтийн асуудал ба бодит байдал, инфляцийн өсөлт, мөнгөний ханшны байдал, эдийн засгийн хямрал, хүндрэл, түүний үндсэн шинж тэмдгүүд, гадаад, дотоод шалтгаан, улсын төсвийн алдагдал, түүний шалтгаан, гадаад өрийн байдал, өрийн дарамт, эдийн засагт гарсан зарим нааштай өөрчлөлтүүд гэх мэтийг хамруулна.

Сэдэв № 8. Монгол Улсын нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн зэрэгцүүлсэн байдал

Сургалтын зорилго: Монгол Улсын нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг олон улсын түвшинд зэрэгцүүлэн судалсан судалгааны үр дүнгээр тодорхой мэдлэг олгож, улс орныхоо цаашдын нийгмийн хөгжлийг төлөвлөхөд юунд анхаарах шаардлагатайг эндээс олж мэдэх болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Хүний хөгжлийн үзүүлэлт, дундаж наслалт, сургууль сурах дундаж хугацаа, ажилгүйдэл, бичиг үсгийн мэдлэг, ядуурал, зэрэг үзүүлэлтүүдээр олон улсын түвшинд зэрэгцүүлэлт хийсэн судалгааны дүнг танилцуулж, ямар ямар үзүүлэлтээр хоцрогдож, Монгол Улсыг хойш чангааж байгааг харуулна.

Сэдэв № 9. Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшинг зэрэгцүүлсэн байдал

Сургалтын зорилго: Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг гол үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэлт хийсэн дүнг танилцуулж, өөрийн аймгийн хөгжлийн түвшингийн талаар зөв үнэлэлгээ, дүгнэлттэй болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Нэг хүн амд ногдох ДНБ, эдийн засгийн өсөлт, нэг хүн амд ногдох малын тоо, нэг хүн амд ногдох хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн, дэд бүтцийн хөгжил, үүний дотор эрчим хүч үйлдвэрлэл, авто замын хөгжил, байгалийн баялаг, үйлдвэрлэлийн хүчин чадал, чадавх, хөдөлмөрийн нөөц зэрэг үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэлт хийнэ.

Сэдэв № 10. Аймгуудын нийгмийн хөгжлийн түвшинг зэрэгцүүлсэн байдал

Сургалтын зорилго: Аймгуудын нийгмийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг гол үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэлт хийсэн дүнг танилцуулж, өөрийн аймгийн хөгжлийн түвшингийн талаар зөв үнэлэлгээ, дүгнэлттэй болно.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Аймгуудыг хүний хөгжлийн индекс, хүн амын дундаж наслалт, сургуульд хамрагдалтын түвшин, нялхсын эндэгдэл, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл, 1000 хүнд ногдох эмчийн тоо, хүн амын бичиг үсгийн мэдлэг, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлтээр зэрэгцүүлэх, эдгээр үзүүлэлтүүдийн аймгуудын дунджийг тооцох, түүнтэй зэрэгцүүлэх талаар үзнэ.

Сэдэв № 11. Статистикийн судалгааны зарим үзүүлэлт тооцох арга зүй

Сургалтын зорилго: Судалгаа, дүн шинжилгээ хийхэд ашиглагддаг статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүйд сургах.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Арифметикийн болон геометр дундажийн утга агуулга, түүнийг тооцох арга, түүнийг дүгнэлт үнэлгээ хийхэд хэрхэн ашиглах, абсорлют цэвэр өсөлтийн хэмжээ, өсөлтийн хувь, цэвэр өсөлтийн хувийн утга агуулга, тооцох аргыг авч үзнэ.

Сэдэв № 12. Задгай мэдээллийг нэгтгэх, боловсруулах арга техник

Сургалтын зорилго: Задгай мэдээллийг нэгтгэх, боловсруулах арга техникт сургах

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Ангилах, бүлэглэх, тархалтын цувааг байгуулах, нэгтгэл хийх арга техникийн талаар авч үзнэ.

Сэдэв № 13. Судалгааны хэрэгтэй мэдээллийг өөрсдөө цуглуулах, судалгаа явуулах арга

Сургалтын зорилго: Судалгааны зорилгоор мэдээлэл цуглуулах арга зүйд сургана.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Мэдээлэл цуглуулах хэлбэр, аргууд, судалгааны асуулга боловсруулах, асуулгад тавигдах гол шаардлагууд, судалгааны бэлтгэл ажил, зохион байгуулалтын талаар авч үзнэ.

Сэдэв № 14. Хэлбэлзлийн үзүүлэлтүүд тооцох, тэдгээрийг судалгаа шинжилгээнд ашиглах, улирлын хэлбэлзлийг тооцох арга

Сургалтын зорилго: Хэлбэлзлийн үзүүлэлтүүд тооцох, тэдгээрийг судалгаа шинжилгээнд ашиглах, улирлын хэлбэлзлийг тооцох арга зүйд сургана.

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Статистикийн үзүүлэлтийн хэлбэлзэл гэж юу болох, түүний үндсэн үзүүлэлтүүд: Тархалтын цувааны далайц , Шугаман дундаж хэлбэлзэл , Дисперс, Квадрат дундаж хэлбэлзэл, Вариацийн коэффициент , Детерминацын коэффициент , Корреляцын коэффициентын тухай авч үзнэ.

Сэдэв № 15. Динамик эгнээний ерөнхий чиг хандлагыг тодорхойлох, прогноз хийх аргууд

Сургалтын зорилго: Олон жилийн тоо баримтыг үндэслэн тухайн үзэгдлийн ерөнхий чиг хандлагыг илрүүлэх, ойрын жилүүдийн хүрэх түвшний урьдчилсан тооцоо , прогноз хийх статистикийн аргуудад сургах

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Динамик эгнээний чиг хандлагыг гулсуулсан дунджийн аргаар тооцох, динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга, ойрын жилүүдийн хүрэх түвшний урьдчилсан тооцоо , прогноз хийх статистикийн аргуудыг авч үзнэ.

Сэдэв № 16. Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг хэмжих энгийн аргууд

Сургалтын зорилго: Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг хэмжих статистикийн энгийн аргуудын талаар мэдлэгтэй болгох

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа:Фехнерийн тэмдэгтийн корреляцийн коэффициент, Спирмений эрэмбийн корреляцийн коэффициент, Конкордацийн коэффициент, сэлгээ шинж тэмдгийн хоорондын хамаарлын хүчийг хэмжих коэффициентууд, Чупровын коэффициент зэргийг авч үзнэ.

Сэдэв № 17. Чанарын судалгааны аргууд

Сургалтын зорилго: Чанарын судалгааг явуулах арга зүйн анхан шатны ойлголт, мэдлэг олгох

Үргэлжлэх хугацаа: 45 минут,

Сургалтын хэлбэр: Танхимийн хэлбэрээр лекц ба харилцан ярилцлага,

Сэдвийн задаргаа: Чанарын судалгаа гэж юу болох, түүний онцлог, тоогоор илэрхийлэгддэггүй шинж тэмдгийг хэмжих тухай, чанарын судалгааны аргууд, судалгааг бэлтгэл ажил, чанарын судалгааг явуулахад анхаарах асуудлууд, тавигдах шаардлагууд, чанарын судалгааны жишээнүүдийн талаар заана.

Бид санал болгож байгаа сургалтын модулийг амьдралд хэрэгжүүлэхэд тус дэм үзүүлэх зорилгоор “Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх гарын авлага” боловсруулж, тайланд хавсаргалаа /Хавсралт-12/. Энэхүү гарын авлагыг боловсруулахдаа хүн бүхний сайн мэддэг зүйлийг давтан тайлбарлахаас аль болох зайлсхийж, зайлшгүй нэмэлт тайлбар шаардлагатай гэж үзсэн ойлголтуудыг түүвэрлэн авч, мэргэжлийн бус хэрэглэгчдэд хялбарчлан тайлбарлах чиглэл барьсан болно.

11. ОРОН НУТАГ ДАХЬ ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ

Манай улс өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаагаар ядуурлын үзүүлэлтүүдийг тооцож байна. Ингэхдээ улс, бүс нутгийн түвшинд ядуурлын хамрах хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмж, амьжиргааны ялгааг тооцож нийтэд мэдээлж байна. Аймгийн түвшинд ядуурал тооцох ажил эхлэлтийн байдалтай байгаа. Гэтэл орон нутагт амьжиргааны үзүүлэлтийг засаг захиргааны хамгийн доод нэгж болох баг,сумаар тооцож, бодлого, төлөвлөлтөд ашиглах хэрэгцээтэй байгаа юм. Сүүлийн жилүүдэд орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны судалгааг ХАНХЯ эрхлэн явуулж байна. Энэ судалгааг үндэслэн өрхийг 1-20 зэрэглэлд ангилж, доод бүлгийн өрхөд хүнсний талон өгөх ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Өнөөгийн байдлаар 1-2 бүлэгт хамрагдах өрхийн нэг том хүнд сард 13000 төг., хүүхдэд 6500 төгрөгийн талон олгож байна. Судалгааг өрхөөр явуулдаг учир өөрийн гэсэн гэр оронгүй, айлаар дамжин амьдардаг хүмүүс энэ тусламжид хамрагдахгүй хоцордог байдал ажиглагдлаа. Зарим үед орон нутгийнхан зайлшгүй тусламж авах ядуу өрх энэ жагсаалтад орохгүй үлдэх явдал гарч байна. Аймаг, сумын хэмжээнд хэчнээн ядуу өрх байгаа, тэдгээрийн хэд нь тусламж дэмжлэгт хамрагдсан, хэдэн өрхөд цаашид анхаарах шаардлагатай талаарх мэдээлэл нэн чухал гэдгийг орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд онцлон тэмдэглэж байна. Ядуурлын түвшин, түүний өөрчлөлтийг тооцож ажиллах хэрэгцээтэй байдаг юм байна. Энэ асуудлыг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг өргөжүүлж, түүврийн хүрээг нэмэгдүүлэх замаар шийдэхэд ихээхэн цаг хугацаа,хөрөнгө шаардлагатай. Асуудлыг хэрхэн шийдэх вэ? Зарим сумдад энэ чиглэлээр судалгаа явуулж, ядуу өрхүүдээ сум багаар нь тооцож гаргах оролдлого хийж байна. Хүмүүсийн дунд орон нутагт ямар хүнийг, өрхийг ядуу гэж үзэх төсөөлөл байдаг бололтой. Энэ байдалтай танилцсаны үндсэн дээр орон нутгийн ядуу өрхийн дүр төрхийг тодруулах оролдлого хийлээ. Бид судалгааг хийхдээ ядуу өрхийн байдлыг агуулга, бодит байдал талаас нь хүмүүсийн ядуурлын талаарх төсөөллийг судалж тодорхойлох зорилт тавьж ажиллалаа. Түүнчлэн ядуурлыг орон нутагт тоогоор тооцон илэрхийлэх талаар хэрэгжүүлж байгаа туршлагыг судлах чиглэл барьж ажиллалаа.

11.1. Ядуу өрхийн талаарх хүмүүсийн төсөөлөл.

Бид сумдын Засаг дарга,багийн Засаг дарга нараас орон нутагт ядуу өрхийг хэрхэн төсөөлж байгаа талаар харилцан ярилцах хэлбэрээр судалгаа явууллаа. Судалгаанд Хэнтий аймгийн Хэрлэн, Мөнххаан, Дэлгэрхаан,Баянмөнх, Өвөрхангай аймгийн

Арвайхээр, Баянгол, Төгрөг, Хайрхандулаан, Хужирт сумдын Засаг дарга, бүх багийн Засаг дарга нар хамрагдсан болно. Хүмүүсийн хариултаас үзэхэд сумын төв, малчин өрхийн ядуурал хоорондоо ялгаатайг онцолж байлаа.

Сумын төвийн хувьд 4-5 хүүхэдтэй, гэр бүлийн дотор мэргэжилтэй, ажил тогтмол эрхэлдэг хүнгүй, голдуу өрх толгойлсон эмэгтэйтэй, гэр бүлтэй ядуу өрхийн хувьд нөхөр нь голдуу архичин, гэр бүлийн гишүүд өндөр настай, харж хандах ах дүүгүй, өөрийн гэсэн мал, хөрөнгөгүй, 10-20 толгой малтай боловч тэр нь амьжиргаанд нь хүрэлцдэггүй, 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой, эцэг, эхээсээ өмч хөрөнгө өвлөж аваагүй үе дамжин ядуу амьдарч ирсэн, гэрийн доторх ахмад настны тэтгэврээр амьдардаг, гэрлэсэн хүүхдүүд нь эцэг, эхтэйгээ хамт амьдардаг, амьдралдаа арчаагүй, залхуу, бусдын дэмжлэг, тэтгэвэр тусламжаар амьдрах сэтгэлгээтэй, худал хэлдэг, хулгай хийхээс буцахгүй байдалтай учраас ах дүү нар болон хувь хүмүүсээс тусламж үзүүлэх итгэл алдарсан өрхүүд ядуу амьдарч байна Энэхүү орон нутаг дахь ядуурлын дүр төрхийг судалгаанд хамрагдсан бүх хүмүүсийн хэлсэн нийтлэг санааг нэгтгэндүгнэх замаар тодорхойлсон болно.

Орон нутагт ядуу гэсэн ангилалд хамрагдаж байгаа өрхүүдийн байдал ямар байгаатай танилцах оролдлого хийлээ. Үгээгүй ядуу өрх ховор байна. Харин харж хандах ах дүүгүй, ганц бие, өөрийн гэсэн гэр оронгүй хувь хүмүүс сумдад ганц нэг байдаг. Ийм хүмүүс айл айл дамжиж ойр зуурын ажилд нь тусалж хооллож, гэрт нь хоноглож амьдардаг. Бидний очсон сумдаас Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд 2 хүн, Өвөрхангайн Баянгол суманд 1 хүн, Хужирт суманд 3 хүн байсан. Иймэрхүү амьдралтай хүмүүст өөрийн гэр орон, ам бүл байхгүй учраас орлогыг орлуулан тооцох өрхийн судалгаанд хамрагдаагүй үлддэг. Нэгэнт өрхийг уг судалгаанд хамруулах журамтай учраас сум ийм хүмүүсээ мэддэг ч гэсэн судалгаанд хамруулж, хүнсний талон олгож чаддаггүй юм байна.

Ядуу өрх голдуу өөрийн гэсэн гэртэй ч тэр нь давхарга байхгүй учраас өвөлд их хүйтэн, зутруу байдаг. Нэлээд нь өөрийн эзэмшлийн хашаагүй учраас гац гэрээр, ил газар өвөлждөг, эсвэл айлын хашаанд гэрээ барьдаг ч хүмүүс төдийлөн таагүй хүлээж авдаг учраас богино хугацаанд амьдрах хашаагаа сольдог. Өвлийн цагт түлш авах мөнгөгүй учраас хүмүүсээс гуйх, мод, аргал түүх зэргээр аргацаадаг. Иймэрхүү айл өрхүүд хүүхдийн мөнгө, өндөр настны тэтгэвэр, тэжээгчээ алдасны болон түүнтэй адилтгах

тэтгэмж, ах дүү, нутгийн хүмүүсийн дэмжлэг, халамжийн дэмжлэг зэргээр голдуу амьдардаг ажээ. Зарим сумын төвийн ядуу өрх 20 хүртэл малтай түүнээсээ бага зэрэг орлого олно.

Хөдөө амьдардаг ядуу өрхийн байдал сумын төвийхтэй олон талаар төстэй. Мөн л олон хүүхэдтэй, байнгын орлогогүй гээд олон шинжүүдээр адилхан. Харин түр зуурын орлого олох арга нь онцлогтой. Голдуу айлын хаяанд мал аж ахуйн ажилд нь тусалж амьдардаг. Өөрийн гэсэн 100 хүртэл тооны малтай ч тэр нь амьдралд нь хүрэлцэхгүй. Гэхдээ хөршийн мал хариулах, сүү саах, ноос, ноолуурын ажилд тусалж хөлсөнд нь цайны сүү, бага хэмжээний цагаан идээ авна. Зарим сумдад 150 малтай өрх ч ядууд тооцогдоно. Ядуучуудын дунд ажил хийх сонирхолгүй, тэтгүүлэх сэтгэлгээ давамгайлсан хүн олон байдаг. Эрүүл мэнд муу учраас түр ажил, барилга дээр ажиллах гэх мэт шаардлага хангахгүй. Хөдөөгийн малчид мөнгө амлаад ажиллуулсны дараа хөлс мөнгийг нь багаар өгдөг тохиолдол байдаг учир очиж ажиллах сонирхолгүй байдаг. Халамж авахын тулд өөрийгөө ядуу гээд явдаг, тэр байдлаа өөрчлөх сонирхолгүй хүмүүс ч байна. Амьдралдаа арчаагүй, хүнд зарцлагдахгүй гэсэн сэтгэлгээтэй хүмүүс ч бий.

11.2. Сумын ядуурал түүнийг тооцох оролдлого.

Зарим сумд ядуу өрхөө тооцож гаргах оролдлого хийсэн байна. Сумд айл өрхийн амьжиргааг тооцож бүх өрхүүдээ нэн ядуу, ядуу, дундаж, боломжийн гэж ангилах оролдлого хийж байна. Өвөрхангай аймгийн Баянгол сум энэ талаар нэлээд зүйл санаачлан ажилладаг нь ажиглагдлаа. Тус сум өрхийн орлого тооцох аргачлал боловсруулж, ИТХ-р батлуулж ажилладаг юм байна. Энэ аргачлалаа ашиглаад нийт өрхүүдээ амьжиргаагаа авч явж чадаж байгаа, амьжиргаагаа дөнгөн данган авч явдаг, амьжиргаа нь хүндэрсэн гэж 3 ангилж, судалгаа явуулсан байна. Энэ аргачлалыг 2010 онд зудын дараа боловсруулж, тэр ондоо амьжиргааг тооцоход ядуурал их өндөр хувьтай гарч байжээ. Харин 2013 онд өмнөх аргачлалаа шинэчилж батлаад мөрдөж байна. Бусад сум ч гэсэн ядуу өрхийн тухай ярьж байгаа ч тогтсон аргачлалгүй, баримжаагаар тооцоолдог нь ажиглагдаж байлаа. Харин Баянгол сумын жишээгээр, тэр аргачлалыг нь арай боловсронгуй болгоод орон нутагт ядуурлыг арилгах бодлого явуулахад ашиглаж болмоор санагдлаа. Энэ сум өрхийн орлого тооцох замаар амьжиргаанд үнэлгээ өгөх оролдлого хийжээ. Сум жижигхэн, хүн бүр хэн нь юу хийж, ямар орлого олж байгааг сайн мэддэг учраас нэг өрхийн орлогыг багцаалан тооцох боломжтой гэж сумын удирдлагууд үзэж байв.

Баянгол сум 4 төрлийн орлого тооцох оролдлого хийсэн байна. Үүнд:

1. Малын ашиг шимийн орлого. Ингэхдээ тухайн өрхийн нийт малаа хонин толгойд шилжүүлж, нэг жишиг хониноос жилд авах ашиг шимийг орон нутгийн жишээгээр нормчилсон байна. Тухайлбал, нэг жишиг хониноос жилд 1,2 кг ноос, 6,5 кг сүү, 20,5 кг мах, нэг ширхэг нэхий, нэг нэгж дайвар бүтээгдэхүүн бий болно гэж тооцоолоод өрхийн хонин толгойд шилжүүлсэн нийт малын 40%-ийг зарлагадана гэж үзээд малын ашиг шимийн орлогыг боджээ. Бодын хөөвөр, хялгасны зах зээлийн үнэ бага учраас бодитой орлого орохгүй гэж үзээд тооцоонд оруулаагүй байна. Орлогыг дараах хэлбэрээр тооцжээ. Үүнд:
 2. Цалин хөлсний орлого байхгүй гэж үзсэн.
 3. Халамжийн сангийн орлого:
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр
 - Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
 - Асаргааны тэтгэмж
 - Асаргаа шаардлагатай иргэнд олгох улирлын тусламж
 - Алдарт эхийн 1,2- р зэргийн одонгийн тусламж
 - Гавьяат цолтны тэтгэмж
 - Ахмад дайчны тэтгэмж
 - Гурав хүртэл насны ихэр хүүхдийн нэг удаагийн мөнгө
 - Амаржсаны дараах тэтгэмж
 - Өрх толгойлсон эхийн жилд олгох нэг удаагийн тэтгэмж
 4. Нийгмийн даатгалын сангаас олгох орлого:
 - Өндөр насны тэтгэвэр
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр
 5. Хүний хөгжил сангаас олгосон эх орны хувь хишиг, хүүхдийн мөнгө

Энэхүү тооцоог хийхдээ аж ахуй эрхэлдэг болон байнгын орлоготой хүмүүсийг дунджаас дээш орлоготой гэж үзээд судалгаанд хамруулаагүй байна. Өрхийн нийт орлогыг ам бүлд нь харьцуулж нэг хүнд ногдох орлогыг гаргажээ. Нэг хүнд ногдох орлого нь ҮСХ-ноос тогтоосон бүсийн амьжиргааны доод түвшнээс доогуур бол амьжиргааг нь дэмжих шаардлагатай өрхөд тооцдог байна.

Энэ арга нь бүрэн төгс боловсрогдсон зүйл биш ч гэсэн орон нутгийн бодит амьдарлын хэрэгцээнд тулгуурласнаараа чухал ач холбогдолтой юм. ҮСХ-д мөрдөгдөж байгаа ядуурлыг тооцох өнөөгийн аргачлал нь өрхийн хэрэглээг тооцох

аргад үндэслэдэг. Харин орон нутгийн жижиг нэгжид анхаарал татаж байгаа бүлгийн орлогыг тооцох бололцоотой гэж үзсэнд уг аргачлалын онцлог оршиж байгаа юм.

Зөвлөмж.

Цаашид сумын түвшинд амьжиргааны байдлыг тооцож, ядуурлыг бууруулах тодорхой ажил зохиох зайлшгүй шаардлагатай байгаа учраас орон нутагт чиглэгдсэн нэгдсэн аргачлал боловсруулж, зөвлөмж болгох бололцоотой. Ингэхдээ улсын хэмжээнд ядуурал тооцдог аргачлалыг ашиглахад их хэмжээний хөрөнгө, цаг хугацаа шаардагдах учир суманд ашиглах гэж оролдох шаардлагагүй. Харин орон нутгийн хэмжээнд ашиглаад ажлаа явуулахад чиглэгдсэн аргачлал байх нь зүйтэй. Ингэхдээ бүх өрхийг судалгаанд хамруулах шаардлагагүй. Эхлээд амьжиргаанд нь үнэлгээ өгөх шаардлагатай хүрээгээ оновчтой тогтоох хэрэгтэй. Дараа нь энэ бүлгийн орлогыг тооцох арга зүйг тусгаж өгөх шаардлагатай. Өрхийн нэг гишүүний дундаж орлого нь аймгийн ядуурлын шугамыг л тооцсон нөхцөлд түүнээс доогуур орлоготой бол ядуу гэж үзэх нь зүйтэй. Аймгаар ядуурал тооцож эхлээгүй нөхцөлд бүсийн ядуурлын шугамыг ашиглах бололцоотой. Орон нутагт амьжиргааны баталгаажих түвшинг ашиглана гэсэн ойлголт түгээмэл байгаа учраас ядуурлын шугам, амьжиргааны доод түвшингийн ялгааг уг аргачлалд тодорхой тайлбарлаж, ядуурлын шугам ашиглах шаардлагатайг тусгаж өгвөл зохино.

12. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРСЭН ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

12.1. Төслөөс гарсан гол үр дүн

1. Сонгосон 2 аймгийн хэмжээнд мэдээлэл хэрэглэгчдийн зорилтот бүлгийг тогтоож, хамрагдсан хүмүүсийн статистик мэдээллийн талаарх мэдлэг, мэдээллийг олж авах чадвар, ашиглалтын байдалд үнэлгээ хийж, орон нутаг дахь статистик мэдээллийн эрэлт хэрэгцээг тандан судалсан.
2. Орон нутгийн хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулсан. Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх жилийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах зөвлөмжийг 9 зүйлтэйгээр санал болгов.
3. Орон нутгийн янз бүрийн түвшний хэрэглэгчдэд мэдээллийн боловсролыг дээшлүүлэх 2016-2020 оны стратеги ба бодлогын баримт бичгийг боловсрууллаа. Үүнд орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд баримтлах бодлогын 8 чиглэл, стратегийн 5 зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тусгалаа. Түүнчлэн статистикийн мэдээллийн боловсрол олгох 8 хэлбэрийг санал болголоо.
4. Статистикийн мэдээлэл хэрэглэдэг орон нутгийн зорилтод бүлгүүдэд зориулагдсан сургалтын модуль боловсруулж, зарим сэдвээр нь туршилтын сургалтыг онлайн болон танхимын хэлбэрээр явууллаа. Орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийг анхан, дунд, ахисан түвшинд хувааж, тус бүрт нь зориулагдсан сургалтын модуль боловсрууллаа. Нэг модулийн дотор 8-17 сэдвээр сургалт явуулах хэрэгцээ байгааг тодорхойллоо.
5. Хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд тусламж болгож сургалтын гарын авлага боловсруулав. Энэхүү гарын авлагад макро эдийн засгийн 8, хүн ам, нийгмийн статистикийн 21, бусад 10 чиглэлийн мэргэжлийн бус хүмүүст зайлшгүй нэмэлт тайлбар өгөх шаардлагатай ойлголтуудыг аль болох хялбар аргаар тайлбарлаж, үзүүлэлтүүдийн урт хугацааны тоон утгыг тусгах чиглэл баримталсан болно.
6. Орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, статистикийн хэлтсээс орон нутгийн хэрэглэгчтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийсэн.

7. Хүн ам орон сууцны завсрын тооллогыг 2015 оны эцсээр бүртгэлд суурилсан аргаар явуулах болсонтой холбоотойгоор Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сан (ХАӨМС)-ийн мэдээллийг сонгосон аймгуудад багийн засаг дарга нар хэрхэн үнэн зөв, бүрэн нөхөж, хөтөлж байгааг газар дээр нь хянан, шалгаж, ҮСХ-ноос гаргасан тухайн аймгийн ХАӨМС-д гарсан алдааг засварлах, учир шалтгааныг нь олох, ХАӨМС-д байхгүй хэрнээ Нийгмийн даатгалын мэдээллийн санд байгаа иргэдийг газар дээр нь олж тодруулах, шилжсэн иргэдийн баталгаажуулалтыг хийгээгүй учир шалтгааныг газар дээр нь тодруулах, боломжтой хүмүүсийн хувьд баталгаажуулалтыг баг дээр нь хийлгүүлэх, засвар өөрчлөлт оруулах заавар, зөвлөгөө өгсний үр дүнд 2 аймгийн дүнгээр алдаа багасаж, шилжих хөдөлгөөний баталгаажуулалт нэмэгдэж, олон зүйлийн тодорхойгүй байдлын учир шалтгаан тодорхой болсон. Төслийг хэрэгжүүлэх явцад ХАӨБ-ийн сангийн алдаа 34.7%-иар, олж тогтоох шаардлагатай хүний тоо 46,4%-иар, шилжих хөдөлгөөнийг нь баталгаажуулах иргэдийн тоо 40,0%-иар тус тус багассан шууд үр дүн гарлаа.
8. ХАӨМС-д гарсан алдаа, тодруулах, лавлах зүйлийн талаар 2 аймгийн 37 сумын 196 багт газар дээр нь гарсан нөхцөл байдлыг ҮСХ –дээр холбогдох мэргэжилтний түвшинд танилцуулж, цаашид анхаарах асуудлыг дэвшүүлж, бүх аймаг, хотод зааварчилга, нэмэлт зөвлөмж хүргүүлж ажилласнаар мэдээллийн алдаа эрс багасаж, ХАӨБ-ийн санг бүрдүүлэх ажилд ахиц дэвшил гарсан гэж үзэж байна.
9. Сонгосон аймгуудын сум, багийн ажилтнууд ХАӨМС-гийн программыг бүрэн ашиглах, мэдээллийн баяжилт хийхтэй холбоотой дадлага сургалт хийж, сайн туршлагатай болсон.
10. ҮСХ-ны статистик мэдээллийг олон нийтэд тархаадаг цахим хуудас www.1212.mn нь ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 10 –ны өдрийн 1/101 тоот тушаалаар аймаг, сум, багийн түвшинд тооцож, мэдээлж байх үзүүлэлтүүдийг хэрхэн оруулсан, орон нутгийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг нь хэр зэрэг хангаж байгаа болон эдгээр мэдээллийн сангийн үзүүлэлтүүдийг орон нутгийн хэрэглэгчид ашиглаж чадаж байгаа байдалд үнэлгээ өгсөн.
10. ҮСХ-ны статистик мэдээллийг олон нийтэд тархаадаг цахим хуудас www.1212.mn-н мэдээллийн бүрдэлт, шинэчлэлтийг сайжруулах, мэдээллийг аль болох бүрэн шивж оруулах талаар багийн гишүүд ҮСХ-ны даргын зөвлөлд асуудлыг танилцуулж, холбогдох газар, хэлтсийн дарга нарт хугацаатай үүрэг, даалгавар өгүүлж, мэдээллийн бүрдэлт, шивж оруулах үзүүлэлтийн тоог 2015 оны 12 дугаар

сарын 5 –ны байдлаар аймгийн түвшинд 31 үзүүлэлтээр, сумын түвшинд мөн 31 үзүүлэлтээр, багийн түвшинд 14 үзүүлэлтээр нэмэгдүүлсэн.

11. ҮСХ-ны www.1212.mn цахим хуудсыг хэрэглэгчдэд сургалчлах, хэрхэн ашиглах, товч сургалт явуулав. ХАӨМС-ын зориулалт, ач холбогдолын талаар орон нутгийн хэрэглэгчдэд сурталчлав. Энэ ажилд 2 аймгийн 348 хэрэглэгч хамрагдлаа. Сонгосон аймгийн телевиз, радиод ярилцлага өгч, төслийн зорилгыг танилцуулж, статистикийн мэдээлэл хаанаас хэрхэн олж ашиглах талаар зөвлөгөө өглөө.
12. Хоёр аймгийн нийт сумдаас 669 хэрэглэгчийг сонгон авч ҮСХ-ны 1212 мэдээллийн санг байнга ашигладаг болгох ажлыг онлайнаар хийж, нийт 14 удаа нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтүүдийг тайлбарласан, урт хугацааны динамикийг тусгасан мэдээлэл дамжууллаа. Статистикийн бүтээгдэхүүний идэвхтэй хэрэглэгчдийн хүрээг бий болгож, түүгээр дамжуулан нийт хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх ажлыг эхлүүлээд байна.
13. ХАӨМС,нийгмийн халамж, боловсролын болон эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сангуудыг уялдуулах, тэдгээрийг ҮСХ –ны мэдээллийн нэгдсэн сантай холбох боломж, арга замын талаар санал, зөвлөмж гаргав.
14. ҮСХ-ны мэдээллийн сантай нягт уялдаа бүхий орон нутгийн мэдээллийн сан үүсч аймгуудад мэдээллийг тархах тогтолцоог боловсронгуй болгох зөвлөмж гарлаа.
15. ҮСХ-ны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу боловсролын мэдээллийн сангийн албан ёсны статистикт ашиглах үзүүлэлтүүдийг тооцож байгаа аргачлал, арга зүйд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулав.
16. Хэрэглэгчдийн 3 түвшний 6 зорилтот бүлгийг хамарсан социологийн судалгаа явуулж, хэрэглэгчдийн мэдлэгт өгсөн үнэлгээ , мэдээллийн эрэлт хэрэгцээ, статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх чиглэлийг тусгасан судалгааны тайлан боловсрууллаа.
17. Сонгогдсон 2 аймгийн 196 багийн Засаг дарга нарын компьютер, интернет ашиглалтын байдалд үнэлгээ өглөө. Нийт Засаг дарга нарын 70 орчим хувь нь шаардлага хангахгүй байгааг тогтоолоо.
18. Орон нутгийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын анхаарлын төвд байдаг ядуурлын үзүүлэлтийг сумын түвшинд тооцох талаар хийж байгаа оролдлого, орон нутагт ядуурлыг хэрхэн төсөөлж байгаа талаар судалгаа хийж, нэгтгэн дүгнэж, санал боловсруулав.

12.2. Дүгнэлтүүд

1. Орон нутгийн статистик мэдээллийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, тандалтын дүнгээс харахад хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн талаарх боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийг олж авах, ашиглах чадварыг дээшлүүлэх асуудал нэн чухал болох нь харагдаж байна. Орон нутагт хэрэглэгчид статистикийн мэдээллийг хаанаас яаж олж авах, яаж ашиглах талаар анхан шатны мэдлэг, дадлага дутагдаж байна.
2. Орон нутагт албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн зэрэгцээ эдгээр эх үүсвэрүүдээс хангалттай задаргаатай гарахгүй байгаа эрэлт хэрэгцээтэй мэдээлэл цөөнгүй байна. Энэ талаар тайлангийн 5.2 дахь хэсгээс тодруулж, харж болно.
3. Сонгосон аймгуудын статистикийн хэлтсээс статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх талаар тэдэнтэй тодорхой харилцааг тогтоож, мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулж ирсэн боловч энэхүү үйл ажиллагаа нь зорилтот бүлгүүдэд бүрэн хүрэхгүй, төрийн захиргааны байгууллагуудын хэрэглэгчдээр ихэвчлэн хязгаарлагдсан байдалтай байна. Энэ нь ҮСХ-ны цахим хуудасны талаар сэтгүүлчид, багш нарын ихэнх нь мэдэхгүй, тэдгээрийг ашиглаж үзээгүйгээр нотлогдож байна.
4. Статистикийн мэдээллийг нийтэд хүргэж байгаа ҮСХ-ны www.1212.mn цахим хуудсыг сонгогдсон 2 аймгийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн дөнгөж 39.4% л мэдэж байгаа нь түүний ашиглалтын түвшин орон нутагт хангалтгүй байгааг харууллаа.
5. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11-ны өдрийн 1/101 тоот тушаалын 2А, 2Б хавсралтад заасан аймаг, сум, багийн түвшинд тооцож, мэдээлэх ёстой үзүүлэлтүүдийг ҮСХ-ны www.1212.mn цахим хуудсанд байрлуулах, мэдээллийн баяжилт хийх ажил нэн хангалтгүй түвшинд байсан. Тухайлбал, 2015 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар дээрх тогтоолын хавсралтад тусгагдсан аймгийн түвшинд гаргаж, мэдээлэх ёстой 217 үзүүлэлтээс www.1212.mn цахим хуудсанд 111 нь буюу 51,2 хувь нь тавигдсан байсан. Харин сумдын түвшинд гаргах 151 үзүүлэлтээс зөвхөн 21 үзүүлэлт буюу 13,9 хувь нь, багийн түвшинд гаргах 36 үзүүлэлтээс зөвхөн 6 үзүүлэлт нь буюу 16,7 хувь л тавигдсан байсан юм. Нэлээд хүчин чармайлт тавьж, үүрэг даалгавар өгүүлж, ажилласны дүнд дээрх тогтоолын хавсралтад тусгагдсан аймгийн түвшинд гаргаж, мэдээлэх ёстой 217 үзүүлэлтээс www.1212.mn цахим хуудсанд 2015 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар 142 нь буюу 65,4 хувь нь

тавигджээ. Сумын түвшинд гаргахаар тогтоосон нийт 151 үзүүлэлтээс дээрх цахим хуудсанд 52 нь буюу 34,5 хувь нь тавигдаад байна. Багийн түвшинд гаргаж байх ёстой 36 үзүүлэлтээс 20 нь буюу 55,5 хувь нь д тавигджээ. Өөрөөр хэлбэл, 2015 оны 12 сарын 5-ны байдлаар ҮСХ-ны мэдээллийн нэгэдсэн санд нэмж оруулах нийт үзүүлэлтийн тоо 20 пунктээр нэмэгдлээ. Эдгээрээс аймгийн түвшний үзүүлэлт 14,2 пунктээр, сумын түвшний үзүүлэлт 21,2 пунктээр, багийн түвшний үзүүлэлт 35,5 пунктээр нэмэгдээд байгаа нь төсөл хэрэгжүүлэх явцад гарсан ахиц, өөрчлөлт юм. Гэвч орон нутагт статистикийн мэдээллийг хүргэх гол эх үүсвэр болсон цахим хуудасны мэдээлэл байх ёстой түвшнээсээ ийм бага байгаа нь хэрэглэгчдийн мэдээллийн эрэлт хэрэгцээг хангах талаасаа болон тэдэнд хүрч ажиллах үйл ажиллагаанд томоохон саад болж байна.

6. ҮСХ-ны цахим хуудасны (www.1212.mn) статистикийн мэдээллийн сангаас орон нутгийн хэрэглэгчид хүн амын амьжиргааны түвшин, хүнс тэжээлийн хангамжийн талаар аймгаар тооцсон ямар ч үзүүлэлт байхгүй,, мөн сумын түвшинд боловсролын 18 үзүүлэлт гарахаас зөвхөн 2 үзүүлэлт олж ашиглах боломжтой байна.
7. ҮСХ-ны цахим хуудас нь хэрэглэгчдийн зүгээс албан ёсны статистикийн тоо мэдээллийг хайж олоход тийм хялбар бус, хэрэглэгчдэд хайж олоход зохих бэрхшээл учруулж байна. Эхний ээлжид хэрэглэгч цахим хуудасны статистикийн мэдээллийн санд холбогдох сэдвээр нь хэрэгцээтэй үзүүлэлтээ хайж, тэнд байхгүй бол цахим хуудасны бусад хэсгээс, тухайлбал, статистикийн жил бүрийн эмхтгэл, статистикийн бюллетень, орон нутгийн задаргаатай мэдээллийг “Аймгийн статистикийн товчоон” товхимлоос хайхад хүрнэ. Гэхдээ энд зөвхөн 2012 оны статистикийн эмхтгэл нийтэд тавигдсан, харин 2013 болон 2014 оны эмхтгэлүүд тавигдаагүй байна. Иймд албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийг жилийн эмхтгэл бүрнээр цахим хуудсанд тавигдахаас өмнө 1212-т тусгадаг болох шаардлагатай байна.
8. ҮСХ-ны цахим хуудас, түүний статистикийн мэдээллийн санд тавигдсан үзүүлэлтүүд нь хэрэглэгчдийн хувьд цөөхөн оноор тавигдсан, 2012 оноос өмнөх оны тоо мэдээлэл ховор тавигдсан, зарим нь зөвхөн 2013 оноор тавигдсан нь нэлээд хуучирсан, түүнийг шинэчлэх ажил хангалтгүй байна.
9. ХАӨМС-ын хувьд бүс нутгуудын хөгжлийн ялгаатай байдал, эд хөрөнгө, орон байр, мал, газар эзэмшилтэй холбоотойгоор нэг айл хоёр өрх болон амьдарч байгаа нөхцөлийг хэлэлцэж, нэгдсэн шийдэлд хүрэх хэрэгтэй байна. Энэ нь өрхийн тоог

зохиомлоор өсгөх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

10. Боловсролын салбарын мэдээллийн сан (БСМС-д) -гийн тайлангийн системийг ҮСХ-ны 1212 системд шууд холболт хийж болохоор байна. Хэрэгцээ шаардлагаас хамаарч 1212 системийн боловсролын бүлэгт мэдээллийг онлайнаар татах боломж байгаа тул мэргэжилтнүүд шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.
11. Статистикийн анхан шатны мэдээллийн чанарыг гардан хариуцдаг багийн засаг дарга нарын компьютер, интернет ашиглах чадварыг тасралтгүй дээшлүүлэх, сумдын интернетийн хурдыг нэмэгдүүлэх талаар системтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

12.3. Санал, зөвлөмжүүд

1. Хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх 2016-2020 оны стратеги ба бодлогын баримт бичгийг ҮСХ анхааралдаа авч, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.
2. Орон нутгийн хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийн статистик мэдээллийн боловсролыг дээшлүүлэх сургалтын модулийг ашиглан ирэх 2016 оноос сургалт явуулах тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг санал болгож байна.
3. Цаашид энэхүү төслийн хүрээнд зөвхөн очиж ажилласнаар хязгаарлахгүй аймгуудын бүх сумдын идэвхтэй хэрэглэгчдийн жагсаалт боловсруулж, холбоо тогтоож, онлайн хэлбэрээр хамтран ажиллахыг зөвлөж байна.
4. Хэрэглэгчдийн бүлэг тус бүрийн онцлогт тохирсон мэдээллийг энэ сүлжээг ашиглан тодорхой давтамжтайгаар ҮСХ-ны мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв болон аймгуудын статистикийн хэлтэсээс хүргэдэг болох шаардлагатай гэж үзлээ. Ямар асуудлыг төв, орон нутаг хариуцах чиглэл, хугацааны давтамжийг ҮСХ-ноос нэгдсэн журмаар тогтоож өгөх нь зүйтэй байна.
5. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хялбарчлан тайлбарлах, цаг үеийн шинжтэй шуурхай мэдээлэл дамжуулах, шинээр гарсан аргачлал, арга зүйг хүргэх, тайлбарлах асуудлыг төвөөс боловсруулж хүргэдэг байхыг санал болгож байна. Харин орон нутгийн чанартай асуудлуудаа аймгуудын статистикийн хэлтэс хариуцаж байвал тохиромжтой гэж үзэж байна.
6. Цаашид багийн Засаг дарга нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэд нарыг сонгон шалгаруулахдаа мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг нь харгалзан үзэж

байх талаар сонгон шалгаруулалтын холбогдох баримт бичигт тусгуулах ажлыг хөөцөлдөж хийх шаардлагатай байна.

7. Статистикийн мэдээллийн MONSIS нэгдсэн сангийн хайлтын системд нэмэлт хийх хэрэгтэй гэж үзлээ. Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хайлтын хэсэгт “АЙМГААР” гэсэн бүлэг нэмж, MONSIS санд байгаа мэдээллийг аймаг аймгаар нь ялгаж харуулдаг шийдэл хийвэл хэрэглэгчдэд зөвхөн өөрийн эсвэл сонирхсон аймгийнхаа мэдээллийг аймгийн дүнгээр болон сум, багийнхаа түвшинд харах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь хэрэглэгчийн тухайд мэдээллийн хайлтыг ихээхэн хялбарчилна гэж үзлээ.
8. Орон нутгийн болон нийт хэрэглэгчдийн статистик тоо мэдээллийн хэрэгцээг "Статистикийн тухай" хуульд заагдсан 48 бүлэг үзүүлэлтүүдийн хүрээнд хангахын тулд ҮСХ нь өөрийн цахим хуудасны (www.1212.mn) тоо мэдээллийг аль болох яаралтай бүрдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.
9. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б –д тусгагдсан үзүүлэлтүүдийг www.1212.mn цахим хуудсанд оруулах ажлын хуваарийг газар, хэлтэс, хариуцах мэргэжилтэн нэг бүрээр гаргаж, гүйцэтгэлийг нь 15 хоног тутамд хянаж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцэж байхыг зөвлөмж болгож байна.
10. ҮСХ-ны даргын 2014 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 1/101 тоот тушаалын Хавсралт 2а болон 2б –д тусгагдсан үзүүлэлтүүд өөр хоорондоо зөрүүтэй, газар хэлтсийн дарга нарын ойлголт зөрүүтэй байгааг ҮСХ-ны удирдлага анхааралдаа авч, тодорхой болгох шаардлагатай байна. Үнэхээр сум, багаар гаргах боломжгүй үзүүлэлтүүдээ хэрхэх талаар шийдвэр гаргах шаардлагатай гэж үзлээ.
11. Хэнтий болон Өвөрхангай аймгийн удирдлага, хөгжлийн бодлогын хэлтсийн гаргасан санал болон өмнөх “Үндэсний бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх MON/13/201 төсөл”-ийн хүрээнд хийсэн “Орон нутгийн түвшин дэх статистикийн мэдээллээр хангах одоогийн боломж, дутагдалтай байдлыг үнэлж, хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан”- гаас харахад ДНБ-ийг сумдаар тооцож, аймгийнхаа эдийн засагт сум бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэх практик хэрэгцээ, шаардлага орон нутагт байна. Иймээс ҮСХ ДНБ-ийг сумдаар тооцох аргачлалаа боловсруулж, мөрдүүлэх, тооцоог тогтмол хийж, мэдээлж байх шаардлагатай болжээ.
12. Макро түвшинд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг аль нэг оныг суурь болгосон зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ний өсөлтөөр хэмждэг. Гэтэл аймаг орон нутгийн

түвшинд ДНБ-ийг тухайн үеийн үнээр тооцож байгааг өргөжүүлж, зэрэгцүүлэх үнээр үнэлж тооцох шаардлагатай байна.

13. ХАӨМС-ын хувьд дэд өрхийг очиж буй газар нь заавал байнга оршин суугч байхыг шаардахгүй байх, түр оршин суугаа, түр эзгүй төлөвөөр бүртгэх боломжийг ашиглахыг зөвлөмж болгож, дэд өрхийн мэдээлэлд үндсэн өрхийн дугаарыг холбох, хадгалах шийдэл хийвэл өрх, өрхийн тэргүүлэгчийн тоог өсгөж буй одоогийн энэхүү асуудлыг шийдвэрлэх гарц болж болох юм.
14. Нийгмийн даатгалын сангаас олж авсан, ХАӨМС-д байхгүй хүмүүсийг олж тодруулах үүрэг өгөхдөө хайж байгаа хүний эцэг, эхийн овог, нэр, хаягийг УБЕГ-ын бүртгэлийн сангаас гаргуулж өгвөл хайлтыг илүү хурдан болгоход дэмжлэг болохоор байна.
15. ХАӨМС-ын хувьд шилжих хөдөлгөөний хугацааг НҮБ-ын зарчимд нийцүүлэн өөрчлөх нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор хүн амын хөдөлгөөн харьцангуй их байгаа үед их чухал байна.
16. Боловсролын салбарын мэдээллийн санд (БСМС-д) хандахад мэдээллийн ангилал, кодлолтод анхаарах, тухайлбал, статистикийн мэдээллийн системд ашигладаг олон улсын стандарт ангилалтай нэг мөр болгон нийцрүүлэх боломжийг хоёр тал хамтарч үзэх, ХАӨМС-д оруулах боловсролын түвшний мэдээллийг авахын тулд ангилал, кодын тодорхойлолтоо БШУЯ-нд гаргаж өгөх хэрэгтэй.
17. Сурагчдын мэдээллийг өрхийн мэдээлэлтэй холбох БСМС-ийн хэрэгцээ нь ХАӨМС-д боловсролын мэдээллийг өрхийн түвшинд татах хэрэгцээтэй тохирч байгаа боломжийг хэн хэндээ ашигтай зөв хувилбараар шийдвэрлэх хэрэгтэй байна.
18. Эрүүл мэндийн салбарын Н-Info-3 мэдээллийн систем хүн амын регистрийн системд суурилагагүй тул ХАӨМС-тэй уялдуулахын өмнө өөрийнх нь мэдээллийг зөв болгох ажил хийгдэх шаардлагатай.
19. Төрөлтийг хаа ч хүлээж авах ёстой тул регистрийн дугааргүй эхчүүд олон (мэдээллийн системд бид өөрсдийн нүдээр харсан) байгаагийн дээр регистрийн дугаар, овог, нэр нь алдаатай шивэгдэх магадлал ихтэй байгааг анхаарах шаардлагатай.
20. Гадаадын харьяат иргэдийн төрөлтийг бүртгэхэд олгох тусгай дугаартай болох талаар холбогдох талууд харилцан ярилцаж, тохиролцох шаардлагатай.
21. Цаашид статистикийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлж, мэдээллийг хэрэглэхэд хялбар болгохын тулд ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн эхлэл хэсэгт албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийн хүрээг нэгдсэн хүснэгтээр тусгах шаардлагатай байна.

Үүний үр дүнд хэрэглэгч ямар үзүүлэлтүүд улсын хэмжээнд, ямар нь аймаг, сум, багаар гарч мэдээлэгддэгийг эхлээд төвөггүй харах бололцоотой болно. Үүний үр дүнд ямар нэгэн үзүүлэлт олох хэрэгтэй болоход 1212 сайтаа ашиглахаас өмнө статистикийн байгууллагад хандаж, албан тоот явуулдгаа больж, мэдээллийн санг ашиглаж бэлэн байгаа мэдээллийг шуурхай олж авдаг болно.

22. ХАӨМС-г нийтэд ашиглуулахад мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

ХАВСРАЛТУУД:

ХАВСРАЛТ -1. *ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, газрын дарга нартай хийсэн
уулзалтын протокол*
Огноо: 2014/08/19

ҮСХ-ны дарга С.Мэндсайхантай хийсэн уулзалтын протокол

Хуралд суусан гишүүдийн нэрс:

Төсөл гүйцэтгүүлэгч талаас: ҮСХ-ны дарга С.Мэндсайхан, ҮСХ-ны ерөнхий менежер Т.Гантөмөр, Бүртгэл, тооллого, мэдээллийн газрын дарга Б.Ганбат, Мэдээллийн боловсруулалт, технологийн газрын дарга Л.Мягмарсүрэн

Төсөл гүйцэтгэгч талаас: НМТ-ийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэсүрэн, төвийн зөвлөх Б.Батмөнх, Б. Цэрэнханд, Г.Дагвасүрэн

Төслийн зохицуулагч: Энхнаран

Т.Гантөмөр:

- Төслийн эцсийн хугацаа 2014/12/25 гэдэгт итгэл үнэмшилтэй байгаа эсэхийг лавлаж, сонгосон Өвөрхангай аймгийн хувьд мэдээллийн тархаалтыг сайжруулах чиглэлээр өмнө нь ҮСХ-ны ажлын хэсэг явж тодорхой ажлууд хийсэн харин Хэнтий аймгийн хувьд ийм ажил хийгдээгүй тухай дурдаж, өөр санал байхгүй гэдгээ илэрхийлэв.

Б.Эрдэнэсүрэн: Төслийн багийн бүрэлдэхүүнийг танилцуулж, төсөл болон гэрээнд тусгасан асуудлынхаа талаар танилцуулга хийв.

С.Мэндсайхан: Төслийг хэрэгжүүлэх гэрээний зүйл заалтуудтай танилцлаа. Эхний хоёр бүлгийн талаар санал нэг байна. Харин мэдээлэл тархаалт, хэрэглэгчидтэй харилцах харилцааг сайжруулах, орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх асуудалтай холбогдуулан ҮСХ-ны эрэлт хэрэгцээтэй холбогдсон өөрийн үзэл бодлыг илэрхийлэв. Ингэхдээ 2 зүйлийг тодотгон сануулав.

2. Орон нутагт статистик мэдээллийн хэрэглээ ямар байгааг тодруулж, түүнийг ашиглах чадавх ямар байгааг үнэлж, тодорхой санал, зөвлөмж боловсруулах.
3. Орон нутгийн мэдээллийг ҮСХ-ны мэдээллийн төвлөрсөн сангуудаас татан авч бүрдүүлэх чиглэл барьж ажиллах.

ҮСХ-ны нэгдсэн мэдээллийн санд аймаг, сум, багийн түвшний мэдээллийг нэмэгдүүлж, орон нутгийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангасан загварыг сонгосон аймгуудад бий болгох нь маш чухал зорилт гэдгийг анхааралдаа авах.

С.Мэндсайхан дарга дараах тодорхой чиглэлээр үүрэг даалгавар өгөв.

Бидний төлөвлөж байгаа бүх ажлыг энэ баг дангаараа хийх бололцоогүй учраас яг хорооны хүсэж байгаа гол асуудалд анхаарлаа хандуулж, орон нутагт нь баг, загвар бий болгоход анхаарч ажиллахыг төслийн багаас хүсэх болно. Үүнд:

- Сумын хэмжээнд ДНБ-ыг тооцох, ядуурлыг тодорхойлох талаар өмнөх төслөөр нэлээд судалгаа хийсэн. Туршилт явуулсан. Харин орон нутгийн амьдрал дээр ядуу хүн гэж яг ямар хүнийг хэлээд байгаа нь тодорхойгүй байна. Онолын талын зөвлөгөөнүүд өгөгдөөд байна. Энэ талаар ажиглалт, судалгаа явуулж, сум, багт хэнийг ядуу гээд байгаа талаар зөвлөмж өгөх хэрэгтэй байна.
- Баг, сум, аймгийн хувьд одоогийн статистик үзүүлэлтүүдийн хүрээг өнгөрсөн жил шинэчлэн тогтоосон. Харин тэдгээрийг бүрэн тооцох ажил ямар байдалтай байгааг газар дээр нь тодруулах хэрэгтэй байна. Ер нь ҮСХ-ноос боловсруулж, мөрдүүлсэн аргачлал, үзүүлэлт газар дээрээ ямар байдалтай байгаа талаар маш тодорхой мэдээлэл хэрэгтэй байна. Шинээр аргачлал боловсруулахыг би та бүхнээс шаардахгүй. Багийн ажлаа ҮСХ-ны ажилтай уялдуулж, ажлынхаа явцыг мэдээлж, хамтран ажиллах.
- Одоогийн байдлаар 1212 болон ХАӨМС гэсэн 2 мэдээллийн сан ажиллаж байна. Тухайн сонгосон аймаг, багт эдгээр мэдээллийн сангуудын мэдээллийн чанарыг тодорхойлох, үзүүлэлтүүд хэрэгцээ шаардлагыг нь хангаж байгаа эсэх болон эдгээр мэдээллийн сангийн үзүүлэлтүүдээ ашиглаж чадаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх.
- Чанарт үнэлгээ өгөх ажлыг давхар хийе.
- Та бүхэн манай хорооны мониторингийн баг гэж өөрсдийгөө ойлгож ажиллаарай. Төвд гаргасан шийдвэр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа нь бид нарт маш чухал байгаа юм.
- Тухайн орон нутгийн хүмүүст эдгээр мэдээллийн санг хэрхэн ашиглах сургалт зохион байгуулбал статистикийн бүтээгдэхүүний орон нутгийн хэрэглээ эрс нэмэгдэнэ, энэ чиглэлээр та бүхэн олон зүйл хийнэ байх..

- ХАӨМС 40 үзүүлэлттэй. Эндээс баг, сумын үзүүлэлтийг харах бололцоотой. Үүнийг хэрхэн ажиллуулах асуудал тодорхойгүй байна. Энэ санг ашиглуулж хэрэглээ болгоход анхаарах.
- Мөн ХАӨМС-ын мэдээллийг хэнд хэрхэн ашиглуулах, нууцлалыг хэрхэн хангах журам гараагүй байгаа тул энэ талаар мэдэж авмаар байна. ХАӨМС-г засаг захиргаа, судлаачид, иргэдэд ашиглуулахдаа мэдээллийн нууцлалыг хэнд ямар түвшинд ямар задаргаатай өгөх вэ гэдэг зөвлөмж, чиглэлийг гаргаж өгөх хэрэгтэй байна.
- Аймгийн статистикийн товчоон номыг энэ төслийн эхний шатанд гаргасан. Энэ номонд тусгагдсан мэдээллийн ашиглалт ямар байгаад үнэлэлт өгч, цаашлаад ийм хэлбэрийн номыг аймаг өөрөө үргэлжлүүлэн гаргах бололцоог бий болгоход анхаарах. 2014, 2015 оны мэдээллийг яаж оруулж болохоор байна, цаашид хэрхэн тогтмол баяжилт хийх талаар санал зөвлөмж өгөх. Багийн түвшинд ашиглах программ хангамж бид бүтээнэ. Бидний хувьд нууцлах, ашиглуулах хүрээг нь тогтоож өгөх гол үүрэг хүлээнэ.
- 1212 сайтыг оффлайн горимоор ашиглах CD гаргаж аймгуудад хүргүүлсэн. Тухайн аймаг, сум, багт энэхүү CD ашиглахад хүндрэл бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлох. Хэрэглэгчийн зүгээс тавих шаардлага, санал, хүсэлт чухал байна.
- Сонгосон 2 аймгийн хувьд статистикийн мэдээллийг хөгжлийн бодлого төлөвлөлтөд ашиглах тал дээр анализ хийж, тоон дээр суурилсан тооцоог хийлгэж сургах арга хэмжээг зохион байгуулах. Ингэхдээ гол салбарууд болох хүн ам, эрүүл мэнд, боловсрол, ХАА авч болно. Магадгүй шилжих хөдөлгөөн байж болно
- Статистик мэдээллийн хэрэглээг сургуулийн багш нарын хичээл заалтад статистикийн үзүүлэлтүүдийг ашигладаг болгох, сурагчдаар статистик мэдээллийг ашиглуулж сургах чиглэлээр юу хийж болох талаар зөвлөмж боловсруулах хэрэгтэй байна. Ингэснээр эцэг эхчүүдэд хүүхдүүд нь зааж өгөх болно. Магадгүй Сэлэнгэ аймгийн туршлагыг авч болно. Багш нараар дамжуулж хүүхдүүдэд статистик мэдээллийг олж ирэх даалгавар өгсөн байдаг. Ингэснээр эцэг эхчүүд, хүүхдүүд статистикийн хэлтэст ханддаг болно. Сургууль бүр дээр 11 сарын 11-нд ажил зохион байгуулдаг болгох гэх мэт..
- Төвөөс тархааж буй мэдээлэл орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх дээр үнэлгээ өгөх

- ХАӨБ-ын сангийн мэдээлэл багийн дарга нараар дамжиж бүрддэг.Энэ ажил орон нутагт хэрхэн хийгдэж байгаа, багийн дарга нарын чадвар ямар байгааг анхааралдаа аваарай. Сонгосон аймагтаа түүврээр 10 өрхийн тоо мэдээлэл газар дээрээ ХАӨМС-тай хэр таарч байгааг тулган шалгах хэрэгтэй. Дэмжлэг үзүүлэх маягаар зөвлөж зааж засуулах ажил хийе.

Эцэст нь

- Шинээр үзүүлэлт тооцох асуудал байхгүй
- Гаргасан үзүүлэлтийн чанарт үнэлгээ өгөх , бодит байдалтай хэрхэн нийцэж байна гэж харах
- Тэнд ямар үзүүлэлтийн хэрэгцээ байгааг ҮСХ-д мэдээлэх
- Мэдээллийг авах тал дээр дэмжлэг үзүүлэх Хэнд ямар мэдээллийг ямар нууцлалтай өгөх вэ гэдэг хэрэгцээ, хэрэглээний заагийг гаргаж өгөх
- Танай баг Үндэсний СХ-ний итгэмжлэгдсэн мониторингийн баг гэдэг итгэл үнэмшилтэйгээр ажиллах
- Орон нутагт өөрсдөө бий болгосон мэдээллийн сан байгаа эсэх, туршлага болохоор юм байвал судлах, тэднийг ҮСХ ашиглах боломж байхыг үгүйсгэхгүй.
- Байхгүй байгаа зайлшгүй шаардлагатай мэдээллийг бий болгох саналыг ҮСХ-нд уламжлах, байгаа мэдээллийг ашиглуулж сургахад та бүхний ажил чиглэгдэх учиртай.
- ХАӨБ-ийн санг төвлөрсөн сангуудтай холбох програм боловсруулах бие даасан том ажлыг бид хийнэ. Харин та бүхэн энэ чиглэлээр юу анхаарах талаар зөвлөмж өгөөрэй.

**ХАВСРАЛТ-2. ҮСХ-ны мэдээллийн системтэй танилцсан уулзалтын
протокол**

ODC NSO project meeting minutes N-02

ҮСХ-ны мэдээллийн системтэй танилцсан уулзалтын протокол

2015 оны 8 дугаар сарын 20, 10:00-12:30

Уулзалтад оролцогчид:

НМТ-ийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэсүрэн, төвийн зөвлөх
Б.Батмөнх, Б.Цэрэнханд, Г.Дагвасүрэн

ҮСХ-ны МБТГ-ын дарга Л.Мягмарсүрэн, ахлах шинжээч
Ц.Эрдэнэмөнх, шинжээч М.Жаргал,

БТМГ-ын Бизнес регистр хариуцсан шинжээч
Ц.Амаржаргал

Уулзалтын байр: ҮСХ-ны хурлын танхим

Энэхүү уулзалтаар

- Мал тооллогын мэдээллийн сан,
- Хүн Ам Өрхийн Мэдээллийн сан
- Бизнес регистрийн сан гэсэн 3 үндсэн сангийн үйл ажиллагаатай танилцав.

Мал тооллогын мэдээллийн сан:

- Мал тооллогын мэдээллийн сангийн ажиллах зарчимтай онлайн орчинд танилцав.
- Багийн Засаг дарга нар мал тооллогын анхан шатны мэдээллээ онлайнаар, өрхөөр шивдэг болсон.
- Малчны зээлийн асуудлыг хөнгөвчлөх зорилгоор Монгол банкны зээлийн системийг “Малын лавлах”-тай болгоход гэрээ байгуулан хамтран ашигласан байна. Банкны зээлийн эдийн засагчид малчны регистрийн дугаараар “А” дансыг нь шалган тухайн малчны малын мэдээллийг харах боломжтой.
- “Малын лавлах”-ыг УБЕГ-ын ТҮЦ машинд оруулахаар ажиллаж байгаа.
- Мөн ezasag.mn сайтаас мэдээлэл авах боломжтой.
- 12 сард мал тооллогод 1600 баг, зарим малтай хороод хамрагдана. Багийн засаг дарга нар өөрсдийн кодоор санд орж байгаа. Баг бол өөрийн багийн мэдээллээ, сум бол сумын (төрийн санд нь эрх өгсөн) эрхээр хандана.

Тус санд

- Багийн дүнгээр (I бүлэг) 21 үзүүлэлт
- Өрхийн дүнгээр (II бүлэг) 5 хүснэгт бүхий үзүүлэлт
- Тавиул малын (III бүлэг) 5 хүснэгт бүхий үзүүлэлт

- ААН байгууллагын (IV бүлэг) 13 хүснэгт бүхий үзүүлэлт
- Малчин, малтай өрхийн бүлэглэлт (V бүлэг) 20 хүснэгт бүхий үзүүлэлт
- Өрхийн жагсаалт (VI бүлэг) 5 хүснэгттэй бөгөөд хүн бүрээр харах боломжтой.

Эдгээр бүх тооноос 1212-т аль хүснэгтүүдийг оруулах шаардлагатай байгааг тодорхойлох!!!

Хүн ам өрхийн мэдээллийн сан (ХАӨМС):

Тус сангаас дараах тайлангууд гарна.

- Хүн ам (24 хүснэгт)
- Өрхийн (15 хүснэгт бүхий үзүүлэлт)
- Системийн тайлан (3 хүснэгт бүхий үзүүлэлт)
- График
- Бэлэн тайлан
- ХАӨМС-ийн явцын тайлан
- Жагсаалт өрх, хүн амаар
- Судалгаа (багийн даргад, тухайн багт судалгааны түүвэрт хамрагдсан өрх байгаа эсэх нь харагдана)
- ҮСХ-ны вэб хуудасны **ХАӨМС** гэсэн icon дээр дарахад сум, багийн мэдээллийн санд хандах эрхтэй хэрэглэгчдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой форум бий. (үүнийг ашиглаж байгаа эсэхийг тодорхойлох) Орон нутгаас мэдээллийн сангийн талаар санал хүсэлтээ байнга ирүүлэх боломжтой боловч багийн дарга нараас санал цөөн ирж байгаа. Үүнийг орон нутагт явахдаа анхааруулж сургаж, зааварлах шаардлагатай.
- Өрхийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг төслийн баг сонгогдсон сум, багтаа түүвэр байдлаар шалгаж, тулгалт хийж үзэх шаардлагатай гэж тохиролцлоо.
- Хувь хүний үзүүлэлт
 - боловсролын түвшин
 - СӨБ, сургуульд хамрагдсан байдал (эхний 2 үзүүлэлтийг боловсролын яамны сантай холбохоор ажиллаж байгаа)
 - Гэрлэлтийн байдал

Иргэн бүр өөрийнхөө мэдээллийг ХАӨМС-д шалгаад хариу өгөх боломжтой юм байна.

ХАӨМС-нь иргэдийн шилжих хөдөлгөөний талаар маш нарийн мэдээлэл агуулдаг бөгөөд шилжих хөдөлгөөнийг тухай бүр нь бүртгэдэг. Ингэхдээ иргэд эхлээд шилжин очиж байгаа газрынхаа засаг захиргаанд шилжин ирэх хүсэлтээ илэрхийлж, бүртгүүлдэг. Хүлээн авч байгаа газрын хорооны буюу багийн засаг дарга уг иргэнийг бүртгэн авснаа санд оруулдаг. Сан автоматаар уг иргэний хуучин амьдарч байсан үндсэн хаягаар тухайн хүнийг шилжүүлэхийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг илгээдэг. Хуучин оршин сууж байсан засаг захиргаа нь шилжүүлэхийг зөвшөөрсөн хариу ирсний дараа уг хүний бүртгэл байнгын оршин суугч болж баталгааждаг.

Шилжих хөдөлгөөнтэй холбоотой 2 төрлийн жагсаалт Багийн Засаг даргад байдаг байна.
Үүнд:

1. БЗД шилжих хөдөлгөөнийг баталгаажуулаагүй / иргэн өөрөө зөвшөөрөөгүй шилжих хөдөлгөөн: Засаг захиргааны өөр нэгж үрүү шилжсэн иргэдийн шилжилтийг БЗД баталгаажуулахгүй гацааж байгаа хүмүүсийн жагсаалт юм. Мөн шилжих хөдөлгөөнөө баталгаажуулахыг зарим иргэд өөрсдөө зөвшөөрдөггүй гэнэ. Энэ жагсаалт ХАӨМС-д өмнөх дугаар нь улаан өнгөөр тэмдэглэгдсэн байгаа. Үүнийг төслийн багийнхан сонгосон аймаг, сум, дүүргийнхээ Засаг даргатай уулзаж, хувийн кодоор нь орж, дээрх жагсаалтыг олж, ямар шалтгаанаар шилжин явахыг нь зөвшөөрсөн хариу өгөхгүй байгааг торуулахаар тогтлоо.
2. Шараар тэмдэглэгдсэн жагсаалт: Энэ нь Засаг даргын мэдлийн хаягаараа оршин суудаггүй, хаягандаа байхгүй, хаачсан нь тодорхойгүй байгаа иргэд бөгөөд өмнө нь тухайн орон нутагт оршин суудаг гэж бүртгэгдсэн хүмүүс болно. (Шар тэмдэгтэй хүний асуудлыг яаж шийдвэрлэж байна вэ, ямар санал бодол байгааг олж мэдэх)

Бизнес регистрийн сан:

- Санг ажиллуулах STAT.SIDB, STAT.ECO гэсэн онлайн горимтой 2 програм ашиглаж байгаа.
- STAT.SIDB: БР-1, БР-2 маягтуудаар цуглуулсан мэдээллийг оруулах, нэмэгдсэн хуулийн этгээдийг шинээр нэмэх, засвар өөрчлөлт хийх (хэрэглэгчдэд хэрэглээний эрх, нууц үг өгдөг) хэрэглэгчийн эрхтэй хүн хандана.
- Хуулийн этгээдийн жагсаалтыг хүссэн хэлбэр, төрлөөр үүсгэх боломжтой. Жишээ нь: захирлын нэрээр, байгууллагын регистрийн дугаараар, ААН-ын төрлөөр, орон нутгийн нэгжийн нэрээр, үйл ажиллагааны чиглэлээр гэх мэт
- STAT.ECO: Түүх гэсэн хэсэгт өмнөх улирлын хадгалсан баазаа харах боломжтой. Үр дүнгээ л харна.
- Одоогоор бизнесийн регистрийн сан нь аймгийн түвшинд шинэ аж ахуйн нэгжийг нэмэх, хасагдсаныг хасах замаар ажиллуулж байгаа бөгөөд сум, багт өөрчлөлт оруулах эрх өгөгдөөгүй байгаа ажээ.
- Мэдээллийн санг үүсгэхдээ УБЕГ-аас шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдийн мэдээллийг (нийтдээ 140 мянга байгаа) авдаг бөгөөд бизнесийн мэдээллийн сан нь одоогоор 120 мянган ААН-ыг хамруулж байна. Татварын Ерөнхий газраас ажиллагсдын тоо, цалинг авдаг.
- Энэхүү сангаас холбогдох мэдээлэлд анализ хийх, хүснэгт гаргах боломж байдаг бөгөөд орон нутагт үүнийг ашиглах тал дээр анхаарах шаардлагатай. Мөн орон нутаг ААН-ыг ангилахдаа алдаа их гаргадаг.
- Энэ талаар ҮСХ онлайн сургалт явуулж, гарын авлага хүргүүлсэн ажээ.

Мониторингийн багийн зүгээс гаргах зөвлөмжийн санал:

1. Мэдээлэл солилцох эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах,
2. Мэдээллийн нууцлалыг хэрэглэгчийн түвшин бүрд хэрхэн хангах санал,

3. Эдгээр сангуудын мэдээлэл хэрэглэгчдэд бүрэн тараагдаж байгаа эсэхэд 1212 системд буй мэдээлэлтэй тулгаж хяналт хийх,
4. ХАӨМС сангийн форумыг сум, багийн мэдээллийн санд хандах эрхтэй хэрэглэгчид хэрхэн ашиглаж байгааг тодруулах, хэлэлцүүлэгт оролцож байгаа эсэхийг олж мэдэх,
5. Гэр бүл, өрхийн тодорхойлолтыг хэрхэн ойлгох вэ,
6. Хүн амын шилжих хөдөлгөөнийг баталгаажуулж байгаа байдалтай танилцах,
7. Бизнес регистрийн сангийн мэдээлэл орон нутгийн (баг, сумын) хэрэглэгчдэд хэр хэрэгтэй байна вэ
8. Аймгууд бизнес регистрийн сангийн цахим заавар, програмаа хэр ашиглаж байна
9. ААН-г хайхдаа үйл ажиллагааг нь буруу кодлоод байдаг, ямар тусламж дэмжлэг хэрэгтэй байна вэ?

ХАВСРАЛТ-3. ҮСХ-ны Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн мэдээ хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын протокол

2015 оны 8 дугаар сарын 21, 11:00-13:30

Уулзалтад оролцогчид:

НМТ-ийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэсүрэн, төвийн зөвлөх Б.Батмөнх, Б.Цэрэнханд, Г.Дагвасүрэн

ҮСХ-ны МБТГ-ын ахлах шинжээч Ц.Эрдэнэмөнх, ХАНСГ-ын Боловсрол, снижлэх ухааны салбар хариуцсан шинжээч Э.Ариунчимэг, Эрүүл мэнд нийгмийн үзүүлэлт хариуцсан шинжээч Н.Алтантүлхүүр, Нийгмийн даатгал, халамжийн үзүүлэлт хариуцсан шинжээч Амарбаясгалан, Хүн ам хариуцсан статистикч Т.Уянга, Тооллогын товчооны дарга Ж.Мөнхбадар

Уулзалтын байр: ҮСХ-ны хурлын танхим

Захиргааны статистик мэдээллийг нийлүүлэгч гол гол салбаруудын мэдээ хариуцсан ҮСХ-ны ажилтнуудтай уулзаж, мэдээ тайланг хүлээн авч байгаа хэлбэр, мэдээлэл солилцох үйл ажиллагаанд нэвтэрч буй мэдээллийн технологийн шийдлүүд, тохиолдож буй хүндрэл бэрхшээлийн талаар ярилцлаа. Энэ уулзалт нь холбогдох салбаруудын мэдээллийн системтэй танилцах, салбар хоорондын мэдээлэл солилцох шийдлийн санал боловсруулахад ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

Боловсрол, шинжлэх ухаан: Э.Ариунчимэг

- ЕБС-ийнхан яам руу төгсөгчдийн мэдээллээ БСМС-д онлайнаар шивдэг. (Замд нь аймгийн боловсролын газар нь хянаж, баталгаажуулдаг)
- МСҮТ-ийн мэдээллийг хөдөлмөрийн яамнаас авдаг.
- ЕБС-аас бусад СӨХ болон дээд боловсролын мэдээ одоогоор БСМС-д сан байхгүй, эксел нэгтгэлээр авдаг.
- Боловсролын яамны мэдээллийн сан зөвхөн 2014 оны тоотой байгаа.
- БСШУЯ мэдээлээ шууд ҮСХ-ны серверт оруулах заавартай, энд ҮСХ-ны мэргэжилтэн хүлээн авах ёсгүй.

Төгсөгчдийн мэдээлэл сүүлийн жилүүдийнх байгаа. Харин өмнөх олон жилийн мэдээлэл байхгүй.

- Орон нутагт мэдээллийн хэрэгцээ гарсан үед 1212-д байхгүй тохиолдолд хаанаас мэдээллийг авч байгааг тодруулах.
- СӨБ, Их Дээд сургууль төгсөгчдийн мэдээг сантай холбох шаардлага байгаа, одоогоор маягтаар авч байгаа.
- МУ-аас гадаадад суралцагчдын мэдээллийг авахад хүндрэлтэй. Тодорхой маягтаар мэдээ авдаг ч маягт дахь үзүүлэлтүүд бүрэн гүйцэд бөглөгддөггүй.

- Төгсөгчдийн тоо хугацаандаа ирдэггүй хүндрэл бэрхшээл гардаг
- ХАӨМС-ийн боловсролын үзүүлэлтийг холбож үзсэн үү? гэсэн асуултад энэ талаар уулзалт хийгдсэн байх ёстой гэхдээ тодорхой мэдэхгүй байна гэж хариулав. Хоёр санд ижил мэдээллийн тулгалт хийгдээгүй ажээ.

Эрүүл мэнд: Н. Алтантүлхүүр

- ЭМСЯ-ны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс мэдээгээ авдаг.
- Мэдээллийг цахимаар болон тамгатай маягтын хэлбэрээр мэдээгээ явуулдаг. (сар болгоны 6-нд)
- Шууд онлайн аар хандаж авдаг уу? гэсэн асуултад Тэгж хандах яриа хийгээгүй. Шууд нэгтгэсэн мэдээг нь онлайн болон цаасан хэлбэрээр маягтын дагуу авдаг гэж хариуллаа.
- САРЫН МЭДЭЭГ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ГАРГАЖ БОЛОХ ЮМ ГЭСЭН САНАЛ яригдав.
- Мэдээ аваад тархаах хугацаа давчуу байдаг. Тэр хооронд яамнаас засвар ирэх тохиолдолд олонтаа.
- Оруулах засварыг яам medee.nso-гоор дахин авдаг. (Давхар өөрийн хаягаар, IT*гаар дамжуулж авахаар IT*ууд майлээ шалгахгүй удах тохиолдол гардаг)
- Нялхсын эндэгдлийн мэдээг эрүүл мэндийн яамны мэдээгээр авдаг.
- Нас баралт жилийн эцэст өвчлөлийн шалтгаанаар ирдэг.
- ЭМ-ийн мэдээ гарахаад өөр асуудал харьцангуй гайгүй.
- Эрүүл мэндийн сантай ХАӨМС-г холбох тухай яригдаж байгаа яг яаж хэрэгжүүлэх ажилд нь оролцоогүй. Эрүүл мэндийн санд хандах эрх байхгүй.

Хүн ам: Т.Уянга

- Хүн амын ердийн хөдөлгөөний ХА-1 мэдээг аймгийн иргэний бүртгэлээс Статистикийн хэлтсээр дамжуулж авч байгаа.
- Хүн амын шилжих хөдөлгөөний ХА-2, суурин хүн амын ХА-3 мэдээг хуучнаараа Засаг захиргааны бүртгэлээс баг хорооны засаг дарга, аймгийн статистикийн хэлтсээр дамжуулж авч байгаа.
- Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралт иргэний бүртгэлийнхээс өндөр. Энэ 2 эх үүсвэрийн зөрүү ойртох хандлага байхгүй. (төрөлт нас баралт зөрүү дээр + гадаадад төрсөн нас барсан зөрүү). Үүн дээр гадаадад төрсөн, нас барсан хүний тоог иргэний бүртгэлээс авч, энэ 2 –ыг нэгтгэн мэдээг гаргаж байна.

Ж.Мөнхбадар:

- ХА-1, ХА-2, ХА-3-г 2015 оныхыгоо аймгаас авсан.
- 2016 оноос ХАӨМС-аас шууд авч эхэлнэ.
- Эрүүл мэндийн Н-Info-3 мэдээллийн системээс төрөлт, нас баралтын мэдээг онлайн авахаар тохиролцож байгаа.

Нийгмийн даатгал, халамж : Амарбаясгалан

- Халамжийн мэдээг аймгийн халамж, үйлчилгээний газараас статистикийн хэлтсээр дамжуулан авдаг
- Нийгмийн даатгалын мэдээг НДЕГ-аас сар бүрийн 5-ны дотор албаны мэйлээр авдаг.
- Халамж асуудалтай байгаа. 2011 онд Халамж үйлчилгээний ерөнхий газраа мэдээлэл нь төвлөрдөг байсан юм байна лээ. Харин одоо халамж олгодог эрхийг аймгуудад өгсөн. Аймгаас мэдээ авсан чинь мэдээ алдаатай хангалтгүй байхаар нь халамжийн ерөнхий газраас аймгуудын мэдээг авахад хэцүү байгаад байгаа. Аймгуудын халамж үйлчилгээний газар нь цахим сантай. Харин ХҮЕГ нь аймгуудын санг зөвхөн харах эрхтэй тул засвар өөрчлөлт хийх, мэдээг нь үнэн зөв эсэхийг нягтлах боломжгүй байдаг гэсэн хариу өгдөг.
- Ерөнхий газраас мэдээ өгөх сонирхол бага байгаа. Та нар өөрсдөө мэдээгээ аймгаасаа ав гэдэг.
- Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
- Албан ёсны маягт байхгүй учраас халамж үйлчилгээний ерөнхий газар мэдээ өгөх боломжгүй.
- Аймгууд нэгдсэн сан руу мэдээллээ шивдэг гээд байгаа.
- Бид нарт сангийн яаманд явуулж байгаа ерөнхий гол мэдээллээ өгөөд байгаа.
- Мэдээллийг өмнө гардаг байсан үзүүлэлтүүдээрээ л гаргаж байгаа.
- Даатгал бол мэдээллийн сантай. Надад онлайн эрх өгөөгүй байгаа. Хариуцаж байгаа хүмүүс нь ч гайгүй.
- Даатгалын мэдээллийг тэндээ татаад нааш нь явуулдаг.
- Хөгжлийн бэрхшээл аймгийн засаг захиргаанаас авж байгаа юу? Тийм.
- Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийг нийгмийн даатгалаас авах хэрэгтэй!!!
- Нийгмийн хамгааллын халамж, үйлчилгээний статистик үзүүлэлтийг сайжруулах төсөл хэрэгжиж байгаа !!!
- Даатгалын сан олон жил болж байгаа сайн сан байгаа. Даатгалын сантай сайн танилцах хэрэгтэй.

Мониторингийн багийн зүгээс гаргах зөвлөмжийн санал:

1. ҮСХ-ны салбар хариуцсан ажилтнууд МБТГ-н ажилтнуудад технологижуулах ажлыг хэт даатгаж, өөрсдөө төдийлөн оролцохгүй байна уу гэж ажиглагдаж байна. Энэ нь ажлын хурдад нөлөөлж болох талтай тул ажлын явцад тодруулж, дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх санал бэлтгэх,
2. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, даатгалын салбаруудын мэдээллийн системтэй танилцах, ҮСХ-ны мэдээллийн системтэй харилцан мэдээлэл солилцох боломжууд, мэдээллийн технологийн шийдлүүдийг судалж санал, зөвлөмж гаргах
3. Монгол Улсаас гадаадад суралцагчдын тухай мэдээллийг сайжруулах чиглэлээр БШУЯ-ны бодлого чиглэлийг судлах, албан ёсны статистикийн мэдээнд хамруулах санал боловсруулах,
4. НДЕГ-ын мэдээллийн сангаас хөгжлийн бэрхшээлийн мэдээллийг онлайн авч болох боломж байгаа эсэхийг тодруулах,

5. Орон нутагт ажиллахдаа Халамжийн мэдээллийн сантай танилцах, мэдээнд алдаа гарсан тохиолдолд статистикийн байгууллагатай хамтарч ажиллах боломжийг судлах,
6. Орон нутгийн хэрэглэгчид хэрэгцээт мэдээлэл нь 1212-т байхгүй тохиолдолд хаанаас мэдээллийг авч байгааг тодруулах,
7. Мэдээллийн технологийн дэд бүтцийн хүртээмжтэй холбоотойгоор орон нутагт тулгарч буй мэдээллийг онлайнаар шуурхай авч чадахгүй байгаа нөлөөллийг бууруулах арга замыг олж харахыг хичээх, холбогдох байгууллагуудад хандаж зөвлөмж гаргах.

1.5. БСШУЯ-ны Боловсролын мэдээллийн систем, ЭМЯ-ны эрүүл мэндийн мэдээллийн сан, ХАНХЯ-ны нийгмийн халамж, даатгалын мэдээллийн сангуудтай танилцах зөвшөөрлийг холбогдох яамдаас авч, уулзалт зохион байгуулах.	Б.Эрдэнэсүрэн																		
1.6. Мал тооллогын сан, ХАӨБ-ийн сан, Бизнес регистрийн сан, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн даатгал, халамжийн сангуудын талаар дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл бэлтгэх.	Б. Цэрэнханд																		
1.7. Энэхүү төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн ажил, судалгааны талаар дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэх.	Б.Эрдэнэсүрэн																		
1.8. Өнөөгийн байдлаар аймаг, сум, багийн түвшинд тооцохоор шийдвэрлэсэн статистикийн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлох.	Б.Эрдэнэсүрэн																		
1.9. ҮСХ-ны цахимхуудас www.1212mn-д тавигдсан эдийн засаг, шинжлэх ухаан, шүүхийн статистик үзүүлэлтүүдийг орон нутгийн статистик үзүүлэлтийн хүрээтэй тулганшалга, дүгнэлт, санал бэлтгэх, 1212.mn сайтыг баяжуулах зөвлөмж боловсруулах.	Б.Батмөнх																		
1.10. ҮСХ-ны цахим хуудас 1212.mn-д тавигдсан нийгмийн статистик үзүүлэлтүүдийг орон нутгийн статистик үзүүлэлтийн хүрээтэй тулган шалгаж, дүгнэлт, санал бэлтгэх, 1212.mn сайтыг баяжуулах зөвлөмж боловсруулах.	Б.Цэрэнханд Г.Дагвасүрэн																		

<p>2.2. Зорилтот бүлэг тус бүрийн статистик мэдээллийн талаарх чанарын судалгааг явуулж, мэдлэг боловсролын түвшинд үнэлгээ хийнэ. Тус ажлын хүрээнд хэрэглэгчдийн мэдлэгийг үнэлэх, сул талыг нь олж тогтоох асуулга боловсруулна.</p>	<p>Б.Эрдэнэ-сүрэн</p>																
<p>2.3. Зорилтот бүлгийн хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн талаарх боловсролыг дээшлүүлэх стратеги, бодлогын баримт бичиг боловсруулна.</p>	<p>Б.Эрдэнэсүрэн Б.Батмөнх</p>																
<p>2.4. Зорилтот бүлэг тус бүрт зориулсан сургалтын модуль боловсруулна.</p>	<p>Б.Эрдэнэ-сүрэн Б.Бат-мөнх</p>																
<p>2.5. Орон нутгийн хэрэглэгчдийн статистикийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулах</p>	<p>Багийн гишүүд</p>																
<p>2.6. www.1212.mn болон ХАӨМС-г хэрхэн ашиглах талаар хэрэглэгчдэд зориулсан сургалт зохион байгуулна.</p>	<p>Багийн гишүүд</p>																
<p>2.7. Аймгийн статистикийн товчоон эмхтгэлд тусгагдсан мэдээллийн ашиглалт ямар байгаад үнэлэлт өгч, цаашлаад ийм хэлбэрийн номыг аймаг өөрөө үргэлжлүүлэн гаргах бололцоог бий болгоход анхаарах. 2014, 2015 оны мэдээллийг яаж оруулж болохоор байна, цаашид хэрхэн тогтмол баяжилт хийх талаар санал зөвлөмж өгөх</p>	<p>Багийн гишүүд</p>																

Бүлэг 3. Мэдээлэл тархаалт, хэрэглэгчидтэй харилцах харилцааг сайжруулах

<p>3.1. Аймаг, сум, багийн түвшинд цуглуулдаг статистикийн мэдээллийн үзүүлэлтийн жагсаалтыг албан ёсны болон захиргааны төрлөөр байгууллага нэг бүрээр, түүний давтамж, хариуцан гаргадаг албан тушаалтан, хүлээн авч ашигладаг байгууллага, хүн, хамрах хүрээний хамт доорх хүснэгтээр гаргуулан авна. Үүнд: - Өвөрхангай, Хэнтий аймгийн албан ёсны болон захиргааны мэдээллийн эх үүсвэр, тархаалтын судалгаа (Дэлгэрэнгүй хүснэгтийг хавсралтад тусгав)</p>	<p>Б.Эрдэнэ-сүрэн Б.Батмөнх</p>															
<p>3.2. Орон нутагт статистик мэдээллийн хэрэглээ ямар түвшинд байгааг тодруулж, хэрэглэгчдийн зүгээс ашиглах мэдлэг, чадварын түвшинд зохих үнэлгээ хийх, Ялангуяа www.1212.mn болон ХАӨМСангуудыг хэрхэн ашиглаж байгаа, тэнд байгаа үзүүлэлтүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлгээ хийх, энэ чиглэлээр хэрэглэгчдийн санал хүсэлтийг судлах</p>	<p>Б.Цэрэнханд</p>															
<p>3.3. Мэдээллийн хэрэглэгчидтэй тогтоосон харилцааны талаар хэрэглэгчид, мэдээлэл боловсруулагч нартай уулзалт хийж, чанарын судалгааг явуулна.</p>	<p>Б.Батмөнх Б.Цэрэнханд</p>															

3.4. Аймаг, сум, багийн хэмжээнд тооцох статистикийн үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлгээ өгч, санал боловсруулах, сонгосон аймаг, сум, багийн үзүүлэлтийн хүрээг нарийвчлан тогтоох, чанарын судалгааны үр дүнгээр орон нутгийн мэдээллийн хэрэгцээг нарийвчлан судалж, зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүдийг олж тогтоох	Багийн гишүүд																	
3.5. Аймаг, сум, багийн мэдээллийн эрэлт хэрэгцээний талаар (бизнес эрхлэгчид, төрийн байгууллага, иргэд, ТББ) чанарын судалгааг явуулж дүгнэлт гаргана.	Багийн гишүүд																	
3.6. Чанарын судалгааны үр дүнд үндэслэн орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийх, эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийн энгийн, хүртээмжтэй тархаалтын тогтолцоог бий болгох зөвлөмж боловсруулна.	Багийн гишүүд																	
3.7. Дунд сургуулийн багш нартай уулзаж, статистикийн мэдээллийг сургалтад ашиглах, ҮСХ-ны www.1212mn цахим хуудсыг ашиглах талаар багш нарт сургалт хийж, тэднээр дамжуулан ахлах ангийн сурагчдад статистик мэдээллийг хайж олох, ашиглах дадал олгох талаар хамтран ажиллах	Б.Эрдэнэсүрэн																	

Бүлэг 4. Орон нутгийн мэдээллийн санг хөгжүүлэх талаар

<p>4.1. Зарим салбарын албан ёсны статистикийн мэдээллийн онлайн санг орон нутагт хэрхэн бүрдүүлж, ашиглаж байгаа байдалтай танилцаж, мэдээллийн урсгалыг судлах, Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн - Боловсролын - Бизнесийн регистрийн - Мал тооллогын - Халамжийн г.м 	Б.Цэрэнханд																	
<p>4.2. Орон нутагтай холбоо тогтоож, судалгаа хариуцан ажиллах мэргэжилтэнг сонгож, гэрээ байгуулах.</p>	Б.Эрдэнэсүрэн																	
<p>4.3. Орон нутгийн статистикийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх чиглэлээ урьдчилан боловсруулж, хүргүүлэх.</p>	Б.Эрдэнэсүрэн																	
<p>4.4. ҮСХ-ны даргын 2014 оны 101 тоот тушаалын 2А хавсралтын хэрэгжилтийг тодорхойлж, санал, дүгнэлт боловсруулах.</p>	Б.Батмөнх																	
<p>4.5. ҮСХ-ны даргын 2014 оны 101 тоот тушаалын 2Б хавсралтын хэрэгжилтийг тодорхойлж, санал, дүгнэлт боловсруулах.</p>	Б.Цэрэнханд																	
<p>4.6. Мэдээллийн нэгдсэн сангуудын уялдааг хангаж, ашиглалтыг сайжруулах арга зам нь Орон нутгийн статистик үзүүлэлтийн урсгалд нөлөөлөх эсэхийг тодорхойлох</p>	Б.Цэрэнханд																	
<p>4.7. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн даатгал, халамжийн сангийн мэдээллийг 1212.mn сайт, ХАӨБ-ийн сантай холбох зөвлөмж боловсруулах</p>	Б.Цэрэнханд багийн гишүүд																	

4.8. Орон нутгийнхаа түвшинд ашигладаг захиргааны мэдээллийн бие даасан сан байгаа эсэхийг судлах	Багийн гишүүд																
4.9. Чанарын судалгааны үр дүнг үндэслэн орон нутгийн статистикийн мэдээллийн тархаалтын өнөөгийн байдал, хэрэглэгчтэй тогтоосон харилцаанд дүн шинжилгээ хийх, эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийн энгийн, хүртээмжтэй тархаалтын тогтолцоог бий болгох зөвлөмж боловсруулна.	Багийн гишүүд																
4.10. 1212 сайт болон ХАӨБ-ын сангийн мэдээллийг орон нутгийн мэдээллийн сантай холбох програм, онлайн горимын талаар зөвлөмж боловсруулах.	Г.Дагвасүрэн Б.Цэрэнханд																
4.11. Орон нутгийн байнгын хэрэглээний үр дүнгийн мэдээллийн сан байх хэрэгцээг судалж, тухайлбал “Статистикийн товчоон”-ыг жил бүрийн мэдээллээр баяжуулан шаардлагатай үед хэвлэх хэрэгцээ, хэрэглэгчдийн саналыг үндэслэн боломжит загварыг боловсруулах, турших	Б.Цэрэнханд Г.Дагвасүрэн																
4.12. Сонгосон 2 аймгийн орон нутгийн мэдээллийн санг бүрдүүлэх.	Багийн гишүүд																
4.13. Салбарын мэдээллийн санг ХАӨБ-ийн сантай уялдуулан, түүнийг онлайн горимоор ашиглах боломжийг сонгосон нэг салбараар (боловсрол) жишиг болгон программ боловсруулж, түүнийг турших.	Г.Дагвасүрэн																

эсэх, тэдгээрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгааг судлах																	
4.21. Орон нутгийн мэдээллийн сангийн ашиглалтын асуудлаар зорилтот бүлгүүдийг оролцуулсан хурал зохион байгуулах.	Б.Эрдэнэсүрэн																

ХАВСРАЛТ - 5. Чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлага хэлбэрээр оролцооны аргаар явуулах удирдамж

Нэг. Бүх бүлэгт нийтлэг анхаарах асуудлууд

Ярилцлагын зорилго: Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн статистикийн мэдээлэл, түүний цахим сангуудын тухай мэдлэг, ашиглалт, хэрэглээг үнэлэх, хэрэгцээг олж харах, санал зөвлөмжийг авах

Ярилцлагын дүрэм:

1. Оролцогчдыг бүртгэнэ, хаягийг нь авна. – Статистикийн хэлтсийн ажилтан
2. Асуулга судалгааг бөглүүлнэ – Зөвлөх баг
3. Ярилцлага хийж буй зорилго, ярилцлагын явцын зарчмыг тайлбарлана – Зөвлөх баг
4. Ярилцах а үргэлжлэх хугацаа 2 цаг. Хүн бүрт хугацаа өгч хязгаарлах шаардлагагүй.
5. Ярилцлагын явцын протокол хөтлөх, эсвэл бичлэг хийхээ оролцогчдод хэлэх
6. Ярилцлагыг зорилгын хүрээнд асуудлыг сунжруулахгүй, зөв чиглүүлэх – Зөвлөх баг

Ярилцлагыг чиглүүлэх асуултууд:

Нийтлэг зүйл:

1. Уулзалтын зорилго, төслийн ач холбогдлыг танилцуулах. Он дуустал байнгын холбоотой ажиллаж цаашид ажиллах чиглэлийг тодорхой болгоно.
2. Мэдээлэл сурталчилгаа эрхэлдэг бүх хүний хаяг утас хэрэгтэй. Цаашид онлайн харилцаж байх тухай тохиролцоно..

1-р бүлэг асуулт:Хэрэглэгчдийн статистик мэдээллийн боловсролын түвшин, мэдээллийг олж авах, ашиглах чадвар

- -Орон нутгийн бодлого, төлөвлөлт хийх, албан ажлаа хөтлөн явуулахдаа яг аль байгууллагын мэдээллийг гол төлөв ашиглаж байна вэ?
Жилийн эхний хүн ам: Тайлант оны эхэнд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.

Жилийн эцсийн хүн ам: Тайлант оны эцэст, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.

Хүн амын жилийн дундаж тоо: Тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ бэлэн хүн амын тоог 10 жил тутамд суурин хүн амын тоог жил бүр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр: Хүн ам, орон сууцны тооллогын дүн болон суурин хүн амын жилийн эцсийн мэдээ.

Тооцох аргачлал:

Жилийн эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг хоёрт хувааж жилийн дундаж хүн амын тоог тодорхойлно.

Үзүүлэлтийн тоон утга:

Хүн амын тоо, мянган хүнээр

ОН	2010	2011	2012	2013	2014
Хүн амын тоо	2760,9	2811,6	2867,4	2930,3	2995,9
Хүн ам зүйн ачаалал	46,7	46,5	46,3	47,0	47,2

6. Ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн түвшин

Үзүүлэлтийн гол агуулга: Хөдөлмөрийн насны хүн амын хэд нь эдийн засгийн хувьд идэвхтэй байгаа, хэд нь хөдөлмөр эрхэлж байгааг илтгэн харуулна.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлж байгааг харуулна. Хөдөлмөр

эрхлэлтийн түвшин нь эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг харуулна.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ улирал бүр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны ажиллах хүчний судалгаа

Тооцох аргачлал: Ажиллах хүчний оролцооны түвшинг эдийн засгийн

идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100$$

Үзүүлэлтийн тоон утга:

Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн байдал

	2010	2011	2012	2013	2014
Ажиллах хүчний оролцооны түвшин	61,3	64,2	61,6	60,9	60,3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	55,5	59,7	56,7	56,2	55,6
Эдийн засгийн идэвхтэй хүн ам/мян. хүнээр/	1129,8	1104,0	1106,0	1160,3	1127,7
Эдийн засгийн идэвхгүй хүн ам/мян. хүнээр/	713,7	616,6	688,8	719,3	742,5

7. Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага.

Үзүүлэлтийн гол агуулга: Хүмүүсийн амьжиргааны байдалд үнэлгээ өгөхөд нэг өрх сард хэдий хэмжээний орлого олж, хэдий хэмжээний зарлага гаргаж байгааг тооцох явдал чухал байдаг. Харин тухайн өрхийн орлого, зарлагын хэмжээг тодорхойлох нь тийм ч амар бус ажил байдаг. Ялангуяа хүмүүсийн амьдралд кассаар тооцоо хийх арга давамгайлж чадаагүй, хүмүүс өрхийн тооцоонд суралцаагүй нөхцөлд тооцоо хийхэд бүр ч хэцүү байдаг. Энэ үзүүлэлтийг оновчтой тооцсоноор айл өрхүүд ямар үйл ажиллагаагаар орлого олдог түүнийгээ юунд голлон зарцуулдгийг тооцож, амьжиргааны байдлыг үнэлэх бололцоотой болдог.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Өрхийн сарын орлого нь цалин, хөлс, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж зэрэг мөнгөн хэлбэрээр орж ирэх орлогоос гадна өөрийн эзэмшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж олсон орлого, өөрийн аж ахуйгаас үнэ төлбөргүй хэрэглэсэн болон бусдаас бэлэг, хандив тусламжийн хэлбэрээр орж ирсэн орлогоос бүрдэнэ.

Өрхийн сарын зарлага нь хоол хүнсэнд хэрэглэсэн болон бусад аж төрж амьдрахад ашиглагдсан зүйлсийн хэмжээгээр тодорхойлогдоно. Эдгээрийг мах, гурил, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүний зарлага, хувцас, гутал, бөс бараа, тээвэр, холбоо, орон сууц, түлш, эрчим хүч зэрэг хүнсний бус бараа үйлчилгээний зардал, бусдад үнэ төлбөргүй өгсөн тусламж гэсэн гурван том бүлэгт хувааж тооцно.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил, улирлаар тооцно.

Мэдээллийн эх үүсвэр: Жил тутам ҮСХ-ноос эрхлэн явуулдаг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Тооцох аргачлал: Өрх гэрийн орлого, зарлагыг тооцож гаргах нь ихээхэн хэмжээний судалгаа шаарддаг амаргүй ажил байдаг. Манай улсын ҮСХ бүх аймаг, хот, сумдыг төлөөлж чадах хэмжээний айл өрхийг санамсаргүй аргаар түүвэрлэн авч бүтэн жилийн туршид орж ирсэн орлого, хэрэглэсэн хэрэглээг нь судлах замаар нэг өрхийн орлого, зарлагын дундаж хэмжээг тооцдог.

Үзүүлэлтийн тоон утга: Айл өрхийн орлого ямар хэмжээтэй байдгийг ҮСХ-ноос эрхлэн явуулдаг нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс харж болно. Энэхүү судалгааны дүн хорооны мэдээллийн санд тусгагддаг тул хүссэн он, улирлаар харах бололцоотой. 2015 оны эцсийн байдлаар нэг өрхийн улсын хэмжээний дундаж орлого харилцан адилгүй байна.

Өрхийн сарын дундаж орлого 500 мянган төгрөг буюу түүнээс доош өрх нийт өрхийн 30 орчим хувь болж байхад нэг саяас дээш орлоготой нь нийт өрхийн мөн 30 орчим хувийг эзэлж байна. Орлогоосоо хамаараад өрхүүдийн зарлага харилцан адилгүй байдаг. Нэг өрхийн дундаж зардлын 7-8 хувийг мах, махан бүтээгдэхүүн 6-7 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна. Нийт хэрэглээний 40 гаруй хувь нь хүнсний бус бараа, үйлчилгээнд зарцуулагдаж байна.

Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага, мянган төгрөгөөр

	2010	2011	2012	2013	2014
Өрхийн сарын дундаж орлого	448,0	573,5	819,9	959,2	1080,1
Өрхийн сарын дундаж зарлага	450,2	577,4	820,2	961,7	1076,7

8. Ядуурлын үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн гол агуулга: Хүн амын аж байдлыг дээшлүүлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр нөлөөг тодорхойлохын тулд ядуурлын үзүүлэлтүүдийг тооцдог. Олон улсын аргачлалаар тодорхойлсон ядуу гэдэг ойлголт орон нутагт янз бүрээр ойлгогддог.

Орон нутагт гэр бүлийн дотор мэргэжилтэй, ажил тогтмол эрхэлдэг хүнгүй, голдуу өрх толгойлсон эмэгтэйтэй, олон хүүхэдтэй, гэр бүлийн гишүүд өндөр настай, харж хандах ах дүүгүй, өөрийн гэсэн мал, хөрөнгөгүй, 10-20 толгой малтай ч тэр нь амьжиргаанд нь хүрэлцдэггүй, 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийг ядуу гэж үзэж байна. Харин манай улсын хувьд олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргагүйг ашиглаж ядуурлын үзүүлэлтүүдийг тооцдог.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Өрхийн нэг гишүүнд сард ногдох орлого нь ядуурлын шугамаас доогуур бол тэр өрхийг ядуу гэж тооцдог. Энэхүү ядуурлын шугам нь тухайн хүний амьдралд эн тэргүүнд шаардагдах хүнсний болон хүнсний бус хэрэглээний нийт хэмжээг илэрхийлнэ. Ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхийн нийт өрхөд эзлэх хувийг ядуурлын хамрах хүрээ гэж нэрлээд ядуурлыг хэмжих гол үзүүлэлт болгон ашиглаж байна. Энэхүү ядуурлын шугамаас дээгүүр орлоготой болгох бодлого үйл ажиллагааны чиглэлийг ҮСХ жил бүр бүс нутгаар ялгаатай тооцож зарладаг. Үүнийг амьжиргааны доод түвшин гэнэ.

Ядуурлын хамралтын хүрээ: Нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байгаа хүн амын эзлэх хувийн жин

Ядуурлын гүнзгийрэлт: Ядуу хүн амын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлнэ;

Ядуурлын мэдрэмж: Ядуу хүн амын дундах хэрэглээний тархалтыг илэрхийлнэ;

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ хоёр жилд нэг удаа тооцдог.

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ноос эрхлэн явуулдаг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа.

Тооцох аргачлал: Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдлын хэмжүүр үзүүлэлт болгож сонгож авахыг шийдэх нь юуны түрүүнд чухал юм. Хэрэглээ нь хувь хүн бүр бодитоор юу хэрэглэснийг орлого нь тухайн хүний чадварыг хөрөнгийн хамт илэрхийлнэ. Онолын хувьд ч мөн практик дээр ч амьжиргааны түвшинг хэрэглээгээр тодорхойлох нь орлогоор тодорхойлсноос илүү зохимжтой байдаг. Богино хугацааны буюу жишээ нь нэг жилийн хувьд орлогыг бодвол хэрэглээ нь илүү тогтвортой, өөрчлөлт багатай байдаг ба мэдээлэгчдэд хэрэглээгээр тодорхойлох нь орлогоос илүү хялбар байдаг зэрэг шалтгаанаар манай орны нөхцөлд хэрэглээний үзүүлэлтийг сонгож ядуурлын тооцоог хийнэ.

Монгол улсын ядуурлыг тооцоход Дэлхийн банкнаас улс орнуудын ядуурлыг тооцоход зөвлөмж болгосон аргыг хэрэглэж байна. Энэхүү аргачлал нь хялбарчлан ойлговол өмнөх суурь оны ядуурлын шугамыг тухайн хугацааны үнийн өөрчлөлтөөр өсгөж тооцох зарчимд суурилдаг. Харин ядуурлын шугамыг тодорхой хугацаанд шинэчлэн тооцдог. Улсын нийт аймаг, сумдаас тодорхой тооны өрхийг санамсаргүй түүвэрлэн авч бүтэн жилийн турш хэрэглээг нь судлах замаар өрхийн нэг гишүүний сарын орлогын дундаж хэмжээг тооцож гаргана. Хүн хоногт наад зах нь 2100ккал. илчлэг бүхий хүнс хэрэглэх шаардлагатай. Хүнсний энэ наад захын хэрэглээ бүхий өрхийн орлого нь ядуурлын шугам тооцох үндэслэл болдог.

Үзүүлэлтийн тоон утга:

Ядуурлын үзүүлэлтүүд, хувиар

	2008	2009	2010	2011	2012	2014
Ядуурлын хамралтын хүрээ	35,2	38.7	38.7	33.7	27,4	21,6
Ядуурлын гүнзгийрэлт	10,1	10.6	11.5	9.2	7,1	5,2
Ядуурлын мэдрэмж	4,0	4.1	4.7	3.5	2,7	1,9

Өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээ, төгрөгөөр

	2002-2003	2007-2008	2009	2010	2011	2012	2014
Хамгийн ядуу	10 991	30 497	34 350	42 573	51 023	65 264	88 611
Хамгийн чинээлэг	90 533	280 033	263 801	339 871	419 580	542 621	682 905
Ялгаа	8.2 дахин	9.2 дахин	7.7 дахин	8 дахин	8.2 дахин	8.3 дахин	7,7

9. Хүн амын төрөлтийн ерөнхий коэффициент

Үзүүлэлтийн гол агуулга: Хүн амын төрөлтийн ерөнхий түвшинг харуулах үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт:Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн мэдээгээр,Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), Хүн амын нас баралтын тайлан мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Тухайн онд амьд төрсөн нийт хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$TEK = \frac{AT}{XA_{дүн}} \cdot 1000$$

TEK – Төрөлтийн ерөнхий коэффициент

АТ – Тухайн жилд амьд төрсөн нийт хүүхдийн тоо

ХА_{дүн} – Хүн амын жилийн дундаж тоо

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Үзүүлэлтийн тоон утга: Төрөлтийн ерөнхий коэффициент, улсын дүнгээр, 2011-2014 он

Он	2011	2012	2013	2014
ТЕК	25.1	26	27.5	28

10. Хүн амын төрөлтийн нийлбэр коэффициент

Үзүүлэлтийн гол агуулга:

Үзүүлэлтийн тодорхойлолт: Нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй гэж үзвэл) нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ. Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн, нэг эмэгтэйд ногдохоор тооцдог.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн мэдээ.

Тооцох аргачлал: Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн, нэг эмэгтэйд ногдохоор тооцдог. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициентүүдийн нийлбэрийг насны бүлгийн интервалын уртаар үржүүлж, 1000-д хуваана.

$$ТНК = \frac{n \cdot \sum НБТК}{1000}$$

ТНК – Төрөлтийн нийлбэр коэффициент

n – НБТК – ийг тооцсон насны бүлгийн интервалын урт

НБТК – Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Үзүүлэлтийн тоон утга: Төрөлтийн нийлбэр коэффициент, *улсын дүнгээр, 2011-2014 он*

Он	2011	2012	2013	2014
ТНК	2.6	2.7	3	3.1

11. Хүн амын төрөлтийн тусгай коэффициент

Үзүүлэлтийн гол агуулга: Энэ үзүүлэлт нь хүн амын насны бүтцээс үл хамаарч, тухайн жилийн төрөлтийн дундаж түвшинг илэрхийлнэ.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тухайн жилийн төрөх насны (15-49 насны) 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоогоор илэрхийлнэ

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн мэдээгээр, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), Хүн амын нас баралтын тайлан мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Тухайн жилд амьд төрсөн нийт хүүхдийн тоог төрөх насны буюу 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$ТТК = \frac{АТ}{ХА_{(15-49)}^{эм}} \cdot 100$$

ТТК – Төрөлтийн тусгай коэффициент

АТ – Тухайн жилд амьд төрсөн нийт хүүхдийн тоо

ХА₍₁₅₋₄₉₎^{эм} – Тухайн жилийн 15-49 насны хүн амын тоо

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Үзүүлэлтийн тоон утга: Төрөлтийн тусгай коэффициент, *улсын дүнгээр, 2011-2014 он*

Насны бүлэг	2011	2012	2013	2014
ТТК	82.3	87.2	94.7	97.6

12. Нас баралтын ерөнхий коэффициент

Үзүүлэлтийн гол агуулга:Нас баралтын ерөнхий түвшинг харуулдаг үзүүлэлт.

Үзүүлэлтийн тодорхойлолт:Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн мэдээгээр, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), Хүн амын нас баралтын тайлан мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал:Тухайн жилд нас барсан нийт хүний тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$\text{НБЕК} = \frac{\text{НБТ}}{\text{ХА}_{(\text{дүн})}} \cdot 1000$$

НБЕК –Нас баралтын ерөнхий коэффициент

НБТ – Тухайн жилд нас барсан нийт хүний тоо

ХА_(дүн) –Хүн амын жилийн дундаж тоо

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

13. Дундаж наслалт

Үзүүлэлтийн гол агуулга: Хүний амьдрах хугацааг тодорхойлох үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) хэлнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ны Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан мэдээгээр, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), Хүн амын нас баралтын тайлан мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Тухайн хүн амын тухайн хугацааны насны бүлгийн нас баралтын коэффициентоор тооцсон дундаж наслалт, нас барах магадлалыг нас /эсвэл насны бүлэг/ тус

бүрээр харуулна. Дундаж наслалтын хүснэгтээс хүн амын нас баралтын талаар тодорхой, иж бүрэн дүр зургийг харж болно. Дундаж наслалтын хүснэгт тооцох тухай Үндэсний Статистикийн Хорооны 2013 оны 12 сарын 28-ны өдрийн 1/149 тушаалын хавсралт болох Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлалаас харах боломжтой.

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, аймаг, нийслэл, хүйсээр тооцох боломжтой.

Үзүүлэлтийн тоон утга: Дундаж наслалт, *улсын дүнгээр, 2011-2014 он*

Он	2011	2012	2013	2014
Улсын дүн	68.32	68.71	69.11	69.57

14. Хүний хөгжлийн индекс

Үзүүлэлтийн гол агуулга: ХХИ-ээр дэлхийн улс орнууд дахь хүний амьдралын дундаж наслалт, бичиг үсэг тайлагдалт, боловсролын түвшин, амьдралын хэм хэмжээ зэргээр харьцуулж үнэлдэг болохоор энэ нь хүний сайн сайхан байдал, хөгжлийн тоон хэмжигдэхүүн болдог.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь хүний хөгжлийн түвшинг илэрхийлэгч, хүний хөгжлийн урт хугацааны төлөв байдлын ерөнхий дүр зургийг харуулах, хүний хөгжлийг хэмжих нийлмэл үзүүлэлт юм.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: ХХИ-ийг тооцоолоход дараах эх үүсвэрээс мэдээллийг авна. Үүнд:

- Дундаж наслалт- Хүн амын жилийн эцсийн тайлан (Маягт ХА-3), Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (Маягт ХА-1), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 25, түүнээс дээш насны хүн амын сургуульд суралцсан дундаж хугацаа-Хүн ам, орон сууцны тооллого, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Сургуульд суралцах хугацаа- Хүн амын жилийн эцсийн тайлан (Маягт ХА-3), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; Ерөнхий

боловсролын сургуульд суралцагчдын тайлан (Маягт БДБ-1Б), Их дээд сургууль, коллежид суралцагчдын тайлан (Маягт ДБ-3) Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; Техник болон мэргэжлийн сургалтын байгууллагад суралцагчдын тайлан (Маягт ТМБ-2), Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

- Нэг хүнд ногдох ҮНО (ХАЧП-аар илэрхийлсэн доллар)- Үндэсний тооцооны үзүүлэлтүүд, Хүн амын жилийн эцсийн тайлан (Маягт ХА-3), Хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан (Маягт ХА-2), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; Зээлжих тусгай эрхийн дефляторын тооцоо, Дэлхийн банк; Суурь худалдан авах чадварын паритет, Дэлхийн банк, Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн тайлан;
- Нэг хүнд ногдох ДНБ (ХАЧП-аар илэрхийлсэн доллар)- Үндэсний тооцооны үзүүлэлтүүд, Хүн амын жилийн эцсийн тайлан (Маягт ХА-3), Хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан (Маягт ХА-2), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; Зээлжих тусгай эрхийн дефляторын тооцоо, Дэлхийн банк; Суурь худалдан авах чадварын паритет, Дэлхийн банк, Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн тайлан;

Тооцох аргачлал: ХХИ-ийг дараах гурван индексийг ашиглан тооцно. Үүнд:

1. Хүний амьдрах хугацааг тодорхойлох үзүүлэлт болох хүн амын дундаж наслалтын индекс;
2. Хүн амын боловсролын индекс: 25, түүнээс дээш насны хүн амын амьдралынхаа турш суралцсан дундаж хугацаа болон сургуульд элсэх насны хүүхдийн бүх шатны сургуульд суралцах хугацааны квадрат дунджаас тооцсон индекс;
3. Орлогын индексийг улсын түвшинд нэг хүнд ногдох ҮНО-ыг; аймаг, нийслэлийн түвшинд нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын паритетэд харьцуулж тооцно. Ингэхдээ нэг хүнд ногдох ҮНО болон ДНБ-ийг долларт шилжүүлнэ.

Хүний хөгжлийн индекс тооцох ерөнхий томьёо:

$$\text{ХХИ} = \sqrt[3]{\text{ДН} \times \text{БИ} \times \text{ОИ}}$$

ДН – Дундаж наслалтын индекс

БИ –Боловсролын индекс

ОИ - Орлогын индекс

Дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн тоот тушаалын хавсралтаас харах боломжтой.

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцно.

Үзүүлэлтийн тоон утга: Хүний хөгжлийн индекс, *улсын дүнгээр, 2011-2014 он*

Он	2011	2012	2013	2014
Улсын дүн	0.723	0.732	0.739	0.748

15. Жендэрийн тэгш бус байдлын индекс

Үзүүлэлтийн гол агуулга: Жендэрийн тэгш бус байдлын индексийн тооцоо нь гурван жил тутам эрхлэн гаргадаг хүний хөгжлийн үндэсний илтгэлийн албан ёсны үндсэн мэдээлэл болох бөгөөд хөгжлийн ерөнхий түвшинг хэмжих, үнэлэхэд ашиглагдана.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Жендэрийн тэгш бус байдлын индекс нь хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалах хүний хөгжлийн гурван хэмжүүр болох нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал ба шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс юм. Үүнд:

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтийг эхийн эндэгдлийн түвшин, өсвөр насны охидын төрөлтийн түвшнээр;
- Боловсролын түвшин ба шийдвэр гаргах эрх мэдлийн үзүүлэлтийг 25, түүнээс дээш насны хүн амд дундаас дээш боловсрол эзэмшсэн эмэгтэй, эрэгтэй хүн амын хувийн жингээр, үндэсний парламент дах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жингээр;
- Хөдөлмөрийн зах зээлийн оролцооны үзүүлэлтийг ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр тооцож авч үзнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр:

- Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьдтөрөлтөдногдох) - Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн сарын мэдээ (Маягт МТ-501), Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (Маягт ХА-1), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Өсвөр насны охидын төрөлтийн түвшин – Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (Маягт ХА-1), Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Үндэсний парламент дах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин-УИХ-ын сонгуулийн дүнгийн мэдээ, Сонгуулийн төв байгууллага;
- 25, түүнээс дээш насны хүн амд дундаас дээш боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жин - Хүн ам, орон сууцны тооллого, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Ажиллах хүчний оролцооны түвшин - Ажиллах хүчний судалгаа, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

Тооцох аргачлал: ЖТБИ-ийг дараах таван дарааллын дагуу тооцно. Үүнд:

- Доод болон дээд утгыг тодорхойлох
- Хэмжигдэхүүнийг геометр дунджаар нэгтгэх
- Гармоник дунджаар хүйс тус бүрээр хэмжигдэхүүнийг нэгтгэх
- Үзүүлэлт тус бүрийн арифметик дунджуудын геометр дунджийг тооцох
- Жендэрийн тэгш бус байдлын индексийг тооцох

Дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн тоот тушаалын хавсралтаас харах боломжтой.

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцно.

Үзүүлэлтийн тоон утга:

Жендэрийн тэгш бус байдлын индекс, улсын дүнгээр, 2011-2014 он

Он	2011	2012	2013	2014
Улсын дүн	0.390	0.345	0.323	0.294

16. Сургуульд хамран сургалтын бохир жин

Үзүүлэлтийн гол агуулга:Тухайн боловсролын түвшинд хамран сургалтын ерөнхий түвшинг харуулна.

Үзүүлэлтийн тодорхойлолт:Хамран сургалтын бохир жин нь нас харгалзалгүйгээр боловсролын тодорхой түвшний нийт суралцагчдын тоог тухайн хичээлийн жилд тэр түвшинд суралцвал зохих насны нийт хүүхдэд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тодорхой насны суралцагчдын хэдэн хувь нь боловсролд хамрагдах боломжтойг илэрхийлэхээс гадна сургуулийн наснаасаа хэтэрч сургуульд орсон, эсвэл зохих наснаас өмнө сургуульд орсон суралцагч хэр олон байгааг тодорхойлж, ингэснээрээ хамран сургалтын цэвэр жингийн үзүүлэлтэд нэмэлт үзүүлэлт болдог.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа:ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээ, ҮСХ-ны суурин хүн амын мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Нас харгалзалгүйгээр боловсролын тухайн шатны түвшний сургуульд элссэн суралцагчдын тоог энэ түвшний боловсрол эзэмших насны нийт хүүхдэд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$a) \text{ХСБЖ}_{\text{бага}} = \frac{\text{Бага боловсролд суралцагчдын тоо}}{6-10 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

$$b) \text{ХСБЖ}_{\text{суурь}} = \frac{\text{Суурь боловсролд суралцагчдын тоо}}{11-14 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

$$c) \text{ХСБЖ}_{\text{суурь}} = \frac{\text{Бүрэн дунд боловсролд суралцагчдын тоо}}{15-17 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

Хамран сургалтын бохир жин нь боловсролын бүх түвшин, төрийн болон хувийн өмчийн сургуульд сургуульд суралцагчдыг хамарна. Сургуульд наснаас өмнө, хожуу элссэн, улирсан зэрэг шалтгаанаар нас хэтэрсэн болон нас нь хүрээгүй суралцагчдыг хамруулдаг учир хамран сургалтын бохир жин 100 хувиас давж болдог. Энэ тохиолдолд улирсан суралцагчид болон нас хэтрэн сургуульд орсон суралцагчдын талаарх нэмэлт мэдээллийг сайн нягтлан үзэх хэрэгтэй.

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, боловсролын түвшин, хүйсээр тооцно.

17. Сургуульд хамран сургалтын цэвэр жин

Үзүүлэлтийн гол агуулга: Боловсролын тухайн түвшинд хамрагдах насны суралцагчдын боловсролд хамрагдаж буй түвшинг тодорхойлоход оршино.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Боловсролын тухайн түвшинд албан ёсоор суралцах насандаа элссэн суралцагчдын тооны тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувиар хамран сургалтын цэвэр жинг тодорхойлно. Энэ үзүүлэлтийн дээд хэмжээ онолын хувьд 100 хувь байна. Энэ үзүүлэлтийг тооцохдоо боловсролын бүх байгууллагыг бүрэн хамарсан мэдээлэлд үндэслэх ёстой.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээ, ҮСХ-ны суурин хүн амын мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Боловсролын тухайн түвшинд элсэн суралцаж буй зохих насны суралцагчдын тоог хамрагдвал зохих насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$a) \text{ХСЦЖ}_{\text{бага}} = \frac{6-10 \text{ насны суралцагчдын тоо}}{6-10 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

$$b) \text{ХСЦЖ}_{\text{суурь}} = \frac{11-14 \text{ насны суралцагчдын тоо}}{11-14 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

$$c) \text{ХСЦЖ}_{\text{суурь}} = \frac{15-17 \text{ суралцагчдын тоо}}{15-17 \text{ насны нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, боловсролын түвшин, хүйсээр тооцно.

18. Анги дэвшилтийн хувь

Үзүүлэлтийн гол агуулга: Тухайн насны бүлгийн суралцагчдыг анги дэвшүүлэн сургах талаар боловсролын систем хэр үр дүнтэй байгааг харуулах, ингэснээр энэ нь боловсролын системийн дотоод үр ашигт нь хэрхэн нөлөөлж байгааг илэрхийлэхэд оршино. Энэ үзүүлэлт

нь боловсролын системийн дотор суралцагчдын шилжилт, хөдөлгөөнийг шинжлэхэд гол үзүүлэлт нь болдог.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Анги дэвшилтийн хувийг тухайн ангид дэвшин орсон нийт хүүхдийн тоог өмнөх жил нь үүний өмнөх ангид суралцаж байсан нийт хүүхдийн тоонд харьцуулсан харьцаагаар илэрхийлнэ. Бага, дунд боловсролын дотоод үр ашгийг илтгэх үзүүлэлт бөгөөд тухайн суралцагчдыг зохих хугацаанд нь боловсрол эзэмшиж төгсгөх төлөвлөлтөд ашиглагддаг. Анги дэвшилтийн хувь 100 хувиас доогуур байх нь төсвийн үр ашиггүй зарцуулалт, багшийн мэргэжил, ур чадвар дутмаг, анги, танхимын хүрэлцээгүй байдал гэх мэт суурь үзүүлэлтүүдтэй холбоотой байдаг.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Тухайн ангид өмнөх ангиас дэвшин суралцсан нийт хүүхдийн тоог өмнөх жил үүний өмнөх ангид суралцаж байсан нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$АДХ = \frac{\text{Тухайн ангид дэвшсэн суралцагчдын тоо}}{\text{Өмнөх ангид суралцаж байсан нийт хүүхдийн тоо}} \cdot 100$$

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, анги, өмчийн хэлбэр, хүйсээр тооцно.

19. Анги улиралтын хувь

Үзүүлэлтийн гол агуулга: Дараалсан хоёр хичээлийн жилд анги дэвшихгүйгээр тухайн ангидаа улиран суралцаж байгаа суралцагчдын эзлэх хувийг тодорхойлж, түүний боловсролын үр ашигт хэрхэн нөлөөлөхийг тодорхойлоход ашиглагддаг үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Анги улиран суралцагчид гэж нэг хичээлийн жилд нэг ангид сурахаар элсэн орсон хүүхдийн дотроос тухайн ангидаа дараагийн жилд давтан суралцсан суралцагчдыг ойлгоно.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр:Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал:Анги улиран суралцагчдын хувийг тодорхойлоход тухайн хичээлийн жилд анги улиран суралцагчдын тоог өмнөх хичээлийн жилд анги дэвшсэн суралцагчдын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$AУСХ = \frac{\text{Тухайн хичээлийн жилд улиран суралцагчдын тоо}}{\text{Өмнөх хичээлийн жилд анги дэвшсэн суралцагчдын тоо}} \cdot 100$$

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, өмчийн хэлбэр, анги, хүйсээр тооцно.

20. Сургууль завсардалтын хувь

Үзүүлэлтийн гол агуулга: Үргэлжлүүлэн суралцаагүй завсардалтыг тооцох, түүний үр дагавар нь боловсролын системийн дотоод үр ашигт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино. Сургууль завсардагчдын хувийн жин нь боловсролын системийн дотор суралцагчдын шилжилт, хөдөлгөөнийг тооцоход чухал үзүүлэлт болдог.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Өмнөх хичээлийн жилд тодорхой анги, бүлгийн суралцагчид тухайн хичээлийн жилд үргэлжүүлэн суралцаагүй байвал сургууль завсардалт гэж үзнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Сургууль завсардагчдын хувийн жинг гаргахдаа тухайн хичээлийн жилд анги дэвшсэн болон улирсан суралцагчдын эзлэх хувийн нийлбэрийг 100 хувиас хасна. Бага боловсролын сургууль завсардалтын хувьд, тухайн ангид дэвшин орж чадсан суралцагчдын эзлэх хувийг 100 хувиас хасна.

$$СЗХЖ = 100 - \left(\sum_{i=1}^n АДСХ + \sum_{i=1}^n АУСХ \right)$$

i –анги (1, 2, 3,...,n)

СЗХЖ – Сургууль завсардагчдын хувийн жин
АДСХ – анги дэвшсэн суралцагчдын хувийн жин
АУСХ – анги улиран суралцагчдын хувийн жин

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, боловсролын түвшин, өмчийн хэлбэр, анги, бүлэг, хүйсээр тооцно.

21. Сурагч - багшийн тооны харьцаа

Үзүүлэлтийн гол агуулга: Хүний нөөцийн орцыг хэмжих, сурагч, багшийн харьцааг боловсролын түвшин, төрөл тус бүрээр улс болон аймаг, нийслэлийн түвшинд тогтоосон нормтой харьцуулах зорилгоор тооцдог үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Сурагч, багшийн тооны харьцаа гэж тухайн хичээлийн жилд боловсролын тодорхой нэг түвшинд нэг багшид ногдох суралцагчдын дундаж тоог ойлгоно. Энэ үзүүлэлтийг тооцоход цагийн багш, хичээлийн ээлжийн тоо, олон анги нийлүүлсэн анги гэх мэт олон хүчин зүйл байгааг анхаарах хэрэгтэй. Цагийн багш нарыг үндсэн багшид хөрвүүлэн тооцно. Багш нарын тоонд сургалтын үйл ажиллагаанд оролцож байгаа бүх багшийг оролцуулна.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил бүр

Мэдээллийн эх үүсвэр: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээгээр тооцно.

Тооцох аргачлал: Боловсролын тухайн нэг түвшинд суралцагчдын тоог тухайн түвшний багш нарын тоонд харьцуулна. Энэ харьцааг бага анги, үүний дотор нэгдүгээр ангийн багшид ногдохоор салган тодорхойлно.

$$СБТХ = \frac{\text{Тухайн боловсролын түвшний суралцагчдын тоо}}{\text{Тухайн боловсролын түвшний багш нарын тоо}} \cdot 100$$

Үзүүлэлтийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, боловсролын түвшнээр тооцно.

ШҮҮХИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Үзүүлэлтийн гол агуулга: Гэмт хэрэг бол нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхэд гэмт хэрэг бас нэмэгдэж байдаг. Иймээс гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулахад ашигладаг үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тодорхойлсон байна.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ , сар, улирал, жилээр

Мэдээллийн эх үүсвэр: Цагдаагийн Ерөнхий Газрын сарын мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан

Тооцох аргачлал: 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны суурин хүн амын тоонд харьцуулна.

Үзүүлэлтийн задаргаа: Бүртгэгдсэн гэмт хэргийг МУ-ын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр задалж гаргадаг. Үүнд:

- Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг,
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг,
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг,
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг,
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг,
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг,
- Бусад гэмт хэрэг.

Үзүүлэлтийн тоон утга:

18, түүнээс дээш насны 10000 хунд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг, бүсээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Улс, бүс нутгаар	2014 он		2015 он	
	X	I-X	X	I-X
Улсын дундаж	16	117	14	118
Баруун бүс	9	58	7	57
Хангайн бүс	9	68	8	68
Төвийн бүс	14	110	12	104
Зүүн бүс	13	92	10	81
Улаанбаатар	22	165	19	165

Эх сурвалж: МУ-ын нийгэм, эдийн засгийн танилцуулга, ҮСХ, 2015 оны 10 сар

2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлтийн гол агуулга: Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх ёстой. Иймээс иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байдлыг илэрхийлэх үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллагын тоо, учирсан хохирлын хэмжээ, хохирлыг нөхөн төлүүлсэн хэмжээ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ жилээр тооцож гаргадаг.

Мэдээллийн эх үүсвэр: Цагдаагийн Ерөнхий Газрын сарын мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан

Тооцох аргачлал: Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллагын тоо, учирсан хохирлын хэмжээ, хохирлыг нөхөн төлүүлсэн хэмжээ.

Үзүүлэлтийн задаргаа: Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллагын тоо, учирсан хохирлын хэмжээг гэмт хэргийн төрлөөр задарч гарна.

Үзүүлэлтийн тоон утга:

*Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 10 сарын байдлаар
/ сая төг/*

Үзүүлэлт	2014 он		2015 он	
	Х	I-Х	Х	I-Х
Учирсан хохирол-Бүгд	20 720.7	76 861.5	7 334.1	122 449.0
Үүнээс:				
Төрийн өмчид учирсан	1 128.9	4 472.1	192.1	5 486.4
Хувийн өмчид учирсан*	19 536.7	71 077.9	6 878.0	108 648.0
Нөхөн төлүүлсэн	3 787.2	28 382.4	2 668.7	36 790.4

* - Хувь хүнд учирсан хохирлыг оруулсан.

Эх сурвалж: МУ-ын нийгэм, эдийн засгийн танилцуулга, ҮСХ, 2015 оны 10 сар

3. Аж ахуйн нэгжийн дампуурал

Үзүүлэлтийн гол агуулга: ҮСХ-ны бизнес регистр(БР)-ийн санд аж ахуйн нэгж байгууллагуудын нэмэлт, өөрчлөлт, хасалт хийгээд түүврийн хүрээ тогтооход ашигладаг.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Дампуурсан, хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн, үйл ажиллагаа явуулах зөвшөөрсөн хугацаа нь дууссан, зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан, нэг ч гишүүнгүй болсон зэрэг үндэслэлээр татан буулгах шийдвэр гаргасан аж ахуйн нэгжийг татан буугдсан аж ахуйн нэгж гэнэ..

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, улирал

Мэдээллийн эх үүсвэр: УБЕГ-аас улирал бүр татан буугдсан аж ахуйн нэгжийн мэдээллийг авдаг.

Тооцох аргачлал: Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн санд татан буугдсан ААНБ-ыг бизнес регистрийн санд татан буулгана.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Газрын нэгдмэл сан

Үзүүлэлтийн гол агуулга: Газрын харилцааны суурь бодлогыг тодорхойлно.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Сум, дүүргээс Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан ГТ-1, Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

Тооцох аргачлал: Газрын нэгдмэл сангийн нийт талбайн хэмжээнд хөдөө аж ахуйн газар, хот, тосгон, бусад суурины газар, зам, шугам сүлжээний газар, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар багтана.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ газрын нэгдмэл сангийн ангиллаар тооцдог.

Үзүүлэлтийн тоон утга:

*Монгол улсын газрын нэгдмэл сан, үндсэн ангиллаар
Хэмжих нэгж : мян.га*

Үндсэн ангилал	2012	2013	2014
Нийт талбайн хэмжээ	156,411.6	156,411.6	156,411.6
Хөдөө аж ахуйн газар	115,399.9	115,361.4	115,008.6
Хот, тосгон, бусад суурины газар	702.0	699.6	712.1
Зам, шугам, сүлжээний газар	435.3	437.3	454.8
Ойн сан бүхий газар	14,256.5	14,295.4	14,320.5
Усны сан бүхий газар	686.8	686.7	686.7
Тусгай хэрэгцээний газар	24,931.1	24,931.1	25,228.9

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

2. Улсын тусгай хэрэгцээний газар

Үзүүлэлтийн гол агуулга: Улс орны биологийн төрөл зүйлийн мөхөл, экосистемийн хомсдол зэргийн эсрэг үзүүлж буй хариу арга хэмжээ юм. Мөн биологийн төрөл зүйл, түүх, соёлын дурсгалт, шинжлэх ухааны судалгаанд ашиглах, амралтын зориулалттай болон

бусад байгалийн үнэт зүйлсийн унаган төрхийг хамгаалах зорилго бүхий үйл явцыг түгээн дэлгэрүүлэх зорилгыг агуулна.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хууль тогтоомжийн дагуу хамгаалсан газар нутаг, усны мандал, агаарын давхарга, тэдгээрийн нийт нутаг дэвсгэрийг багтааж ойлгоно.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Газрын нэгдмэл сангийн тайлан” ГТ1-9 маягт

Тооцох аргачлал: Тухайн газар нутгийн хэмжээ, байршил, тусгай хамгаалалтад орсон өдөр, олон улсын зөвлөмж болон тухайн улс орны хууль дүрэмд нийцэж байгаа байдал зэргийг багтаасан мэдээллийн сан. Тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц, дурсгалт газар гэж дөрөв ангилдаг.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

3. Газарт учруулсан хохирол

Үзүүлэлтийн гол агуулга: Байгаль орчинд үзүүлж буй нөлөөг тооцох, түүний чиг хандлагыг тодорхойлоход ашиглана.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Зам, шугам сүлжээний газар, хот тосгон, бусад суурины газар, хог булсан, хаясан газар болон бусад ашиглалт хийсэн газрыг энэ ойлголтод хамруулна.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Газрын нэгдмэл сангийн тайлан” ГТ1-9 маягт

Тооцох аргачлал: Зам, шугам сүлжээний газар, хот тосгон, бусад суурины газар, хог булсан, хаясан газар болон бусад ашиглалт хийсэн газрын хэмжээгээр илэрхийлнэ. Хууль бусаар хог булсан, хаясан газрыг бүрэн бүртгэх нь байнгын хүндрэлтэй байдаг.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

4. Цэвэр усны нөөц, хомсдол

Үзүүлэлтийн гол агуулга: Тухайн улсын тодорхой хугацааны нөхөн сэргээгдэх цэвэр усны хэмжээг тодорхойлоход хэрэглэнэ.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хур тундас, гадаргын болон газрын доорх ус, мөн гадаргаар болон газрын доогуур хөрш орнуудаас урсан ирж буй цэнгэг ус юм.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Цэвэр усны нөөц, хомсдлын 20...оны жилийн мэдээ” БОХ4.1 маягт

Тооцох аргачлал: Нөхөн сэргээгдэх цэвэр усны нөөцийн талаарх мэдээллийг ихэвчлэн ус судлалын станцын удаан хугацааны хэмжилтийн түвшинд үндэслэн тооцооллыг хийнэ. Тооцооллыг хийхдээ урсацын коэффициент, гол болон нуурын дотогш/гадагш урсац, газрын доорх усны хаялбар, хур тунадасны хэмжээ зэргийг ашиглана. Энэ үзүүлэлт нь тухайн улсын усны балансыг тодорхойлоход хэрэглэдэг гол үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

5. Агаарын чанарын стандарт

Үзүүлэлтийн гол агуулга: Агаарын чанарыг хянах, бохирдлыг бууруулах арга хэмжээ авах, бохирдлын нөлөөллийг хэмжихэд хэрэглэнэ.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Дараах үзүүлэлтээр хот орчмын агаарын чанарыг тодорхойлно. Үүнд:

- Агаарын чанарын ажиглалтаар хотын агаарт жилийн хугацаанд нийт хэмжлийн хэдэн хувьд нь агаарын чанарын стандартад заасан жилийн дундаж хүлцэх хэм хэмжээнээс давсан тохиолдлын тоог хувиар;
- Агаар дахь бохирдуулагч бодисуудын агууламж абсолют утга, хамгийн их агууламж.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, сар, жил

Мэдээллийн эх үүсвэр: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Агаарын чанарын төлөв байдлын 20... оны жилийн мэдээ” БОХ 8.1 маягтаар аймаг, нийслэлийн харуулын дүнгээр гаргана. Улаанбаатар хотын агаарын чанарын сар бүрийн мэдээллийг агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба “Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж” ЦУ2 маягт.

Тооцох аргачлал: Агаарын чанарын хяналтын сүлжээ нь суурин болон хөдөлгөөнт харуулаас бүрддэг. Харуулын байрлалыг сонгохдоо агаарын бохирдол ихтэй 9 (аж үйлдвэр, төв зам) орчинд шууд сэргийлэх зорилгоор, хотын хүн ам байнга оршин суух газарт ерөнхий үнэлгээ хийх боломжийг харгалзан байрлуулна. Агаарын чанарын стандартын дагуу дараах хүлцэх хэм хэмжээтэй харьцуулна. Үүнд:

Агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээ, мг/мЗээр

	Хоногийн дундаж	нэг удаагийн	8 цагийн дундаж
Хүхэрлэг хий, SO ₂	0.02	0.45	
Азотын давхар исэл, NO ₂	0.04	0.085	
Тоос, PM _{2.5}	0.05		
Тоос, PM ₁₀	0.1		
Угаарын хий, CO		30	10
Озон O ₃			0.1

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

6. Ойн нөөц, хамгаалалт, зохицуулалт

Үзүүлэлтийн гол агуулга: Ой болон ойн бусад газар нутгийн хэмжээг тооцох болон байгаль орчны зориулалтаар хэрэглэх талбайн хувь хэмжээг тогтоох зорилготой. Ой хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргээх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох замаар ойг хамгаалахад оршино.

Үзүүлэлтийн тодорхойлолт:“Ойн нөөц” гэж ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг хэлнэ.Ой болон ойн бусад газар нутгийн нийт хэмжээ, Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд эзлэх хувь (ойрхог чанар) зэргээр тодорхойлно. Ойн бусад газарт ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбайг хамруулна.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Газрын нэгдмэл сангийн тайлан” ГТ1-9 маягт

Тооцох аргачлал: Мэдээлэл цуглуулах, боловсруулах арга зүй, үйл явц нь түүвэр судалгаа, кадастрын судалгаа, холын зайнаас ажиглалт хийх болон дээрх аргуудын холимог арга байдаг.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ нь улсын дүнгээр тооцдог.

7. Ойн сан бүхий газар

Үзүүлэлтийн гол агуулга: Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Үзүүлэлтийн тодорхойлолт:“Ойн сан” гэж ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг хэлнэ.

Хариуцан гаргадаг байгууллага, хугацаа: ҮСХ, жил

Мэдээллийн эх үүсвэр: Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан ГТ-1.

Тооцох аргачлал: Ой, загаар бүрхэгдсэн, ой модыг нь огтолсон газар, мод үржүүлгийн газар, ой тэлэн ургах нөөц газар, ойн сангийн бусад газар гэж бүлэглэдэг.

Үзүүлэлтийн задаргаа: ҮСХ, ойн сангийн бүрэлдэхүүнээр, улс, бүс, аймгаар

Үзүүлэлтийн тоон утга:

Ойн сан бүхий газар, бүс, аймаг, нийслэлээр, 2014 он

Хэмжих нэгж : га

Аймаг	Бүгд	Ой, загаар бүрхэгдсэн	Ой модыг нь огтолсон газар	Мод үржүүлгийн газар	Ой тэлэн ургах нөөц газар	Ойн сангийн бусад газар
Архангай	1,082,621	847,490	2,764	0	0	232,367
Баян-Өлгий	22,577	22,322	246	9	0	0
Баянхонгор	330,670.8	298,858.5	4,220	3.3	0	27,589
Булган	1,905,008.7	1,428,665.7	7,887	45.3	468,410.7	0
Говь-Алтай	1,221,267	1,215,229.2	5,724.8	0	0	313
Говьсүмбэр	0	-	-	-	-	-
Дархан-Уул	72,019.5	71,392.7	415	211.8	0	0
Дорноговь	158,484.7	115,464.8	0	80.3	0	42,939.6
Дорнод	174,410.7	98,693.6	41,985	1,014.6	32,717.5	0
Дундговь	62,476.6	27,124	0	4,012.6	31,340	0
Завхан	490,729.5	463,235	5,039	50.5	0	22,405
Орхон	15,615.8	15,576	0	22.8	0	17
Сэлэнгэ	1,534,122.5	1,376,641	20,670	106.5	27,120	109,585
Сүхбаатар	81.7	27.4	42.3	12.1	0	0
Төв	563,417.2	535,207	3,255	7,664.2	1,193	16,098
Увс	110,218.9	72,519.9	4,512.1	96.4	33,090.5	0
Улаанбаатар	74,006.3	64,657.7	12	1,990.3	154	7,192.2
Ховд	467,315.5	310,483.5	322.1	13,432.1	95	142,982.8
Хэнтий	1,132,693.9	980,852.7	1,549.4	13	79,200	71,078.8
Хөвсгөл	4,005,408	3,383,856	36,455	50	57,070	527,977
Өвөрхангай	150,749.5	129,365.9	5,968	91.5	13,208.8	2,115.4
Өмнөговь	746,591.5	723,668	920	22,003.1	0.4	0

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” MON/13/201 төслийн баримт бичиг;
2. “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” MON/13/201 төслийн “Орон нутгийн статистикийн чадавхыг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зөвлөхийн ажлын тайлан;
3. Орон нутгийн түвшин дэх статистикийн мэдээллээр хангах одоогийн боломж, дутагдалтай байдлыг үнэлж, хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан;
4. Аймаг, нийслэлийн ДНБ-ийг нутаг дэвсгэрийн зарчмыг харгалзан үзэж хуваарилах арга зүйн санал;
5. Орон нутгийн статистикийн чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд сумын түвшинд өрхийн амьжиргааг тогтоох, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт тооцох аргачлал боловсруулах явцын тайлан;
6. Албан ёсны статистикийн нэгдсэн үзүүлэлтүүд, үзүүлэлтүүдийг шинэчлэн батлах тухай” ҮСХ-ны даргын 2014 оны 09 сарын 11-ний А-101 тоот тушаал, тушаалын нэгдүгээр хавсралт;
7. Мөн тушаалын 2А хавсралтаар баталсан “Орон нутгийн эдийн засгийн үзүүлэлтүүд, тооцон хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”;
8. Мөн тушаалын 2Б хавсралтаар баталсан “Орон нутгийн нийгмийн үзүүлэлтүүд, тооцон хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”
9. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн эмхтгэл;
10. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн товчоон;
11. Хэнтий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал, статистикийн сарын бюллетень, 2015 оны 7 сар
12. Хэнтий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал, статистикийн сарын бюллетень, 2015 оны 8 сар
13. 2015 оны эхний хагас жилд хийж, хэрэгжүүлсэн ажлын товч тайлан, Хэнтий аймгийн Жаргалтхаан сум
14. М.Амартүвшин “ДНБ, ХҮИ-ийг сумын түвшинд тооцох” ажлаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөхийн ажлын тайлан
15. Орон нутагт статистикийн мэдээлэл тархаалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх боломж, нөхцөлийг судлах, энэ чиглэлээр төслийн хүрээнд хийх ажлын хөтөлбөр боловсруулах зорилгоор 2015.07.06– 07.08-нд Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэст ажилласан ажлын тайлан.
16. Өвөрхангай аймгийн Баянгол сумын “Орон нутагт ядуурлын байдлыг тодорхойлж буй” аргачлал,
17. ҮСХ-ны мэдээний график, 2015 он;

18. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн хэлтсүүдийн сарын танилцуулга бэлтгэдэг загвар;
19. Хэнтий, Өвөрхангай аймгийн статистикийн мэдээллийн DevInfo сан;
20. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, даатгалын салбаруудын мэдээллийн сангийн бүтэц, танилцуулга;
21. Статистикийн эмхтгэл, 2014;
22. Тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийн нууцлалыг хангах, нууцлал хангагдсан анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулахад баримтлах журам, ҮСХ, 2012;
23. Хувь хүний нууцын тухай МУ-ын хууль, 2012;
24. Байгууллагын нууцын тухай МУ-ын хууль, 2011;
25. www.nso.mn ;
26. www.1212.mn ;
27. <http://www.datacenter.gov.mn/>;
28. www.legalinfo.mn: Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам;
29. <http://www.ibm.com/big-data/us/en/>;
30. https://en.wikipedia.org/wiki/Big_data;
31. www.Strategic Planning ;
32. www. How to Prepare A basic Training Modules;
33. www. Training Modules